ИНВЕСКОР ӨСӨЛТ
ХБҮЦ-НЫ ТАНИЛЦУУЛГА



Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Үүсгэн байгуулагч	Үндсэн Андеррайтер	Туслах Андеррайтер	Зээлийн шинжилгээ гаргагч	Хуулийн фирм	Хөрөнгө итгэмжлэн удирдагч
InvesCore	Golomt Capital	√Capital	CDTA AUDIT LLC	MDS KhanLex	MICG

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаасны тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох дүрэм, журмын дагуу Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргаж байгаа болно.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 500,000 ширхэг буюу нийт 50,000,000,000 (тавин тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Бирж дээр гарган олон нийтэд нээлттэй арилжихтай холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар өөрийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд өөрийн мэргэжлийн санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэйгээ зөвлөлдөхийг зөвлөж байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа аль болох үнэн зөв мэдээллийг ашиглан бодит байдалд нийцүүлэхийг зорьсон боловч цуглуулсан мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

ЭНЭХҮҮ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСАНД ГАРГАСАН БАТАЛГАА БИШ БӨГӨӨД ТҮҮНИЙ АГУУЛСАН МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ, БҮРЭН БҮТЭН БАЙДАЛ БОЛОН АЛИВАА ЭРСДЭЛИЙГ СЗХ БОЛОН МХБ ХАРИУЦАХГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ.

ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч "Инвескор Өсөлт ТЗК" ХХК болон Үндсэн андеррайтер "Голомт Капитал ҮЦК" ХХК-д хандаж тодруулна уу.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
АТ 7167257 9025701486

Голомт Капитал ҮЦК ХХК
Голомт Капитал

2025/11/28

ХӨРӨНГИЙН БИРЖ STOCK EXCHANGE
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

2025 -12- 26
БҮРТГЭВ
01

АГУУЛГА

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД 2
АГУУЛГА 3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ 5
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ 6
СХЕМИЙН ЖАГСААЛТ 6
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР 9
ТОВЧИЛСОН ҮГНИЙ ТАЙЛБАР 10
ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД 11
1. ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА 17
1.1. ҮНЭТ ЦААСНЫ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ 17
1.2. ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ 18
1.3. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ 18
1.4. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД ХБҮЦ-НЫ ТӨЛБӨР ТӨЛӨХ 19
2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ 22
2.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРӨЛ 22
2.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ 23
2.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ 23
2.3.1. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ 24
2.3.2 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ 24
2.3.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ 26
3. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ 29
3.1. ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ХЭЛЦЛИЙН ЕРӨНХИЙ ЗУРАГЛАЛ 29
3.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН ГЭРЭЭНҮҮД 33
3.3. ХӨРӨНГИЙН БАГЦ 36
3.3.1. ХӨРӨНГИЙН БАГЦАД ТАВИХ САНХҮҮГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 36
3.3.2. ХӨРӨНГИЙН БАГЦАД ТАВИХ ХУУЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 37
3.3.3. ЗЭЭЛИЙН БАГЦЫН ГОЛЛОХ МЭДЭЭЛЭЛ 38
3.4. ЗЭЭЛИЙН БАГЦЫН ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН 40
3.5. ЗЭЭЛИЙН БАГЦЫН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ГЭРЭЭТ АЖЛЫН ТАЙЛАН . 40
3.6. ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 40
3.7. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙГ ТӨЛӨХ ТӨЛБӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ 42
3.8. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ХУГАЦААНДАА ТӨЛӨГДӨХГҮЙ НӨХЦӨЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭ 44
4. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ 47
4.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан гэрээний тухай 47
4.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон үүсгэн байгуулагчийн үйл ажиллагааны тухай 49

ИНВЕСКОР өсөлт ТӨК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

Golomt Capital Delivery Activity
Улаанбаатар хот

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2025-12-31 БҮРТГЭВ-02

ХХК 2025.12.25 БҮРТГЭВ №-01

4.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтэц, зохион байгуулалт 52
4.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн удирдлага 58
4.5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн засаглалын кодекс 60
4.6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хүний нөөц, программ хангамжийн тухай 62
4.7. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө нь гаргасан үнэт цаасны мэдээлэл 62
4.8. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн байдал 63
5. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ 71
6. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУХАЙ 76
6.1. Ерөнхий танилцуулга 76
6.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээний тухай 77
7. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН 80
7.1. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ 80
7.2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ 83
7.3. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ 88
7.4. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ 90
8. ХБҮЦ-НЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН 96
8.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин 96
8.2. Үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин 98
8.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон хөрөнгийн багцтай холбоотой хууль эрх зүйн орчин 99
8.4. ИНВЕСКОР ӨСӨЛТ ХБҮЦ-тай холбоотой үйл ажиллагааны зохицуулалт: 100
9. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ 104
9.1. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ 104
9.1.1. Үнэт цаасны арилжаанд оролцох, захиалга авах заавар 105
9.1.2. Албан татвар 106
9.1.3. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа 106
9.1.4. Үнэт цаасны арилжаа, хүүгийн төлбөр 106
9.1.5. Үнэт цаас эзэмшигчийн эрх, үүрэг 106
9.1.6. Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг 107
9.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ТАНИЛЦУУЛАХ, МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ 108
9.3. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА 111
10. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД 119
10.1. Үндсэн андеррайтер 119
10.2. Туслах андеррайтер 120
10.3. Зээлийн шинжилгээ гаргагч 120
10.4. Хуулийн фирм 121
10.5. Хөрөнгө итгэмжлэн удирдагч 123
10.6. Оролцогч байгууллагууд нь нэгдмэл сонирхол, бизнесийн холбоо хамааралтай эсэх талаарх мэдээлэл 123

ИНВЕСКОР ӨСӨЛТ ХХК InvesCore Growth ABS LLC УЛААНБААТАР ХОТ ATA16551 7167257 9025101486

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital 1115269111 5481569 Улаанбаатар хот

ХӨРӨНГИЙН БИРЖ STOCK EXCHANGE
InvesCore FI
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

2025 12. 25
БҮРТГЭВ
No. 01

11. ХАВСРАЛТ 127

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Үнэт цаасны ерөнхий нөхцөл 17
Хүснэгт 2. ХБУЦ төлберийн хуваарь, сая төгрөгөөр 19
Хүснэгт 3. Үнэт цаас гаргагчийн мэдээлэл 22
Хүснэгт 4. Үүсгэн байгуулагчийн мэдээлэл 23
Хүснэгт 5. "Инвескор ББСБ" ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн мэдээлэл 23
Хүснэгт 6. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн, танилцуулга 24
Хүснэгт 7. Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн баланс, төгрөгөөр 25
Хүснэгт 8. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр 26
Хүснэгт 9. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр 27
Хүснэгт 10. Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр 27
Хүснэгт 11. Үнэт цаас гаргагчийн оролцогч талуудтай хийсэн гэрээ 33
Хүснэгт 12. Хөрөнгийн багцын үндсэн мэдээлэл 38
Хүснэгт 13. Зээлийн багцын задаргаа, үнийн дүнгээр 38
Хүснэгт 14. Зээлийн багцын задаргаа, хугацаагаар 39
Хүснэгт 15. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн талаарх мэдээлэл 49
Хүснэгт 16. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл 49
Хүснэгт 17. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн толгой компанийн тухай 50
Хүснэгт 18. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Инвескор ББСБ" ХК-ийн хамаарал бүхий этгээдүүд 51
Хүснэгт 19. Инвескор ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн боловсрол, ажлын туршлагын мэдээлэл 53
Хүснэгт 20. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтэц 56
Хүснэгт 21. Инвескор ХК-ийн удирдах албан тушаалтнуудын боловсрол, ажлын туршлагын мэдээлэл 56
Хүснэгт 22. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу үүсгэн байгуулагчаар оролцсон ХБУЦ-ны мэдээлэл 62
Хүснэгт 23. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүү байдлын тайлан, сая төгрөгөөр 63
Хүснэгт 24. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн идэвхтэй байгаа өрийн хэрэгслийн мэдээлэл, 2025 оны 3-р улирлын байдлаар 66
Хүснэгт 25. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн гэрээний нөхцөлүүд 66
Хүснэгт 26. Орлого, үр дүнгийн тайлан, сая төгрөгөөр 67
Хүснэгт 27. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн мөнгөн гүйлгээний тайлангийн голлох үзүүлэлтүүд, сая төгрөгөөр 68
Хүснэгт 28. Үнэт цаас гаргагчийн зохистой харьцаа үзүүлэлтүүд 69
Хүснэгт 29. Үнэт цаас гаргагчийн салбарт эзлэх хувь 69
Хүснэгт 30. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тухай 76
Хүснэгт 31. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн удирдлагын багийн мэдээлэл 76
Хүснэгт 32. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн ажиллаж буй төслийн мэдээлэл 77
Хүснэгт 33. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төрөл 82
Хүснэгт 34. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны давуу болон сул тал 83
Хүснэгт 35. Монгол улсын макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд 83
Хүснэгт 36. Бодит ДНБ-ий өсөлтийн төсөөлөл, хувиар 85
Хүснэгт 37. Инфляцын төсөөлөл, хувиар 86
Хүснэгт 38. ББСБ салбарын зээлийн зээлдэгчийн ангилал 92
Хүснэгт 39. ББСБ салбарын зээлийн хэлбэрийн ангилал 92
Хүснэгт 40. Салбарын ашигт ажиллагааны харьцаа 94
Хүснэгт 41. ХБУЦ гаргахтай холбоотой хууль, дүрэм журмууд 98

ИНВЕСКОР ӨМЧИЙН ХӨРӨНГӨ
InvesCore
Capital ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

Capital
1119089111 5481589
Улаанбаатар хот

2025/11/28

Хүснэгт 42. Үнэт цаас эзэмшигчдэд тайлан мэдээлэл түгээх нь 108
Хүснэгт 43. ХБУЦ-ны хүрээнд учирч болзошгүй эрсдэлүүд 111

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Үнэт цаасны хүү болон арилжааны банкны 18 сарын хугацаатай хадгаламжийн хүүгийн харьцуулалт 18
График 2. Фидуци бүхий зээлийн багцын задаргаа /үлдэгдэл дүнгээр/ 39
График 3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нийт хөрөнгө, сая төгрөгөөр 64
График 4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн цэвэр зээл, сая төгрөгөөр 64
График 5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн чанаргүй зээлийн хувь 65
График 6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эх үүсвэрийн бүтэц 65
График 7. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өр төлбөрийн бүтэц 65
График 8. Орлого, зардлын задаргаа, сая төгрөгөөр 67
График 9. Цэвэр ашиг, сая төгрөгөөр 68
График 10. Монгол Улсын нэрлэсэн ДНБ (их наяд төгрөгөөр) болон бодит ДНБ-ний өсөлт, хувиар 85
График 11. Инфляцын түвшин, хувиар 86
График 12. Төсвийн тэнцэл, тэрбум төгрөгөөр 87
График 13. Гадаад худалдааны тэнцэл, сая ам.доллароор 87
График 14. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, их наяд төгрөгөөр 88
График 15. Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо 88
График 16. ТОП-20 индекс 89
График 17. Үнэт цаасны арилжаа, тэрбум төгрөгөөр 89
График 18. Санхүүгийн салбарын бүтэц, 2025У2 90
График 19. ББСБ салбарын тоо, харилцагчдын тоо /мянган хүнээр/ 90
График 20. ББСБ салбарын хөрөнгийн бүтэц, тэрбум төгрөгөөр 91
График 21. ББСБ салбарын нийт зээл, тэрбум төгрөгөөр 91
График 22. ББСБ салбарт олгогдсон зээлийн хугацаа, сараар 92
График 23. ББСБ салбарын эх үүсвэрийн бүтэц, тэрбум төгрөгөөр 93
График 24. Хүүгийн орлого, зардал, цэвэр ашиг, тэрбум төгрөгөөр 93

СХЕМИЙН ЖАГСААЛТ

Схем 1. Үнэт цаасжуулах процесс зураглал 32
Схем 2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Инвескор ББСБ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц 50
Схем 3. Инвескор ББСБ ХК-ийн бүтэц, зохион байгуулалт 52
Схем 4. Инвескор ББСБ ХК-ийн эрсдэлийн засаглал 58
Схем 5. Инвескор ББСБ ХК-ийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо 59
Схем 6. ХБУЦ-ны төлбөр цуглуулах зураглал 71
Схем 7. ХБУЦ-ны зураглал 80
Схем 8. Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө 104
Схем 9. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцох заавар 105

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
АГА16551 7167257 9025101486

2025/11/28

11.1 Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ 127

11.2 Үнэт цаас гаргагчийн дүрэм 129

11.3 Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 135

11.5 Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн баланс 140

11.6 Үнэт цаас гаргагчийн дүрмийн сан 141

11.7 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Инвескор ББСБ ХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ 142

11.8 Анхнsы үүрэг гүйцэтгүүлэгч Инвескор ББСБ ХК-ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 144

11.9 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Инвескор ББСБ ХК-ийн дүрэм 149

11.10 Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Инвескор ББСБ ХК-ийн 2024 оны аудитын тайлан 163

11.11 Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ, зээлийн багцын жагсаалт 232

11.12 Зээлийн багцын жагсаалт 270

11.13 Мэргэжлийн байгууллагуудыг сонгох тухай ТУЗ-ийн тогтоол 306

11.14 Оролцогч талуудын сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл 307

11.15 Зээлийн шинжилгээ гаргагч "Си Пи Ти Эй Аудит" ХХК-ийн гэрчилгээ 317

11.16 Зээлийн шинжилгээ гаргагч "Си Пи Ти Эй Аудит" ХХК-ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 319

11.17 Санхүүгийн дүн шинжилгээний тайлан 322

11.18 Хуулийн фирм "Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс " ХХН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ 333

11.19 Хуулийн фирм "Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс " ХХН-ийн тусгай зөвшөөрөл 335

11.20 Хуулийн фирмийн зээлийн шинжилгээний тайлан 336

11.21 Хуулийн дүгнэлт 361

11.22 Үндсэн Андеррайтер "Голомт Капитал ҮЦК" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ 413

11.23 Үндсэн андеррайтер "Голомт Капитал ҮЦК" ХХК-ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 415

11.24 Туслах андеррайтер "Инвескор Капитал ҮЦК" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ 420

11.25 Туслах андеррайтерийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 422

11.26 Андеррайтерийн тодорхойлох захидал 427

11.27 Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Эм Ай Си Жи" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ 433

11.28 Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Эм Ай Си Жи" ХХК-ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 435

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -12- 31
БҮРТГЭВ

2025 12 25
БҮРТГЭВ
№ 01

11.29 Аудитын үйлчилгээ үзүүлэгч "Лидер Экаунт Аудит" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ 437

11.30 Аудитын үйлчилгээ үзүүлэгч "Лидер Экаунт Аудит" ХХК-ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 439

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ASS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Голомт Капитал ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 5481589
Улаанбаатар хот

2025/11/28

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Нэр томьёо	Тайлбар
Үнэт цаас гаргагч	Үнэт цаасны эзэмшлээр арилжихаар санал болгож Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид Үнэт цаасаа бүртгүүлсэн этгээд.
Үүсгэн байгуулагч	Компанийг үүсгэн байгуулсан Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, хуульд заасан бол гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн, ТЗК-ийн үүсгэн байгуулагчийн хувьд хуульд заасан банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага.
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан хөрөнгөөр баталгааждаг, хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжид төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас буюу энэхүү танилцуулгад заасан ирээдүйд олох зээлийн орлогоор хөрөнгийн багц бүрдүүлэн тусгай зориулалтын компанид шилжүүлэх замаар үнэт цаасжуулсан санхүүгийн хэрэгсэл.
Андеррайтер	Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч.
Тусгай зориулалтын компани	Хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хязгаарлагдмал хариуцлагатай компани.
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	Өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд туссан хөрөнгийг тусгай зориулалтын компанид шилжүүлсэн, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд.
Үйлчилгээ үзүүлэгч	Үүрэг гүйцэтгэгчтэй харилцаж, хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулан тусгай зориулалтын компанид шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан бусад үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээд.
Зээлийн шинжилгээ гаргагч	Хөрөнгийн багц дахь зээлийн данснуудад тавигдах санхүүгийн шалгуур үзүүлэлт хангагдсан эсэхэд дүгнэлт гаргагч, үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээд.
Хөрөнгө итгэмжлэн удирдагч	Тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан, хөрөнгө оруулагчид барьцаалуулсан хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах болон Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан үүрэг бүхий хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд.
Хууль зүйн дүгнэлт гаргагч	Хөрөнгийн багц дахь зээлийн данснуудад тавигдах хуулийн шалгуур үзүүлэлт хангагдсан эсэх тухай хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан болон Хорооны журмаар тогтоосон агуулгын хүрээнд хууль зүйн дүгнэлт гаргагч үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий, СЗХ-д бүртгэлтэй хуулийн этгээд.
Үнэт цаасны танилцуулга	Хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах, үнэт цаасны захиалга авах, худалдах зорилгоор холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу бэлтгэж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгүүлсэн танилцуулга, баримт бичгийн бүрдэл.
Хөрөнгийн багц	Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны нэг удаагийн гаргалтыг баталгаажуулж байгаа хөрөнгийн нийлбэр.
Анхдагч зах зээлийн арилжаа	Үнэт цаас гаргагч хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасаа нийтэд санал болгох замаар анхдагч зах зээлд байршуулах хуваарилалт хийх арилжих үйл ажиллагаа.

Хөөрдөгч зах зээлийн арилжаа	Үнэт цаасны анхдагч зах зээлд гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг дахин арилжих үйл ажиллагаа.

ТОВЧИЛСОН ҮГНИЙ ТАЙЛБАР

Товч үг	Тайлбар
ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
СЗХ эсхүл Хороо	Санхүүгийн Зохицуулах Хороо
МХБ эсхүл Бирж	Монголын Хөрөнгийн Бирж
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ТЗК	Тусгай зориулалтын компани
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХИУ	Хөрөнгө итгэмжлэн удирдагч
АҮГ	Анхны үүрэг гүйцэтгүүлэгч
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ
ӨОХ	Өр орлогын харьцаа
ЗҮХ	Зээл үнэлгээний харьцаа
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЭК ХХК

InvesCore

ABS LLC

2025/11/28

ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч

“ИНВЕСКОР ББСБ” ХК
Утас: (+976) 7709 0077
Вэбсайт: www.invescore.mn
И-мэйл: info@invescorefi.mn
Хаяг: Улаанбаатар, СБД, 1 хороо, Парисын гудамж, IC tower 14 давхар

Үндсэн андеррайтер

“ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК” ХХК
Утас: (+976) 7012 1530
Вэбсайт: www.golomtcapital.com
И-мэйл: info@golomtcapital.com
Хаяг:Улаанбаатар, СБД, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 24, Парк Плэйс оффис 403, 404 тоот

Туслах андеррайтер

“ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК” ХХК
Утас: (+976) 7755 0077
Вэбсайт: www.icapital.mn
И-мэйл: info@icapital.mn
Хаяг:Улаанбаатар, СБД, 1 хороо, Парисын гудамж, IC tower 1503 тоот

Хуулийн фирм

“ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС ” ХХН
Утас: (+976) 1133 0048
Вэбсайт: www.mdsa.mn
И-мэйл: info@mdsa.mn
Хаяг: Улаанбаатар, СБД, 8-р хороо, Сүхбаатарын талбай 2, Сентрал Тауэр 1301 тоот

Хөрөнгө Итгэмжлэн Удирдагч

“ЭМ АЙ СИ ЖИ” ХХК
Утас: (+976) 7515 7733
Вэбсайт: www.micg.mn
И-мэйл: info@micg.mn
Хаяг: Улаанбаатар, БГД, 6-р хороо, Пума 2-2 тоот

Зээлийн шинжилгээ гаргагч

“СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ” ХХК
Утас: (+976) 7723 3030
Вэбсайт: www.cptaaudit.mn
И-мэйл: info@cptaaudit.mn
Хаяг: Улаанбаатар, БЗД , 3-р хороо, Оршил төв 501 тоот

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

InvesCore FI

Үнэт цаасны танилцуулга

2025 оны 12 сарын 15
БҮРТГЭВ
№ 01

ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ

"ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК" ХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 11 сарын 10-ны өдөр Дугаар: 25/2-5 Улаанбаатар хот

Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.18 дах заалт, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын холбогдох хэсэг, Компанийн дүрмийн 4.8.2 дахь хэсэг, Үүсгэн байгуулагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 25/35 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компани олон нийтэд нээлттэй санал болгон Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (Цаашид "**Үнэт цаас**" гэх) гаргасугай.
2. Компанийн гаргах Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нөхцөлийг дор дурдсан байдлаар тогтоосугай. Үүнд:

Үнэт цаасны нэр	Инвескор Өсөлт ХБҮЦ
Үнэт цаасны төрөл	"Инвескор ББСБ" ХК-н авто тээврийн хэрэгсэл болон үл хөдлөх барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас
Үнэт цаас гаргагч	"Инвескор Өсөлт ТЗК" ХХК
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	"Инвескор ББСБ" ХК
Үнэт цаасыг санал болгох хэлбэр	Олон нийтэд нээлттэй санал болгох
Үнэт цаас гаргах хугацаа	2025 оны 4-р улирал (Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэй холбоотой энэ хугацаа өөрчлөгдөх боломжтой бөгөөд Хороонд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгүүлснээс хойш 6 сарын хугацаанд олон нийтэд санал болгон худалдана)
Татан төвлөрүүлэх хөрөнгийн нийт дүн	50.0 тэрбум төгрөг

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

Golomt Capital
1119260111 5431589
Улаанбаатар хот

2025/11/28

InvesCore FI
2025 -12- 31
БУРТГЭВ-02

2025 -12- 25
БУРТГЭВ
No 01

Үнэт цаасны нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
Үнэт цаасны нийт тоо, ширхэг	500,000 ширхэг
Үнэт цаасны хугацаа	18 (арван найм) сар
Үнэт цаасны хүү (жилийн)	18.5% (арван найм аравны таван хувь)
Хүү төлөх давтамж	Улирал бүр
Үндсэн төлбөр төлөх давтамж	Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 12 сарын дараа 50%, хугацааны эцэст үлдсэн 50%
Үнэт цаасны зарцуулалт	"Инвескор ББСБ" ХК-аас авто тээврийн хэрэгсэл болон үл хөдлөх барьцаалсан зээлийн багц худалдаж авах
Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	Монголын Хөрөнгийн Бирж
Үнэт цаасны хадгаламж. төлбөр тооцоо эрхлэх байгууллага	"Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв"

3. Үнэт цаасны хөрөнгийн багцыг бүрдүүлэх зээлийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг энэхүү тогтоолын 1-р хавсралтаар батлагдсугай.
4. Үнэт цаасны хөрөнгийн багцыг бүрдүүлэх зээлийн барьцаа хөрөнгийн жагсаалтыг 2-р хавсралтаар батлагдсугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Д.Баясгалан/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
Д.БАЯСГАЛАН

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

Төлөөт Капитал ХХК
Delivering diversity
1119289111 5481589
Улаанбаатар хот

2025/11/28

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны
11 дугаар сарын 10-ны өдрийн 25/2-5 тоот тогтоолын Хавсралт 1

САНХҮҮГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

1. СЗХ-нд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн бариимттай нийцэж байх;
2. Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх;
3. Зээлийн эргэн төлөлтийн хугацаарт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацаанд бүрэн хорогдох зээл байх;
4. Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх;
5. Тасалбар болгосон өдрөөрх зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 80%-с хэтрэхгүй байх. ЗҮХ = (Зээлийн үлдэгдэл)/(Үндсэн барьцаа хөрөнгийн үнэлгээ + Нэмэлт барьцаа хөрөнгийн үнэлгээ)
   5.1. Суудлын автомашин барьцаалсан болон худалдан авах хэрэглээний зээлийн хувьд зээл, үнэлгээний харьцаа нь СЗХ-ны "Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам"-д нийцсэн байх;
6. Зээлдэгч нь зээл олгох үеийн байдлаар дараах шаардлагыг хангасан байна:
   6.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт тогтвортой оршин суудаг Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байх;
   6.2. Банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;
   6.3. Зээлдэгчийн төрөл, бүтээгдэхүүнээс хамаарч зээлдэгчийн өр орлогын харьцаа нь СЗХ-ны холбогдох дүрэм журмуудад нийцсэн байх;
      6.3.1. 2025 оны 4 сарын 1-нээс өмнө иргэнд олгосон хэрэглээний болон автомашины зээлийн хувьд өр орлогын харьцаа (ӨОХ) нь татварын өмнөх орлогын 70%-с илүүгүй байх, 2025 оны 4 сарын 1-нээс хойш олгосон зээлийн хувьд 60%-с тус тус илүүгүй байх
      6.3.2. ААН болон иргэнд олгосон бизнесийн зээлийн хувьд холбогдох мөнгөн урсгалын тооцооллын дагуу үүрэг гүйцэтгэгч нь тухайн зээлийн тогтмол төлбөрийг төлөх чадвартай байх;
7. Орлого нотлох баримт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддос мөрддөг шалгуур үзүүлэлтэд нийцсэн байх.

ХУУЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

1. Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх;
2. Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хууль нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа хөрөнгөөс (фидуцийн болон барьцааны) гаргуулан төлүүлэх боломжтой байх;
3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар

2025/11/28

болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсэзгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх;

4. Зээлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах болюмжтой байх;
5. Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн болон барьцаа зүйлийн холбогдох эрхийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй, эсхүл хязгаарлаагүй байх;
6. Фидуцийн болон барьцааны гэрээ хүчин төгөлдөр байлгахад Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх.

oOo

2025/11/28

InvesCore Growth

НЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА



1. ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

1.1. ҮНЭТ ЦААСНЫ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Хүснэгт 1. Үнэт цаасны ерөнхий нөхцөл

Үнэт цаас гаргагч	**Инвескор Өсөлт ТЗК ХХК**
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	Инвескор ББСБ ХК
Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	Монголын Хөрөнгийн Бирж ХК
Үнэт цаасны төрөл	Автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас
Үнэт цаасны нэр	Инвескор Өсөлт ХБҮЦ
Нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
Санал болгож буй тоо ширхэг	500,000 ширхэг
Татан төвлөрүүлэх нийт дүн	50,000,000,000 төгрөг
Үнэт цаас гаргахаар төлөвлөж буй хугацаа	2025 оны 4-р улирал
Үнэт цаасны хугацаа	18 сар
Үнэт цаасны хүү	Жилийн 18.5%
Үнэт цаасны хүү төлөх хугацаа	Улирал тутам
Үнэт цаасны үндсэн төлбөр төлөх хугацаа	Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 12 сарын дараа үндсэн төлбөрийн 50 хувийг, хугацааны эцэст үлдэгдэл төлбөрийг төлнө.
Үнэт цаасны хадгалалт, төлбөр тооцоо	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
Үнэт цаасны зарцуулалт	Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлийн багц худалдан авахад зарцуулна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн багц худалдсанаас хүлээн авах мөнгийг зээлийн багцыг нэмэгдүүлэхэд зарцуулна.
Барьцаа	Автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх барьцаалсан зээлийн багц, зээлийн эргэн төлөлтийн данс
Үнэт цаас төлбөр төлөгдөх эх үүсвэр	Хөрөнгийн багц дахь зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр
Үнэт цаасны хүүд ногдох татвар	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу Хөрөнгө оруулагч нь үнэт цаасны хүүгийн орлогоос 5 хувийн албан татварыг суутгуулна.
Хүү тооцох нөхцөл	Хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх өдрөөс эхлэн жилийн 365 хоногоор тооцно.

2025/11/28

2025 -12- 31
БҮРТГЭВ-02

2025 12 25
БҮРТГЭВ
№ 01

1.2. ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Үнэт цаас гаргагч нь бондын хүүгийн түвшнийг тодорхойлохдоо Монголбанкнаас зарласан бодлогын хүү, зах зээл дэх ижил төстэй өрийн хэрэгслийн хүүгийн түвшин, үнэт цаас гаргагчийн санал болгож буй үнэт цаасны эрсдэлийн хүчин зүйл зэрэгт үндэслэж тооцсон.

2025 оны 9 дүгээр сарын байдлаар Монголбанкнаас зарласан бодлогын хүүгийн түвшин 12.0% бөгөөд улсын инфляц 9.0% байна. Монголбанкны 2025 оны 9-р сарын байдлаарх статистикийн дагуу арилжааны банкнуудын шинээр татсан төгрөгийн 13-18 сарын хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 14.5 хувь байгаа ба хадгаламжийн бодит хүү 5.5 хувь байна.
Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Инвескор Өсөлт ХБҮЦ нь 18.5 хувийн хүүгийн түвшинд буюу шинээр татаж буй төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүүтэй харьцуулахад татварын дараах байдлаар тооцвол 4.5 нэгжээр өндөр өгөөжтэй байна.

2025 оны 9 дүгээр сарын байдлаарх системийн томоохон банкнуудын 18 сарын хугацаатай төгрөгийн хадгаламжийн дундаж хүү болон 2025 онд дотоодын зах зээлд гарсан бусад нээлттэй өрийн хэрэгслийн санал болгосон хүүтэй харьцуулан доор харуулав.

График 1. Үнэт цаасны хүү болон арилжааны банкны 18 сарын хугацаатай хадгаламжийн хүүгийн харьцуулалт



Эх сурвалж: ТОП-5 банк болон биржүүдийн цахим хуудас

1.3. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны төлбөрийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг нийт 61,097,267,982 төгрөгийн дүн бүхий зээлийн багцын эргэн төлөлтийн мөнгөн урсгалаар төлнө. ХБҮЦ нээлттэй арилжаалагдаж буй үед төлөгдсөн зээлийн төлбөр нь ХБҮЦ-ийн үндсэн болон хүүгийн төлбөр, бусад гэрээт төлбөрт ашиглагдана.

Тус багц нь ирээдүйд зээлийн гэрээгээр хүлээсэн эргэн төлөх хуваарийн дагуу эргэн төлөгдөх бөгөөд хуваарь хэтэрч төлөгдөх, хугацаанаас өмнө илүү дүнгээр төлөх зэрэг шалгуур хангахгүй гэж үзэх нөхцөл гарсан үед хөрөнгө итгэмжлэн удирдагч нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шалгуур хангасан зээлээр солих, шинээр зээлийн багц нэмж худалдан авах зэргээр мөнгөн урсгалын удирдлагад өөрчлөлт оруулна. Тус үйл ажиллагааг Хөрөнгө итгэмжлэн удирдагч үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээ хэлцэл, холбогдох хууль, журмын дагуу хэрэгжүүлнэ.

ТЭК-ийн санал болгож буй үнэт цаас нь:

ИНВЕСКОР ӨСӨЛТ
InvesCore
ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

2025/11/28

- Жилийн 18.5 хувийн хүүтэй;
- Улирал тутам хүү төлөх
- Үндсэн төлбөрийн 50 хувийг 12 сарын дараа, үлдэгдэл төлбөрийг хугацааны эцэст төлөх нөхцөлтэй бөгөөд ХБҮЦ-ны эргэн төлөх төлөвлөгөөний задаргааг доор хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 2. ХБҮЦ төлбөрийн хуваарь, сая төгрөгөөр

Үзүүлэлт	У1	У2	У3	У4	У5	У6
ХБҮЦ-ны эхний үлдэгдэл	**50,000.0**	**50,000.0**	**50,000.0**	**50,000.0**	**25,000.0**	**25,000.0**
ХБҮЦ-ны хүүгийн төлбөрт	2,312.5	2,312.5	2,312.5	2,312.5	1,541.7	1,156.3
Үндсэн төлбөрт	-	-	-	25,000	-	25,000.0
Нийт төлбөр	**2,312.5**	**2,312.5**	**2,312.5**	**27,312.5**	**1,541.7**	**26,156.3**
ХБҮЦ -ны эцсийн үлдэгдэл	**50,000.0**	**50,000.0**	**50,000.0**	**25,000.0**	**25,000.0**	-

Эх сурвалж: Андеррайтер, ХИУ-ийн тооцоолол

Анхаарах: Хөрөнгө оруулагчийн эргэн төлөлтөөс авах үндсэн болон хүүгийн төлбөрийг түүний эзэмшиж буй үнэт цаасны тоо ширхэг, дүнгээс тооцно.

1.4. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД ХБҮЦ-НЫ ТӨЛБӨР ТӨЛӨХ

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-аас батлсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-д ХБҮЦ-ны төлбөрийг дараах дарааллаар төлөхөөр тусгажээ.

1. ХБҮЦ-ны төлбөр хүлээн авах үнэт цаас эзэмшигчдийн жагсаалтыг Хөрөнгө итгэмжлэн удирдагч ҮЦТХТ-өөс хүлээн авна.
2. Хөрөнгө итгэмжлэн удирдагч ҮЦТХТ-өөс ирсэн үнэт цаас эзэмшигчдийн нэрсийн дагуу холбогдох тооцооллыг хийсний дагуу ТЗК нь шилжүүлнэ. ХБҮЦ-ны төлбөр хүлээн авах үнэт цаас эзэмшигчдийн жагсаалтыг гаргаснаас хойш үнэт цаас эзэмшигч солигдсон тохиолдолд төлбөрийг өмнөх үнэт цаас эзэмшигч хүлээж авна.
3. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь дээрх жагсаалтад багтсан нэрсийн дагуу тасалбар болгон эзэмшиж буй ХБҮЦ-ны тоо, төлбөрийн хуваарийн тооцооллыг хийж үнэт цаас эзэмшигч тус бүрээр төлөгдөх төлбөрийн тооцооллыг хийж, баталгаажуулсан тооцоог ҮЦТХТ рүү хүргүүлнэ.
4. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тооцоог татварын өмнөх болон дараах байдлаар тус тус гаргах бөгөөд ТЗК нь татварыг хассан дүнгээр ҮЦТХТ рүү шилжүүлж, үнэт цаас эзэмшигчийн нэрээр холбогдох татварыг суутган тайлагнана.
5. ТЗК нь ХБҮЦ-ны төлбөрийг ҮЦТХТ дэх ТЗК-ийн үнэт цаасны дансанд 4-т дурдсан төлбөрийг байршуулж, ҮЦТХТ нь тооцоололд заасны дагуу үнэт цаас эзэмшигч тус бүрд хуваарьт өдөр төлбөрийг шилжүүлнэ.
6. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны төлбөр төлөх хуваарь, үнийн дүнгийн тооцоолол дээр алдсан, мэдээлэл буруу бичсэн зэрэг алдаа гарсан бол нэн даруй алдааг засах арга хэмжээ авна. Хэрэв уг алдаанаас болж үнэт цаас эзэмшигч, ТЗК болон бусад этгээдэд хохирол учирсан бол хохирлыг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хариуцна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүцаан худалдан авах нөхцөл

Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг хуульд заасан болон "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-нд заасан дараах үндэслэлээр анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах тохиолдолд ХБҮЦ-ыг буцаан худалдан авна. Үүнд:

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-нд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18.2.3-д заасны дагуу Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн эсхүл 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасны дагуу Хөрөнгийн багцын үлдэгдлийн дүн түүний анхны үнийн 20 хувьд хүрсэн тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцсон;

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу худалдан авах 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөр тасалбар болгосон нийт 61,097,267,982 төгрөгийн үнийн дүн бүхий автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн багцаас орох мөнгөн хөрөнгөөр төлөх бөгөөд уг үнэт цаасыг гаргахтай холбоотойгоор гуравдагч этгээдээс баталгаа, батлан даалт гаргуулаагүй, мөн эрх бүхий мэргэжлийн байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгоогүй болно.

2025/11/28

InvesCore Growth

ХОЁР. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ



2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

2.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРӨЛ

Үнэт цаас гаргагч "Инвескор Өсөлт ТЗК" ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгын хүрээнд Компанийн тухай хуулийн 12.1, 13.1 дугаар зүйл болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11.1, 12.3, 12.4 дүгээр зүйлийн дагуу үүсгэн байгуулагдсан.

Хуульд заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах "Тусгай зориулалтын компани"-ийг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байгуулж болно.

Иймд "Инвескор ББСБ" ХК нь 2025 оны 05 дүгээр сарын 15-ны өдрийн №25/34 тоот төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоолын дагуу компанийг үүсгэн байгуулж, 2025 оны 06 дүгээр сарын 13-ний өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2025 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 413 тоот тогтоолоор ТЗ 315/81 дугаартай "хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл" авч, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.1 болон 12.5 дүгээр зүйлийн дагуу **"Инвескор Өсөлт ТЗК" ХХК** болон өөрчлөгдөж, холбогдох өөрчлөлтийг улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн.

Хүснэгт 3. Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Үнэт цаас гаргагч	"Инвескор Өсөлт ТЗК" ХХК
Хувьцаа эзэмшигч	"Инвескор ББСБ" ХК, **/100%/**
Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо	2025.06.13
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл авсан огноо	2025.10.09
Регистрийн дугаар	7167257
Улсын бүртгэлийн дугаар	9011880461
Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх
Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	ТЗ 315/81
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	10,000,000 (арван сая төгрөг)
Оршин буй хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, парисын, 42, Ай Си Тауэр 14 давхар 1401 тоот
Утас	(+976) 7709 0099

"Тусгай зориулалтын компани" нь зөвхөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилготой байх бөгөөд Хорооны зөвшөөрөлгүйгээр хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэх эрхгүй болно.

Түүнчлэн хуульд зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэх, Хорооны зөвшөөрөлгүйгээр компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахыг хориглодог.

2025/11/28

2.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ

Үүсгэн байгуулагч: "Инвескор ББСБ" ХК нь үнэт цаас гаргагчийн нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан энгийн хувьцааг 100% эзэмшиж байна. Инвескор ББСБ ХК нь 2016 оны 03 дугаар сарын 30-нд улсын бүртгэлд хуулийн этгээдээр бүртгүүлж, СЗХ-ны 2016 оны 5-р сарын 17-ны өдрийн 159 тоот тогтоолоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан бөгөөд өдгөө ББСБ-ын зээл, итгэлцэл, факторинг, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, гадаад валютын арилжаа, төлбөрийн баталгаа гаргах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 4. Үүсгэн байгуулагчийн мэдээлэл

Нэр:	Инвескор ББСБ ХК
Хаяг:	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, 13-р хороолол /14230/, парисын, 42, 1401, 1402 тоот
Улсын бүртгэлийн дугаар:	9010002004
Регистрийн дугаар:	6060854
Хувьцаа эзэмшигч:	"Эс Ай Би Жэй Капитал" ГХОХХК \80.49%\ Олон нийт \19.51%\
Гүйцэтгэх захирал:	Далайжамц Баясгалан
И-мэйл:	info@invescore.mn
Утас:	(976) 7709 0077
Вэбсайт:	www.invescore.mn

Эцсийн өмчлөгч: "Инвескор ББСБ" ХК-ийн энгийн хувьцааны 80.49%-г буюу нэг бүр нь 227.0 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 60,996,572 ширхэг хувьцааг "Эс Ай Би Жэй Капитал" ГХОХХК эзэмшдэг бөгөөд тус компанийн эцсийн өмчлөгч нь Монгол улсын иргэн Б.Анхболд юм.

Хүснэгт 5. "Инвескор ББСБ" ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн мэдээлэл

Нэр:	Эс Ай Би Жэй Капитал ГХОХХК
Хаяг:	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, парисын, Ай Си Тауэр барилга, 42 дугаар барилга, 15 давхар, тоот
Улсын бүртгэлийн дугаар:	9019097602
Регистрийн дугаар:	6057209
Хувьцаа эзэмшигч:	Ай Си Эф Жи ПТЭ Лтд \100%\
Үйл ажиллагааны чиглэл:	Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх Менежментийн зөвлөгөө өгөх Бизнесийн зөвлөгөө өгөх

2.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.12.5 дугаар заалтад тусгасны дагуу ТЗК нь хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулах хориотой тул үндсэн ажилтангүй болно.

ТЗК нь хөрөнгө худалдаж авах, баталгаат үнэт цаас гаргах, хөрөнгө өмчлөх, хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг удирдах болон бусад эрхийн хүрээнд хийж гүйцэтгэх ажил, үйлчилгээг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлнэ. Компанийн бүтэц, зохион байгуулалт, удирдлага, тэдгээрийн эдлэх эрх, үүрэг нь Компанийн тухай хууль,

2025/11/28

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Компанийн дүрэм журмаар зохицуулагдана.

2.3.1. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Компанийн дүрэмд тусгасны дагуу үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх ба хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хувьцаа эзэмшигч хэрэгжүүлнэ. Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээ болон бусад асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна.

2.3.2 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Компанийн дүрэмд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллагын бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

Үнэт цаас гаргагчийн 2025 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 25/1-4 тоот шийдвэрийн дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг 3 гишүүнтэй байгуулахаар шийдвэрлэсэн байна. Үнэт цаас гаргагчийн 2025 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 25/1-5 тоот шийдвэрийн дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Д.Баясгаланг томилсон.

ТУЗ-ийн гишүүдийн ажлын туршлага, боловсролын мэдээлэл дараах байдалтай байна:

Хүснэгт 6. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн, танилцуулга

Д.БАЯСГАЛАН
ТУЗ-ийн дарга

Боловсрол:

1997-2001 он: МУИС, Эдийн засгийн ухааны бакалавр

Ажлын туршлага:

2001-2011 он: Худалдаа хөгжлийн банк ХК, Санхүүгийн газрын ахлах мэргэжилтэн
2015-2015 он: Монголбанк, Төслийн Менежер
2016-Одоог хүртэл: Инвескор ББСБ ХК, Гүйцэтгэх захирал
2016- Одоог хүртэл: Инвескор ББСБ ХК, ТУЗ-ийн гишүүн

Б.ИТГЭЛ
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Боловсрол:
2004-2008 он: АНУ-ын Жорж Мэйсон их сургууль, Санхүүгийн удирдлагын бакалавр

Ажлын туршлага:

2013-2018 он: Нова Терра ХХК, Санхүүгийн менежер, Гүйцэтгэх захирал
2018-2021 он: Мобиком Корпораци ХХК, Санхүүгийн удирдлага, Бүртгэлийн алба, Корпорацын төлөвлөлтийн албаны захирал
2021-2022 он: Анд Глобал, Хөрөнгө оруулалт хариуцсан захирал
2022-2024 он: ЛэндМН ББСБ ХК, ТУЗ-ийн гишүүн
2018-Одоог хүртэл: Шарын гол ХК, ТУЗ-ийн гишүүн
2023-Одоог хүртэл: Онч Кредит Рэйтинг Эйжинси ХХК, ТУЗ-ийн гишүүн
2024-Одоог хүртэл: Монголын Мянганы сорилтын сан, Санхүү хариуцсан захирал

Э.БААСАНБАТ
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Боловсрол:
1994-1998 он: МУИС, Банкны Эдийн Засагч, бакалавр
2010-2012 он: Австрали улсын Куртин Технологийн Их Сургууль, ББ-ийн Магистр

Ажлын туршлага:

2014-2020 он: Худалдаа хөгжлийн банк ХК, Санхүүгийн удирдлага, хяналтын газрын захирлын орлогч
2020-2021 он: Худалдаа хөгжлийн банк ХК, Төлбөр тооцоо, үйл ажиллагааны газрын захирал
2021-2022 он: М Банк, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын зөвлөх, төлбөр тооцоо, үйл ажиллагааны хэлтсийн захирал
2022- Одоог хүртэл: М Банк, Дотоод аудитын хэлтсийн захирал, Ерөнхий аудитор

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд нь "Инвескор ББСБ" ХК болон "Инвескор Өсөлт ТЗК" ХХК-ийн хувьцааг аливаа хэлбэрээр эзэмшдэггүй болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам:

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11-р сарын 10-ны өдрийн 25/2-8 тоот тогтоолоор "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг батлсан бөгөөд журмаар ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, бүрэн эрх, үүрэг, ажиллах нөхцөл, хариуцлага зэргийг тус журмаар тодорхойлсон байна.

Журамд зааснаар ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлыг гэрээний үндсэн дээр Захиргааны үйлчилгээ үзүүлэгч (ТЗК-ийн үүсгэн байгуулагч) гүйцэтгэнэ. Түүнчлэн ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох нөхцөл, гишүүдийн хүлээх үүрэг, бүрэн эрх, ажиллах зарчим, нөхцөл зэргийг тодорхойлсон байна. Журамд зааснаар компанийн үйл ажиллагааг удирдах, хянах ажлын хүрээнд дараах журмуудыг баталж, мөрдөнө:

- Хөндлөнгийн аудитор, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох солих тухай журам
- Хөрөнгө итгэмжлэн удирдах журам
- Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх тухай журам
- Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх журам
- Эрсдэл сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, дотоод хяналтын журам
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам.
- Тусгай зориулалтын компанийг татан буулгах журам

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭХЛЭЛТИЙН ТАЙЛАН БАЛАНС

Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч "Инвескор ББСБ" ХК нь нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100 ширхэг энгийн хувьцаа буюу 10,000,000 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр "Инвескор Өсөлт ТЗК" ХХК-ийг үүсгэн байгуулсан бөгөөд эхлэлтийн тайлан баланс дараах байдалтай байна.

Хүснэгт 7. Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн баланс, төгрөгөөр

Хөрөнгө	2025.06.06

Мөнгөн хөрөнгө	10,000,000
Нийт хөрөнгө	**10,000,000**
Эх үүсвэр	**2025.06.06**
Энгийн хувьцаа	10,000,000
Өр төлбөр ба эздийн өмч	**10,000,000**

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн баланс

2.3.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөллийг "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Инвескор ББСБ" ХК-аас шилжүүлэх зээлийн хөрөнгийн багцаас орж ирэх мөнгөн урсгал болон үйл ажиллагааны төсөвлөсөн зардалд үндэслэн тооцоолсон.

Төсөөлөлд ашигласан таамаглал:

- Зээлийн багцад багцалсан зээлийн дундаж хүү сарын 2.71%;
- Зээлийн багцад багцалсан зээлийн эргэн төлөгдөх дундаж хугацаа 57.25 сар;
- Зээлийн багцаас хуваарьт төлбөрөө урьдчилж төлөх магадлал 3.6%;
- Хуваарьт төлбөр хугацаа хэтрэх магадлал 4.1%;
- ТУЗ-ийн цалин гэрээний дагуу, тогтмол дүнтэй;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр гэрээний дагуу, улирал бүр;
- Үйлчилгээ үзүүлэгчийн шимтгэл гэрээний дагуу, сар бүр тогтмол;
- Аудитын үйлчилгээний төлбөр жилд 1 удаа, гэрээний дагуу, тогтмол;
- Захиргааны үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр гэрээний дагуу, сар бүр тогтмол;

Хүснэгт 8. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр

	У1	У2	У3	У4	У5	У6
Хүүгийн орлого	4,926.5	4,807.8	4,679.2	4,539.9	4,389.0	4,225.4
Хүүгийн зардал	(2,312.5)	(2,312.5)	(2,312.5)	(2,312.5)	(1,541.7)	(1,156.3)
Цэвэр хүүгийн орлого	**2,614.0**	**2,495.3**	**2,366.7**	**2,227.4**	**2,847.3**	**3,069.2**
Үйл Ажиллагааны Зардал	**85.7**	**87.5**	**89.4**	**111.3**	**93.7**	**96.2**
ТУЗ-ын цалин, НДШ-ийн зардал	5.4	5.4	5.4	5.4	5.4	5.4
Аудитын үйлчилгээний төлбөр	-	-	-	19.8	-	-
Төлбөр цуглуулах үйлчилгээний зардал	21.3	23.1	25.0	27.1	29.4	31.8
Захиргааны үйлчилгээний зардал	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0
ХИУ-ын зардал	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0
Татварын төлөхийн өмнөх ашиг	**2,528.3**	**2,407.9**	**2,277.4**	**2,116.2**	**2,753.6**	**2,973.0**
Татварын зардал	252.8	240.8	227.7	211.6	275.4	297.3
Цэвэр Ашиг	**2,275.5**	**2,167.1**	**2,049.6**	**1,904.5**	**2,478.2**	**2,675.7**

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөллийг ХБҮЦ-ны нөхцөл, зээлийн багцын болон бусад мөнгөн урсгалын төсөөллийг ашиглан тооцоолсон. Үнэт цаас гаргагч нь ХБҮЦ-ыг олон нийтэд санал болгон арилжаалж, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх үед Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс 61.1 тэрбум төгрөгийн зээлийн багцыг худалдан авах бөгөөд ХБҮЦ-ны хугацаа дуусах үед үнэт цаас гаргагч нь өрийцоогоор 24.7 тэрбум

БҮРТГЭВ

төгрөгийн цэвэр хөрөнгөтэй үлдэх ба тус хөрөнгө нь ТЗК татан буугдах үед Анхны үүрэг гүйцэтгэгчид шилжинэ.

Хүснэгт 9. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр

	У1	У2	У3	У4	У5	У6
Эргэлтийн хөрөнгө						
Мөнгөн хөрөнгө	10,255.5	20,353.4	30,291.6	15,038.9	25,310.1	10,725.0
Зээл	53,127.3	45,196.4	37,307.8	29,465.1	21,672.1	13,932.9
Нийт хөрөнгө	**63,382.8**	**65,549.8**	**67,599.5**	**44,504.0**	**46,982.2**	**24,657.9**
Өр төлбөр						
ХБҮЦ-ны өглөг	50,000.0	50,000.0	50,000.0	25,000	25,000	-
Бусад өр төлбөр	11,097.3	11,097.3	11,097.3	11,097.3	11,097.3	11,097.3
Нийт өр төлбөр	**61,097.3**	**61,097.3**	**61,097.3**	**36,097.3**	**36,097.3**	**11,097.3**
Хувьцаат капитал	10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0
Хуримтлагдсан ашиг	2,275.5	4,442.6	6,492.2	8,396.7	10,874.9	13,550.6
Эздийн өмчийн нийт дүн	**2,285.5**	**4,452.6**	**6,502.2**	**8,406.7**	**10,884.9**	**13,560.6**
Нийт өр төлбөр болон эзэмшигчдийн өмч	**63,382.8**	**65,549.8**	**67,599.5**	**44,504.0**	**46,982.2**	**24,657.9**

Үнэт цаас гаргагч нь ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх үед 61.1 тэрбум төгрөгийн зээлийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдан авахтай холбоотой эхний улирлын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ сөрөг 39.8 тэрбум төгрөг байх хүлээлттэй байна. Харин дараагийн улирлуудад үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ эерэг 9.7-10.4 тэрбум төгрөгийн хооронд хэлбэлзэх бөгөөд эдгээр мөнгөн хөрөнгийг банкны харилцах данс болон богино хугацаат хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хуримтлуулан ХБҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөрийг хуваарийн дагуу төлнө. ХБҮЦ-ны өглөг нь 12 дахь сарын эцэст 25.0 тэрбум төгрөг, 18 дахь сарын эцэст 25.0 тэрбум төгрөг тус тус төлөгдөнө. ХБҮЦ-ны хугацааны эцэст 10.7 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө үлдэх ба үүсгэн байгуулагч Инвескор ББСБ ХК-руу шилжинэ.

Хүснэгт 10. Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр

	У1	У2	У3	У4	У5	У6
Цэвэр ашиг	2,275.5	2,167.1	2,049.6	1,904.5	2,478.2	2,675.7
Зээлийн багцын бууралт / (өсөлт)	(53,127.3)	7,930.9	7,888.6	7,842.7	7,793.0	7,739.2
Бусад өглөгийн өсөлт	11,097.3	-	-	-	-	-
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	**(39,754.5)**	**10,098.0**	**9,938.2**	**9,747.2**	**10,271.2**	**10,414.9**
Өрийн бичиг гаргаснаас хүлээн авсан	50,000.0	-	-	-	-	-
Өрийн бичгийн үндсэн төлбөрийн эргэн төлөлт	-	-	-	(25,000.0)	-	(25,000.0)
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	**50,000.0**	**-**	**-**	**(25,000.0)**	**-**	**(25,000.0)**
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	10,245.5	10,098.0	9,938.2	(15,252.8)	10,271.2	(14,585.1)
Бэлэн мөнгөний эхний үлдэгдэл	10.0	10,255.5	20,353.4	30,291.6	15,038.9	25,310.1
Бэлэн мөнгөний эцсийн үлдэгдэл	**10,255.5**	**20,353.4**	**30,291.6**	**15,038.9**	**25,310.1**	**10,725.0**

InvesCore Growth

ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ



3.1. ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ХЭЛЦЛИЙН ЕРӨНХИЙ ЗУРАГЛАЛ

Тусгай зориулалтын компани үүсгэн байгуулах

Хуулийн этгээд нь СЗХ-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр ТЗК болж бүртгэгдэнэ. ТЗК нь баталгаат үнэт цаас гаргах бүрд байгуулагддаг тусгай зориулалттай хуулийн этгээд тул аливаа ТЗК нэг л удаа ХБҮЦ гаргах эрхтэй байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4-т заасны дагуу Инвескор ББСБ ХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор хууль журмын дагуу "Инвескор Өсөлт ТЗК" ХХК-ийг үүсгэн байгуулж, холбогдох зөвшөөрлийн дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Хууль, журмын хүрээнд шаардлага хангаж буй зээлийг багцлан бүрдүүлэх

Шинээр байгуулагдсан "Инвескор Өсөлт ТЗК" ХХК-ийн ТУЗ-өөс үйл ажиллагаа, санхүү, хөрөнгийн удирдлага зэрэг үйл ажиллагаа явуулахтай холбоотой дотоод үйл ажиллагааны журмууд батлан гаргасан бөгөөд эдгээр журам, холбогдох тогтоолд үндэслэн "Инвескор ББСБ" ХК-аас хууль болон санхүүгийн шаардлага хангаж буй зээлийн багцыг сонгон авч, багцыг шилжүүлэн авна.

Үнэт цаас гаргагч нь 2025 оны 10-р сарын 14-ний өдрөөр тасалбар болгосон 61,097,267,982 (жаран нэгэн тэрбум ерэн долоон сая хоёр зуун жаран долоон мянга есөн зуун наян хоёр) төгрөгийн үнийн дүн бүхий зээлийн хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу худалдан авахаар тохиролцсон байна.

Зээлийн багцын хөндлөнгийн дүгнэлт

Зээлийн багц нь санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтийг хангасан байх шаардлагатай бөгөөд хөндлөнгийн мэргэжлийн байгууллагууд зээлийн багцад түүврийн аргаар шалгалт хийж, уг шалгуурт нийцэж буй эсэхэд тус тусын дүгнэлтийг гаргасан. Зээлийн багц нь Үнэт цаас гаргагчаас тогтоосон хуулийн шалгуурыг хангаж буй эсэхэд хөндлөнгийн хуулийн дүгнэлтийг "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН гаргасан бол санхүүгийн шалгуур хангаж буй эсэхэд "Си Пи Ти Эй Аудит" ХХК зээлийн шинжилгээ хийж үр дүнг тайлагнасан байна.

Шинээр байгуулагдсан ТЗК-д зээлийн багцыг шилжүүлэх

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн эзэмшилд буй зээлийн хөрөнгийг багцалж, 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу хөрөнгийн багцыг ТЗК-д шилжүүлнэ. Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Эм Ай Си Жи" ХХК нь ТЗК-тай байгуулсан гэрээний дагуу тус хөрөнгийг хөрөнгө оруулагчдын эрх ашиг нийцүүлэн эзэмшиж удирдана. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ нь үнэт цаасны хугацааны эцэст дуусгавар болно.

Эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэх

Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, СЗХ-ны "Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам", МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу үнэт цаасны танилцуулга, хүсэлтийг боловсруулж, үнэт цаасыг бүртгүүлнэ. Үнэт цаас гаргагч нь УЦТХТ-өөр

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025-12-31
БҮРТГЭСГҮЙ

ҮЦТХТ
2025-12-25
БҮРТГЭВ

дамжуулж Үнэт цаасыг бүртгүүлж хадгалуулах, хүүгийн болон үндсэн төлбөрийн төлбөр тооцоо, эрхийг шилжүүлэх зэрэг үүргийг гүйцэтгүүлнэ.

МХБ-ээр дамжуулан олон нийтэд анх удаа санал болгох

МХБ болон СЗХ-оос зөвшөөрөл авсны үндсэн дээр Андеррайтер нь эрх бүхий байгууллагуудаас гаргасан үнэт цаасыг танилцуулах хууль, дүрэм журмын хүрээнд тогтоосон хугацаанд анхдагч зах зээлд олон нийтэд сурталчилж, санал болгон арилжаалж, захиалгыг хүлээн авна.

Худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагчид МХБ-ээр дамжуулж Үнэт цаас олон нийтэд санал болгох анхдагч зах зээлийн арилжааны хугацаанд өөрийн ҮЦТХТ-д бүртгэлтэй дансанд захиалгын мөнгийг шилжүүлж, арилжаанд оролцоно. Арилжаа амжилттай явагдсаны дараа Үнэт цаасыг хөрөнгө оруулагчдын дансанд байршуулна. Ингэснээр ХБҮЦ-ны үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг үнэт цаасны танилцуулгад заасан хугацаанд авах эрх үүснэ. Үнэт цаас гарган татан төвлөрүүлсэн хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлнэ.

Хөрөнгө Итгэмжлэн удирдах

"Инвескор Өсөлт ТЗК" ХХК-с баталсан Хөрөнгө итгэмжлэн удирдах журам, бусад журам болон Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу "Эм Ай Си Жи" ХХК-аар дамжуулж Хөрөнгө оруулагчдад барьцаалуулсан хөрөнгийг хөрөнгө оруулагчдын эрх ашигт нийцүүлэн итгэмжлэн удирдуулна. Ингэхдээ ХБҮЦ-ны багцтай холбоотой хөрөнгийг бүртгэх, тайлагнах болон Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу гүйцэтгэх бусад үйлчилгээг Хөрөнгө итгэмжлэн удирдах журам, СЗХ, МХБ-н баталсан журамд заасан хугацаанд гүйцэтгэнэ.

Тусгай зориулалтын компанийг татан буулгах

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.15 заалт болон 22 дугаар зүйл, 23 дугаар зүйл, Компанийн дүрмийн 8-р бүлэг, Компанийн ТУЗ-ийн 2025 оны 11-р сарын 10-ны өдөр баталсан "Тусгай зориулалтын компанийг татан буулгах журам"-д Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилго бүхий ТЗК-ийн татан буугдах нөхцөл, дараалыг зааж өгсөн.

"Инвескор Өсөлт ТЗК" ХХК-ийн дүрэмд заасны дагуу:

- Компанийн дүрэм нь Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зориулалтын компани болох зөвшөөрлийг авч, дүрмийн шинэчилсэн найруулгыг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- ТЗК нь дараах үндэслэлээр татан буугдана.
    - Баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн;
    - Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч бусаан худалдан авсан;
    - Баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан;
    - Баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасны эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан;

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 22 дугаар зүйлд дурдсанаар Тусгай зориулалтын компанийг татан буулгах шийдвэрийг дээр дурдсан үндэслэлээр тусгай зориулалтын компани, эсхүл үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлэгч, эсвэл

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
ATA16551 7167257 9025101486

Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн гэрээний үүргийн зөрчилтэй холбоотойгоос бусад тохиолдолд аливаа байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх шүүх, арбитр болон төрийн байгууллагад гомдол нэхэмжлэх гаргах болон бусад арга хэмжээ авахгүй байх, төлбөр нэхэмжлэхгүй байх үүрэг хүлээнэ. Үнэт цаас гаргагчийн эсрэг татан буулгах, дампуурлын хэрэг эхлүүлэхгүй байх зэрэг байдлаар маргаан үүсгэхийг хориглоно" гэж тусгасан байна.

InvesCore FI
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

2025 оны 25 дугаар
БҮРТГЭВ
№ 01

Компанийн ТУЗ-ийн батлсан "Тусгай зориулалтын компанийг татан буулгах журам-д заасны дагуу татан буугдсан тусгай зориулалтын компанийн хөрөнгийг хуваарилахад дараах дарааллыг баримтална:

1. Татан буулгах ажиллагааны зардал;
2. Хөрөнгө оруулагчид олгох үнэт цаасны төлбөр;
3. Тусгай зориулалтын компаниас авлагатай анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад бүх этгээдийн шаардлага;
4. Авлагатай анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлага;
5. Үлдсэн хөрөнгийг оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн хувьцаа эзэмшигчдэд олгоно.

Түүнчлэн ТЗК болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нарын хооронд байгуулагдсан "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-нд **маргаан шийдвэрлэх тухай:**

"Энэхүү гэрээ байгуулагдах үндсэн зорилго болон ХБҮЦ гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн гэрээний үүргийн зөрчилтэй холбоотойгоос бусад тохиолдолд аливаа байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх шүүх, арбитр болон төрийн байгууллагад гомдол нэхэмжлэх гаргах болон бусад арга хэмжээ авахгүй байх, төлбөр нэхэмжлэхгүй байх үүрэг хүлээнэ. Үнэт цаас гаргагчийн эсрэг татан буулгах, дампуурлын хэрэг эхлүүлэхгүй байх зэрэг байдлаар маргаан үүсгэхийг хориглоно" гэж тусгасан байна.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

31

Голомт Капитал УЦК ХХК
Golomt Capital
1119299111 5431589
Улаанбаатар хот

2025/11/28

Схем: Үнэт цаасжуулах процесс зураглал



2025/11/28

3.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН ГЭРЭЭНҮҮД

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 25/2-6 тоот ТУЗ-ийн тогтоолын дагуу үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудыг сонгосон байна.

Тус тогтоолын дагуу Үйлчилгээ үзүүлэгч, захиргааны үйлчилгээ үзүүлэгчээр "Инвескор ББСБ" ХК-ийг, Хөрөнгө Итгэмжлэн Удирдагч байгууллагаар "Эм Ай Си Жи" ХХК-ийг, Үндсэн андеррайтераар "Голомт Капитал ҮЦК" ХХК, туслах андеррайтераар Инвескор Капитал ҮЦК ХХК-ийг, Санхүүгийн хөндлөнгийн аудитороор "Лидер экаунт Аудит" ХХК-ийг тус тус сонгосон байна. Түүнчлэн ХБҮЦ гаргах үйл ажиллагаатай холбоотой зарим гэрээний оролцогч тал нь сонирхлын зөрчилтэй этгээд буюу үүсгэн байгуулагч "Инвескор ББСБ" ХК, туслах андеррайтер Инвескор Капитал ҮЦК ХХК байгаа тул Үнэт цаас гаргагчийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 25/2-7 тоот ТУЗ-ийн тогтоолоор сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрлийг олгосон байна.

Хүснэгт 11. Үнэт цаас гаргагчийн оролцогч талуудтай хийсэн гэрээ

№	Гэрээний нэр, огноо	Оролцогч талуудын нэр	Гэрээний агуулга
1	Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ 2025 оны 11-р сарын 18-ны өдрийн 25/3-2 тоот гэрээ	-Инвескор ТЗК ХХК Өсөлт -Инвескор ББСБ ХК	Гэрээгээр зээлийн багц болон түүнд холбогдох эрхийг худалдан авч, гэрээний үнийг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх, анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг худалдах, зээлийн хөрөнгийг солих, нэмэх, буцаан худалдах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан байна.
2	Хөрөнгийн барьцааны гэрээ 2025 оны 11-р сарын 18-ны өдрийн 25/3-3 тоот гэрээ	-Инвескор ТЗК ХХК Өсөлт -Инвескор ББСБ ХК	Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид худалдсан хөрөнгийн багцад ногдох Фидуцийн гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжсэн автотээврийн хэрэгслүүд, барьцааны гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид барьцаалуулсан үл хөдлөх хөрөнгө, газрын эрхийг энэхүү хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны үүргийн гүйцэтгэлд барьцаалуулахтай холбоотой харилцааг уг гэрээгээр зохицуулсан байна.
3	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ 2025 оны 11-р сарын 18-ны өдрийн 25/3-7 тоот гэрээ	-Инвескор ТЗК ХХК Өсөлт -Эм Ай Си Жи ХХК	Гэрээгээр Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс төлөх болон гэрээний дагуу хамтран ажиллах зарчим, хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаанд баримтлах журам, талуудын эрх үүргийг тодорхойлсон.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 12 31
БҮРТГЭВ-02

2025 оны 12 дугаар сар 25
БҮРТГЭВ
№ 01

4	Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ 2025 оны 11-р сарын 18-ны өдрийн 25/3-4 тоот гэрээ	- Инвескор Өсөлт ТЗК ХХК - Инвескор ББСБ ХК -Эм Ай Си Жи ХХК	Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн багцын эргэн төлөлтөөс орж ирэх мөнгийг Зээлийн эргэн төлөлтийн дансанд төвлөрүүлэх, уг төлбөрийг ТЗК-ийн Төлбөр цуглуулах дансанд шилжүүлэх, хяналт тавих ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан байна.
5	Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ 2025 оны 11-р сарын 18-ны өдрийн 25/3-6 тоот гэрээ	- Инвескор Өсөлт ТЗК ХХК - Инвескор ББСБ ХК -Эм Ай Си Жи ХХК	Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгасан зээлийн эргэн төлөлтийн данс, уг дансанд цугларах зээлийн төлбөрийн орлогыг барьцаалах, ТЗК-ийн ХБҮЦ-ны төлбөрийг төлөх зорилгоор Зээлийн эргэн төлөлтийн данснаас ТЗК-ийн Төлбөр цуглуулах дансанд гэрээ болон журмаар тогтоосон хугацаанд үл маргах журмаар шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.
6	Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ 2025 оны 11-р сарын 18-ны өдрийн 25/3-5 тоот гэрээ	- Инвескор Өсөлт ТЗК ХХК - Инвескор ББСБ ХК	Компанийн ХЭХ, ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах, ТУЗ-ийн нарийн бичгийн чиг үүргийг гүйцэтгэх, албан бичиг хэргийн ажил гүйцэтгэх, мөнгөн хөрөнгөөс шаардлагатай мөнгөн гүйлгээг хийж гүйцэтгэх болон нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, холбогдох тайлан мэдээг хуульд нийцсэн хугацаанд тайлагнахтай холбогдуулан ХИУ-д хяналт тавих, шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах, хүүгийн орлогын албан татвар тайлагнах, компанийн цахим хуудас хөтлөх, жилийн үйл ажиллагааны тайлангийн аудитад бэлтгэх, дүгнэлтийг хүлээн авч ТУЗ болон ХИУ-д хүргүүлэх, ХБҮЦ-ны хэлцлийн гэрээ, журамд өөрчлөлт оруулах тохиолдолд төслийг бэлтгэн баталгаажуулж ХИУ-д хүргүүлэх, ХБҮЦ-ийн зээлийн багц дахь хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлэх зэрэг Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулсан байна. ТЗК-ийн байгууллагын тэмдэг, улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, тусгай зөвшөөрөл, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан зэрэг баримт бичгийг Захиргааны үйлчилгээ үзүүлэгч өөрийн ажлын байранд хадгалах бөгөөд аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хадгалах үүргийг хүлээж, баталгаа гаргасан байна.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

Golomt Capital
Delivering Diversity
1119209111 5481589
Улаанбаатар хот

2025/11/28

7	Андеррайтерийн үйлчилгээний гэрээ 2025 оны 11-р сарын 20-ны өдрийн 25/3-8 тоот гэрээ	-Инвескор ББСБ ХК -Голомт Капитал ҮЦК ХХК -Инвескор Капитал ҮЦХ ХХК -Инвескор Өсөлт ТЗК ХХК	50.0 тэрбум төгрөг хүртэлх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгож, худалдах ажлыг удирдан зохион байгуулахтай холбоотой мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулсан байна.
8	ХБҮЦ Зээлийн багцад санхүүгийн шинжилгээ хийх гэрээ 2025 оны 5-р сарын 27-ны өдрийн 25/73 тоот гэрээ	-Инвескор ББСБ ХК -Си Пи Ти Эй Аудит ХХК	Гэрээгээр гэрээт ажлын цар хүрээ буюу сонгогдсон зээлийн хувийн хэргийг харилцан тохиролцсон ажил үйлчилгээний дагуу хянаж, ажил үйлчилгээний гүйцэтгэл болон илрүүлсэн асуудлуудыг нэгтгэж тайлагнах асуудлыг зохицуулжээ.
9	Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ 2025 оны 5-р сарын 23-ны өдрийн Д-С0032510 тоот гэрээ	-Инвескор ББСБ ХК -Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН	Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ыг бүртгүүлэх, олон нийтэд санал болгон арилжаалах ажлын хүрээнд төслийн бүтэц, оролцогч талууд, тэдгээрийн хооронд үүсэх харилцаа, байгуулсан гэрээ, гэрээний төслүүд нь хүчин төгөлдөр, хуульд нийцсэн эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргаж, үнэт цаасны холбогдох зөвшөөрөл авах асуудлаар хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, багцын хөрөнгөд тавигдах шаардлага зэргийг тодорхойлж, хөрөнгийн багцад шинжилгээ хийж, тайлан гаргуулахаар тохиролцож гэрээ байгуулсан байна.
10	Программ хангамж түрээсээр ашиглах гэрээ 2025 оны 10-р сарын 15-ны өдрийн DXCS25001 тоот гэрээ	-Эм Ай Си Жи ХХК -Дайнамикс Софт ХХК	Дайнамикс Софт ХХК нь “CloundBanker” суурь системтэй хоршин ажиллах системийг хөрөнгөөр итгэмжлэн удирдагч түрээсээр ашиглуулах, түүнтэй холбогдон гарах нэвтрүүлэлтийн ажил, дагалдах засвар үйлчилгээг хүргэх болон мэдээллийн нууцлал, төлбөр тооцоотой холбогдсон харилцааг гэрээгээр тохирсон байна.
11	Санхүүгийн тайлангийн аудитын гэрээ 2025 оны 11-р сарын 19-ний өдрийн СТА/ААНБ-2025/01	-Инвескор Өсөлт ТЗК ХХК -Лидер экаунт-Аудит ХХК	“Аудитын тухай хууль”-ийн 10, 13-р зүйлд заасныг үндэслэн “Компанийн тухай хууль”-ийн 94-р зүйлд заасны дагуу Үнэт цаас гаргагчийн 2025 оны жилийн санхүүгийн тайланд аудит хийхээр харилцан тохиролцож гэрээг байгуулсан.

2025/11/28

3.3. ХӨРӨНГИЙН БАГЦ

3.3.1. ХӨРӨНГИЙН БАГЦАД ТАВИХ САНХҮҮГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

"Инвескор Өсөлт ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 25/2-5 тоот шийдвэрээр Үнэт цаас гаргагч нь ХБҮЦ-ийн ерөнхий нөхцөл болон ХБҮЦ-д багцлах зээлийн хөрөнгөд дараах санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтүүдийг тавихаар заажээ.

Шалгуур 1:
Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцэж байх;

Шалгуур 2:
Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх;

Шалгуур 3:
Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацаанд бүрэн хорогдох зээл байх;

Шалгуур 4:
Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх;

Шалгуур 5:
Тасалбар болгосон өдрөөрх зээл үнэлгээний харьцаа **(ЗҮХ) 80%**-с хэтрэхгүй байх.

ЗҮХ = (Зээлийн үлдэгдэл)/(Үндсэн барьцаа хөрөнгийн үнэлгээ + Нэмэлт барьцаа хөрөнгийн үнэлгээ)

Суудлын автомашин барьцаалсан болон худалдан авах хэрэглээний зээлийн хувьд зээл, үнэлгээний харьцаа нь СЗХ-ны "Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагааны журам"-д нийцсэн байх;

Шалгуур 6:
Зээлдэгч нь зээл олгох үеийн байдлаар дараах шаардлагыг хангасан байна.

1. Монгол улсын нутаг дэвсгэр тогтвортой оршин суудаг Монгол улсын иргэн, хуулийн этгээд байх;
2. Банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;
3. Зээлдэгчийн төрөл, бүтээгдэхүүнээс хамаарч зээлдэгчийн өр, орлогын харьцаа нь СЗХ-ны холбогдох дүрэм, журмуудад нийцсэн байх;
   3.1 2025 оны 4-р сарын 1-нээс өмнө иргэнд олгосон хэрэглээний болон автомашины зээлийн хувьд өр орлогын харьцаа (ӨОХ) нь татварын өмнөх орлогын 70%-с илүүгүй байх, 2025 оны 4-р сарын 1-нээс хойш олгосон зээлийн хувьд 60%-с тус тус илүүгүй байх;
   3.2 ААН болон иргэнд олгосон бизнесийн зээлийн хувьд холбогдох мөнгөн урсгалын тооцооллын дагуу үүрэг гүйцэтгэгч нь тухайн зээлийн тогтмол төлбөрийн төлөх чадвартай байх;
4. Орлого нотлох баримт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо мөрддөг шалгуур үзүүлэлтэд нийцсэн байх;

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101436

2025/11/28

3.3.2. ХӨРӨНГИЙН БАГЦАД ТАВИХ ХУУЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур 1:

Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх;

Шалгуур 2:

Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа хөрөнгөөс (фидуцийн болон барьцааны) гаргуулан төлүүлэх боломжтой байх;

Шалгуур 3:

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамаруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх;

Шалгуур 4:

Зээлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан Фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, түүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх;

Шалгуур 5:

Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн болон барьцааны зүйлийн холбогдох эрхийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй эсхүл хязгаарлагдаагүй байх;

Шалгуур 6:

Фидуцийн болон барьцааны гэрээ хүчин төгөлдөр байлгахад Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх.

2025/11/28

3.3.3. ЗЭЭЛИЙН БАГЦЫН ГОЛЛОХ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс санал болгосон автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан 2025 оны 10-р сарын 14-ний өдрөөр тасалбар болгосон нийт 1,672 зээлийн гэрээнээс бүрдсэн 61,097,267,982 (жаран нэгэн тэрбум ерэн долоон сая хоёр зуун жаран долоон мянга есөн зуун наян хоёр) төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгийн багцыг бүрдүүлсэн. Хөрөнгийн багцын жагсаалтыг хавсралтаас харна уу.

Хүснэгт 12. Хөрөнгийн багцын үндсэн мэдээлэл

Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлт	
	Дүн /төгрөгөөр/
Нийт зээлийн багцын дүн	**61,097,267,982**
Зээлийн хөрөнгийн барьцааны дүн	171,699,787,224
Зээлийн гэрээний тоо	1,672
Зээлийн дундаж үлдэгдэл	36,541,428
Барьцааны дундаж дүн	102,691,260
Жигнэсэн дундаж хүү /сар/	2.7%
Жигнэсэн дундаж хугацаа /сар/	57.2
Жигнэсэн дундаж LTV%	53.6%
Багцын зээлийн чанар	**100% хэвийн зээл**

Хөрөнгийн багцын 90.7 хувийг автотээврийн хэрэгсэл барьцаалсан зээл бүрдүүлж байгаа ба зээлдүүлэгч нь автотээврийн хэрэгслийн өмчлөлийг шилжүүлэн авч, зээлдэгч зээлийн төлбөрийг төлөхгүй нөхцөлд тус автомашиныг худалдан борлуулах замаар зээлийн үүргийн гүйцэтгэл хангуулах нөхцөлтэй зээл юм. Хөрөнгийн багцын үлдсэн хэсгийг үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл бүрдүүлсэн бөгөөд анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үл хөдлөх хөрөнгийг барьцаалж, барьцааны эрхийг холбогдох улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Зээлийн дүн: Автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн багц нь анх олгосон дүнгээр 80.8 тэрбум төгрөгийн 1,672 ширхэг зээлээс бүрдэх ба хуваарийн дагуу эргэн төлөлт хийгдсээр 2025 оны 10-р сарын 14-ний өдрийн байдлаар 61.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хөрөнгийн багц дахь зээлүүдийг үлдэгдэл дүнгээр нь задалж үзвэл 10-40 сая хүртэлх үлдэгдэл бүхий зээл нь нийт зээлийн багцын 35.1 хувийг, 40-100 сая хүртэлх үлдэгдэл бүхий зээлийн багц нь нийт зээлийн багцын 37.6 хувийг бүрдүүлж байна. Хөрөнгийн багц дах зээлүүдийн дундаж үлдэгдэл 36,541,428 төгрөг байна.

Хүснэгт 13. Зээлийн багцын задаргаа, үнийн дүнгээр

Анх олгосон хугацаа	Тоо	Үнийн дүн /сая төгрөг/	Багцад эзлэх хувь
10 сая хүртэлх	204	1,327.3	2.2%
10-40 сая хүртэлх	998	21,423.9	35.1%
40-100 сая хүртэлх	373	22,954.4	37.6%
100-200 сая хүртэлх	88	11,614.6	19.0%
200 саяас дээш	9	3,777.0	6.2%
Нийт	**1,672**	**61,097.3**	**100%**

2025/11/28

БҮРТГЭВ-02
2025 12 25
БҮРТГЭВ

График 2. *Фидуци бүхий зээлийн багцын задаргаа /үлдэгдэл дүнгээр/*

Зээлийн хугацаа: Хөрөнгийн багцад багтах зээлүүдийн анх олгосон дундаж хугацаа нь 52 сар байгаа бол зээлийн үлдэгдэлд жинлэсэн дундаж хугацаа 57.2 сар байна. Түүнчлэн нийт зээлийн багцын 16.5 хувийг 24-36 сарын хугацаатай зээлүүд, 60.7 хувийг 48 сараас дээш хугацаатай зээлүүд бүрдүүлж байна. Зээлийн багцад шинээр зээл худалдаж авах, солих, зээл урьдчилан төлөгдөх зэргээр багцын дундаж хугацаа ХБҮЦ-ны явцад өөрчлөгдөж болох ба эдгээр зохицуулалт нь ХБҮЦ-ны хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлттэй мөнгөн урсгалыг нийцүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Хүснэгт 14. Зээлийн багцын задаргаа, хугацаагаар

Анх олгосон хугацаа	Тоо	Үнийн дүн /сая төгрөг/	Багцад эзлэх хувь
0-12 сар	71	2,307.6	3.8%
12-24 сар	113	2,064.8	3.4%
24-36 сар	273	10,069.4	16.5%
36-48 сар	468	9,550.5	15.6%
48 сараас дээш	747	37,105.0	60.7%
Нийт	**1,672**	**61,097.3**	**100%**

Зээлийн багцыг хугацаагаар харвал үнэт цаас гаргагч нь багцад хэт богино хугацаат зээл оруулахгүй байх зарчмыг баримталсан байна. Учир нь хэт богино хугацаат зээлүүд нь ХБҮЦ-ийн зөвшөөрөл авах үе шат болон, ХБҮЦ-ийн эхэн үед хуваариас өмнө төлөгдөх магадлал өндөртэй байдаг.

Зээлдэгч: Нийт 1,672 зээл байгаагаас арван зээлдэгчийн авсан 23 зээл буюу нийт 1.1 тэрбум төгрөгийн зээл давхардсан байна. Түүнчлэн хамгийн өндөр дүнтэй зээл буюу 860.0 сая төгрөгийн нэг зээл байгаа нь багцын хувьд тооцоход эргэн төлөлт, мөнгөн урсгалд материаллаг нөлөө байхгүй, багцын 1.4% тай тэнцэж байна.Зээлдэгчийн хувьд өр орлогын харьцаа (ӨОХ) нь бага байх нь өрийн дарамт бага байх, зээлийн эргэн төлөлтөд саатал гарахгүй байх үндсэн шалгуур болдог бөгөөд нийт зээлийн багцын хувьд ӨОХ нь дунджаар 36.6% байна.

Барьцаа хөрөнгө: Хөрөнгийн багц дахь барьцаа хөрөнгийн үнэлгээ нь 2025 оны 10-р сарын 14-ний өдрөөр тасалбар болгосон зээлийн үлдэгдэл дүнгээс 2.8 дахин их байгаа бөгөөд зээлийн багцын жигнэсэн дундаж LTV харьцаа 53.6 хувь байна.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЭК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

2025/11/28

3.4. ЗЭЭЛИЙН БАГЦЫН ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Инвескор Өсөлт ХБУЦ-ны хөрөнгийн багц дахь зээлүүд нь хуулийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан эсэхэд "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН дүн шинжилгээ хийсэн бөгөөд зээлийн хөрөнгийн багцаас 95% итгэлцлийн түвшин, 5%-ийн хүлээгдэж буй алдааны дээд хязгаартай байхаар тооцож, нийт зээлийн багцын үнийн дүнгийн 9.19 хувьтай тэнцэх 83 зээлийн данснуудыг санамсаргүй түүврийн аргаар сонгосон байна.

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь хөндлөнгийн дүн шинжилгээг хийхдээ

- Санхүүгийн хөндлөнгийн шинжээчийн сонгосон данстай давхардуулахгүй байх;
- Салбар бүрээс тээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл хамруулах;
- Зээлийн багц дахь барьцаа хөрөнгө (автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө)-ийн эзлэх хувь хэмжээ ойролцоо түвшинд байх;
- Үл хөдлөх хөрөнгийн барьцааны хувьд газар, орон сууц, хашаа байшин, үйлдвэрийн зориулалттай бүс зэрэг бүх төрлийн үл хөдлөх хөрөнгийг оролцуулах;
- Зээл олгосон хугацаа ойролцоо түвшинд байх;
- Зээлийн төлөгдөөгүй үлдэгдлийн хэмжээ дундаж зээлийн дүнгээс багагүй байх шалгуурыг мөн тавьсан байна.

Хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлангийн дагуу түүвэрт сонгогдсон зээлийн данснууд нь тасалбар болгох өдрийн байдлаар хуулийн 6 шалгуурыг хангасан бөгөөд зээлийн данснуудаас зээлийн хөрөнгө болон зээлдэгчдэд тавигдах хуулийн шаардлага хангаагүй эрсдэлтэй гэж үзсэн зээлийн данс илрээгүй гэж дүгнэсэн байна. Хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайланг үнэт цаасны танилцуулгын хавсралт хэсгээс харна уу.

3.5. ЗЭЭЛИЙН БАГЦЫН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ГЭРЭЭТ АЖЛЫН ТАЙЛАН

Зээлийн шинжилгээ гаргагч буюу "Си Пи Ти Эй Аудит" ХХК нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу хөрөнгийн багц дахь зээлүүд нь санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан эсэхэд шинжилгээ хийж үр дүнг тайлагнасан байна. Тус ажил үйлчилгээ нь тохиролцсон горимоор гүйцэтгэсэн гэрээт ажил бөгөөд "Холбогдох үйлчилгээний Олон Улсын Стандарт 4400" -ын дагуу гүйцэтгэсэн байна.

Зээлийн багцын эх олонлог болох 1,672 зээлээс итгэлцлийн түвшин 95%, байж болох хамгийн их алдаа 10%, хүлээгдэж буй алдаа 5% гэсэн үзүүлэлтүүдийг харгалзан, урт хугацаат болон өндөр дүнтэй зээлүүдээс нийт 10.52 тэрбум төгрөгийн үлдэгдэл бүхий 120 зээлийг сонгон шалгасан. Түүвэрлэлт хийхдээ ЗҮХ болон ӨОХ өндөр зээлийн дансыг аль болох ихээр хамруулах, салбар бүрээс багадаа 2 зээл хамрагдсан байх, Улаанбаатар болон орон нутагт олгогдсон зээлийн тоо нь нийт багцын бүтэцтэй ойролцоо байх гэдэг зарчмуудыг баримталсан байна.

Зээлийн багцын шинжилгээний дагуу түүвэрт сонгогдсон 120 зээл нь шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан гэж дүгнэсэн байна. Тус Харилцан тохиролцсон горимоор гүйцэтгэсэн ажлын тайланг үнэт цаасны танилцуулгын хавсралт хэсгээс харна уу.

3.6. ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу багцыг шилжүүлэн авсан зээлийн хөрөнгө нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл болон зээлийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон эсхүл Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн

2025/11/28

25/2-8 тоот тогтоолоор батлсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад дараах байдлаар өөрчлөлт оруулна. Өөрчлөлт оруулах үндэслэлийн дэлгэрэнгүйг холбогдох журмаас харна уу.

Үүнд:

- Багцын хөрөнгийг солих;
- Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах.

Солих: Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд тухайн хөрөнгийг шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож, шаардлага хангаж буй шинэ зээлийн хөрөнгөөр солино. Үүнд:

- Зээлдэгчийн хүсэлтээр зээлийн гэрээ болон барьцаа хөрөнгөд өөрчлөлт оруулсан;
- Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-нд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн;
- Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн зээл эргэн төлөх үүргээ биелүүлээгүй 90-ээс дээш хоног хэтэрсэн;
- Зээлийн эргэн төлөлт нь 30 хоногоос дээш хоногоор хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болох нь үндэслэл бүхий бол.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс харилцан тохиролцсон орлуулах хөрөнгийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн программд оруулж, холбогдох акт үйлдсэнээр хөрөнгийг сольж бүртгэсэнд тооцно. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК-д шилжүүлж буй орлуулах хөрөнгийн зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр хэмжээ нь шаардлага хангахгүй хөрөнгийн үндсэн төлбөр болон хуримтлагдсан хүүгийн дүнгийн нийлбэр дүнгээс зөрүүтэй тохиолдолд авлага, өглөгийг тооцоо нийлсэн актад тусгаж, барагдуулна.

Нэмэгдүүлэх: Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад хөрөнгийг нэмэгдүүлнэ. Үүнд:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 32.1-д заасан шаардлагыг хангахгүй буюу ХБҮЦ-ны хөрөнгийн багцаас орох орлого нь үнэт цаасны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.2-д заасны дагуу Үнэт цаас гаргагч нь нэлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт үнэт цаас гаргахаар болсон;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор үнэт цаас эзэмшигчдэд төлөх үнэт цаасны төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон;
- Хууль болон гэрээнд заасан бусад;

Багц дахь зээлүүдийн эргэн төлөлтийн мэдээлэл агуулсан үйлчилгээ үзүүлэгчийн тайланд үндэслэн багцын хөрөнгийг нэмэгдүүлэх дүнг гаргаж, шаардлагатай тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шалгуур хангасан нэмэгдүүлэх

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025-12-31
БҮРТГЭВ 02
он 2025 сар 12. 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

хөрөнгийн жагсаалтаар нэмэгдүүлнэ. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс харилцан тохиролцсон нэмэгдүүлэх хөрөнгийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн программ оруулж, холбогдох актыг үйлдсэнээр хөрөнгийн багцыг нэмэгдүүлж бүртгэсэнд тооцно.

Буцаан худалдах: Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана. Үүнд:

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү журамд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;
- Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн эсхүл 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд;

Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэхэд багцад ийнхүү нэмэгдсэн хөрөнгө нь ХБҮЦ гаргах өргөдөл, үнэт цаасны танилцуулгад тусгагдсантай адил онцлог, шинж чанартай байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй зээлийн хөрөнгийг буцаан худалдах акт үйлдэж, буцаан худалдсан зээлийн холбогдох төлбөрийг ТЗК хүлээж авна.

Сул чөлөөтэй эх үүсвэрийн удирдлага: Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Төлбөр цуглуулах данс дахь үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл хэсгээр дараах зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтыг төгрөгөөр хийж болно. Үүнд:

- Арилжааны банкны хадгаламж;
- Монгол улсын Засгийн газар, Монголбанкнаас гаргасан үнэт цаас;
- Зохицуулагч байгууллагаас хориглоогүй бусад хөрөнгө оруулалт.

3.7. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙГ ТӨЛӨХ ТӨЛБӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

ТЗК нь Зээлийн эргэн төлөлтийн дансанд цугларсан мөнгийг хүлээн авах, ХБҮЦ-ны төлбөр төлөх зорилгоор Төлбөр цуглуулах дансыг банканд тусгайлан нээлгэж, төлбөр төлөх бэлэн байдлыг хангана. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа, төлбөр цуглуулах, хүлээн авах үйл ажиллагаанд зориулж оролцогч талууд дараах төрлийн данснуудыг нээлгэж, ашиглана.

Зээлийн эргэн төлөлтийн данс:

Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах данс буюу зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй Зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийг бусад хөрөнгөөс ангид бүртгэнэ. Зээлийн эргэн төлөлтийн дансыг зарцуулах эрхтэй этгээд нь үйлчилгээ үзүүлэгч (Инвескор ББСБ ХК) байна.

Гэхдээ зээлийн эргэн төлөлтийн данс болон түүний мөнгөн хөрөнгийг "Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ"-ээр Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид барьцаална. Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийн дансанд тухай бүр орж ирсэн мөнгийг дараа сарын 5-ны өдрийн дотор холбогдох авлагыг суутган Төлбөр цуглуулах данс руу шилжүүлнэ.

ИНВЕСКОР ББСБ ТЗК ХХК
InvesCore
Securities ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486
Golomt Capital
Delivering diversity
Улаанбаатар хот
2025/11/28

Төлбөр цуглуулах данс:

ТЗК нь Төлбөр цуглуулах дансыг банканд тусгайлан нээлгэнэ. Төлбөр цуглуулах данс нь Үйлчилгээ үзүүлэгчийн нээсэн Зээлийн эргэн төлөлтийн дансанд цугларсан мөнгийг хүлээн авах, үнэт цаасны төлбөр төлөх зорилгоор ашиглах богоод төлбөр хүлээн авах бэлэн байдлыг хангана. ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн нэрийн өмнөөс ТУЗ-өөс баталсан Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам болон төсвийн дагуу төлбөр цуглуулах данснаас зардал гаргах эрхтэй байна.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх данс:

ТЗК нь ХБҮЦ-ийг хадгалуулах, ХБҮЦ-ийн төлбөрийн үүргийг гүйцэтгэх зорилгоор ҮЦТХТ дээр гэрээ байгуулж, данс нээлгүүлнэ. Тус үнэт цаасны данснаас зөвхөн ТЗК-ийн байгуулсан төлбөр цуглуулах данс руу зарлага гаргах боломжтой байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлагатай тохиолдолд уг данс дахь мөнгөн үлдэгдлийг төлбөр цуглуулах данс руу татан, шаардлагатай зарцуулалтыг хийх эрхтэй байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн гаргасан тооцооллын дагуу ТЗК нь үнэт цаасны хүүгийн болон үндсэн төлбөрийн төлөлтийг хийхдээ өөрийн харьцдаг брокерын компаниараа дамжуулан ҮЦТХТ дээр нээлгэсэн дансаараа дамжуулан үнэт цаас эзэмшигч нарт холбогдох гүйлгээг хийнэ.

Хадгаламжийн данс:

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Төлбөр цуглуулах данс дахь үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл хэсгээр, мөнгөн хөрөнгийг ашиглагдахгүй хугацаанд үр ашигтай байлгах үүднээс тодорхой хэмжээг гэрээ болон хуулиар зөвшөөрөгдсөн хэлбэрээр байршуулж болно. Үүний тулд хадгаламжийн данс нээлгэн ашиглах бөгөөд энэ данснаас зөвхөн ТЗК-ийн байгуулсан төлбөр цуглуулах данс руу зарлага гаргах боломжтой байна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлагатай тохиолдолд хадгаламжийг цуцлан, мөнгөн үлдэгдлийг төлбөр цуглуулах данс руу татан шаардлагатай зарцуулалтыг хийх эрхтэй байна.

ТЗК-ийн ТУЗ-аас баталсан “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам”-д тусгасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь программаар зээлийн төлбөрийг хянах бөгөөд төлбөр цуглуулах данснаас доор дурдсан зарцуулалтыг хийх арга хэмжээг авч, Үнэт цаас эзэмшигчдэд төлөгдөх төлбөрийг зориулалт бусаар зарцуулахаас сэргийлнэ.

Төлбөр цуглуулах данснаас гарах гүйлгээ: Түүнчлэн ТЗК-ийн төлбөр цуглуулах данснаас зөвхөн журамд заасан дараах гүйлгээг гүйцэтгэнэ.

1. Үнэт цаас эзэмшигчдэд төлөх төлбөрийг ҮЦТХТ-ийн өөрийн данс руу шилжүүлэх
2. Үнэт цаасны хүүгийн орлогын татварыг төлөх
3. Хөрөнгийн багцад хөрөнгө солих, нэмэгдүүлэх гүйлгээ
4. Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах
5. ТЗК-ийн ТУЗ-аас баталсан төсвийн дагуу ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий удирдлагын зардал (Эдгээр зардлыг журмын 3.3 хэсэгт тусгайлан зааж өгсөн бөгөөд ТУЗ нь зардлын төсвийг баталж, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид мэдэгдэнэ. ТЗК нь журамд зааснаас бусад зардал гаргахгүй.)

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025-12-31
БҮРТГЭВ-02

2025 оны 12. 25-ны өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс батлсан Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журамд зааснаар ХБҮЦ-ны болон ТЗК-аас гарах бусад зардлыг дараах дарааллын дагуу төлнө. Үүнд:

- ТЗК-ийн татварын төлбөр;
- ХБҮЦ-ны хүүгийн орлогын татвар;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр, үүргийн гүйцэтгэлийн хангуулахтай холбоотой зардал;
- Үйлчилгээ үзүүлэгчийн шимтгэл, зардал;
- Аудитын зэрэг бусад мэргэжлийн оролцогчид, үйлчилгээ үзүүлсэн этгээдийн үйлчилгээний төлбөр;
- ТУЗ-ийн гишүүдийн цалин;
- ХБҮЦ-ны хүүгийн төлбөр;
- ХБҮЦ-ны үндсэн төлбөр;
- Журамд заасан бусад зардал.

Үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад олгохоос өмнө төлөгдөх төлбөр, зардлын мэдээлэл

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ыг хөрөнгө оруулагчдад олгохоос өмнө дараах төлбөрүүдийг Үнэт цаас гаргагчийн өмнөөс хариуцаж төлөх бөгөөд Үнэт цаас гаргагчаас тус төлбөрүүдийг нэхэмжлэхгүй. Үүнд:

- Андеррайтерийн үйлчилгээний төлбөр;
- Зээлийн багц нь санхүүгийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаарх хөндлөнгийн аудитын тайлангийн үйлчилгээний төлбөр;
- Зээлийн багц нь хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан, хууль зүйн дүгнэлт гаргах үйлчилгээний төлбөр;
- Маркетингийн зардал;
- СЗХ болон МХБ-д бүртгүүлэхтэй холбоотой төлбөр, хураамжууд;
- ХБҮЦ гаргах болон арилжаалахтай холбоотой маркетингийн зардал.

3.8. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ХУГАЦААНДАА ТӨЛӨГДӨХГҮЙ НӨХЦӨЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь багцын хөрөнгийг солих, багцын хөрөнгийг нэмэгдүүлэх, анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах зэргээр багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах боломжгүй тохиолдолд барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулан ХБҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөр төлөх үүргийг хэрэгжүүлэх бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой Үйлчилгээ үзүүлэгчид шүүхэд нэхэмжлэл гаргахыг мэдэгдэж, хэрэгжилтэд хяналт тавина.

Хэрэв Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг төлөх чадваргүй болсон тохиолдолд барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэл хангуулах бөгөөд дараах алхмуудыг хэрэгжүүлнэ:

1. Барьцаалуулагч нь Зээлдэгчтэй байгуулсан Зээлийн, Фидуцийн болон Барьцааны гэрээний дагуу фидуцийн болон барьцааны зүйлээс зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээ авах үүрэгтэй. Уг үүргийг ТЗК-тай байгуулсан

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
GROWTH ASSET LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

Голомт Капитал УЦК ХХК
Golomt Capital
Delivering Diversity
Улаанбаатар хот

2025/11/28

Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд Үйлчилгээ үзүүлэгч хэрэгжүүлнэ.

2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн төлбөрийг цуглуулж ТЗК-д шилжүүлэх үүргээ биелүүлж чадахгүй нөхцөл байдал үүссэн үед Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх ТЗК-д үүснэ.

3. Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх ТЗК-д шилжсэнээр тэрээр барьцааны зүйлийг өөрийн өмчлөлд үл маргах журмаар шилжүүлэн авч болно. Энэ тохиолдолд барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээг ТЗК-ийн нэрийн өмнөөс Хөрөнгө итгэмжлэн удирдагч хэрэгжүүлнэ. Барьцаалуулагч төлбөрийн чадваргүй болж, мэдэгдлийг хүлээн авах боломжгүй болсон нь түүнийг барьцааны үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

2025/11/28

InvesCore Growth

ДӨРӨВ. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ



4. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ

4.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан гэрээний тухай

Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ

Оролцогч талууд: Инвескор Өсөлт ТЗК ХХК – Инвескор ББСБ ХК

Үнэт цаас гаргагч нь 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу "Инвескор ББСБ" ХК-тай 25/3-2 тоот "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ" байгуулсан. Гэрээгээр зээлийн хөрөнгийн багц болон түүнд холбогдох эрхийг худалдан авч, гэрээнд заасан үнийг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх, анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг худалдах, зээлийн хөрөнгийг солих, нэмэх, буцаан худалдах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан байна.

Үнэт цаас гаргагч нь Анхдагч зах зээлийн арилжааны хугацаа дуусахад хөрөнгө оруулалтын хэмжээ талуудын хооронд тохирсон хэлцэл биелэх дүнд хүрсэн тохиолдолд төлбөрийг анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн төлбөр хүлээн авах дансанд шилжүүлнэ.

Хөрөнгө оруулалтаас босгосон дүн нь хэлцэл биелэх дүнд хүрээгүй тохиолдолд хэлцлийг амжилтгүй болсон хэмээн үзэж, анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийг үнэт цаас гаргагчид шилжүүлэхгүй.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багц дахь зээлийн дансны бүртгэлийг тусад нь хөтөлж, холбогдох баримт бичгийг өөрийн оффис дээр хадгална.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагч руу худалдаж буй зээлийн багцын дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтад жагсаалтаар оруулж баталсан.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцад шалгуур хангасан хөрөнгийг оруулах ба хөрөнгө, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, холбоотой баримт бичгийг үнэн зөв гаргаж өгнө. Хөрөнгө Үнэт цаас гаргагчид бүрэн шилжихэд ямар нэг хязгаарлалтгүй байна.

ТЗК-ийн хөрөнгийн багц дахь хөрөнгөөс ХБҮЦ эзэмшигч этгээдээс өөр гуравдагч этгээд нэхэмжлэл гаргах эсхүл шаардах эрх хэрэгжүүлэхгүй. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлдэгчид төлөх аливаа ер төлбөр, бусад нэмэлт үүрэг байхгүй, хөрөнгийн багцад байгаа зээлтэй холбоотой аливаа шүүхийн маргаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгээгүй болохыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч баталгаа гаргажээ.

Хөрөнгийн барьцааны гэрээ

Оролцогч талууд: Инвескор Өсөлт ТЗК ХХК – Инвескор ББСБ ХК

Үнэт цаас гаргагч нь 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй 25/3-3 тоот "Хөрөнгийн барьцааны гэрээ"-г байгуулсан. Гэрээний дагуу "Инвескор Өсөлт ТЗК" ХХК нь барьцаалагч байх ба "Инвескор ББСБ" ХК нь барьцаалуулагч байна.

"Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ"-ний дагуу ББСБ-аас ТЗК-д худалдсан хөрөнгийн багцад ногдох Фидуцийн гэрээний дагуу ББСБ-ын өмчлолд шилжсэн, эсхүл Барьцааны гэрээний дагуу ББСБ-д барьцаалуулсан авто тээврийн хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгө, газрын эрхийг энэхүү хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны үүргийн гүйцэтгэлд барьцаалуулахтай холбоотой харилцааг уг гэрээгээр зохицуулна.

Тус гэрээ нь ТЗК-ийн ХБҮЦ-аар хүлээсэн үүрэг бүрэн биелэгдэх хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байж, уг үүрэг бүрэн биелснээр дуусгавар болно. Барьцаалуулагч нь "Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ"-ний дагуу хүлээсэн үүргээ хүлээ, гэрээнд

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-02
2025 -12- 25
БҮРТГЭВ
№ 21

заасны дагуу биелүүлээгүй тохиолдолд барьцаалуулагчийн барьцааны зүйлийн хувьд эдлэх аливаа эрхийг (үүнд, шаардах эрх, одоо болон ирээдүйд үүсэх эд хөрөнгийн эрх, орлого, үр шим хүртэх эрх гэх мэт) "Инвескор Өсөлт ТЗК" ХХК-д шилжүүлж, бусад үүрэг гүйцэтгүүлэгчээс тэргүүн ээлжид барьцааны зүйлээс шаардлага хангуулах эрх үүснэ.

Хөрөнгийн барьцааны гэрээний зүйл болох авто тээврийн хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгө, газрын эрх, түүнтэй холбоотой мэдээллийг гэрээний хавсралтад жагсаалтаар оруулж өгсөн байна.

Барьцаалуулагч нь энэхүү гэрээг байгуулахдаа барьцааны зүйлтэй холбоотойгоор дараах баталгааг гаргасан:

- Барьцаалуулагч нь Барьцааны зүйлийн өмчлөгч мөн болно.
- Барьцаалуулагч нь Хөрөнгийн барьцааны гэрээний дагуу барьцааны зүйлийг ТЗК-д барьцаалах бүрэн эрх, эрх мэдэл, эрх зүйн чадамж, хууль ёсны эрхтэй ба барьцааны зүйлийг барьцаалуулахад шаардлагатай бүхий л зөвшөөрөл, баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн;
- Гэрээ дуусгавар болох хүртэлх хугацаанд барьцааны зүйлийг аливаа хохирол, өр төлбөр, зардал, анз, маргаан, хэрэг, шүүхийн ажиллагаа, шийдвэр гүйцэтгэл зэргээс ангид байлгана. Энэхүү баталгаанд барьцаалуулагчийн аливаа үйлдэл, эс үйлдлээс үүдэн гарсан эсхүл цаашид гарч болох гомдол, үүрэг хариуцлага мөн адил хамаарна;
- Барьцаалуулагчийн хүлээсэн үүрэг нь хууль ёсны, хүчин төгөлдөр бөгөөд Барьцаалуулагчийн хүлээсэн үүрэг, хариуцлага нь түүний аливаа дотоод баримт бичиг, дүрэм журам, Барьцаалуулагчийн хувьд заавал биелүүлэх аливаа шүүх, арбитрын шийдвэр, гэрээ хэлцэлтэй зөрчилдөхгүй;
- Барьцааны зүйлийг бүхэлд нь болон хэсэгчлэн хураах, нийгэмчлэх, битүүмжлэх, аливаа гуравдагч этгээдээс хөрөнгөтэй холбоотой нэхэмжлэл ба бусад байдлаар халдаж болзошгүй хүчин зүйлсээс ангид байлгах, хэрэв үүссэн тохиолдолд нэн даруй барьцаалагчид мэдэгдэнэ;
- Барьцаалагч нь гэрээг байгуулах, биелүүлэх эрхтэй бөгөөд ийнхүү эрхээ хэрэгжүүлэхээр бүхий л шаардлагатай арга хэмжээг авсан;
- Барьцааны эрх нь гэрээгээр үүсэж байгаа бөгөөд Барьцаалуулагчийн шийдвэр, хүсэлтээр эсвэл дампуурсан нь уг эрх хүчингүй болох үндэслэл болохгүй;
- Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж, хуулийг чандлан баримтална;
- Барьцааны зүйлд аливаа гуравдагч этгээдийн барьцааны эрх, шаардах эрх үүсээгүй, барьцааны зүйл нь эрхийн зөрчилгүй, биет байдлын доголдолгүй.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
9025101486

2025/11/28

4.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон үүсгэн байгуулагчийн үйл ажиллагааны тухай

Инвескор ББСБ ХК нь 2016 оны 3 дугаар сарын 30-нд үүсгэн байгуулагдаж, СЗХ-ны 2016 оны 5-р сарын 17-ны өдрийн 159 тоот тогтоолоор Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө авсан. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь 2019 онд нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд Монгол улсын Засгийн Газар болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас шалгаруулдаг "ТОП-100 АЖ АХУЙ НЭГЖ"-ийн нэг юм.

Өдгөө анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Улаанбаатар хотод байрлах 14 салбар, хөдөө орон нутгийн 3 салбар, Киргиз болон Казакстан улсад бүртгэлтэй охин компаниудаараа дамжуулан харилцагчдад уламжлалт болон финтек зээлийн үйлчилгээг хослуулан санал болгож байна.

Хүснэгт 15. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн талаарх мэдээлэл

ИНВЕСКОР ББСБ ХК

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, 13-р хороолол /14230/, парисын, 42, 1401, 1402 тоот
9010002004
6060854
shareholders@invescore.mn
(976) 7272-2828
www.invescore.mn

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд ББСБ-ын дараах үйл ажиллагааг эрхэлж байна:

Хүснэгт 16. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл

№	Тусгай зөвшөөрлийн чиглэл	Олгосон огноо
1	Зээл	2016.05.17
2	Итгэлцлийн үйлчилгээ	2016.05.17
3	Факторингийн үйлчилгээ	2016.05.17
4	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2016.05.17
5	Төлбөрийн баталгаа гаргах	2018.01.10
6	Гадаад валютын арилжаа	2025.06.26

Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси УЦК ХХК нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлжих зэрэглэлийг 2025 оны 8-р сарын 26-ны өдөр байгууллагын болон үнэт цаасны (нээлттэй болон хаалттай гаргаж буй бонд) түвшинд **"А"** тогтвортой гэж тогтоосон байна.

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025-12-31
БҮРТГЭВ-02

ХЗХ
2025 оны 12 сарын 25
БҮРТГЭВ
№ 01

Хувьцаа эзэмшигчид, холбоотой этгээдүүд

Инвескор ББСБ ХК нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй, хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалдаг компани юм. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нийт гаргасан энгийн хувьцааны 80.49% хувьцаа буюу нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 60,966,572 ширхэг хувьцааг Эс Ай Би Жэй Капитал ХХК, 19.51 хувийг олон нийт эзэмшиж байна. Эс Ай Би Жэй Капитал ХХК нь 2016 оны 3-р сарын 21-нд үүсгэн байгуулагдсан бөгөөд тус компанийн энгийн хувьцааг Бүгд найрамдах Сингапур улсад бүртгэлтэй Ай Си Эф Жи Пте.Лтд эзэмшиж байна.

Схем 2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Инвескор ББСБ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц



Хүснэгт 17. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн толгой компанийн тухай

Нэр	**Эс Ай Би Жэй Капитал ГХОХХК**
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, парисын, Ай Си Тауэр барилга, 42 дугаар барилга, 15 давхар, тоот
Улсын бүртгэлийн дугаар	9019097602
Регистрийн дугаар	6057209
Хувьцаа эзэмшигч	Ай Си Эф Жи ПТЭ Лтд \100%\
Үйл ажиллагаа	Бизнесийн зөвлөгөө өгөх Менежментийн зөвлөгөө Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЭК ХХК
InvesCore
Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

2025/11/28

№	Нэр	Үйл ажиллагаа	Холбоо хамаарал
1	Ай Си Эф Жи Лтд	Лондонгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй хуулийн этгээд	Эцсийн толгой компани
2	Ай Си Эф Жи ПТЭ Лтд	Бүгд Найрамдах Сингапур Улсад бүртгэлтэй хуулийн этгээд	Толгой компани
3	Эс Ай Би Жэй Капитал ГХОХХК	Монгол улсад бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд	Толгой компани
4	Покет ББСБ ХХК	Монгол улсад ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	Инвескор ББСБ ХК-ийн охин компани
5	Покет КГ ХХК	Бүгд Найрамдах Киргиз улсад Покет гар утасны аппликэйшнээр дамжуулан онлайн зээлийн үйлчилгээ үзүүлдэг.	Инвескор ББСБ ХК-ийн охин компани
6	Инвескор Си Эй МФК ХК	Бүгд Найрамдах Киргиз улсад бичил санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа явуулдаг.	Инвескор ББСБ ХК-ийн охин компани
7	Инвескор КЗ Лтд	Бүгд Найрамдах Казакстан улсад уламжлалт болон финтек зээлийн бүтээгдэхүүний үйлчилгээ.	Инвескор ББСБ ХК-ийн охин компани
8	Инвескор Юү И ХХК	Бүгд Найрамдах Узбекистан улсад 2023 онд үүсгэн байгуулагдсан. Уламжлалт болон финтек зээлийн үйлчилгээ, цахим хэтэвчийн үйлчилгээ үзүүлж байна.	Инвескор ББСБ ХК-ийн охин компани
9	Инвескор Эй Би Эс ТЗК ХХК	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор үүсгэн байгуулсан тусгай зориулалтын компани.	Инвескор ББСБ ХК-ийн охин компани
10	Инвескор Финанс МФО ХХН	Бүгд Найрамдах Казакстан улсад бичил санхүүгийн үйлчилгээ .	Инвескор КЗ ХХК-ийн охин компани
11	Инвескор Капитал ҮЦК ХХК	Андеррайтер, брокер, диллер, хөрөнгө оруулалтын зөвлөх	Инвескор ББСБ ХК-ийн зэрэгцээ компани
12	Инвескор Проперти ХХК	Үл хөдлөх хөрөнгийн зуучлал, менежментийн үйлчилгээ	Инвескор ББСБ ХК-ийн зэрэгцээ компани
13	Эй Ай Лаб ХХК	Систем хөгжүүлэлт, программ хангамж, аппликэйшн хөгжүүлэлт	Инвескор ББСБ ХК-ийн зэрэгцээ компани
14	Инсур ХХК	Программ хангамж үйлдвэрлэл	Инвескор ББСБ ХК-ийн зэрэгцээ компани
15	Инвескор Жапан ХХК	Япон улсад бүртгэлтэй санхүүгийн зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа	Инвескор ББСБ ХК-ийн зэрэгцээ компани
16	Айкор Партнерс ХХК	Бизнесийн болон менежментийн зөвлөгөө өгөх, төсөл хэрэгжүүлэх	Инвескор ББСБ ХК-ийн зэрэгцээ компани

2025/11/28

	Ай Си Рэит ХХК	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн менежмент	Инвескор ББСБ ХК-ийн зэрэгцээ компани
18	Финберри ХХК	Санхүүгийн лизингийн үйлчилгээ, бизнесийн болон менежментийн зөвлөгөө өгөх, төсөл хэрэгжүүлэх үйлчилгээ	Инвескор ББСБ ХК-ийн зэрэгцээ компани
19	Инвескор Ассет Менежмент ХХК	Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа	Инвескор ББСБ ХК-ийн зэрэгцээ компани
20	Монголиа Талент Нэтворк ХХК	Хүний нөөц зуучлал, менежментийн компани	Инвескор ББСБ ХК-ийн зэрэгцээ компани

4.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтэц, зохион байгуулалт

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12-р сарын 24-ний өдрийн 68 дугаартай тогтоолын дагуу баталсан компанийн зохион байгуулалтын бүтэц дараах байдалтай байна:

Схем 3. Инвескор ББСБ ХК-ийн бүтэц, зохион байгуулалт



Төлөөлөн удирдах зөвлөл: Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Инвескор ББСБ ХК-ийн дүрмийн 8.1 дэх заалтад тусгаснаар компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд дүрмийн 9.1 дэх заалтад хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага Төлөөлөн удирдах зөвлөл байна гэж тусгасан. Компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ нь 9 гишүүнтэй үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байх бөгөөд ТУЗ-ийн гишүүнийг 3 жилийн хугацаатай сонгодог. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4-р сарын 28-ны өдрийн хурлаар дараах ТУЗ-ийн дарга, гишүүдийг томилсон байна.

2025/11/28

Б.АНХБОЛД
ТУЗ-ийн дарга

Боловсрол:
2000-2004 он: Рицумэйкан Ази-Номхон Далайн Их сургууль, Бизнесийн удирдлагын бакалавр
2004-2006 он: Рицумэйкан Ази-Номхон Далайн Их сургууль, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага:

2006-2012 он: Абим Консалтинг ХХК, Менежментийн зөвлөх
2012-2015 он: Шунхлай Групп ХХК, Дэд ерөнхийлөгч
2016-Одоог хүртэл: Инвескор ББСБ ХК-ийн ТУЗ-ийн дарга
2016-Одоог хүртэл: Эс Ай Би Жэй Капитал ГХОХХК, Гүйцэтгэх захирал
2022-Одоог хүртэл: Инновэйшн инвестмент ХК, ТУЗ-ийн гишүүн
2024-Одоог хүртэл: Инвескор ассет менежмент ҮЦК ХХК, ТУЗ-ийн дарга

Д.БАЯСГАЛАН
ТУЗ-ийн гишүүн

Боловсрол:

1997-2001 он: МУИС, Эдийн засгийн ухааны бакалавр

Ажлын туршлага:

2001-2011 он: ХХБ, Санхүүгийн газрын ахлах
2011-2015 он: Монголбанк, Төслийн менежер
2016- Одоог хүртэл: Инвескор ББСБ ХК, ТУЗ-ийн гишүүн
2016-Одоог хүртэл: Инвескор ББСБ ХК, Гүйцэтгэх захирал

ХИРОХИТО НАМИКИ
ТУЗ-ийн гишүүн

Боловсрол:

1988-1992 он: Япон улсын Кейо их сургууль, Эдийн засгийн ухааны бакалавр
2003-2005 он: АНУ-ын Рочестар их сургууль, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага:

1992-1999 он: Tokyo Trust Securities Co.Ltd, Мэргэжилтэн, Туслах менежер
1999-2003 он: Mitsubishi UFG Trust and Banking Corporation, Туслах менежер
2005-2011 он: Japan Shareholder Services Ltd, Санхүүгийн төлөвлөлтийн хэлтсийн ерөнхий менежер
2011-2014 он: Mitsubishi UFG Trust and Banking Corporation, Ахлах зөвлөх
2014- Одоог хүртэл: Инвескор Санхүүгийн Групп, Гүйцэтгэх захирал
2014- Одоог хүртэл: Стандарт Проперти Групп, Захирал
2019- Одоог хүртэл: Инвескор ББСБ ХК, ТУЗ-ийн гишүүн

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

2025/11/28

Р.ПҮРЭВ
ТУЗ-ийн гишүүн

Боловсрол:

1998-2002 он: МУИС, Бизнесийн удирдлагын бакалавр
2009-2011 он: Япон улсын Олон Улсын Их сургууль, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага:

2002-2003 он: Голомт банк ХК, Дилер
2003-2009 он: Сангийн яам, Мэргэжилтэн
2011-2016 он: Оюутолгой ХХК, Ахлах дотоод аудитор
2016-2022 он: Инвескор ББСБ ХК, Санхүү эрхэлсэн захирал
2022-Одоог хүртэл: Эс Ай Би Жэй Капитал ГХОХХК, Эрсдэл, дотоод аудит хариуцсан захирал
2024-Одоог хүртэл: Инвескор ассет менежмент ХХК, Гүйцэтгэх захирал

Ш.ЭРДЭНЭБАТ
ТУЗ-ийн гишүүн

Боловсрол:

1994-1998 он: Отгонтэнгэр их сургууль, Эдийн засгийн бакалавр

Ажлын туршлага:

1996-1998 он: Бармон ХХК, Менежер
1998-2004 он: Барилга ХК, Менежер
2004-2008 он: Барилга ХК, Дэд захирал
2008-Одоог хүртэл: Барилга ХК, Гүйцэтгэх захирал, Дэд ерөнхийлөгч

Б.ЭНХМАРАЛ
ТУЗ-ийн гишүүн

Боловсрол:

2008-2013 он: МУИС, Эрх зүйн бакалавр
2015-2016 он: Англи улсын Лондон хотын Их сургууль, Хууль зүйн магистр
2022-2024 он: Сингапур улсын Наньянг Бизнесийн Сургууль, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага:

2013-2015 он: Өмгөөллийн И Эл Би Партнерс ХХН, Хуульч
2016-2018 он: Өмгөөллийн И Эл Би Партнерс ХХН, Хуульч
2018-2021 он: Инвескор Капитал ҮЦК ХХК, Хөрөнгө оруулалтын зөвлөх
2020-2023 он: Инвескор Актив ТЗК ХХК, ТУЗ-ийн харааг бус гишүүн
2021-2022 он: Инвескор Капитал ҮЦК ХХК, Үйл ажиллагаа хариуцсан захирал
2022-Одоог хүртэл: Ай Си Эф Жи Пте Лтд. Хуулийн зөвлөх

2025/11/28

Ч.ХАШЧУЛУУН
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Боловсрол:

1984-1989 он: ОХУ-ын Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургууль, Эдийн засгийн ухааны бакалавр
1994-1996 он: Япон улсын Йокохома хотын их сургууль, Эдийн засгийн ухааны магистр
1996-2003 он: Япон улсын Кейо их сургууль, Эдийн засгийн ухааны доктор

Ажлын туршлага:

2004-2009 он: МУИС, Эдийн засгийн сургууль, Захирал
2006-2012 он: Монголбанк, Захирлуудын зөвлөлийн гишүүн
2009-2012 он: Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, ЗГ-ын тохируулагч агентлаг, Хорооны дарга
2010-2011 он: Хөгжлийн банк, ТУЗ-ийн дарга
2012-Одоог хүртэл: МУИС, Эдийн засгийн тэнхим, профессор, дэд профессор, Эрдмийн зөвлөлийн гишүүн
2016-Одоог хүртэл: ММС, ТУЗ-ийн гишүүн
2017-2021 он: MMFG, ТУЗ-ийн гишүүн
2017-Одоог хүртэл: Практикал Даатгал ХХК, ТУЗ-ийн гишүүн,
2017-Одоог хүртэл: МИК ОССК, ТУЗ-ийн гишүүн
2020-Одоог хүртэл: Инвескор ББСБ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
2022-Одоог хүртэл: МИРА судалгааны байгууллага, ТУЗ-ийн гишүүн
2022-Одоог хүртэл: BKG консалтинг, ТУЗ-ийн гишүүн

Д.ЭНХБАТ
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Боловсрол:

1975-1980 он: ОХУ-ын Уралын Техникийн Их сургууль, Системийн инженерийн бакалавр
1984-1988 он: ОХУ-ын Шинжлэх Ухаан, Технологийн Их сургууль, Техникийн шинжлэх ухааны доктор

Ажлын туршлага:

1980-1984 он: Статистикийн төв газар, Программ зохиогч
1988-1989 он: Микропроцессорын техникийн олон улсын лаборатори, Эрхлэгч
1989-1991 он: Үндэсний информатикийн төв, Захирал
1990-1991 он: Шинжлэх ухаан техникийн улсын хороо, Дэд дарга
1991-1993 он: Үндэсний хөгжлийн яам, Дэд сайд
1994-2008 он: Датаком ХХК, Ерөнхий захирал
2008-2012 он: УИХ, УИХ-ын гишүүн
2012-2018 он: Нээлттэй мэдлэг боловсролын хүрээлэн, Удирдах зөвлөлийн дарга

2025/11/28

Ч.ӨНӨРЖАРГАЛ
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Боловсрол:

1993-1997 он: СЭЗИС, Нягтлан бодох бүртгэлийн бакалавр
2000-2002 он: МУИС, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага:

1996-2000 он: Монгол Ханамаса ба ГБ ХХК, Тооцооны нягтлан бодогч, ерөнхий нягтлан бодогч
2000-2002 он: Засагт хан дээд сургууль, Цагийн багш
2002-2005 он: Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль, Багш
2005-Одоог хүртэл: СЭЗИС, багш, ахлах багш
2019-Одоог хүртэл: Инвескор ББСБ ХК, ТУЗ-ийн гишүүн

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод: Компанийн тухай хуулийн 81-р зүйлд заасны дагуу анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ТУЗ-н дэргэд түүний гишүүдээс бүрдсэн Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Тогтвортой байдлын хороо, Цалин урамшууллын хороо болон Эрсдэлийн удирдлагын хороо гэсэн байгын хороод тус бүр 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Тус хороодын үйл ажиллагааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон ТУЗ-с баталсан тус бүрийн нарийвчилсан журмаар зохицуулдаг.

Хүснэгт 20. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтэц

№	ТУЗ-ийн дэргэдэх хороод	Хорооны дарга	Хорооны гишүүд
1	Аудитын хороо	Ч.Хашчулуун	Ч.Өнөржаргал, Р.Пүрэв
2	Нэр дэвшүүлэх хороо	Ч.Хашчулуун	Д.Энхбат, Х.Намики
3	Цалин урамшууллын хороо	Д.Энхбат	Ш.Эрдэнэбат, Ч.Өнөржаргал
4	Эрсдэлийн удирдлагын хороо	Ч.Өнөржаргал	Б.Анхболд, Ч.Хашчулуун
5	Тогтвортой байдлын хороо	Д.Энхбат	Д.Баясгалан, Б.Энхмарал

Гүйцэтгэх удирдлагын баг: Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь нийт 9 газар, 4 хэлтэс, 242 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Үнэт цаас гаргагчийн удирдлагын баг нь банк санхүүгийн салбарт 5-23 жил ажилласан туршлагатай, мэргэжлийн баг хамт олноос бүрддэг.

Хүснэгт 21. Инвескор ХК-ийн удирдах албан тушаалтнуудын боловсрол, ажлын туршлагын мэдээлэл

Д.БАЯСГАЛАН
Гүйцэтгэх захирал

Боловсрол:

1997-2001 он: МУИС, Эдийн засгийн ухааны бакалавр

Ажлын туршлага:

2001-2011 он: ХХБ, Санхүүгийн газрын ахлах
2011-2015 он: Монголбанк, Төслийн менежер
2016- Одоог хүртэл: Инвескор ББСБ ХК, ТУЗ-ийн гишүүн
2016-Одоог хүртэл: Инвескор ББСБ ХК, Гүйцэтгэх захирал

2025/11/28

Г.ЦЭРЭННАДМИД
Санхүү хариуцсан захирал

Боловсрол:

1998-2002 он: Отгонтэнгэр их сургууль, Эрх зүйч, бакалавр
2018-2019 он: Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль, Нягтлан бодох бүртгэл, Магистр

Ажлын туршлага:

2011-2016 он: ПрайсуотерхаусКуперс-Аудит ХХК, Аудитор
2016-2023 он: Камминс Монголиа Инвестмент ХХК, Санхүүгийн менежер
2023-2024 он: Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны захирал
2024-2025 он: Эс Ай Би Жэй Капитал ХХК, Санхүү хариуцсан захирал
2025-Одоог хүртэл: Инвескор ББСБ ХК, Санхүү хариуцсан захирал

О.ТӨГӨЛДӨР
Цахим хөгжил хариуцсан захирал

Боловсрол:

2008-2012 он: АНУ-ын Сан Францискогийн мужийн их сургууль, Эдийн засгийн ухааны бакалавр

Ажлын туршлага:

2012-2016 он: Энержи Ресурс ХХК, Санхүүгийн шинжээч
2016-2018 он: Грийнсити ХХК, Санхүү, ложистик хариуцсан захирал
2018-2019 он: Монгол Стар Дистрибюшн ХХК, үйл ажиллагаа хариуцсан захирал
2019-2023 он: Гэрэгэ Системс ХХК, Үйл ажиллагаа хариуцсан захирал, Гүйцэтгэх захирал
2023-Одоог хүртэл: Инвескор ББСБ ХК, Цахим хөгжил хариуцсан захирал

З.БАТЦЭЦЭГ
Хүний нөөц хариуцсан захирал

Боловсрол:

2000-2004 он: СЭЗИС, Банкны удирдлагын бакалавр

Ажлын туршлага:

2006-2023 он: Мобиком Корпораци ХХК, Стратеги, шинэ бизнес хөгжлийн менежер
2023-Одоог хүртэл: Инвескор ББСБ ХК, Хүний нөөц хариуцсан захирал

2025/11/28

Ш.ОЮУНЧИМЭГ
Бизнес хариуцсан захирал

Боловсрол:

2001-2005 он: ШУТИС, Бизнесийн удирдлагын бакалавр
2012-2013 он: ИБУИНУ-ын Кентаккийн их сургууль, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага:

2014-2021 он: Мобиком Корпораци ХХК,Дижитал бизнесийн албаны захирал, Стратеги, шинэ бизнес хөгжлийн захирал
2021-2024 он: Мобифинанс ББСБ ХХК, Гүйцэтгэх захирал
2024-Одоог хүртэл: Инвескор ББСБ ХК, Бизнес хариуцсан захирал

4.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн удирдлага

Инвескор ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 20 тоот тогтоолоор "Эрсдэлийн удирдлагын бодлого"-г батлсан. Энэхүү эрсдэлийн удирдлагын бодлогын зорилго нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, бизнесийн үндсэн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийн тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах замаар хүлээж болзошгүй алдагдлыг бууруулах, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг хангах ажиллах үр дүнтэй, үр ашигтай хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэхэд оршино.

Схем 4. Инвескор ББСБ ХК-ийн эрсдэлийн засаглал



Эрсдэлийн удирдлагын тогтолцоо: Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хамгаалалтын гурван бүс"-ийн зарчимд тулгуурласан эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгон үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

2025/11/28



Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээ: Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь эрсдэл даах чадварыг зохицуулагч байгууллагын тавьсан хязгаарлалтын хүрээнд хүлээж чадах эрсдэлийн хэмжээгээр, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг стратеги зорилт болон бизнесийн төлөвлөгөөндөө хүрэхэд хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээгээр тус тус тодорхойлсон байна.

Эрсдэлийн удирдлагын тайлагнал: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хууль, эрсдэлийн удирдлагын газар нь эрсдэлийн тайланг бэлтгэн сар бүр актив пассив, эрсдэлийн удирдлагын хороонд, улирал тутамд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд тайлагнадаг.

Анхны үүрэг үүрэг гүйцэтгүүлэгч нь эрсдэлийн удирдлагатай холбоотой дараах журмуудыг мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- **Эрсдэлийн удирдлагын ерөнхий журам**: Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг тогтоож, эрсдэлийн удирдлагатай холбоотой тайлагнал, хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх, эрсдэлийн журмуудыг журмуудын хэрэгжилтийн үнэлгээг хэрхэн хийх талаар тусгасан.
- **Зээлийн эрсдэлийг удирдах ерөнхий журам**: Зээлийн удирдлагын тогтолцооны хүрээнд зээлийн эрсдэлийн удирдах бодлого журмуудыг тодорхойлох, зээлийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээ болон зээлийн шийдвэр гаргах эрх хэмжээг тогтоож, өндөр эрсдэлтэй зээлийн процесс, хяналт, зээлийн эрсдэлийн дүн шинжилгээ, тайлагналтыг хэрхэн хийх талаар тусгасан.
- **Санхүүгийн эрсдэлийн удирдлагын журам**: Санхүүгийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хяналт тавих, бууруулах, урьдчилан сэргийлэх замаар санхүүгийн эрсдэлүүдийг зохистой түвшинд удирдахтай холбоотой харилцааг зохицуулсан.
- **Үйл ажиллагааны эрсдэлийн журам болон процессын эрсдэлийн үнэлгээний журам**: Хамгаалалтын гурван бүсийн чиг үүрэгт тулгуурлан үйл ажиллагааны эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний хүрээнд удирдах тогтолцоог бий болгох, эрсдэлийн тохиолдлыг залруулах, удирдах, тайлагнах, процессын бүртгэл

2025/11/28

2025 12 1
БҮРТГЭВ-02
СЭХ
он 2025 сар 12 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

болон эрсдэлийн үнэлгээг хийх, хяналтыг хэрэгжүүлэх болон тэдгээрийн хэрэгжилтийг хянах, тайлагнахтай холбоотой үйл ажиллагааг тусгасан.

- **Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг үнэлэх, хянах журам**: Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх, удирдах, хяналтыг хэрэгжүүлэх болон тэдгээрийн хэрэгжилтийг хянах, тайлагнах үйл ажиллагааг тодорхойлсон.

4.5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн засаглалын кодекс

Инвескор ББСБ ХК нь Хорооноос батлсан "Компанийн засаглалын кодекс"-ийг үйл ажиллагаандаа мөрдөж, кодексийн зарчмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал, түүнийг төлөөлөх Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ), гүйцэтгэх удирдлага, тэдгээрийн эрх үүргийг тодорхойлон олон улсын стандартын дагуу санхүүгийн тайлагналыг бэлтгэн, дотоод болон хөндлөнгийн аудитын хяналт шалгалт, дотоод хяналт, зохицуулагч байгууллагаас шаардах эрсдэлийн удирдлагын зохистой хэм хэмжээг мөрдлөг болгон ажиллахыг зорьж байна.

Кодексийн 1-р зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-ыг баталсан ба тус журамд ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, тэдгээрт тавигдах шаардлага, хариуцлагыг нарийвчлан тусгасан. Мөн ТУЗ-аас баталсан ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны журам (ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй этгээдэд тавигдах шаардлага, ТУЗ-ийн гишүүнийг сонгох, улираан томилохтой холбоотой асуудыг зохицуулсан) болон Залгамж халааны бодлогыг (Эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааны төлөвлөгөө, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд авах арга хэмжээний талаар нарийвчлан зохицуулсан) тус тус үйл ажиллагаандаа мөрддөг.

Кодексийн 2-р зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны журам, Аудитын хорооны журам, Цалин урамшууллын хорооны журам, Эрсдэлийн удирдлагын хорооны журам, Тогтвортой байдлын хорооны журам тус бүрийг баталж, хорооны бүтэц бүрэлдэхүүн, гишүүдэд тавигдах шаардлага, эрх үүрэг болон бусад зохицуулалтыг тус тус нарийвчлан тусгаж хороодын хурлыг зохион байгуулах зохицуулалтыг оруулсан.

Кодексийн 3-р зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд "Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам"-ыг баталж тус журамд төрийн эрх бүхий байгууллага болон олон нийтэд үйл ажиллагааг мэдээлэх, тайлагнахад баримтлах зарчмыг тодорхойлж, олон нийтэд хүргэх санхүүгийн болон санхүүгийн бус тайлан, мэдээллүүд, тэдгээрийг мэдээлэх арга хэрэгсэл болон бусад шаардлагатай зохицуулалтуудыг тусгаж, хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Монголын Хөрөнгийн Бирж болон өөрийн цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд компанийн засаглалын баримт бичиг, бодлого, журам болон холбогдох санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллүүдийг тэнцвэртэйгээр хүргэж ажиллаж байна.

Кодексийн 4-р зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагааны журмын 7 дугаар бүлэгт хөндлөнгийн аудитортай харьцах, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжоор хангах талаарх харилцааг нарийвчлан тусгасан. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хөндлөнгийн аудитор нь аудитын тайлан, дүгнэлтийн талаар мэдээлэл өгөх зорилгоор оролцдог. Мөн дотоод аудитын тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, гүйцэтгэсэн онцлох ажлуудыг үйл ажиллагааны тайланд тусгаж цахим хуудсандаа байршуулдаг.

Кодексийн 5-р зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд "ТУЗ-ын дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны журам"-аас гадна "Эрсдэлийн удирдлагын бодлого, "Эрсдэлийн

ИНВЕСКОР ЕСӨЛТ ТӨК ХХК
InvesCore
Инвескор ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486
2025/11/28

СЭХ
он 2025 сар 12 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

удирдлагын ерөнхий журам"-уудыг баталж, үйл ажиллагаандаа баримтлан ажилладаг. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий зарчмыг "Эрсдэлийн удирдлагын бодлого"-р тодорхойлж, бодлогын хэрэгжилтийг хангах үүднээс жил бүр Хуулийн нийцлийн үнэлгээ хийлгэж, ТУЗ-д танилцуулдаг. Мөн "Байгаль орчин, нийгмийн бодлого"-ын хүрээнд компанийн үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлж, БОНЗ-ын үйл ажиллагааны тайланг олон нийтэд мэдээлэн ажиллаж байна.

Кодексийн 6-р зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд Цалин урамшууллын хорооны журамд заасны дагуу Аудитын хорооны гишүүдийг саналыг үндэслэн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг жил бүр ХЭХ-н хэлэлцүүлдэг. "Ажилтны цалин хөлс, хөнгөлөлт хангамж, цалин урамшууллын журам" болон "Ажилтны үнэлгээний журам"-р анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур зэргийг зохицуулж, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо жил бүр компанийн хэмжээнд дагаж мөрдөгдөх цалингийн матрицыг баталдаг. Мөн Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал олгох гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг үйл ажиллагааны тайланд тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулсан байна.

Кодексийн 7-р зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд ТУЗ-аас "Харилцагчийг хамгаалах бодлого"-ыг баталж, тус бодлогоор харилцагчдыг хамгаалах зарчмуудыг тодорхойлж, түүнтэй холбоотой үүрэг хариуцлагыг тусгасан. Анхны үүрэг гүйцэтгэгч нь оролцогч талуудтай хамтран ажиллах, тэдгээрийн санал хүсэлтийг хүлээн авах зорилгоор өөрийн цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр харилцагчидтай холбогдон харилцагчийн үйлчилгээний төвөөр дамжуулан тухай бүр мэдээлэл өгч ажилладаг. Харилцагчийн үйлчилгээний төв нь хүлээн авсан, шийдвэрлэсэн санал, хүсэлт, гомдлыг ангилан, хамаарах нэгжид хүргүүлж, шаардлагатай арга хэмжээг авч шийдвэрлэн, улирал бүр тайлагнан ажилладаг. Мөн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх хүрээнд "Шүгэл үлээх журам", "Хөдөлмөрийн дотоод журам", "Сургалт хөгжлийн журам", "Ажилтны санал хүсэлт, гомдол хүлээн авч шийдвэрлэх журам"-уудыг тус тус баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг.

Кодексийн 8-р зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоох зорилгоор "Бизнесийн ёс зүйн дүрэм", "Ажилтны ёс зүйн дүрэм" болон "Шүгэл үлээх журам"-уудыг баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг. Ёс зүйн дүрмүүдийн хэрэгжилтэд ТУЗ хяналт тавьж ажилладаг бөгөөд тус дүрмийн хэрэгжилтийг хангах зорилгоор Гүйцэтгэх захирлын дэргэдэх Ёс зүйн хороо ажилладаг.

Кодексийн 9-р зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд "Хувьцаа эзэмшигчдийг хурлыг хуралдуулах журам", "Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр", "Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл байгуулах журам"-уудыг баталж, холбогдох зохицуулалтуудыг тусгасан. Мөн анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үйл ажиллагааны тайлангаа хагас жил тутамд, санхүүгийн тайланг жил бүр, тогтвортой байдлын тайланг жил бүр өөрийн цахим хуудас болон МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан хөрөнгө оруулагчид болон олон нийтэд мэдээлдэг.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

Голомт Капитал УЦК ХХК
Golomt Capital
2025/11/28

СЗХ
он 2025 сар 12. 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01
БҮРТГЭВ 03

4.6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хүний нөөц, программ хангамжийн тухай

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Инвескор ББСБ ХК нь үнэт цаас гаргагчид захиргааны болон төлбөр цуглуулах үйлчилгээг үзүүлнэ.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх бүхий албан тушаалтнууд болох Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн захирал, Хөрөнгө оруулалт хариуцсан захирал болон ТУЗ-ийн гишүүд нь санхүүгийн салбарт олон жилийн мэдлэг боловсрол, туршлагатай хамт олон.

Программ хангамжийн хувьд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь олон жилийн туршлагатай программ хангамжийн үйлчилгээ үзүүлэгч Дайнамикс Софт ХХК-ийн хөгжүүлсэн "Lite Banker" буюу Банк бус санхүүгийн байгууллагын үндсэн системийг санхүүгийн болон санхүүгийн бус бүх төрлийн гүйлгээ, бүртгэл хийх, холбогдох тайлангуудад хяналт тавих зэрэгт ашигладаг.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Дайнамикс Софт ХХК-тэй 2025 оны 1 дүгээр сарын 20-ний өдөр SUPX250001 тоот "Ашиглалтын үйлчилгээний гэрээ"-г байгуулсан ба гэрээний дагуу Дайнамикс Софт ХХК нь Lite Banker системд "Хөрөнгийн зээлийн багц"-тай холбоотойгоор нэмэлт модулийг нэвтрүүлж, гэрээ дуусгавар болох хүртэл системийг ашиглуулна. Тус гэрээний дагуу Дайнамикс Софт ХХК нь программын шинэ хувилбар болон бусад нэмэлт программын талаар мэдээлэх, системийн сайжруулалтын талаар анхны үүрэг гүйцэтгэгчид мэдээлж, хамтран ажиллах, системийн найдвартай ажиллагааг хангах, үүнтэй холбоотой шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Иймд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үнэт цаас гаргах үйл ажиллагаанд шаардлагатай хүний нөөц болон программ, техник хангамжийн нөхцөлөөр бүрэн хангагдсан болно.

4.7. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө нь гаргасан үнэт цаасны мэдээлэл

Анхны үүрэг гүйцэтгэгч нь 2020-2025У3 хүртэл нийт 218.2 тэрбум төгрөгийн хаалттай бондыг биржийн бус зах зээлд гаргасан бөгөөд үүнээс үнэт цаасны танилцуулга бэлтгэгдэх үеийн байдлаар 168.2 тэрбум төгрөгийн бонд эргэн төлөгдөж, 50.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Мөн Инвескор ББСБ ХК нь 2021 онд Инвескор Актив ХБҮЦ, 2024 онд Инвескор ХБҮЦ гаргах үйл ажиллагаанд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу Үүсгэн байгуулагчаар оролцсон бөгөөд 2021-2024 оны хооронд нийт 54.0 тэрбум төгрөгийг үүсгэн байгуулсан тусгай зориулалтын компаниудаар дамжуулан татан төвлөрүүлсэн байна. Тус үнэт цааснуудыг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нээлттэй хүрээнд татан төвлөрүүлсэн бөгөөд үнэт цаасны мэдээлэл дараах байдалтай байна:

Хүснэгт 22. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу үүсгэн байгуулагчаар оролцсон ХБҮЦ-ны мэдээлэл

Үнэт цаас	Огноо	Үнийн дүн	Эргэн төлөлт	Барьцаа хөрөнгө	2025.11.24-ний байдлаарх үлдэгдэл
Инвескор Актив ХБҮЦ Үнэт цаас гаргагч: Инвескор Актив ТЗК" ХХК	2021.01	₮4.0 тэрбум	2023.01-р сард эргэн төлөгдсөн	Автомашины фидуци бүхий 4.0 тэрбум төгрөгийн зээлийн багц, нэрлэсэн үнэ ₮400,000 хүү жилийн 14.4%	-
Инвескор ХБҮЦ Үнэт цаас гаргагч:	2024.09	₮50.0 тэрбум	2026.03 сард төлөгдөх	Автомашины фидуци бүхий ₮70.7 төгрөгийн зээлийн	₮25.0 тэрбум

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486
2025/11/28

	багц, нэрлэсэн үнэ ₮100,000 хүү жилийн 17.0%	
Нийт дүн	**₮54.0 тэрбум**	**₹25 тэрбум**

4.8. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн байдал

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн 2022-2024 оны аудитын тайлан болон 2025 оны 3-р улирлын Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнасан тайланг ашиглан доорх санхүүгийн мэдээллийг бэлтгэсэн болно. "Инвескор ББСБ" ХК нь 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дэлхийн топ 4 аудитын компанийн нэг болох "Эрнст энд Янг Монголия Аудит" ХХК-аар аудит хийсэн бөгөөд аудитын дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу материаллаг алдаагүй, бодитойгоор илэрхийлсэн байна гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн байдлын тайлангийн шинжилгээ

Хүснэгт 23. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүү байдлын тайлан, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он	2025У3
Бэлэн ба банкин дахь мөнгөн	42,345.1	75,680.8	120,981.8	118,352.5
Зээл /цэвэр/	259,530.3	441,545.2	591,005.5	581,464.0
[illegible]	[illegible]	[illegible]	[illegible]	[illegible]
[illegible]	[illegible]	[illegible]	[illegible]	[illegible]
БҮЦБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө	7,164.1	7,587.3	21,910.6	22,570.6
Бусад хөрөнгө	5,029.3	7,042.8	6,528.0	23,203.1
Өмчлөх бусад хөрөнгө	1,439.6	918.5	1,991.1	2,036.7
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	-	-	3,309.9	11,336.8
Үндсэн хөрөнгө	1,534.9	6,930.7	8,562.0	7,308.3
Биет бус хөрөнгө	3,709.5	4,741.3	2,817.9	2,485.6
Ашиглах эрхтэй хөрөнгө	519.1	1,680.0	2,394.4	2,756.0
Охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт	5,803.4	8,654.1	15,676.1	20,540.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**327,075.2**	**554,780.8**	**775,177.4**	**792,053.5**
Зээлээр авсан санхүүжилт	63,750.0	200,491.0	304,644.7	350,223.5
Бондын өр төлбөр	44,170.5	66,829.5	44,268.2	57,794.4
Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр	111,873.6	140,489.4	181,194.3	142,321.2
Бусад өр төлбөр	7,641.8	15,172.1	61,823.8	37,430.8
Нийт өр төлбөрийн дүн	**227,435.9**	**422,982.0**	**591,931.0**	**587,769.9**
Эзэмшигчдийн өмч				
Хувьцаат капитал	17,194.0	17,194.0	17,194.0	17,194.0
Нэмж төлөгдсөн капитал	29,820.7	29,820.7	29,820.7	29,651.7
Давуу эрхийн хувьцаа	-	-	11,831.0	12,000.0
Бусад нөөц	2,384.4	1,690.9	5,821.7	7,355.6
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	50,240.3	83,093.2	118,579.1	138,082.2

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

2025/11/28

Эзэмшигчдийн өмчийн дүн	99,639.3	131,798.8	183,246.5	204,283.5
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	327,075.2	554,780.8	775,177.4	792,053.5

Эх сурвалж: "Инвескор ББСБ" ХК-ийн санхүүгийн тайлан

Хөрөнгө: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нийт хөрөнгө 2022 оноос 2025 оны 3-р улирал хүртэл дунджаар 34.3 хувиар өсөж, 792.1 тэрбум төгрөг хүрээд байна. Уг өсөлтөд нийт хөрөнгийн дунджаар 77.1 хувийг бүрдүүлж буй цэвэр зээлийн багц жилд дунджаар 30.9 хувиар өссөн нь шууд нөлөөлсөн байна.

График 3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нийт хөрөнгө, сая төгрөгөөр



График 4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн цэвэр зээл, сая төгрөгөөр



Эх сурвалж: "Инвескор ББСБ" ХК-ийн санхүүгийн тайлан

Зээлийн багц: Инвескор ББСБ ХК нь 2025 оны 3-р улирлын байдлаар 82,402 зээлдэгчийн нийт 581.5 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй байгаа ба нэг зээлдэгчийн дундаж зээлийн хэмжээ 7.4 сая төгрөг, зээлийн жигнэсэн дундаж хүү 3.1 хувь байна. Зээлийн багцын 60.9 хувийг бизнесийн зээл, 21.5 хувийг автотээврийн хэрэгслийн зээл, 16.8 хувийг хэрэглээний зээл, үлдсэн хэсгийг үл хөдлөх хөдлөх хөрөнгө худалдан авахад зориулсан зээл бүрдүүлж байна. Мөн нийт зээлийн багцын 5.2 хувийг ногоон зээлийн багц бүрдүүлсэн.

Топ-40 зээлдэгчид олгосон нийт зээлийн үлдэгдэл 95.7 тэрбум төгрөг бөгөөд энэ нь нийт зээлийн багцын 15.8 хувийг бүрдүүлж байна. ТОП-40 зээлдэгчийн нийт зээлд эзлэх хувь бага байгаа нь зээлийн төвлөрлийн эрсдэл буюу зээлдэгч талаас үүсэх эрсдэл бага байгааг илэрхийлж байна.

2025 оны 3-р улирлын байдлаар нийт зээлийн 85.0 хувийг хэвийн зээл бүрдүүлж байгаа бол чанаргүй зээл 9.6 хувийг бүрдүүлж байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь тайлант хугацаанд 40.2 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан нь нийт зээлийн 6.6%-тай тэнцэх үзүүлэлт юм. 2025 оны 3-р улирлын байдлаар 34.8 тэрбум төгрөгийн эрсдэлийн сангаас зардал бүртгэсэн байна.

2025/11/28

График 5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн чанаргүй зээлийн хувь



Эх сурвалж: "Инвескор ББСБ" ХК-ийн санхүүгийн тайлан

Эх үүсвэр: 2025 оны 3-р улирлын байдлаар эх үүсвэрийн 74.2 хувийг өр төлбөр, 25.8 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна. Нийт өр төлбөрийн 59.6 хувийг банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (үүнээс банкны зээл 219,238.8 сая төгрөгийг, бусад санхүүгийн байгууллагаас авсан зээл 124,362.1 сая төгрөгийг), 24.2 хувийг итгэлцлийн үйлчилгээнээс татан төвлөрүүлсэн хөрөнгө, 9.8 хувийг бондын өр төлбөр, үлдсэн хувийг бусад өр төлбөр тус тус бүрдүүлж байна. Тайлант хугацаанд цэвэр ашгийн өсөлт өндөр байгаа нь хуримтлагдсан ашгийг өсгөж, цаашлаад өөрийн хөрөнгө өсөх үндсэн шалтгаан болж байна. ББСБ-уудын хувьд өөрийн хөрөнгийн хэмжээ өндөр байх нь эрсдэл даах чадварыг нэмэгдүүлдэг тул нэмэлт хөшүүрэг ашиглах байдлаар орлого болон ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэх илүү боломжтой болдог.

График 6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эх үүсвэрийн бүтэц



График 7. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өр төлбөрийн бүтэц

Эх сурвалж: "Инвескор ББСБ" ХК-ийн санхүүгийн тайлан

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эх үүсвэрийн төрлүүд:

Итгэлцэл:

Инвескор ББСБ ХК нь 2025 оны 3-р улирлын байдлаар Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хүрээнд нийт 135.6 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий итгэлцлийг 276 харилцагчаас татсан ба энэхүү дүн нь өөрийн хөрөнгийн 66.4 хувьтай тэнцэж байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нийт

2025/11/28

зээлийн багцад эзлэх ногоон зээл хэмжээ 5 хувиас их тул журмын дагуу өөрийн хөрөнгийн 80% хүртэлх дүнгээр итгэлцэл татан төвлөрүүлэх бөгөөд тус зохистой харьцааг хангаж байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь итгэлцлийг дунджаар 1 жилийн хугацаатай, дунджаар жилийн 18.2% өртөгтэйгөөр татан төвлөрүүлсэн байна.

Бонд:

Инвескор ББСБ ХК нь 2021 оноос 2025 оны 3-р улирал хүртэл Биржийн бус зах зээлээс нийт 218.2 тэрбум төгрөгийн бондын эх үүсвэрээр татан төвлөрүүлж, эргэн төлөлтүүдийг хуваарийн дагуу амжилттай хийж байна. 2025 оны 3-р улирлын байдлаар хаалттай бондын үлдэгдэл 56.8 тэрбум төгрөг байгаа бөгөөд тайлант хугацаанаас хойш буюу 2025 оны 10-р сард 6.8 тэрбум төгрөгийн бонд эргэн төлөгдөж 50.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 24. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн идэвхтэй байгаа өрийн хэрэгслийн мэдээлэл, 2025 оны 3-р улирлын байдлаар

№	Симбол	Валют	Татан төвлөрүүлсэн	Хүү	Татан төвлөрүүлсэн огноо	Хугацаа
1	IVND-TBC-3.4-18	MNT	6,800,000,000	18.0%	2024.10.25	12 сар
2	IVNE-TBC-1.1-17.5	MNT	10,000,000,000	17.5%	2025.01.15	12 сар
3	IVNE-TBC-1.2-17.5	MNT	2,000,000,000	17.5%	2025.02.27	12 сар
4	IVNE-TBC-1.3-18	MNT	5,000,000,000	18.0%	2025.04.23	12 сар
5	IVNE-TBC-1.4-18	MNT	4,000,000,000	18.0%	2025.04.30	12 сар
6	IVNE-TBC-1.5-18	MNT	6,700,000,000	18.0%	2025.05.05	12 сар
7	IVNE-TBC-1.6-18	MNT	10,000,000,000	18.0%	2025.06.04	12 сар
8	IVNE-TBC-1.7-18	MNT	8,400,000,000	18.0%	2025.08.22	12 сар
9	IVNE-TBC-1.8-18	MNT	3,900,000,000	18.0%	2025.08.28	12 сар
			56,800,000,000			

Эх сурвалж: "Инвескор ББСБ" ХК-ийн санхүүгийн тайлан

Банкны зээл:

2025 оны 3-р улирлын байдлаар нийт 345.7 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа ба үүнээс 219.2 тэрбум төгрөг нь банкнуудаас авсан зээл, 124.4 нь санхүүгийн байгууллагаас авсан зээл, үлдэгдэл хэсгийг бусад этгээдээс авсан зээл бүрдүүлж байна.

Хүснэгт 25. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн гэрээний нөхцөлүүд

№	Зээл олгосон банк	2025.09.30-ны үлдэгдэл /сая төгрөгөөр/	Жинлэсэн дундаж хүү	Дундаж хугацаа
1	Банкны зээл	219,238.8	16.7%	33 сар
2	Бусад санхүүгийн байгууллагаас авсан зээл	124,362.1	12.2%	33 сар
3	Бусад зээл	2,065.5	18.5%	35 сар
Нийт		**345,666.4**		

Эх сурвалж: "Инвескор ББСБ" ХК-ийн санхүүгийн тайлан

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-02

СЭХ
2025 .12. 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Хүснэгт 26. Орлого, үр дүнгийн тайлан, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он	2025У3
Хүүгийн орлого	73,298.5	113,554.3	185,854.1	144,684.6
Хүүгийн зардал	(23,847.0)	(44,089.1)	(79,403.1)	(70,671.3)
Хүүгийн цэвэр орлого	**49,451.5**	**69,465.2**	**106,451.0**	**74,013.3**
Хүүгийн цэвэр орлогын маржин	*67.5%*	*61.2%*	*57.3%*	*51.2%*
Хураамж ба шимтгэлийн орлого	209.7	232.5	429.9	2,380.5
Хураамж ба шимтгэлийн зардал*	(748.0)	(537.7)	(16,017.0)	(180.1)
Хураамж ба шимтгэлийн цэвэр зардал	**(538.3)**	**(305.1)**	**(15,587.1)**	**2,200.4**
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал, алдагдал	(8,434.2)	(7,471.5)	(14,786.7)	(34,788.0)
Үйл ажиллагааны бусад орлого	347.4	2,792.1	3,011.5	10,165.6
Хүний нөөцийн зардал	(6,000.7)	(9,197.8)	(12,657.0)	(9,114.2)
Элэгдэл, хорогдлын зардал	(1,651.3)	(2,420.7)	(2,524.6)	(2,042.3)
Үйл ажиллагааны бусад зардал	(5,158.4)	(4,956.8)	(9,670.7)	(6,318.0)
Татварын өмнөх ашиг	**28,015.9**	**47,905.4**	**54,236.3**	**34,116.7**
Орлогын татварын зардал	(7,416.4)	(12,174.2)	(12,241.8)	(7,005.1)
Цэвэр ашиг	**20,599.5**	**35,731.2**	**41,994.5**	**27,111.6**
Цэвэр ашгийн маржин	*28.1%*	*31.5%*	*22.6%*	*18.7%*

Эх сурвалж: "Инвескор ББСБ" ХК-ийн санхүүгийн тайлан

Орлого, зарлага: "Инвескор ББСБ" ХК-ийн хүүгийн орлого 2022-2024 онд жилд дунджаар 59.2 хувь, цэвэр хүүгийн орлого жилд дунджаар 46.7 хувиар тус тус өссөн байна. Компанийн хувьд цэвэр хүүгийн орлогын маржин 2022 онд 67.5 хувь байсан бол 2024 оны эцэст 57.3 хувь болж буурсан байна. Цэвэр хүүгийн орлогын маржин сүүлийн жилүүдэд буурч байгаа нь компани итгэлцэл, банк санхүүгийн байгууллагаас авсан зээл, өрийн хэрэгсэл гэх мэт санхүүжилтийн өртөгтэй эх үүсвэрийг материаллаг хэмжээгээр нэмэгдүүлснээс шалтгаалж хүүгийн зардал өссөнтэй холбоотой юм.

2025 оны 3-р улирлын байдлаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хүүгийн орлого 144.7 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд цэвэр хүүгийн орлогын маржин 51.2 хувь байна.

График 8. Орлого, зардлын задаргаа, сая төгрөгөөр

Эх сурвалж: "Инвескор ББСБ" ХК-ийн санхүүгийн тайлан

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
Өсөлтийн ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

Colombo Capital
Delivering diversity
Улаанбаатар хот

*Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь 2024 онд 16.0 тэрбум төгрөгийн хураамж шимтгэлийн зардал бүртгэсэн бөгөөд үүний 98.4 хувийг Инвескор Хэтэвч ББСБ ХХК-тай байгуулсан ашгийн хуваарилалтын гэрээтэй холбоотойгоор гарсан зардал бүрдүүлж байна. Үлдсэн хэсгийг банкны үйлчилгээний хураамж бүрдүүлсэн.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн цэвэр ашиг 2022-2024 онд жилд дунджаар 42.8 хувь өссөн бөгөөд хөрөнгийн эх үүсвэрт өрийн хэрэгсэл, зээл ашиглаж байгаатай холбоотойгоор цэвэр ашгийн маржин 2022 онд 28.1 хувь байсан бол 2024 онд 22.6 хувь болж буурсан байна.

График 9. Цэвэр ашиг, сая төгрөгөөр



Эх сурвалж: "Инвескор ББСБ" ХК-ийн санхүүгийн тайлан

Хүснэгт 27. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн мөнгөн гүйлгээний тайлангийн голлох үзүүлэлтүүд, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он	2025У3
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(76,630.0)	(134,582.8)	(57,968.5)	(10,101.2)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(8,608.8)	(10,325.0)	(18,922.5)	(4,317.9)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	109,923.0	176,972.2	119,751.1	9,734.1
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**24,684.2**	**32,064.4**	**42,860.2**	**(4,684.9)**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,245.7	42,345.1	74,493.3	120,981.8
Гадаад валютын ханшийн зөрүү	415.2	83.7	(354.2)	2,055.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**42,345.1**	**74,493.3**	**116,999.3**	**118,352.5**

Эх сурвалж: "Инвескор ББСБ" ХК-ийн санхүүгийн тайлан

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнд харилцагчдад олгосон зээл, түүний эргэн төлөлт, зээлийн хүүгийн орлого, хүүгийн зардал болон бусдад үндсэн үйл ажиллагаатай холбоотой ажил гүйлгээг тусгадаг. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн эх үүсвэрт зээл, өрийн бичиг, итгэлцэл зэрэг санхүүгийн өр төлбөрүүдийг материаллаг хэмжээгээр ашиглаж байгаатай холбоотой санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ эерэг байгаа бөгөөд түүнээс үүсвэрээр үйл ажиллагааны сөрөг мөнгөн гүйлгээг санхүүжүүлж байна.

2025/11/28

СЗХ
2025 .12. 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зохистой харьцаа болон салбарт эзлэх хувь

Зохистой харьцааны үзүүлэлт: ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмын дагуу ББСБ-ын үйл ажиллагааны эрсдэлийг урьдчилан тооцох, үнэлэх, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоож, түүний биелэлтийг хянадаг. ББСБ нь үйл ажиллагааныхаа эрсдэлийг үнэлэх, хянахын тулд Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур болон холбогдох хууль тогтоомжийг дотооддоо мөрдөн ажилладаг.

Хүснэгт 28. Үнэт цаас гаргагчийн зохистой харьцаа үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2022	2023	2024	2025У3
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 10%<	32.2%	25.0%	25.8%	25.4%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 20%<	33.7%	25.9%	28.0%	27.7%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 8%<	25.2%	25.3%	29.4%	51.7%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа <80%	77.0%	96.0%	92.1%	66.4%
Өрийн бичгийн зохистой харьцаа <30%	40.7%	47.0%	23.8%	27.8%
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа <15%	0.6%	1.3%	1.2%	1.3%
ROA	9.0%	7.6%	6.3%	3.4%
ROE	27.2%	27.4%	29.8%	14.6%

Салбарт эзлэх хувь: 2025 оны 3-р улирлын байдлаар анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь нийт хөрөнгийн хэмжээгээр ББСБ-ын салбарын 9.29 хувийг, зээлийн багцын хэмжээгээр 8.48 хувийг, орлогын хэмжээгээр 8.43 хувийг, цэвэр ашгийн хэмжээгээр 3.78 хувийг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 29. Үнэт цаас гаргагчийн салбарт эзлэх хувь

	Үзүүлэлт	Эзлэх хувь		Үзүүлэлт	Эзлэх хувь
1	Нийт хөрөнгө	**9.29%**	4	Нийт итгэлцэл	**11.00%**
2	Цэвэр зээл	**8.48%**	5	Өөрийн хөрөнгө	**4.43%**
3	Хүүгийн орлого	**8.43%**	6	Цэвэр ашиг	**3.78%**

Эх сурвалж: СЗХ-ны тайлан, Голомт капитал УЦК тооцоолол

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

Голомт Капитал УЦК ХХК
Golomt Capital
Delivering Diversity
Улаанбаатар хот

2025/11/28

InvesCore Growth

ТАВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ



5. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт зааснаар үйлчилгээ үзүүлэгч нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцаж, хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулан тусгай зориулалтын компанид шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэхээр үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулсан хуулийн этгээд байна. Мөн хуулийн 19.8 дахь хэсэгт заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч нь үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэж болно.

Үнэт цаас гаргагчийн Үйлчилгээ үзүүлэгчээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу "Инвескор ББСБ" ХК ажиллах ба Үйлчилгээ үзүүлэгч нь хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр бүрэн хангагдсан, компанийн засаглалын үнэлгээ хийж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст заасан зарчмуудыг хэрэгжүүлэх хөтөлбөр батлан ажилладаг хуулийн этгээд юм.

Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ: Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой "Инвескор Өсөлт ТЗК" ХХК, "Инвескор ББСБ" ХК, "Эм Ай Си Жи" ХХК нарын хооронд 2025 оны 11-р сарын 18-ны өдөр 25/3-4 тоот "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 9 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчаас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулан, шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, хөрөнгийн багцад хамаарах зээлийн мэдээллийг хадгалах, шаардлагатай баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх, "Зээлийн эрсдэлийг удирдах журам"-ын дагуу зээлийн хяналт тавьж, зээл төлүүлэх ажиллагаа явуулах, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас төлбөр цуглуулах үйл ажиллагаанд хяналт тавих, Үнэт цаас гаргагч нь үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбогдох харилцааг зохицуулсан байна. Түүнчлэн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмыг удирдлага болгоно.

Төлбөр цуглуулах үйл ажиллагаа нь төлбөр буюу зээлийн эргэн төлөлтийг цуглуулах, ТЗК-д багцын эргэн төлөлтийг шилжүүлэх гэсэн 2 үе шаттай байна.

Схем 6. ХБҮЦ-ны төлбөр цуглуулах зураглал



2025/11/28

Үйлчилгээ үзүүлэгчийн хэрэгжүүлэх арга хэмжээ, чиг үүрэг:

- Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний нөхцөл болон Үнэт цаас гаргагч түүний төлөөлөгч эсхүл Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас бичгээр эсхүл цахим хэлбэрээр өгсөн зааварчилгаанд дурдсан нөхцөлийн дагуу үйлчилгээ үзүүлнэ;
- Хөрөнгийн багцад багтсан зээлийн Зээлдэгч, үүрэг гүйцэтгэгч нартай харилцах, төлбөр цуглуулах, зээл төлүүлэх арга хэмжээг өөрийн холбогдох Зээлийн эрсдэлийг удирдах журамд заасны дагуу хэрэгжүүлэх, зээлдэгчийн өмнө ТЗК- г төлөөлж, зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хугацаанд ТЗК-д шилжүүлэх, бүртгэх, тайлагнах;
- Зээлдэгчийн хүсэлтийн дагуу Зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулсан бол Үйлчилгээ үзүүлэгч нь энэ талаарх мэдээллийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан сард багтааж мэдэгдэнэ. Зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт орсноор Хөрөнгөд багтсан зээлийн багцын шалгуур үзүүлэлт хангахгүй болсон тохиолдолд ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу арга хэмжээ авна;
- Хөрөнгийн багцад багтсан зээлийн мэдээллийг хадгалах, ТЗК, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн хууль ёсны шаардлагаар ТЗК-тай холбоотой аливаа дүгнэлт гаргахад шаардагдах мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, мэдээллээр хангах, өөрийн гаргасан дүгнэлтийг холбогдох баримтыг бүрэн судалж, зохих стандартын дагуу үйл ажиллагаа явуулж, гаргасан дүгнэлтийн хариуцлагыг бие даан хариуцна;
- Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ТЗК болон Үнэт цаас эзэмшигчдэд хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр тэдний өмнө хариуцлага хүлээнэ;
- ТЗК-ийн нэрийн өмнөөс зээлийн хүүгийн төлбөрийн нэмэгдсэн өртгийн албан татварын баримтыг зээлдэгчид хүргүүлнэ;
- Хууль тогтоомжид заасан бусад

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү гэрээний дагуу багцын эргэн төлөлтийг хянаж, ТЗК болон Үйлчилгээ үзүүлэгчтэй тогтмол хамтран ажиллана.

Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээг цуцлах нөхцөл

Гэрээ нь талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж дуусгавар болох хүртэл буюу ХБҮЦ-ны төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлж дуусган, Үнэт цаас гаргагчийг татан буугдах өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19.4 заалт болон Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгасны дагуу "Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол тусгай зориулалтын компани нь гэрээг цуцалж, шинэ үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ байгуулах эрхтэй" байна.

Гэрээг цуцалсан тохиолдолд түүнээс хойш 5 хоногийн дотор дараагийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгоно. Шинэ үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд Үйлчилгээ үзүүлэгч Төлбөр цуглуулах үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэх үүрэгтэй ба ТЗК-аас нэмэлт төлбөр шаардах эрхгүй байна.

Түүнчлэн хуульд заасны дагуу Үйлчилгээ үзүүлэх гэрээг цуцалсан тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нь тусгай зориулалтын компанийн сонгож, гэрээ байгуулсан шинэ

2025/11/28

СЗХ
2025 12 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

үйлчилгээ үзүүлэгчид хөрөнгөтэй холбоотой мөнгөн хөрөнгө, нягтлан бодох бүртгэлийн баримт, санхүүгийн тайлан зэрэг бүх материалын эх хувийг цахим хувийн хамт үнэ төлбөргүй шилжүүлэх бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь бусдад санаатай буюу болгоомжгүй үйлдлийн улмаас учруулсан хохирлыг хариуцна.

Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам: ТЗК-ийн ТУЗ-аас батлагдсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-д талуудын үйлчилгээ үзүүлэх, төлбөр цуглуулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. ТЗК, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. Төлбөр цуглуулахад Үйлчилгээ үзүүлэгч нь дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

- Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах данс буюу Зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй Зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийг бусад хөрөнгөөс ангид бүртгэнэ.
- Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийн дансанд тухай бүр орж ирсэн мөнгийг уг дансанд төвлөрүүлж, дараа сарын 5-ны дотор багтаан холбогдох авлагыг суутган Төлбөр цуглуулах данс руу шилжүүлсэн байна.
- Зээлдэгчийн хүсэлтийн дагуу Зээлийн гэрээ болон мэдээлэлд өөрчлөлт оруулж, төлбөрийн хуваарь өөрчлөгдсөн бол Үйлчилгээ үзүүлэгч нь энэ талаарх мэдээллийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид Зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан өдөрт багтаан мэдэгдэнэ. Зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт орсон нь Зээлийн багц дахь шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон тохиолдолд ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу арга хэмжээ авна;
- Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг тооцоолсон зээлийн данс бүртгэлийг хөтөлж, зээлийн болон төлбөрийн мэдээллийг сар бүр нэгтгэн гаргаж, дараа сарын ажлын 3 хоногийн дотор багтаан ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлэн, тайлагнана.
- Зээлдэгч зээлийн эргэн төлөлтийн хугацааг хэтрүүлсэн тохиолдолд тухай бүр бүртгэж, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид тайлангаар мэдээлэх ба СЗХ-ноос батлагдсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын дагуу уг зээлийг чанаргүй ангилалд шилжихээс өмнө буцаан худалдаж авах буюу өөр хэвийн, шаардлага хангасан зээлээр сольж өгнө.
- ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай харилцах ажилтыг тусгайлан томилно.
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-н төлбөр цуглуулах дансанд цугларсан төлбөрөөр ХБҮЦ-н болон ТЗК-ийн бусад төлбөрийн үүргүүдийг гүйцэтгэх боломжгүй болсон эсхүл, Хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гарвал энэ тухай нэн даруй ТЗК-д буюу ТЗК-ийн ТУЗ-д мэдэгдэнэ.

Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ: Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагч (Үүргийн гүйцэтгэл хангуулагч) болон Барьцаалуулагч (Инвескор ББСБ ХК) талуудтай 2025 оны 11-р сарын 18-ны өдөр 25/3-6 тоот гэрээ байгуулсан байна. Энэхүү гэрээний зорилго нь ТЗК болон Үйлчилгээ үзүүлэгч нарын хооронд байгуулсан Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгасан зээлийн эргэн төлөлтийн данс, уг дансанд цугларах зээлийн төлбөрийн орлогыг барьцаалах, ТЗК-ийн, ХБҮЦ-ны төлбөрийг төлөх зорилгоор Зээлийн эргэн төлөлтийн данснаас ТЗК-ийн Төлбөр

ИНВЕСКОР ӨӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

Golomt Capital
Улаанбаатар хот

2025/11/28

цуглуулах дансанд гэрээ болон журмаар тогтоосон хугацаанд үл маргах журмаар шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Гэрээний дагуу Инвескор ББСБ ХК нь барьцаалуулагч байх бөгөөд Зээлийн эргэн төлөлтийн дансыг эзэмшиж, худалдсан зээлийн багцын төлбөрүүдийг уг дансанд цуглуулна.

"Зээлийн эргэн төлөлтийн данс, түүнд цугларсан хөрөнгө нь Барьцаалуулагчийн бусад хөрөнгөөс тусгаарлагдсан, барьцаалуулагчийн бусдын өмнө хүлээсэн аливаа үүрэг, төлбөрийн чадваргүй байдал, дампуурал, татан буулгах ажиллагаанаас ангид байна."

Уг гэрээгээр барьцаалуулагч нь гэрээнд тусгасан Зээлийн эргэн төлөлтийн дансыг Үүргийн гүйцэтгэл хангуулагч (Эм Ай Си Жи ХХК)-д барьцаалж байгаа бөгөөд холбогдох гэрээнд заасан үүргээс бусад байдлаар уг данс дахь мөнгийг бүхэлд нь болон хэсэгчлэн захиран зарцуулахгүй, зарлагын гүйлгээ хийхгүй байх, зээлийн эргэн төлөлтийн дансанд нөлөөлөх аливаа эрхийн доголдол үүсгэхгүй байх, дансны тайлан мэдээллийг шаардлагатай тохиолдолд гаргаж өгөх, баталгаажсан өр төлбөр бүрэн төлөгдөх хүртэл дансыг хаахгүй байх, Үүргийн гүйцэтгэл хангуулагчийн эрх, эрхээ хангуулахад сөргөөр нөлөөлөхгүй байх, үүргийн гүйцэтгэлийг хангах эд хөрөнгөд нөлөөлж болох аливаа зүйлийг хийхгүй байх зэрэгт үүрэг хүлээж, баталгаа гаргасан.

Гэрээ нь байгуулагдсан үеэс эхлэн талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж дуусгавар болох хүртэл буюу ХБҮЦ-ны төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлж дуусган Үнэт цаас гаргагчийг татан буугдах өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
ӨСӨЛТ ТЗК
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

Голомт Капитал УЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119089111 5481559
Улаанбаатар хот

2025/11/28

InvesCore Growth

ЗУРГАА. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУХАЙ



6. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУХАЙ

6.1. Ерөнхий танилцуулга

"Эм Ай Си Жи" ХХК нь 2009 оны 12-р сард бизнесийн зөвлөх үйлчилгээ эрхлэх чиглэлээр үүсгэн байгуулагдсан. 2020 оноос хөрөнгийн зах зээлтэй холбоотой судалгаа, төсөл хөтөлбөрүүд дээр ажиллаж эхэлж, 2022 оноос "Хөрөнгө итгэмжлэн удирдах" тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хороноос авснаар тусгай зориулалттай компанитай гэрээ байгуулж, хөрөнгийг нь хөрөнгө оруулагчдын эрх ашигт нийцүүлэн удирдах үйл ажиллагааг явуулж байна.

Хүснэгт 30. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тухай

Байгууллагын нэр	"Эм Ай Си Жи" ХХК
Компанийн регистрийн дугаар	5344891
Тусгай зөвшөөрлийн дугаар:	ТЗ 316/19
Гүйцэтгэх захирал	Б.Билэгтсайхан
Үйл ажиллагааны чиглэл	Бизнесийн зөвлөгөө өгөх Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа
Хаяг	Улаанбаатар, Баянгол, 6-р хороо, Пума 2-2 тоот

"Эм Ай Си Жи" ХХК нь Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, үнэт цаасны баталгаа болж буй хөрөнгийн эргэн төлөлтийг цуглуулж, үнэт цаасны хэлцэлтэй холбоотой төлбөрийг гүйцэтгэх, мөнгөн хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах, хөрөнгө оруулагч болон зохицуулагч байгууллагад тайлан мэдээ гаргах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах ажлыг гүйцэтгэнэ.

Компани нь хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаандаа зориулан "Дайнамикс софт" ХХК-ийн хөгжүүлсэн "CloudBanker" программыг ашиглах гэрээг 2025 оны 10-р сард байгуулсан бөгөөд тус программын тусламжтайгаар зээлийн багцыг удирдах, нягтлан бодох бүртгэл хөтлөж, санхүүгийн тайлан бэлтгэх, бусад холбогдох тайлан тооцоо гаргах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 31. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн удирдлагын багийн мэдээлэл

Албан тушаал	Нэр	Боловсрол, ажлын туршлага
Гүйцэтгэх захирал	Б.Билэгтсайхан	"Southern Taiwan University of Science and Technology" их сургуулиас бизнесийн удирдлагын докторын хөтөлбөрт хамрагдсан, нийт 15 жил ажилласан туршлагатай байна.
Хөрөнгө итгэмжлэн удирдах ажиллагааг хариуцсан ажилтан /Нягтлан бодогч/	Б.Наранчимэг	Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийг бизнес эдийн засаг мэргэжлээр төгссөн бөгөөд санхүүгийн салбарт нийт 11 жил ажилласан туршлагатай.

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эрх бүхий албан тушаалтан, хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг хариуцан ажиллах мэргэжилтэн нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийн журмын шаардлагыг хангасан, Гүйцэтгэх захирал, ХИУ үйл ажиллагааг хариуцан ажиллах мэргэжилтэн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан, үйл

2025/11/28

ажиллагааг эрхлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр хангагдсан болно.

Компани нь 2024 онд Чингис Хаан Хөрөнгийн Биржээр дамжуулан нээлттэй гаргасан БИД ХБҮЦ-ны Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Хүснэгт 32. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн ажиллаж буй төслийн мэдээлэл

№	ХБҮЦ гаргагч	Гаргасан огноо	Гаргасан дүн (тэрбум.төг)	ХБҮЦ-ны үлдэгдэл дүн (тэрбум.төг)	Хугацаа
1	"Бид Ассет ТЗК" ХХК	2024.04.15	15.00	10.00	24 сар
Нийт			**15.00**	**10.00**	

6.2. Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээний тухай

Үнэт цаас гаргагч болон "Эм Ай Жи Си" ХХК нарын хооронд 2025 оны 11 дүгэр сарын 18-ны өдөр хийгдсэн 25/3-7 тоот "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-ээр автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө, түүнтэй холбоотой эрх барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө итгэмжлэн удирдагчаас үзүүлэх үйлчилгээ, гэрээний дагуу талуудын хамтран ажиллах зарчим, эрх үүргийг зааж өгчээ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн үйл ажиллагаанд энэхүү гэрээ болон ТЗК-ийн баталсан заавар журмуудыг удирдлага болгоно.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ***Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн* 20.2**-т заасан ажил үйлчилгээг үзүүлэх үүрэг хүлээнэ.

Хөрөнгийг эзэмших, удирдах, төлбөр төлөх харилцаа

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тус гэрээний дагуу хөрөнгө итгэмжлэн удирдах үүргээ үнэнч шударгаар биелүүлж, үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, мэргэжлийн ёс зүйг баримтлан ажиллах бөгөөд дараах үүргүүдийг хүлээсэн. Үүнд:

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө оруулагчийн эрх ашгийг нийцүүлэн хөрөнгийг эзэмшиж удирдана;
- Хөрөнгийн багцтай холбоотой санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг Хорооноос тогтоосон журамд нийцүүлэн өөрийн хөрөнгийн бүртгэлээс тусад нь хөтөлнө;
- Хөрөнгө оруулагчдад шаардлагатай тайлан, мэдээг гаргаж өгөх;
- Баталгаат үнэт цаасны төлбөрийг шилжүүлэх;
- Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалахад чиглэсэн Хорооноос тогтоосон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ дуусгавар болоход шинээр томилогдсон хөрөнгө итгэмжлэн удирдагчид ТЗК-н хөрөнгөд хамаарах бүх баримт бичгийг электрон болон бусад хэлбэрээр төлбөргүйгээр хүлээлгэн өгөх;
- ТЗК татан буугдах журамд заасан ТЗК-г татан буулгахтай холбоотой бусад чиг үүргийг хүлээсэн.

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солих: Талуудын хооронд байгуулсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ" болон ТЗК-ийн ТУЗ-аас батлагдсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-д заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг дараах тохиолдолд зөрчил гаргасанд тооцож, гэрээг цуцлах арга хэмжээ авна.

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гэрээнд заасан Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас үзүүлэх үйлчилгээг 2 болон түүнээс дээш удаа гүйцэтгээгүй, гүйцэтгэхийг шаардсан хэдий ч зөрчлөө заасан хугацаанд арилгаагүй,
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэд, зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас үнэт цаас эзэмшигчид болон ТЗК-д шууд болон шууд бусаар хохирол учирсан,
- Хөрөнгийн багцыг буруу удирдсан, зохих өөрчлөлт оруулаагүйгээс ХБҮЦ-ийн төлбөр хүрэлцэхгүй болсон, ХБҮЦ эзэмшигчид хугацаандаа төлбөр хүлээн авах боломжгүй нөхцөлийг бий болгосон,
- Үнэт цаас эзэмшигчид, эрх бүхий этгээдэд хүргэх мэдээллийг "Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам"-д заасан хугацаанд удаа дараа мэдээлээгүй.

Эдгээр тохиолдолд гэрээг ТЗК-н ТУЗ-ийн шийдвэрээр цуцлах ба хөрөнгө итгэмжлэн удирдагч солигдсон тохиолдолд ажлын 3 хоногт багтаан Хороо, Бирж болон хөрөнгө оруулагч нарт мэдээлнэ. Үнэт цаас гаргагч нь шинэ хөрөнгө итгэмжлэн удирдагчтай гэрээ байгуулах хүртэл ТЗК-ийн ТУЗ өөрөөр шийдвэрлээгүй бол итгэмжлэн удирдагч нь хууль тогтоомж болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэвийн, урьдын адил гүйцэтгэх үүрэгтэй.

2025/11/28

InvesCore Growth

ДОЛОО. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН



7. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

7.1. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь Монгол улсын "Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаасны тухай" хуульд зааснаар санхүүгийн мөнгөн урсгал бий болгох хөрөнгөөр баталгааждаг ба хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжид төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас юм. Тухайлбал, олон улсад хамгийн түгээмэл танигдсан бүтээгдэхүүн бол АНУ-ын моргейжийн гэрээг багцалсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас юм. Энгийнээр тайлбарлавал тухайн компанийн ирээдүйд орж ирэх гэрээгээр баталгаажсан мөнгөн урсгалыг багцлан, бүтээгдэхүүн болгож ирээдүйн төлбөрийг тухайн гэрээгээр баталгаажсан мөнгөн урсгалаар төлөх үйл явц юм.

Схем 7. ХБҮЦ-ны зураглал



ХБҮЦ гаргах болон үйл ажиллагаа хэвийн явагдахад оролцогч талууд:

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч – Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т заасанчлан анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд туссан хөрөнгийг тусгай зориулалтын компанид шилжүүлсэн, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд байна.

Тусгай Зориулалтын компани – Тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасанчлан Тусгай Зориулалтын Компани нь Компанийн тухай хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу байгуулагдсан, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл авсан хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

Хөрөнгө Итгэмжлэн удирдагч – Тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т заасанчлан Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан,

2025/11/28

ТЗХ
2025 .12. 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

хөрөнгө оруулагчид барьцаалуулсан хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах эрх үүрэг бүхий этгээд байна.

Үйлчилгээ үзүүлэгч – Тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т заасанчлан Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд Хөрөнгөтэй холбоотой төлбөр цуглуулан ТЗК-д шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд байна.

Захиргааны үйлчилгээ үзүүлэгч – Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.12.5-д заасны дагуу тусгай зориулалтын компани хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулахыг хориглодог тул компанийн ХЭХ, ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах, албан бичиг хэргийн ажил гүйцэтгэх, Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай хамтран нягтлан бодох бүртгэл хөтлөх, ТЗК-ийн мөнгөн хөрөнгөөс шаардлагатай мөнгөн гүйлгээг ХИУ-ийн хяналт доор хамтран гүйцэтгэх, хүүгийн орлогын албан татвар төлөх, компанийн цахим хуудас хөтлөх зэрэг Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд байна. Захиргааны үйлчилгээг Үйлчилгээ үзүүлэгч гүйцэтгэнэ.

Хуулийн фирм – ТЗК-иас тогтоосон хууль зүйн шалгуур үзүүлэлтийн дагуу санамсаргүй түүврийн сонгосон хөрөнгийн багцад багтсан зээлийн данснуудад дүн шинжилгээ хийж, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд хөндлөнгийн хууль зүйн үйлчилгээ үзүүлж, хууль зүйн дүгнэлт гаргах, үнэт цаас гаргагчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх эрх бүхий хуулийн этгээд байна.

Аудитын байгууллага – Үнэт цаас гаргагчийн зээлийн багцад болон санхүү аудитын дүгнэлт гаргах, ТЗК-тай холбоотой аудитын дүгнэлт гаргах эрх бүхий хуулийн этгээд байна.

Зээлийн шинжилгээ гаргагч – Хөрөнгийн багц дахь зээлүүд нь ТЗК-иас тогтоосон санхүүгийн шалгуур үзүүлэлтэд нийцэж буй эсэхэд санхүүгийн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх эрх бүхий аудитын компани байна.

Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны онцлог:

Тодорхой байдал

Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас нь Зээлийн багцын ирээдүйн мөнгөн урсгалаар баталгаажсан байдаг. Цаашлаад зээлийн үндсэн хүү, төлөгдөх хугацаа, үе шатлал зэрэг нь хуваарийн дагуу явагддаг учир мөнгөн хөрөнгө эргэн төлөгдөх баталгаат урсгалтай.

Найдвартай байдал

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тайлан балансаас зээлийн багцыг хасаж ТЗК-д шилжүүлснээр тусдаа хяналтын бүтцэд оруулдаг.

Эрсдэлийг бууруулна

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тайлан балансаас зээлийн багцыг хасаж бүртгэсний хүрээнд компанийн аливаа эрсдэл, мөнгөн хөрөнгө тасалдал, дампуурал зэрэг нь хөрөнгөөр баталгаажсан зээлийн багцад нөлөө үзүүлэхгүй.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

Голомт Капитал
1119289111 5481589
Улаанбаатар хот

2025/11/28

ХБҮЦ-ны өгөөжийн түвшин өндөр тогтох боломжтой байдаг ба эрсдэлээр жигнэсэн өгөөжийн хувьд харьцангуй өндөр.

Менежмент

Зээлийн багцыг шаардах эрхийг Тусгай Зориулалтын Компанид шилжүүлэхээс гадна хөрөнгө итгэмжлэн удирдагч нь зээлийн багцад хяналт тавьснаар олон талт менежментийн системийг бий болгоно.

Үнэт цаасжуулалт

Тусгай зориулалтын компани нь ирээдүйн орлогоо барьцаалан шинээр санхүүжилт татах боломжтой байдаг. ХБҮЦ гаргаж татан төвлөрүүлэх дүн нь зээлийн багцад суурилж тодорхойлогддог.

Эрсдэл

Компанийн зээлийн багцыг салгаж дампуурах эрсдэлийг хязгаарлаж өгдөг хэдий ч багц зээл нь тасалдах эрсдэлтэй. Мөн харилцаанд орж буй талуудын уялдаа холбоог нарийн тодорхойлж өгөөгүйгээс үүдэн үүргийн гүйцэтгэл хангагдахгүй байх, ХБҮЦ-ны эргэн төлөлтийн үйл ажиллагаа тасалдах магадлалтай. Түүнчлэн ТЗК-ийн баталсан журмуудыг баримталж ажиллахгүй байх эрсдэл гарах магадлалтай.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь дараах хоёр төрлөөс бүрдэнэ.

1) Баталгаат үнэт цаас, 2) Барьцаат үнэт цаас.

Хүснэгт 33. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төрөл

	1) Баталгаат үнэт цаас	2) Барьцаат үнэт цаас
Үнэт цаас гаргагч	Тусгай зориулалтын компани	Орон сууцны санхүүжилтийн компани, Банк

1) Баталгаат үнэт цаас нь
Хөрөнгийг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үнэт цаас гаргагчийг үүсгэн байгуулагч, худалдагчийн санхүүгийн тайлан, тэнцлээс хасаж, хөрөнгөтэй холбоотой шаардах эрх болон олох орлогыг тусгай зориулалтын компанийн санхүүгийн тайлан, тэнцэлд шилжүүлэн анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчийг хөрөнгөтэй холбоотой үүргээс бүрэн чөлөөлснийг гэрчилсэн үнэт цаас байна.

2) Барьцаат үнэт цаас нь
Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, тэнцэлд тусгаарлан бүртгэгдсэн, орон сууцны зээлийн болон хуулиар зөвшөөрсөн бусад үл хөдлөх эд хөрөнгийн барьцаатай холбоотой шаардах эрхээр баталгаажсан, үнэт цаасны танилцуулгад заасан хугацаанд үндсэн төлбөр, түүний хүүг хөрөнгө оруулагчид төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаас байна.

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

СЗХ
2025 12 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Хүснэгт 34. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны давуу болон сул тал

Давуу тал	Сул тал
• Аюулгүй байдал /Анхны үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагааны эрсдэлийг тусгаарласан/ • Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаа тасалдах, дампуурсан тохиолдолд ч ХБҮЦ нь зээлийн багцаас цуглуулах мөнгөн урсгалаар хэвийн төлөгдөнө. • Гэрээлэгдсэн учир Зээлийн багцын эргэн төлөлтийн мөнгөн урсгал, орж ирэх эх үүсвэр тодорхой. • Биржээр дамжуулж хугацааны өмнө борлуулах боломжтой өндөр • Нээлттэй үнэт цаас учир хүүгийн орлогын албан татвар бага буюу 5 хувь	• Эргэн дуудах нөхцөл Зээлийн багцын төлөлт хугацаанаас өмнө орж ирсэн тохиолдолд ХБҮЦ-ыг эргэн дуудах нөхцөлтэй гаргадаг. Ингэснээр худалдан авсан хөрөнгө оруулагчид хугацаанаас өмнө эргэн төлөлтөө авах магадлалтай. "Инвескор Өсөлт ТЗК" ХХК-ийн гаргаж буй ХБҮЦ-ны хувьд ХБҮЦ-ны тухай хууль, холбогдох гэрээнд зааснаас бусад тохиолдолд эргэн дуудаж төлөлт хийх нөхцөлгүй тул энэхүү эрсдэлийг хаасан байна. • Бүтцийн эрсдэл ХБҮЦ-тай холбоотой оролцогч талуудын уялдаа холбоог журам бүтцээр зохицуулаагүй тохиолдолд үүргийн гүйцэтгэл хангагдахгүй мөнгөн урсгалд эрсдэл үүсэх

7.2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ[1]

Дэлхийн улс орнуудын хооронд худалдааны хэлэлцээр хийгдэж, АНУ-ын зүгээс тарифын түвшнийг анх зарласан дүнгээс багаар ногдуулсан ч дэлхийн эдийн засаг геополитикийн тодорхой бус байдал өндөр хэвээр байгаатай холбогдуулан Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2025 оны 9-р сарын 16-ны өдрийн хурлаар бодлогын хүүг 12 хувь болгож хэвээр хадгалах шийдвэр гаргасан.

Хүснэгт 35. Монгол улсын макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Нэгж	2022	2023	2024	2025Y2
Бодит сектор					
ДНБ, оны үнээр	тэрбум төг.	53,852	70,442	80,663	40,262
ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр	тэрбум төг.	28,455	30,567	32,133	15,257
ДНБ-ний бодит өсөлт	хувь	5.0%	7.2%	5.1%	5.7%
Нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр	сая төг	15.9	20.3	22.6	11.3
Мөнгөний сектор	**Нэгж**	**2022**	**2023**	**2024**	**2025Y2**
Мөнгө М1	тэрбум төг.	7,201.3	9,853.1	11,687.4	10,645.8
Мөнгө М2	тэрбум төг.	29,664.8	37,624.1	43,276.3	42,999.3
Нэгдсэн төсвийн орлого	тэрбум төг.	17,127	23,295	29,671	13,216
Нэгдсэн төсвийн тэнцэл	тэрбум төг.	(1,033)	786	(920)	(758)
Гадаад валютын албан нөөц	сая ам.дол.	3,400	4,922	5,510	5,206

[1] Ашигласан эх сурвалж: Мөнгөний бодлогын тайлан, Үндэсний статистикийн хороо, Монголбанк

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

Golomt Capital
Delivering diversity
Улаанбаатар хот

MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -12- 01
БҮРТГЭВ-02

СЭХ
2025 .12. 25
БҮРТГЭВ
№ 01

Үзүүлэлт	Нэгж	2022	2023	2024	2025Y2
Нийт гадаад өр	сая ам.дол.	33,345	34,569	37,237	39,612
Засгийн газрын гадаад өр	сая ам.дол.	8,012	8,105	8,397	8,837
Гадаад сектор	**Нэгж**	**2022**	**2023**	**2024**	**2025Y2**
Экспорт	сая ам.дол.	12,539	15,187	15,783	6,581
Импорт	сая ам.дол.	8,704	9,250	11,615	5,521
Худалдааны тэнцэл	сая ам.дол.	3,834	5,937	4,169	1,059
Хүүгийн түвшин	**Нэгж**	**2022**	**2023**	**2024**	**2025Y2**
Бодлогын хүү	%	13.0%	13.0%	10.0%	12.0%
Инфляцын түвшин	%	13.2%	7.9%	9.0%	8.2%
Төгрөг ам.долларын албан ханш	төг.	3,444	3,410	3,420	3,581

Эх сурвалж: УСХ, Монголбанк

ДНБ: Монгол Улсын эдийн засгийн өсөлт, бууралт нь экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, стратегийн ач холбогдолтой томоохон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтээс шууд хамааралтай байдаг.

Монгол улсын эдийн засаг 2024 онд 5.1 хувиар өссөн бөгөөд тус өсөлтөд нүүрсний олборлолт түүхэнд хэмжээнд хүрч, Оюу толгойн далд уурхайн олборлолт эрчимжиж зэсийн үйлдвэрлэл нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлсэн бол зудын гамшиг нүүрлэсэнтэй холбогдуулан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл өсөлтийг сааруулсан.

Харин 2025 оны 2-р улирлын байдлаар эдийн засаг 5.7 хувиар тэлсэн бөгөөд хөдөө аж ахуйн салбарын сэргэлт эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бол уул уурхайн салбарын өсөлт удааширч, түүнийг дагасан тээвэр худалдааны салбарууд агшиж, өсөлтийг сааруулав.

Хаваржилт тогтуун байж, мал төллөлт, бойжилт хэвийн үргэлжилсний үр дүнд бойжсон төлийн тоо толгой 20.8 саяд хүрч өмнөх оны мөн үеэс 5.4 сая толгой малаар нэмэгдэн, том малын зүй бус хорогдол 189 мянга болж, өмнөх оны мөн үеэс 7.9 сая толгой малаар буурсны нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбар 36 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 3.6 хувийг бүрдүүлсэн.

Улаанбаатар хотын орон сууц, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилга болон Багахангай-Хөшигийн хөдий чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын голлох нөлөөгөөр барилгын салбар 25 хувиар өссөнөөр эдийн засгийн өсөлтийг 0.4 хувиар дэмжлээ. Мөн шинээр ашиглалтад орсон Тосон, Бөөрөлжүүт зэрэг ДЦС-уудын үйлдвэрлэлийн нөлөөгөөр цахилгаан болон дулааны эрчим хүч үйлдвэрлэл нэмэгдсэнээр эрчим хүчний үйлдвэрлэл 8.4 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн 0.3 хувиар дэмжсэн байна.

Оюу толгойн далд уурхайн үйлдвэрлэл эрчимжиж, зэсийн баяжмалын олборлолт нэмэгдсэнээр нийт зэсийн үйлдвэрлэл 29.0 хувиар өсөж 970 мянган тоннд хүрсэн ч бусад гол түүхий эдийн олборлолт болох нүүрс 11.4 хувь, газрын тос 11.0 хувь, алт 16.2 хувиар буурснаар уул уурхайн салбарын өсөлт өнгөрсөн оноос буурч, эдийн засгийн өсөлтийн 0.1 хувийг бүрдүүлсэн байна.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

2025/11/28

График 10. Монгол Улсын нэрлэсэн ДНБ (их наяд төгрөгөөр) болон бодит ДНБ-ний өсөлт, хувиар



Эх сурвалж: УСХ

Олон улсын худалдааны бодлогын чиг өөрчлөгдөж, геополитикийн тодорхой бус байдал өндөр байгаа хэдий ч Дэлхийн банк, ОУВС, АХБ-ны шинжээчид Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд Оюу толгойн далд уурхайн үйл ажиллагаа өргөжиж, зэсийн олборлолтын өсөлт болон хөдөө аж ахуйн салбарын сэргэлт голлох нөлөөг үзүүлснээр 2025 онд дунджаар 6.1 хувь, 2026 онд 5.5 хувиар сэргэнэ гэж таамаглал дэвшүүлсэн.

Хүснэгт 36. Бодит ДНБ-ий өсөлтийн төсөөлөл, хувиар

	2025Т	2026Т
Дэлхийн банк	6.3%	5.2%
АХБ	6.6%	5.9%
ОУВС	5.5%	5.5%
Дундаж	**6.1%**	**5.5%**

Эх сурвалж: Дэлхийн банк, АХБ, ОУВС

Инфляц, мөнгөний бодлого:

Монголбанк Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлийн төслөө өргөн барьсан бөгөөд инфляцын түвшнийг 2025-2026 онуудад 6%(±2) хувийн зорилтод түвшинд тогтвортой барих, 2027 оноос инфляцын зорилтыг 5 хувь болгон бууруулахаар төлөвлөж байна.

Инфляцын түвшин хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт болон цахилгааны үнийн тарифын өсөлтөөс үүдэн 2024 оны жилийн эцэст 9.0 хувьд хүрч Төвбанкны зорилтот түвшнийг давсан.

2025 он гарснаас хойш Монголбанкнаас мөнгөний хатуу бодлогын олон талт арга хэмжээг хэрэгжүүлж буй бөгөөд 2025 оны 3-р сараас бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 12 хувь, банкнуудын заавал байлгах нөөцийн хэмжээг нэмэгдүүлж, банкнаас иргэдэд шинээр олгох болон нөхцөлийг өөрчлөх хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 50 хувьд шинэчлэн тогтоосон. Улмаар эдийн засгийн дотоод идэвхжил саарч, эрэлтийн инфляцын дарамт буурахын зэрэгцээ

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
УПАА НБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486
2025/11/28

нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт саарснаас үүдэн 2025 оны 2-р улирлын эцэст инфляцын түвшин улсын хэмжээнд 8.2 хувьд хүрсэн.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2025 оны 9-р сарын 16-ны өдрийн хурлаар бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргасан ч хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалан 2025 оны 9-р сарын байдлаар улсын инфляцын түвшин 9.0 хувьд хүрсэн байна.

График 11. Инфляцын түвшин, хувиар



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Дэлхийн банк, ОУВС, АХБ-ны шинжээчид инфляцын түвшнийг 2025 онд дунджаар 9.4 хувь, 2026 онд дунджаар 7.7 хувьд хүрнэ гэж таамагласан.

Хүснэгт 37. Инфляцын төсөөлөл, хувиар

	2025Т	2026Т
Дэлхийн банк	10.0%	8.0%
АХБ	9.1%	7.0%
ОУВС	9.0%	8.2%
Дундаж	**9.4%**	**7.7%**

Эх сурвалж: Дэлхийн банк, Азийн Хөгжлийн Банк, Олон Улсын Валютын Сан

Төсвийн тэнцэл: Монгол улсын төсвийн орлого 29,371 тэрбум төгрөгт, төсвийн зарлага 30,591 тэрбум төгрөгт тус тус хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 920 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Төсвийн орлогын бүрдүүлэлтэд уул уурхайн салбарын өсөлтийг даган аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс төвлөрүүлэх орлого өсөж, импортын барааны эрэлт өссөнөөр нэмэгдсэн өртгийн албан татвар нэмэгдсэн нь эергээр нөлөөлсөн байна. Харин инфляцыг давсан тэтгэвэр цалингийн зардлын өсөлт болон сонгуультай давхцан эрчимтэй нэмэгдсэн бараа үйлчилгээний зардлын өсөлтийн улмаас төсвийн зардал өмнөх оноос 34.9 хувиар өсөж, КОВИД-19 цар тахлын үеийн өндөр түвшнийг давсан.

Нүүрсний үнийн бууралттай холбоотойгоор уул уурхайн салбараас төсөвт төвлөрүүлэх орлого саарч 2025 оны 2-р улирлын байдлаар төсвийн тэнцвэржүүлсэн орлого 13,216 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар буурсан. Төсвийн нийт зарлага 13,973 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 8.2 хувиар тэлэхэд төрийн албан хаагчдын цалин, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн нь нөлөөлсөн. Улмаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 758 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

График 12. Төсвийн тэнцэл, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Гадаад худалдаа: 2024 оны байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт 27,398 сая ам.долларт хүрсэн ба нийт экспорт 15,783 сая ам. доллар, нийт импорт 11,615 сая ам.доллар хүрснээр гадаад худалдааны тэнцэл эерэг гарсан. Нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээнд хүрч, зэсийн экспорт 2024 оны сүүлийн улиралд огцом нэмэгдсэн ч хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт буурснаар экспортын орлого өмнөх оноос 3.9 хувиар өсөв. Уул уурхайн салбарын идэвхжилтэй холбоотой тоног төхөөрөмжийн худалдан авалт болон улсын төвийн хөрөнгө оруулалтын хүчин зүйлсээс хамааран импорт өмнөх оны мөн үеэс 25.6 хувиар өссөн байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2025 оны 2-р улирлын байдлаар 12,102 сая ам.долларт хүрч худалдааны тэнцэл 1,060 сая ам.долларын ашигтай гарсан. Оюу толгойн далд уурхайн олборлолтын үйл ажиллагаа тогтворжиж, зэсийн эрэлт дэлхийн зах зээл дээр өндөр түвшинд хадгалагдаж байгаа ч БНХАУ-ын коксжих нүүрсний олборлолт нэмэгдсэнээр гангийн томоохон үйлдвэрүүдийн коксжих нүүрсний эрэлт буурч нүүрсний экспортын хэмжээ буурсан, мөн дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ буурснаар экспортын орлого 2025 оны 2-р улиралд өмнөх оны мөн үеэс 16 хувиар буурч 6,581 тэрбум ам.долларт хүрсэн. Нийт импорт 2025 оны 2-р улирлын байдлаар 5,521 сая ам.долларт хүрсэн бөгөөд суудлын автомашин болон хүнсний бүтээгдэхүүний импорт өндөр хэвээр байгаа нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

График 13. Гадаад худалдааны тэнцэл, сая ам.доллароор

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2025/11/28

2025 -12- 11
БҮРТГЭВ-02

СЗХ
2025 12 25
БҮРТГЭВ
№ 01

7.3. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ[2]

Үнэлгээ: Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2019 оноос 2024 оны хооронд жилд дунджаар 37.0 хувиар өсөж 2024 оны жилийн эцсийн байдлаар 13.0 их наяд төгрөг хүрсэн. 2023 оноос эхлэн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нэмэгдсэн нь системийн нөлөө бүхий банкнуудын IPO хийсэнтэй холбоотой байна.

График 14. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Санхүүгийн зохицуулах хороо

2025 оны 2-р улирлын байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар өсөж 12.2 их наяд төгрөгт хүрлээ. Системийн нөлөө бүхий 5 банкны зах зээлийн үнэлгээ нь нийт хөрөнгийн зах зээлийн 42.8 хувийг бүрдүүлсэн байна.

Хувьцаат компани: Хөрөнгийн зах зээлд шинээр нэмж хувьцаа гаргасан болон нэмэлт хувьцаа гаргасан хуулийн этгээдийн тоо жилээс жилд аажмаар буурсан. Үүнд 2020-2021 он буюу ковидын үед эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн хөрөнгийн зах зээлийн идэвх, тэр тусмаа IPO гаргалтын тоо мэдэгдэхүйц буурсан. 2022 оноос арилжааны банкнуудын IPO нь салбарын өсөлтийг дэмжсэн. 2024 онд Эм Жи Эл Акуа ХК, Гранд Системс ХК, Тэнгэр даатгал ХК IPO хийж нээлтэй компани болсон бөгөөд түүнээс хойш 2025 оны 2-р улирлын байдлаар МХБ-д томоохон компанийн IPO хийгдээгүй байна.

График 15. Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо

ТОП 20 индекс: 2019 оноос 2024 оны хооронд жилд дунджаар 18.8 хувиар өсөж, 2024 оны эцэст 51,296,4 нэгжид хүрсэн. 2025 оны 2 сард оройн цэг болох 54,018 нэгжид

ИНВЕСКОР ЭССЭТ МЭНЭЖМЕНТ ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

Golomt Capital
Улаанбаатар хот

СЗХ 2025 -12- 25 БҮРТГЭВ

хүрсэн бөгөөд 2025 оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаар индекс 49,246.2 болоод байна. Топ-20 индексийн багцын 61.2 хувийг банк санхүү, 18.8 хувийг аж үйлдвэр, 18.4 хувийг уул уурхай, 1.6 хувийг харилцаа холбоо, тээвэр логистикийн салбарын компаниуд бүрдүүлж байна.

График 16. ТОП-20 индекс



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Арилжааны идэвх: 2025 оны 2-р улиралд 503.9 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжигдсан нь өмнөх оны мөн үеэс 40.8 хувиар буурсан үзүүлэлт юм. Нийт арилжааны 33.4 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 22.1 хувийг хувьцааны, 17.5 хувийг компанийн бондын, 15.5 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн, 11.5 хувийг Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаа тус тус бүрдүүлсэн байна.

График 17. Үнэт цаасны арилжаа, тэрбум төгрөгөөр

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7157257 9025101486

Төлөөт Капитал ҮЦК ХХК
Capital Delivering diversity
2025/11/28

7.4. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ[3]

2025 оны 2-р улирлын байдлаар нийт санхүүгийн зах зээлийн хөрөнгийн хэмжээ ойролцоогоор 93.8 их наяд төгрөгт хүрсэн. Үүнээс банкны салбарын хөрөнгө 72.6 их наяд төгрөг буюу 77.4 хувийг, хөрөнгийн зах зээл 12.16 их наяд төгрөг буюу 13.0 хувийг, ББСБ салбар 8.0 их наяд төгрөг буюу нийт зах зээлийн 8.5 хувийг, даатгалын салбар 703.0 тэрбум төгрөг буюу 0.7 хувийг, үлдсэн 380.0 тэрбум төгрөг буюу 0.4 хувийг хадгаламж зээлийн хоршооны салбар бүрдүүлсэн.

График 18. Санхүүгийн салбарын бутэц, 2025У2



Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо

2025 оны 2-р улирлын байдлаар СЗХ-ноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан нийт 573 ББСБ байна. Харин салбарын хэмжээнд харилцагчдын тоо давхардсан тоогоор 3.6 сая, зээлдэгчийн тоо 2.8 саяд хүрсэн байна.

График 19. ББСБ салбарын тоо, харилцагчдын тоо /мянган хүнээр/



Эх сурвалж: СЗХ, ББСБ салбарын тайлан 2025У2

Активын бүтэц: 2025 оны 2-р улирлын байдлаар дотоодын ББСБ-ын нийт активын хэмжээ 8.0 их наяд төгрөгт хүрсэн ба энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38.7 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 93.6 хувийг цэвэр зээлийн өсөлт бүрдүүлж байна. Тайлант хугацаанд ББСБ-уудын нийт актив **банкны салбарын**

[3] Ашигласан эх сурвалж: СЗХ, Санхүүгийн салбарын тойм

2025/11/28

нийт активын 11.0 хувьтай, нийт зээлийн үлдэгдэл 15.6 хувьтай тэнцэж байна. Салбарын нийт хөрөнгийн 98.3% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 411 ББСБ, 0.6% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 20 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 1.1 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 142 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна. Мөн хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын актив 4.6 их наяд төгрөг байгаа нь нийт активын 58.0 хувийг, нийт зээлийн үлдэгдэл 4.0 их наяд төгрөг байгаа нь нийт зээлийн үлдэгдлийн 60.0 хувийг бүрдүүлж байна.

График 20. ББСБ салбарын хөрөнгийн бүтэц, тэрбум төгрөгөөр

Эх сурвалж: СЗХ, ББСБ салбарын тайлан 2025У2

Зээлийн багц: ББСБ-ын салбарын нийт зээлийн үлдэгдэл 2025 оны 2-р улирлын байдлаар 6.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 45.4 хувиар буюу 2.1 их наяд төгрөгөөр өссөн байна. Үүнд 357.5 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулснаар цэвэр зээлийн хэмжээ 6.6 их наяд төгрөг байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хэмжээ 6.1 хувь, хугацаа хэтэрсэн зээл 3.1 хувь, хэвийн зээл 90.8 хувьтай байсан бол 2025 оны 2-р улирлын байдлаар чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь өсөж 7.7 хувь буюу 514.0 тэрбум төгрөг, хугацаа хэтэрсэн зээл 5.0 хувийг буюу 332.4 тэрбум төгрөг, хэвийн зээл 87.3 хувь буюу 5.8 их наяд төгрөг байна.

График 21. ББСБ салбарын нийт зээл, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: СЗХ, ББСБ салбарын тайлан 2025У2

Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх зээлдэгчдийн ангиллыг авч үзвэл 89.4 хувь нь иргэнд, 10.6 хувь нь хуулийн этгээдэд олгосон зээл юм. Олгосон зээлийн зориулалтын хувьд томоохон салбарууд нь 7.0 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, 2.6 хувь нь барилга, 1.4 хувь нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, 1.1 хувь нь үл хөдлөх

2025/11/28

хөөнгийн үйл ажиллагаанд олгогдсон байна. Олгосон болон төлөгдсөн зээлийн дийлэнх буюу ойролцоогоор 82 гаруй хувь нь бусад (ихэвчлэн хэрэглээний зээл) ангилалтай байна.

Хүснэгт 38. ББСБ салбарын зээлийн зээлдэгчийн ангилал

Зээлийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
Иргэнд олгосон зээл	6.9	92.9%	6.1	94.0%	6.0	89.4%
Хуулийн этгээдэд олгосон зээл	0.5	7.1%	0.4	6.0%	0.7	10.6%
Нийт	7.4	100%	6.5	100%	6.7	100%

Эх сурвалж: СЗХ, ББСБ салбарын тайлан 2025У2

Банк бус санхүүгийн салбарт финтек зээл олгодог нийт 72 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байгаа ба 2.5 сая зээлдэгчийн 1.9 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 88.5 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 28.0 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 765.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 19.8 дахин бага байна.

Хүснэгт 39. ББСБ салбарын зээлийн хэлбэрийн ангилал

	Зээлийн дүн /тэрбум төгрөг/	Эзлэх хувь	Зээлдэгчийн тоо	Эзлэх хувь	Дундаж зээл /мян.төгрөг/
Уламжлалт	4,808.7	72.0%	321,187	11.5%	14,971.8
Цахим зээл	1,866.1	28.0%	2,466,888	88.5%	756.5
Нийт зээл	6,674.9	100.0%	2,788,075	100%	2,394.1

Эх сурвалж: СЗХ, ББСБ салбарын тайлан 2025У2

Тайлант хугацаанд олгогдсон зээлүүдийг хугацаагаар нь харвал 1 сар хүртэлх хугацаатай олгогдсон зээл хамгийн их хувийг буюу 25.5 хувийг, 6-12 сарын хугацаатай зээл нийт олгогдсон зээлийн 22.3 хувийг бүрдүүлж байна. Түүнчлэн салбарын жигнэсэн дундаж зээлийн хүү сарын 3.6 хувьтай байна.

График 22. ББСБ салбарт олгогдсон зээлийн хугацаа, сараар



Эх сурвалж: СЗХ, ББСБ салбарын тайлан 2025У2

Пассивын бүтэц: 2025 оны 2-р улирлын байдлаар нийт пассив 7.98 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд эх үүсвэрийн 52.9 хувийг өөрийн хөрөнгө, 47.1 хувийг өр төлбөр

2025/11/28

СЗХ 2025 12 25 өдөр БҮРТГЭВ №01

бүрдүүлж байна. ББСБ-ын салбарын өөрийн хөрөнгийн хэмжээ 2019-2024 оны хооронд жилд дунджаар 23.8 хувийн өсөлтийг үзүүлж, 2025 оны 2-р улирлын байдлаар 4.22 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүний 46.9 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө, 47.6 хувийг хуримтлагдсан ашиг, 5.5 хувийг өөрийн хөрөнгийн бусад хэсэг бүрдүүлсэн байна.

Салбарын нийт өр төлбөр 2025 оны 2-р улирлын байдлаар 3.8 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүний 31.3 хувийг итгэлцлийн эх үүсвэр, 37.8 хувийг банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, 16.9 хувийг өрийн бичгээр татсан эх үүсвэр, үлдсэн хэсгийг бусад өр төлбөр бүрдүүлж байна.

График 23. ББСБ салбарын эх үүсвэрийн бүтэц, тэрбум төгрөгөөр

Эх сурвалж: СЗХ, ББСБ салбарын тайлан 2025У2

Ашигт ажиллагаа: 2025 оны 2-р улирлын байдлаар ББСБ-ууд нийт 1.3 их наяд төгрөгийн орлого олж, 807.2 тэрбум төгрөгийн зардал гаргаж 457.7 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Салбарын хүүгийн орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 58.4 хувь өсөж, 1.3 их наяд төгрөг болсон байна. Түүнчлэн ББСБ-ууд өрийн хэрэгсэл тулхүү ашиглах болсноос үүдэн хүүгийн зардал 77.7 хувь өсөж 298.0 тэрбум төгрөг болжээ.

График 24. Хүүгийн орлого, зардал, цэвэр ашиг, тэрбум төгрөгөөр

Эх сурвалж: СЗХ, ББСБ салбарын тайлан 2025У2

ББСБ-уудын хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 51.3 хувь өсөж 2.0 их наяд төгрөгт хүрсэн нь банк бус санхүүгийн салбарын өсөлт эрчимтэй явагдаж байгааг

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025-12-31
БУРТГЭВ-02

СЗХ
2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр
БУРТГЭВ
№ 01

харуулж байна. Тайлант хугацаанд 489 ББСБ нийт 461.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 8 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 76 ББСБ 3.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 40. Салбарын ашигт ажиллагааны харьцаа

	2024У2	2025У2	<1%	<5%	<10%	>10%
Өөрийн хөрөнгийн өгөөж ROE	**11.5%**	**12.4%**	23.7%	27.7%	22.9%	25.7%
Нийт хөрөнгийн өгөөж ROA	**6.7%**	**6.7%**	23.7%	32.3%	26.5%	17.5%

Эх сурвалж: СЗХ, Санхүүгийн салбарын тойм 2025У2

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ARS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

2025/11/28

InvesCore Growth

НАЙМ. ХБҮЦ-НЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН



8. ХБҮЦ-НЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

8.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин

Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, арилжихтай холбогдсон нийтлэг харилцааг энэ хуулиар, нарийвчилсан харилцааг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомжийн дагуу зохицуулна" гэж заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүнд хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг 2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр баталж, 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тогтоосон байдаг.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай, Компанийн тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахаас гадна дараах хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна. Үүнд:

- Иргэний хууль;
- Компанийн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль;
- Компанийн засаглалын кодекс;
- СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам;
- СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам;
- СЗХ-ны Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам;
- СЗХ-ны Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчаас зар сурталчилгаа явуулах журам;
- СЗХ-ны Үнэт цаасны зах зээлд дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам;
- МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам;
- МХБ-ийн Арилжааны журам; Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам;
- МХБ-ийн Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам;
- Холбогдох эрх бүхий байгууллагын тогтоосон бусад дүрэм, журам болон бусад хууль тогтоомж.

2025/11/28

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргагч нь тусгай зориулалтын компани байх ба тус хуульд тусгай зориулалтын компанийн үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, дүрэмд тусгагдах асуудал, хориглох болон зөвшөөрөх үйл ажиллагаа, тэдгээрийг хэрэгжүүлэх субъектийн талаар тусгайлан зохицуулсан байна. Тухайлбал, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу тусгай зориулалтын компанид хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулахыг хориглодог бөгөөд хувьцаа эзэмшигчид нь Хорооны зөвшөөрөлгүйгээр үнэт цаас гаргагчийн хувьцааг бусдад худалдах, шилжүүлэхгүй байх, Хорооны зөвшөөрөлгүйгээр компанийн дүрэмд өөрчлөлт оруулахгүй байх зэрэг зохицуулалтуудыг тусгасан байдаг. Түүнчлэн тус хуулиар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч болон оролцогч этгээдүүдэд тавигдах шаардлага, баталгаат болон барьцаат үнэт цаас гаргах оролцогчдын хоорондын эрх зүйн харилцаа, эрх үүрэг, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах асуудлуудыг тусгайлан зохицуулсан байдаг.

Мөн Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-аар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага, ТЗК-н удирдлага, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн эрх хэмжээ, ХБҮЦ гаргах тусгай зөвшөөрөл олгох, хүсэлтийг хянах, шийдвэрлэх, барьцаат болон баталгаат үнэт цаас гаргахад тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, үнэт цаасны танилцуулгад тусгах мэдээлэл, түүний агуулга, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч, аудит, хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, бүрэн эрх, үүргийг тодорхойлж, ТЗК-н мэдээлэл хүргүүлэх тухай харилцааг зохицуулж байна. Журмын 3 дугаар зүйлд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотойгоор түүний үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлага, төлөөлөн удирдах зөвлөлийн эрх хэмжээ, зарчим, үйл ажиллагааны тайлан мэдээ хүргүүлэх болон хөндлөнгийн аудит хийлгэх тухай нарийвчлан зохицуулсан байдаг.

МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-аар ХБҮЦ-ийн хөрөнгийн биржид бүртгэх бэлтгэл ажил, ХБҮЦ бүртгүүлэх хүсэлт гаргах, ХБҮЦ-ны танилцуулгын агуулга, хэлбэр, ХБҮЦ-ийн бүртгэлийн шалгуур, шаардлага, ХБҮЦ гаргагч болон үнэт цаасанд тавигдах шалгуур, шаардлага, шалгуур, шаардлагаас чөлөөлөгдөх, хөнгөлөх үндэслэл, ХБҮЦ бүртгэх, бүртгэхээс татгалзах болон ХБҮЦ гаргагчийн бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүргийг тодорхойлж, түүнтэй холбогдох харилцааг зохицуулж байна.

Үнэт цаас гаргагчийн татвар төлөх үүрэг болон хөрөнгө оруулагчийн хүүгийн орлогоос албан татвар суутган төлөхтэй холбоотой харилцааг Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон эрх бүхий этгээдээс баталсан холбогдох журам, зааврын дагуу зохицуулж байна.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК

InvesCore Growth ABS LLC

УЛААНБААТАР ХОТ

АТА16551 7167257 9025101486

2025/11/28

8.2. Үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин

Монгол Улсын хэмжээнд үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаа, зах зээлд оролцогчдод хяналт тавих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахтай холбоотой бүхий л харилцаа Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулагддаг.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрддэг болно. Үнэт цаас гаргах үйл ажиллагаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулагдахаас гадна бусад зохицуулагч байгууллагууд буюу Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж болон Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвийн холбогдох дүрэм, журмаар зохицуулагддаг. Үүнд:

Хүснэгт 41. ХБҮЦ гаргахтай холбоотой хууль, дүрэм журмууд

Зохицуулагч байгууллага	Хууль дүрэм, журам
Санхүүгийн Зохицуулах Хороо	• Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам • Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам • Үнэт цаасны бүртгэлийн журам • Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох журам
Монголын Хөрөнгийн Бирж	• Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам • Үнэт цаасны бүртгэлийн журам • Арилжааны журам • Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам • Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам • Үнэт цаас гаргагчаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар
Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв	• Үнэт цаасны хадгаламжийн журам • Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам • Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг хадгалах, биржийн бус арилжаагаар өмчлөх эрх бүртгэх журам

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулиар үнэт цаасыг гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгийн багцад тавигдах шаардлага, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, зохицуулах төрийн эрх бүхий байгууллага болон үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа явуулагч байгууллагын эрх хэмжээ, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэхтэй холбоотой үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан байдаг.

Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-д үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулдаг бөгөөд Хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 1.5 дахь хэсэгт

2025/11/28

"Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас хадгаламжийн бичиг гаргах болон бусад үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэх харилцаа нь тус тусын үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан Хорооны журмаар зохицуулагдана" гэж заасны дагуу ийнхүү тусгайлсан журмаар зохицуулагдаж байна.

Биржийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-д үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тус биржийн бүртгэлд бүртгэх, бүртгэлийн шалгуур, шаардлагыг тогтоох, бүртгэлтэй байх хугацаанд үнэт цаас гаргагчийн хүлээх үүрэг, түүнд хяналт тавих, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулдаг бөгөөд Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 1.4 дэх хэсэгт "Биржийн бусад дүрэм журамд өөрөөр заагаагүй бол хувьцаа, өрийн хэрэгслээс бусад үнэт цаас, санхүүгийн хэрэгслийг бүртгэхтэй холбоотой харилцааг тусгайлсан журмаар зохицуулна" гэж заасны дагуу тус журмаар зохицуулж байна.

8.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон хөрөнгийн багцтай холбоотой хууль эрх зүйн орчин

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаа болон үнэт цаас гаргах үйл ажиллагаанд гүйцэтгэх үүргийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулиар зохицуулж байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа нь Хорооны журам болон бусад холбогдох хууль, дүрэм журмаар зохицуулагддаг.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааг зохицуулахтай холбогдох дараах хууль, дүрэм журмууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнд:

- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль;
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль;
- Иргэний хууль;
- Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль;
- Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль;
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль;
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль;
- Зээлийн мэдээллийн тухай хууль;
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам;
- Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам;
- Мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам;
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам;
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам;
- Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам;
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам;
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам;
- Үл хөдлөх хөрөнгө барьцаалуулагчид мэдээлэл өгөх журам;

- Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам;
- Гүйлгээнээс илэрсэн хуурамч мөнгөн тэмдэгтийг хүргүүлэх, бүртгэх, хадгалах, устгах журам;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам;
- Бусад.

8.4. ИНВЕСКОР ӨСӨЛТ ХБҮЦ-тай холбоотой үйл ажиллагааны зохицуулалт:

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаанд мөрдөх дараах журмуудыг Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 25/2-8 тоот тогтоолоор батлсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам

Тус журамд хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотойгоор үүсгэн байгуулагдсан төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан. Журамд зааснаар ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлыг Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээний үндсэн дээр ТЗК-ийн үүсгэн байгуулагч гүйцэтгэнэ. Түүнчлэн ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрх, зохион байгуулалт, ТУЗ-ийн гишүүний ажлын нөхцөл, хангамж зэргийг дэлгэрэнгүй оруулж өгсөн байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам

Тус журамд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх харилцааг зохицуулсан.

Компани нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.3-т зааснаар "Инвескор ББСБ" ХК-ийн охин компани болохын хувьд "Инвескор ББСБ" ХК-ийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой дотоод хяналтын хөтөлбөр, дүрэм, журам, зааврыг мөрдөн ажиллана.

Түүнчлэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд ХБҮЦ гаргах ажиллагаанд оролцогч талуудаас Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг дагаж, мөрдөж ажиллахыг шаардах, шаардлагатай тохиолдолд талуудаас мэдээлэл, тайлан, баталгаа гаргуулан авах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
Энэхүү журмын дагуух чиг үүргийг ТУЗ-өөр дамжуулан хэрэгжүүлэх бөгөөд ТУЗ нь бодлогын баримт бичиг, дотоод дүрэм, журам батлах, эрсдэлийн түвшинтэй уялдуулан дотоод хяналтын хөтөлбөрийг шинэчлэх, эрсдэл үүссэн тохиолдолд арилгах, бууруулах арга хэмжээ авах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам

Тус журамд хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол болон тухай бүр хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан.

2025/11/28

Компани нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдийг мэдээллээр хангах тал дээр ижил, тэгш хандах, үйл ажиллагаандаа нээлттэй, ил тод зарчмыг баримтлах ба хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчтэй харилцах, хууль тогтоомжийн дагуу тогтмол мэдээ, мэдээллийг хүргэх нөхцөлийг бүрэн хангаж ажиллах ба Үнэт цаасны тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Хороо, Биржээс батлагдсан холбогдох журамд заасны дагуу мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, ашуулгын хувьд хоёрдмол утгагүйгээр, бүрэн гүйцэт мэдээлэх үүрэгтэй.

Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам

Тус журамд хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч этгээдүүдэд тавигдах шаардлага, шалгуур, гэрээ байгуулах, тэдгээрийг солих болон гэрээ цуцлахтай холбоотой харилцааг зохицуулсан. Компани нь эдгээр үйл ажиллагаанд Хороо, Биржээс батлагдсан холбогдох журам болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг баримтлан ажиллана.

Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам

Тус журамд ТЗК-аас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгийн багц дахь зээлүүдийн төлбөрийг цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр төлөхтэй холбоотойгоор ТЗК, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулсан.
Уг журмаар төлбөр цуглуулах данснаас гарах гүйлгээ, ХБҮЦ болон ТЗК-аас гарах бусад зардлын дараалал, тэдгээрт оролцох, хяналт тавих талуудын оролцоог журамлажээ.

Хөрөнгө итгэмжлэн удирдах журам

Тус журамд компанийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болох зээлийн хөрөнгийн багцад буй хөрөнгийг солих, нэмэх, хасах замаар багцад өөрчлөлт оруулахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад оролцогчтой холбоотой харилцааг зохицуулсан.
Журмаар хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах нөхцөл, дараалал, түүнчлэн сул чөлөөтэй эх үүсвэрийн удирдлага, хариуцлага зэргийг заасан ба хавсралтаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгч рүү хөрөнгө буцаан худалдах үед үйлдэх “Хөрөнгө буцаан худалдах тухай мэдэгдэл”-ийг баталжээ.

Эрсдэл сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, дотоод хяналтын журам

Тус журамд ТЗК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль, журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан байна.
ХБҮЦ-ны төлбөр төлөхтэй холбоотой учирч болох эрсдэлийг дараах байдлаар 3 ангилах ба эдгээр нь:

- Зээлтэй холбоотой эрсдэл
- ХБҮЦ гаргах үйл ажиллагаанд оролцогч талуудтай холбоотой эрсдэл
- Бусад гаднын хүчин зүйлстэй холбоотой эрсдэл.

2025/11/28

Журмаар эдгээр эрсдэлийг удирдах арга хэмжээ, эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээ, сонирхлын зөрчил, тэдгээрийг мэдэгдэх тухай харилцааг мөн зохицуулсан байна.

Тусгай зориулалтын компанийг татан буулгах журам

Тус журамд Тусгай зориулалтын компани нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэсний дараа компанийг татан буулгахтай холбоотойгоор ТЗК, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулсан байна. Журам нь ТЗК-ийг татан буулгах нөхцөл, бэлтгэл ажлыг хангах, татан буулгахтай холбоотой үйл ажиллагаа, оролцогч талуудын хариуцлага зэргийг тодорхойлсон байна.

2025/11/28

InvesCore Growth

ЕС. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ



9. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ

9.1. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нь МХБ-ийн ТУЗ-ийн 2020 оны 2-р сарын 07-ны өдрийн 2020/06 дугаар тогтоолоор баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам, СЗХ-ны 2022 оны 6-р сарын 22-ны өдрийн 360 дугаар тогтоолоор батлагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам, МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10-р сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам болон 2012 оны 02-р сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан Арилжааны журмын дагуу явагдана.

Үнэт цаас гаргагчийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн ТУЗ-ийн 25/2-5 тоот тогтоолын дагуу 500,000 ширхэг Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй "Инвескор Өсөлт" Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд танилцуулах үйл ажиллагааг МХБ болон СЗХ үнэт цаасыг бүртгэсэн өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг ажлын 5 хоногийн дотор хүлээн авна.

Схем 8. Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө

Анхдагч зах зээлийн арилжих арга

"Монголын хөрөнгийн биржЖ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-д заасны дагуу үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнэ (өгөөж)-ээр санал болгох ба захиалга 100 хувь биелсэн тохиолдолд анхдагч зах зээлийн арилжааг хаана.

Үнэт цаасыг бүртгүүлж, холбогдох зөвшөөрөл авах

Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгох үнэт цаасыг бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг СЗХ болон МХБ-д гаргах бөгөөд эдгээр эрх бүхий байгууллагуудаас үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно.

Олон нийтэд танилцуулах

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
InvesCore FI

СЗХ
2025 -12- 25
БҮРТГЭВ
01

Үнэт цаасыг анхдаг зах зээлд санал болгох тухай мэдэгдлийг СЗХ-нд хүргүүлснээс хойш 3-аас доошгүй өдрийн дараа үнэт цаасыг нийтэд санал болгон танилцуулах аяныг зохион байгуулна. Үүнд хөрөнгийн зах зээлийн оролцогч, олон нийтэд зориулсан танилцуулга уулзалт болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэт цаасыг танилцуулах, мэдээ мэдээлэл зэрэг нь багтана.

Анхдагч зах зээлийн арилжааны захиалга хүлээн авах

Үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс ажлын 3-с доошгүй хоногийн өмнө анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх мэдэгдлийг СЗХ-нд хүргүүлснээр анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авах болно. Анхдагч зах зээлийн захиалгыг Биржийн гишүүн бүх үнэт цаасны компаниар дамжуулан авна.

9.1.1. Үнэт цаасны арилжаанд оролцох, захиалга авах заавар

Схем 9. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцох заавар



Үнэт цаас худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нь анхдагч зах зээлийн арилжаанд дараах зааврын дагуу оролцоно.

Мөнгөн хөрөнгө байршуулах заавар

Үнэт цаас худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь өөрийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгэлтэй дансанд мөнгө байршуулна.

Дансны нэр:	Таны өөрийн нэр
Дансны дугаар:	**** **** **** /Брокероос авах/
Банкны нэр:	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
Гүйлгээний утга:	Нэр, Регистрийн дугаар, Инвескор Өсөлт ХБҮЦ

Арилжааны шимтгэл

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон үнэт цаасны компанид төлөх ба уг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын болон үнэт цаасны компаниудын шимтгэлийн нийт дүн багтсан байна. Үнэт цаасны компаниудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг анхаарна уу.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

2025/11/28

9.1.2. Албан татвар

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч буюу Монгол Улсад байрладаг хувь хүн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.4-т заасан орлого (хүүгийн орлого)-ын нийт дүнгээс тус хуулийн 21.5-т заасан 5 хувийн хэмжээгээр татвар суутгана.

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч Монгол Улсад байрладаг хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.6.3-т заасан (хүүгийн орлого) нийт дүнгээс тус хуулийн 20.2.5-т заасан 5 хувийн хэмжээгээр татвар суутгана. Гадаад улсын иргэн, хуулийн этгээд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу татвар төлөх үүрэг хүлээх бөгөөд тухайн харьяаллын улстай давхар татварын гэрээ байгуулсан эсэх болон гэрээний нөхцөлийг судлан үзсэний үндсэн дээр хөрөнгө оруулахыг зөвлөж байна.

9.1.3. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Үнэт цаасыг анх удаа нийтэд санал болгох ажиллагаа амжилттай болсон тохиолдолд МХБ-ийн журмын дагуу СЗХ-ны зөвшөөрлөөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр үнэт цаасыг анхдагч зах зээлээс худалдан авсан хөрөнгө оруулагчид үнэт цаасыг бусдад худалдаалах эрх нээлттэй болно.

9.1.4. Үнэт цаасны эргэн төлөлт, хүүгийн төлбөр

Үнэт цаасны эргэн төлөлтийн эх үүсвэр нь ТЗК-д шилжсэн 61.1 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлтөөс бүрдэнэ.

9.1.5. Үнэт цаас эзэмшигчийн эрх, үүрэг

Үнэт цаас эзэмшигч нь дараах эрхтэй байна:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг МХБ-ийн арилжааны журмын дагуу худалдан авснаар үнэт цаасыг эзэмших, түүнийг шаардах эрхтэй;
- Эзэмшиж буй үнэт цаасыг чөлөөтэй арилжих, захиран зарцуулах (үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй болно);
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүү болон үндсэн төлбөрийг хуваарийн дагуу хүлээн авах, төлбөрийг хуваарийн дагуу төлөхийг үнэт цаас гаргагчаас шаардах;
- Үнэт цаас эзэмших эрхээ чөлөөтэй арилжаалах, захиран зарцуулах;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас эзэмшиж буй хугацаанд Үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийг хүлээн авах, шаардах, танилцах;
- Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулгад тусгасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол биелүүлэхийг шаардах;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан үндэслэлээр хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг буцаан худалдах санал гаргах;
- Бусад тохиолдолд Үнэт цаас эзэмшигч нь үнэт цаас худалдах, худалдан авах эрхээ өөрийн харьцдаг брокер, дилерийн компаниар дамжуулан захиалга өгөх замаар хэрэгжүүлнэ.
- Хууль тогтоомжид заасан бусад.

2025/11/28

9.1.6.Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг

Үнэт цаас гаргагч нь дараах эрх үүрэгтэй байна.

- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хүү болон үндсэн төлөлтийн график, схемийн дагуу төлбөрийг хуваарийн дагуу төлөлт хийж барагдуулах;
- Үнэт цаас гаргагч нь зохицуулах байгууллагуудын тогтоосон хүүгийн орлогын татварыг зохих хуулийн дагуу суутган үнэт цаас худалдан авагчид шилжүүлж, татварын төлбөрийг төсөвт төлөх, тайлагнах;
- Үнэт цаасны танилцуулга болон хууль, журмыг зөрчиж Үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг Үнэт цаас гаргагч нь үл маргах журмаар нөхөн барагдуулах;
- Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой аливаа үйл явцын мэдээллийг ТЗК-н баталсан хууль журмын дагуу Үнэт цаас эзэмшигчдэд болон эрх бүхий байгууллагад мэдээлэх;
- Хууль тогтоомж, энэхүү үнэт цаасны танилцуулгад заасан үндэслэлээр хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцон буцаан худалдах;
- Бусад хууль тогтоомж, гэрээнд тусгагдсан эрх, үүргийг хүлээнэ.

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 12 31
БҮРТГЭВ-02

СЗХ
2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр
БҮРТГЭВ
№ 01

9.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ТАНИЛЦУУЛАХ, МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад мэдээлэл хүргэхдээ Үнэт цаас гаргагчийн Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журмыг баримтлах бөгөөд тус журам нь Үнэт асны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон МХБ-ээс гаргасан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны *бүртгэлийн журамд нийцсэн байна.*

Хүснэгт 42. Үнэт цаас эзэмшигчдэд тайлан мэдээлэл түгээх нь

Давтамж	Тайлагнах хугацаа	Тайлагнах мэдээлэл
Мэдээлэлд өөрчлөлт орсон бол	Дараа сарын 10-ны дотор хүргүүлнэ. Ингэхдээ СЗХ болон үнэт цаас эзэмшигчдэд цахим хэлбэрээр мэдээлнэ.	Төлбөр, зарлага, хөрөнгө оруулагчдад төлөх үнэт цаасны эргэн төлөлтөөс бусад хөрөнгө, хөрөнгө оруулалтаас олсон орлогын зарцуулалт, хөрөнгийн багцын мэдээлэл, тэдгээрийн шинж байдал, хөрөнгийн багцад нэмэгдсэн, хасагдсан хөрөнгө, нэмэх хасах болсон үндэслэл, шалтгаан, үнэт цаасны жигнэсэн дундаж хүү, эргэн төлөгдөх нөхцөл, үлдэгдэл хөрөнгийн тоо хэмжээ, төлөгдөөгүй хөрөнгийн үлдэгдэл болон зээлийн харьцаа, төлөгдсөн үндсэн зээл, үндсэн төлбөр, баталгаат үнэт цаасны үлдэгдэл, бэлэн мөнгөний төвлөрсөн хэмжээ, түүний ашиглалт, санхүүгийн үзүүлэлт, тоо баримтууд, улирлын санхүүгийн тайлан, хууль тогтоомж, энэ журам, ТЗК-ийн дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу мэдээлэх бусад.
Улирал тутам	Улирал бүрийн эхний сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ. Ингэхдээ СЗХ болон МХБ-д цахимаар, болон олон нийтэд биржийн цахим хуудсаар дамжуулан хүргэх бөгөөд компанийн цахим хуудсанд мөн тайлагнана.	Багцын хөрөнгө, мөнгөн урсгалын хөдөлгөөн, үнэт цаасны төлбөр, тооцоотой холбоотой Хороо болон хөрөнгө оруулагчдад хүргүүлсэн улирал тутмын тайлан, мэдээлэл зэрэг хамаарна.
Хагас жил тутам	СЗХ болон МХБ-д дараа сарын 20-ны дотор тайлагнана. Ингэхдээ МХБ, СЗХ-д бичгээр болон олон нийтэд биржийн хуудсан дээр мөн компанийн цахим хуудсанд тайлагнана.	Хагас жилийн санхүүгийн тайлан, Хөрөнгийн багцын үлдэгдэл, хугацаандаа болон хугацаа хэтэрч төлөгдсөн үндсэн төлбөрийн хэмжээ, хугацаанаасаа өмнө төлөгдсөн үндсэн төлбөрийн хэмжээ, хугацаа хэтэрсэн хөрөнгийн хэмжээ, хөрөнгө болон ХБҮЦ-ны санхүүгийн нөхцөлд нөлөөлөхүйц бусад мэдээлэл.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ETS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101466

Голомт Капитал ТЗК ХХК
Golomt Capital
Delivering Diversity
1119209111 5481589
Улаанбаатар хот

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
InvesCore FI
2025 12 31
БҮРТГЭВ 03

СЗХ
2025 . 12 . 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Жил тутам	СЗХ болон МХБ-д 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор бичгээр болон цахимаар, олон нийтэд биржийн цахим хуудсаар дамжуулан хүргэх бөгөөд компанийн цахим хуудсанд түгээх үүрэгтэй.	Жилийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, ҮЦТ-д заасан хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайлан, хөрөнгийн багцад бүртгэгдсэн хөрөнгийн 5-аас дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн үүрэг гүйцэтгэгч, зээлийн баталгаа гаргагчийн сүүлийн тайлангаас гарсан баталгаат үнэт цаас болон үүсгэн байгуулагчид мэдэгдсэн мэдэгдэл, санхүүгийн баримтын талаарх мэдээлэл, компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан, гарсан шийдвэрүүд, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл.
Тухай бүр тайлагнах	Холбогдох шийдвэр, өөрчлөлт гарсан, эсхүл тухайн үйл явдал болсноос хойш ажлын 3 хоногийн дотор цахимаар мэдээлнэ.	Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийн мэдээлэл, төлбөрийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсэх, хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд түүний шалтгаан, авах арга хэмжээний тухай; Хөрөнгийн багц, барьцааны зүйлийн нийт үнийн дүнгийн 10 хувь буюу түүнээс дээш хэмжээтэй өөрчлөлт орох;
	ТЗК нь дараах мэдээллийг дараа улирлын 20-ны өдрийн дотор, өөрчлөлт орсон бол ажлын 3 хоногийн дотор тухай бүр Хороо болон хөрөнгө оруулагчид цахим хэлбэрээр мэдээлэх бөгөөд хагас жилийн болон жилийн эцсийн мэдээллийг Хороонд бичгээр ирүүлнэ	Бүртгэлтэй үнэт цаастай холбоотой аливаа өөрчлөлт (ХБҮЦ-ны нөхцөл, төлбөрийн хуваарь өөрчлөгдөх, гаргасан ХБҮЦ-ыг хугацаанаас нь өмнө буцаан дуудах, нэмэлт үнэт цаас гаргах гэх мэт)-ийн талаарх мэдээлэл; Бүртгэлтэй ХБҮЦ-ны 10 хувиас дээш үнийн дүн бүхий буцаан дуудсан, эргүүлэн худалдаж авсан үнэт цаасны мэдээлэл, цаашид 5 хувиар өөрчлөгдөх тутамд; ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, дүрэм, журам, хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, холбоо барих хаяг, байршил, утас зэрэгт өөрчлөлт орох;
	Биржийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 9.7.2-д заасан мэдээлэлд өөрчлөлт орсон бол Биржид тус тус өөрчлөгдсөн тухай бүр ажлын 3 хоногт багтаан мэдэгдэнэ.	Үнэт цаас эзэмшигчдийн эрхэд өөрчлөлт оруулах, компанийн дүрэм, холбогдох гэрээ, журамд тэдгээрийн эрх ашигт нөлөөлөх нэмэлт өөрчлөлтийг тусгах; Үнэт цаас эзэмшигчдийн хурал зохион байгуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд хурал хуралдуулах тухай шийдвэр, хурлын мэдэгдэл, хурлаас гарсан шийдвэр; ХБҮЦ-ны харилцаанд оролцогч этгээд солигдох, бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөх, түүнтэй байгуулсан гэрээнд өөрчлөлт орох; Төлбөрийн чадваргүй болох, эсхүл бусад байдлаар шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэнтэй холбоотой мэдээлэл; Эрх бүхий байгууллагаас ХБҮЦ гаргагчид авсан арга хэмжээний тухай;

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

Голомт Капитал
111209111—5031589
Улаанбаатар хот

2025/11/28

Үнэт цаас эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын шийдвэр, ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаа, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх, зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэлд хамаарах бусад мэдээллүүд.

Биржээс хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах буюу зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай гэж үзсэн бүх төрлийн мэдээлэл

Бүртгэлийн журмыг зөрчсөн байж болзошгүй үйлдлийг шалгах болон тус журмыг дагаж мөрдүүлэх зорилгоор Биржээс шаардсан бусад мэдээлэл, тайлбар

Компанийн дүрэмд Хорооны зөвшөөрлөөр өөрчлөлт оруулах бөгөөд өөрчлөлт оруулсан дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, мэдээлнэ.

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, ТУЗ-ийн дарга гишүүдэд өөрчлөлт оруулсан бол мэдээлнэ.

Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журмын тухай

“Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-д заасны дагуу Үнэт цаас гаргагч нь мэдээлэл хүргэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам” Монголын хөрөнгийн биржийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам” болон холбогдох бусад журамд заасны дагуу мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэт мэдээлэх үүрэгтэй гэж заасан. Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь энэхүү Журамд заасан мэдээллийг Монгол хэл дээр хүргэх ба мэдээллийг олон нийт болон хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид өөрийн болон Биржийн цахим хуудсаар хүргэнэ. Шаардлагатай гэж үзвэл гадаад хэл дээр мэдээллийг давхар хүргэж болно. “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-ыг хавсралтаас дэлгэрэнгүй үзнэ үү.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

2025/11/28

9.3. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь бусад төрлийн өрийн хэрэгсэлтэй харьцуулахад харьцангуй эрсдэл багатайд тооцогддог. Учир нь үнэт цаасжуулах үе шат болон үнэт цаасны эргэн төлөлтийг хянах, шийдвэрлэх процесс нь илүү олон оролцогч талын хяналт, байнгын оролцоо, хууль эрхзүйн зохицуулалттай байдгаараа онцлог юм. Гэвч хөрөнгийн багц буюу тусгаарласан зээлийн багцын эргэн төлөлт муудах, зээлдэгч зээлийг урьдчилж төлснөөр орлогын таамаг өөрчлөгдөх, энэ нь ТЗК-ийн мөнгөн урсгалын удирдлагад хүндрэл учруулах зэрэг эрсдэл үүсэж болзошгүй байдаг.

Үнэт цаас гаргагчийн зүгээс эдгээр болон үйл ажиллагаанд тулгарч болзошгүй олон төрлийн эрсдэлийг бууруулах зорилгоор "Эрсдэл сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам" болон бусад журмуудыг баталсан байна. Тус журамд ТЗК-ийн ХБҮЦ гаргах, үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдох дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэл бууруулах, сонирхлын зөрчлийг илрүүлэх арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан байна.

Андеррайтерын зүгээс хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд дараах төрлийн эрсдэлүүд учирч болзошгүй хэмээн үзэж, эрсдэлийн удирдлагын арга замын тодорхойлов. Үүнд:

Хүснэгт 43. ХБҮЦ-ны хүрээнд учирч болзошгүй эрсдэлүүд

Эрсдэлийн тодорхойлолт	Эрсдэлийн удирдлага
Зээлийн багцын эрсдэл	
• Зээлийн багцад байгаа зээлдэгчид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үүсэх эрсдэлийг ойлгоно. Үүнд зээлдэгч зээлийн хугацаа хэтрүүлэх, төлбөрийн чадваргүй болох, эрх зүйн чадамжгүй болох, нас барах, сураггүй алга болсон нь шүүхийн шийдвэрээр тогтоогдох зэрэг багтана. • Мөн зээлийн багц төвлөрөл өндөр байх, барьцаа хөрөнгийн үнэлгээ бага, өр орлогын харьцаа өндөртэй зээлүүд	• Инвескор өсөлт ТЗК-ийн багцалж буй зээлийн багц нь нийт 1,672 зээлдэгчийн 61.09 тэрбум төгрөгийн үлдэгдэл бүхий автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн багц юм. Нэг зээлийн дундаж хэмжээ 36.5 сая төгрөг. Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.7%, жигнэсэн дундаж хугацаа 57.2 сар бөгөөд зээлүүдийн дуусгавар болох хугацаа нь хоорондоо харилцан адилгүй. • ХБҮЦ нь 18 сарын хугацаатай байхаар санал болгож байгаа тул зээлийн багцын жигнэсэн дундаж хугацаанаас бага, түрүүлж төлөгдөх юм. Хэдийгээр багцалсан зээлийн багцын хугацаа санал болгож буй ХБҮЦ-ийн хугацаанаас урт байх нь оновчтой байдаг хэдий ч хэт их хугацааны зөрүү, урт хугацаатай зээлүүд нь сарын дундаж эргэн төлөлт бага буюу мөнгөн урсгал хангалтгүй байх эрсдэлийг үүсгэж болно. • Дунджаас дээш дүнтэй нийт 528 ширхэг зээл байгаа нь 40.6 тэрбум төгрөг буюу нийт зээлийн багцын 66.4%. Үүнээс харахад зээлийн багц нь төвлөрөл өндөртэй багц байх боломжтой байна.

2025/11/28

байх зэрэг эрсдэл байж болно. • Мөн хугацаанаас өмнө эргэн төлөгдөх эрсдэл буюу зээлдэгч зээлээ хугацаанаас өмнө төлж, хүлээгдэж байсан хүүгийн орлого буурах, хаагдах эрсдэл хамаарна.	• Зээлийн гэрээнд өөрчлөлт орсон тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид мэдэгдэх бөгөөд тус өөрчлөлт нь шалгуур үзүүлэлтэд нийцэхгүй тохиолдолд зээлүүдийг зээлийн багцаас хасаж, шалгуур хангах зээлээр солих эсхүл буцаан худалдах нөхцөлтэй. • Хугацаа хэтэрсэн зээл дээр үйлчилгээ үзүүлэгч талаас зээлийг эргэн төлүүлэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгчийн дотооддоо мөрдөж буй холбогдох заавар журмын хүрээнд үйлчилгээг авч, хяналт тавьж ажиллана. • Зээл хугацаанаас өмнө эргэн төлөгдөх эрсдэл үүссэн тохиолдолд хөрөнгийн багцад хөрөнгө нэмэх арга хэмжээ авна. • Зээл хугацаа хэтэрсэн тохиолдолд зээлийн шалгуур хангахгүй болсонд тооцож, зээлийг багцаас хасаж, шалгуур хангасан шинэ зээлээр солих, эсхүл Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана.
Мөнгөн урсгалын эрсдэл	
• Зээлдэгчдийн орлогын өөрчлөлт, зах зээл дээрх хүүгийн хөдөлгөөнөөс үүдэн зээлийн багц гэрээнд заасан хуваарьт төлбөрөөс өмнө эргэн төлөгдөж болдог. Үүнээс үүдэн тухайн зээлээс хүлээж байсан хүүгийн орлого буурах, зогсох, мөнгөний тооцоолгүй сул эх үүсвэр үүсэх, тухайн шинээр байршуулсан эх үүсвэрийн өгөөж өмнөхөөсөө буурах зэрэг нөлөө үзүүлж болдог. • Зээлийн багцын хугацаа хоцорч болон түрүүлж төлөгдөх нь оролцогч талуудын үйл ажиллагааны процессыг нэмэгдүүлж, тухайн бүр тооцооллоо шинэчлэх шаардлагагыг үүсгэдэг.	• Хөрөнгийн багцын зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.7% буюу хэрэглээний бусад зээлтэй харьцуулахад хүү багатайд тооцогдоно. Бодлогын хүү буурах, бусад өртөг багатай зээлийн сонголт гарч ирэх үед зээлдэгчид шинэ зээлээр хуучин зээлээ төлж хаах эрсдэл үүсдэг. Монгол банкны Мөнгөний бодлогын хорооны 2025 оны 9-р сарын ээлжит хурлаар мөнгөний бодлогын хатуу бодлогыг үргэлжлүүлж, бодлогын хүүг 12% хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн. Иймд ойрын хугацаанд хүүгийн түвшин эрчтэй буурах, түрүүлж төлөх нөхцөл бүрдэх эрсдэл харьцангуй бага байна. Зээлийн багцын хүү бусад төрлийн зээл, зээл олгогчтой харьцуулахад харьцангуй бага, эсвэл хугацаа богино үед уг эрсдэл харьцангуй бага учирна. • Түүнчлэн зээл хугацаанаас өмнө эргэн төлөгдөж, сул мөнгөн хөрөнгө үүссэн тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор сул мөнгөн дүнгээр шинэ зээлийн багц худалдан авах боломжтой гэж үзсэн, анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон бол багцыг нэмэгдүүлэх тухай заалтыг холбогдох дотоод журам болон гэрээгээр зохицуулжээ.

2025/11/28

Барьцаа хөрөнгийн эрсдэл	
• Тааварлаагүй хүчин зүйл, осол гэмтэл, байгалийн гамшиг зэргээс үүдэн хөрөнгийн багцад байгаа зээлийн фидуциар барьцаалсан хөрөнгөд хохирол, эвдрэл учрах, зах зээлийн үнэлгээ унах зэрэг эрсдэлийг ойлгоно.	• Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-нд тусгасны дагуу зээлийн багцын эргэн төлөлт болон үнэт цаасны эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллана. Шаардлагатай тохиолдолд Хөрөнгийн багц дахь зээлийг нэмэгдүүлэх, шаардлага хангаагүй зээлүүдийг солих, анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах арга хэмжээ авна. • Зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангах үл хөдлөх эд хөрөнгө, газрын эрхийн барьцааг баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг бүртгэсэн тухай Хорооны шийдвэрийг үндэслэн холбогдох улсын бүртгэлд барьцааны тухай "тусгай тэмдэглэл" хийлгэнэ. Бусад хөдлөх эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны цахим мэдээллийн санд бүртгүүлнэ.
Макро орчны эрсдэл	
• Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, ХБҮЦ, ТЗК, оролцогч талуудад тавигдах шаардлагатай холбоотой хууль, журам, зохицуулалт өөрчлөгдөж болно. • Монгол улсын макро эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн зээлдэгчдийн зээл авах эрэлт, зээлийн ачаалал даах чадамж өөрчлөгдөх, хүүгийн түвшин өөрчлөгдсөнөөс эх үүсвэрийн дутагдал үүсэх зэрэг макро орчны эрсдэл үүсэж болно.	• 2025 онд Fitch агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "B+, Тогтвортой" төлөвт хэвээр хадгалсан бол 2025 оны 10-р сарын 16-ны өдөр Moody's агентлаг үнэлгээгээ нэг шат ахиулж "B2, Тогтвортой"-гоос "B1, Тогтвортой" болгон сайжруулсан юм. Мөн S&P агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг ахиулж, өмнөх "B+, эерэг" үнэлгээг "BB-, Тогтвортой" болгон сайжруулснаа энэ оны 10-р сарын 30-нд зарласан.[4] Эдгээрийн голлох хүчин зүйл нь 2024 оноос эхлэн нүүрсний үнийн уналт үргэлжилж байгаа хэдий ч зэс, алт, газрын ховор элементийн хайгуул болон олборлолт нэмэгдсэнээр уул уурхайн салбарын орлого төрөлжих боломжтой гэж үзсэн явдал байв. • Гэвч төсвийн тэлэлт, иргэдийн хэт хэрэглээнээс үүдсэн эрэлтийн шинжтэй инфляц өнгөрсөн онд өндөр гарсан ба 2025-2026 онуудад ч инфляцын түвшин Монгол банкны зорилтоос давах хүлээлттэй байна. Инфляц өсөх нь өрхийн секторын бодит худалдан авах чадвар буурах, өрхийн зарлага орлогоосоо давах зэрэг эдийн засгийн сөрөг нөлөөтэй ба цаашлаад банк, банк бус санхүүгийн байгууллагын иргэдэд олгох зээлийн чанарт шууд нөлөөлнө.

[4] Эх сурвалж: Засгийн газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газар

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

СЗХ
2025 оны 12 сарын 25-нөөр
БҮРТГЭВ
№ 01

	• Харин хууль эрхзүйн талаас, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулиар үнэт цаасыг гаргах үйл ажиллагаатай холбоотой хөрөнгийн багцад тавигдах шаардлага, үнэт цаас гаргах үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, зохицуулах торийн эрх бүхий байгууллага болон үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа явуулагч байгууллагын эрх хэмжээ, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэхтэй холбоотой үйл ажиллагааг тусгайлан зохицуулдаг. Иймд тухайн хуульд гарсан аливаа өөрчлөлт, шаардлагыг дагаж мөрдөж ажиллах шаардлагатай. • ТЗК-ийн ТУЗ-ийн хурал хуралдаж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ, үр нөлөөтэй холбоотой хөндлөнгийн байгууллага, хуулийн фирмийг хөлслөн ажиллуулах, зохицуулагч эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулж ажиллана. • Давагдашгүй хүчин зүйл бий болсон тохиолдолд энэ тухай Үнэт цаас эзэмшигчдэд тухайн брокерын компаниар дамжуулан бичгээр мэдэгдэх, ТЗК болон Биржийн цахим хуудсаар мэдээлнэ. • Давагдашгүй хүчин зүйлийн улмаас ТЗК нь Үнэт цаас эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй нь хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөх ч үндсэн үүргээс чөлөөлөхгүй. Давагдашгүй хүчин зүйлийн үед ТЗК ийн үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
Салбарын эрсдэл	
• Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаа эрхэлж буй салбар буюу банк бус санхүүгийн байгууллагын салбар нь сүүлийн жилүүдэд өндөр өсөлт үзүүлсэн салбар юм. Тэр хэрээр зах зээлийн өрсөлдөөн өндөр байх, зах зээлд эзлэх хувь хэмжээгээ	• СЗХ-ээс гаргасан салбарын тоон үзүүлэлтээр, 2025 онд 3 дугаар улирлын байдлаар 577 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байсан нь өнгөрсөн оны мөн үеэс 4.0 хувиар өссөн үзүүлэлт юм. Салбарын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 32.9% өсөж, 8.5 их наяд төгрөгт хүрсэн нь банк бус санхүүгийн салбарын зээлийн эрэлт, зээлийн өсөлт өндөр хэвээр байгааг харуулж байна. [5] • 2025 оны 3-р улирлын байдлаар салбарын хэмжээнд чанаргүй зээлийн эзлэх хувь 8.9%, хугацаа хэтэрсэн зээлийн хувь 4.7%, хэвийн

[5] Эх сурвалж: СЗХ, Санхүүгийн салбарын тойм, 2025У3

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

Төлөөт Капитал ҮЦК ХХК
Capital
Delivering diversity
1119209111 ● 3481509
Улаанбаатар хот

2025/11/28

алдах, ашигт ажиллагаа буурах эрсдэлтэй. • Түүнчлэн салбарын хэт өндөр өсөлт нь найдваргүй зээл гарах, зээлийн багц чанаргүйдэх, нэг зээлдэгчийн зээл даах чадамж хэтрэх зэрэг эрсдэлийг дагуулдаг. • Иргэдийн санхүүгийн чадамж буурах, зээлийн ачаалал хэтрэх, найдвартай зээлийн багц гаргах нөхцөл боломж буурах нь ХБҮЦ-ээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн үр ашгийг бууруулах эрсдэлтэй.	зээл 86.4% байсан. Энэ нь салбарын өндөр ашигт ажиллагаа нь шинэ тоглогчдыг зах зээлд ихээр татаж, өрсөлдөгчдийн тоо нэмэгдсэн, давхар зээлтэй иргэдийн тоо өссөн зэрэг нь зээлийн чанарт сөргөөр нөлөөлж эхэлснийг харуулж байна. • Салбарын хувьд зээлийн эрсдэлийн сангийн харьцаа 110% буюу байгуулбал зохих эрсдэлийн сангаас өндөр дүнгээр байгуулсан. Гэвч компанийн дампуурах магадлалыг харуулдаг Z индекс шалгуур буурах трендтэй байгаа, нийт хөрөнгийн өгөөжийн стандарт хазайлт өсөлттэй байгаа нь салбарын компаниудын үзүүлэлт харилцан адилгүй буюу санхүүгийн эрсдэл нэмэгдсээр байгааг илтгэнэ.
Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэл	
• Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь төлбөрийн чадваргүй болох, дампуурах, татан буугдах нөхцөл үүсэх • Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэх, солих, буцаан худалдах үед гэрээ болон холбогдох журмаар тохирсон үүргээ биелүүлэхгүй байх, хугацаа хоцроох • Нэмэгдүүлсэн, сольсон хөрөнгө нь гэрээгээр тохирсон зээлийн багцын шалгуурыг хангахгүй байх.	• Хөрөнгө итгэмжлэн удирдах журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан зээл шилжүүлсэн эрсдэл үүссэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгийн багцыг солихыг шаардах, ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу эрсдэлийг удирдана. • 2025У3 байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нийт 604.6 тэрбум төгрөгийн зээлийн багц байгаагаас 129.7 тэрбум төгрөгийн багц нь автотээврийн хэрэгслийн зээл, 5.2 тэрбум төгрөгийн багц нь үл хөдлөх эд хөрөнгө худалдан авахад зориулсан зээл байна. Харин хөрөнгийн багцыг багцалсны дараа ойролцоогоор 68.5 тэрбум тэрбум төгрөгийн багц үлдэх ба үнэт цаасаар татан төвлөрүүлсэн эх үүсвэрээр авто машины багц тодорхой хэмжээнд нэмэгдэнэ. Шинээр олгосон зээл нь хэвийн зээлийн багцыг нэмэгдүүлэх юм. Одоо байгаа авто машины зээлийн багцын 91.25 хувь нь хэвийн ангилалтай. Иймд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хэвийн ангилалтай зээлийн багцаас ХБҮЦ-д багцалсан зээлийн багцыг солих, нэмэгдүүлэх тохиолдолд автотээврийн хэрэгслийн зээлийн дийлэнх нь шалгуур хангахаар байна. • Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь сайн дурын үндсэн дээр эсхүл хуульд заасан үндэслэлээр татан буугдах тохиолдолд түүний ТЗК-д шилжүүлсэн Багцын хөрөнгийн үлдэгдлийг зохих журмын дагуу сонгогдсон өөр Үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх арга хэмжээ авна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -12- 31
БҮРТГЭВ 02

ҮЦХ
2025 .12. 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

2025/11/28

	• ТЗК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”, “Фидуцийн барьцааны гэрээ”-нд холбогдох журам, гэрээнд тус бүр эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтыг тусгасан. • ТЗК-ийн хөрөнгийн багц дахь хөрөнгөөс ХБҮЦ эзэмшигч этгээдээс өөр гуравдагч этгээд нэхэмжлэл гаргах эсхүл шаардах эрх хэрэгжүүлэхгүй. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлдэгчид төлөх аливаа өр төлбөр, бусад нэмэлт үүрэг байхгүй, хөрөнгийн багцад байгаа зээлтэй холбоотой аливаа шүүхийн маргаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгээгүй болохыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч баталгаа гаргасан ба ХБҮЦ-ны туршид уг баталгааг хангаж ажиллана.
Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэл	
• Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийг бүрэн гүйцэд, гэрээгээр хүлээсэн хугацааны дагуу цуглуулан ТЗК-д шилжүүлэхгүй байх • Үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийг хорооноос цуцлах нөхцөл үүсэх, торгууль хүлээх, системээс үүдэлтэй алдаа гарах • Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй, татан буугдсан, дампуурах, эсхүл тусгай зөвшөөрлийг цуцлах эрсдэлийг ойлгоно.	• Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийг өөрийн нэр дээрх харилцах данс буюу зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй зээлүүдийн үндсэн болон хүүгийн төлөлтийг цуглуулан өөрийн бусад хөрөнгөөс ангид байлгана. ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үйлчилгээ үзүүлэгчтэй зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ байгуулна. • Үйлчилгээ үзүүлэгчийн бууртай үйлдлийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг өөрийн хөрөнгөөр төлж барагдуулна. • Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлэхгүй, эсхүл Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдах, дампуурах эрсдэл үүссэн, төрийн зохицуулах байгууллагаас тусгай зөвшөөрлийг цуцалсан тохиолдолд ТЗК нь тусгаарласан зээлийн багцтай холбоотой авлага цуглуулах, төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг өөр хэвийн үйл ажиллагаатай үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх, үйлчилгээ үзүүлэгчийг солих арга хэмжээ авна. • ТЗК нь үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

2025/11/28

СЗХ
2025 . 12 . 25 өдөр
ТӨРТГЭВ
№ 01

Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэл	
• Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийг гэрээнд зааснаас бусад нөхцөлөөр, Үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчдад хохиролтойгоор зүй бусаар удирдах, ашиглах • Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг СЗХ-с цуцлах нөхцөл үүсэх, торгууль хүлээх, систем, дотоод үйл ажиллагаанаас үүдэн алдаа гаргах • Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь татан буугдсан, дампуурах эрсдэлийг ойлгоно.	• Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын удирдлагатай холбоотой тайлан мэдээллийг үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, холбогдох эрх бүхий байгууллагад тогтмол хүргэх боогоод хууль болон гэрээнд зааснаас гадуур, зүй бусаар удирдаж, ашиглах тохиолдолд ТЗК-ийн ТУЗ нь хөрөнгө итгэмжлэн удирдагчийг нэн даруй солих шийдвэр гаргах, эсхүл үйл ажиллагааг залруулах, хохирлыг барагдуулах тодорхой хугацаа өгөх эрхтэй. Мөн зүй бус хөрөнгийн удирдлагатай холбоотой аливаа хохирол учирсан тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах талаар гэрээнд тодорхой тусгаж баталгаажуулсан байна. • Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг төрийн зохицуулах байгууллагаас цуцлах, хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах нөхцөл үүссэн тохиолдолд шаардлага хангах хөрөнгө итгэмжлэн удирдагчийг яаралтай шинээр сонгон ажиллуулна. • ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

2025/11/28

InvesCore Growth

АРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД



10. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудыг томилох тухай

Үнэт цаас гаргагчийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 25/2-6 тоот ТУЗ-ийн тогтоолын дагуу үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудыг томилсон байна. Тус тогтоолын дагуу үйлчилгээ үзүүлэгчээр, захиргааны үйлчилгээ үзүүлэгчээр "Инвескор ББСБ" ХК-ийг, хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Эм Ай Си Жи" ХХК-ийг, Санхүүгийн хөндлөнгийн аудиторoор "Лидер экаунт Аудит" ХХК-ийг, Үндсэн андеррайтераар "Голомт Капитал ҮЦК" ХХК-г, туслах андеррайтераар "Инвескор капитал ҮЦК" ХХК-ийг тус тус сонгосон байна. ТУЗ-ийн тогтоолыг хавсралтаас харна уу.

10.1. Үндсэн андеррайтер

Голомт Капитал ҮЦК ХХК

Улсын бүртгэлийн дугаар	9011287134
Регистрийн дугаар	5481589
Үүсгэн байгуулагдсан огноо	2011.05.19
Үйл ажиллагааны чиглэл	Брокер, Дилер, Андеррайтерийн үйл ажиллагаа, Номинал дансаар дамжуулан харилцагчдад үйлчилгээ үзүүлэх, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 24, Парк плэйс оффис, 403, 404 тоот;
Утас	(+976) 7012 1530
Веб хуудас	www.golomtcapital.com
Цахим хаяг	info@golomtcapital.com
Гүйцэтгэх захирал	С.Ган-Эрдэнэ
ХБҮЦ дээр ажилласан туршлага	Нөмөр Кредит ассет ХБҮЦ Бэрс-2 ХБҮЦ Бэрс – 3 ХБҮЦ Бичил 2 ХБҮЦ (синдикатор) Бид ХБҮЦ Бичил-4 ХБҮЦ Бэрс-4 ХБҮЦ (синдикатор)

Андеррайтертай байгуулсан гэрээ:

Үнэт цаас гаргагч нь үндсэн андеррайтер Голомт Капитал ҮЦК ХХК, туслах андеррайтер Инвескор Капитал ҮЦК ХХК, анхны үүрэг гүйцэтгүүлэгч Инвескор ББСБ ХК-тай 2025 оны 11-р сарын 20-ны өдөр 25/3-8 тоот Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан. Тус андеррайтерийн гэрээний хүрээнд Андеррайтер нь Үнэт Цаас Гаргагчид МХБ-р дамжуулан 50.0 тэрбум төгрөг хүртэлх хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг олон нийтэд санал болгох, худалдах ажлыг удирдан зохион байгуулах, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татан төвлөрүүлэхэд шаардлагатай мэдээлэл, шинжилгээ, тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх боломжит

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 12 31
БҮРТГЭВ-02

ТЗК
2025 12 25
БҮРТГЭВ

хөрөнгө оруулагчдад Үнэт цаасыг танилцуулах, санал болгох, арилжих үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үзүүлэхээр заасан.

ТЗК нь үнэт цаас гаргах, түүний танилцуулга бэлтгэх, олон нийтэд хувьцааг санал болгох, хөрөнгө оруулагч татах үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэхийг Андеррайтеруудаас шаардах эрхтэй. Мөн түүнчлэн үйл ажиллагааны явцын талаар бүрэн мэдээлэл авч, үр дүнд өөрийн зүгээс санал огох, Андеррайтеруудаас санал болгосон хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах, мөн тухайн хөрөнгө оруулалтыг хүлээн авахаас татгалзах эрхтэй.

10.2. Туслах андеррайтер

Инвескор Капитал ҮЦК ХХК

Улсын бүртгэлийн дугаар	9011741137
Регистрийн дугаар	6317839
Үүсгэн байгуулагдсан огноо	2018.06.08
Үйл ажиллагааны чиглэл	Брокер, Дилер, Андеррайтерийн үйл ажиллагаа, Хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, гудамж Ай Си Тауэр барилга 15 давхар, 1503 тоот
Утас	(+976) 7755 0077
Веб хуудас	www.icapital.mn
Цахим хаяг	info@icapital.mn
Гүйцэтгэх захирал	М.Бат-Оргил
ХБҮЦ дээр ажилласан туршлага	Инвескор Актив ХБҮЦ Инвескор ХБҮЦ

10.3. Зээлийн шинжилгээ гаргагч

“СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ” ХХК

Улсын бүртгэлийн дугаар	9018001113
Регистрийн дугаар	5530121
Үүсгэн байгуулагдсан огноо	2011.11.08
Үйл ажиллагааны чиглэл	Аудитын үйл ажиллагаа эрхлэх Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ
Хаяг	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, 45А байр Оршил төв 5 давхар 501 тоот
Утас	(+976) 7723 3030
Веб хуудас	cptaaudit.mn
Цахим хаяг	info@cptaaudit.mn
Гүйцэтгэх захирал	Л.Энхчимэг

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

2025/11/28

ХБҮЦ дээр ажилласан туршлага	Бичил-3 ХБҮЦ Бэрс – 3 ХБҮЦ Инвескор ХБҮЦ Бичил-4 ХБҮЦ

Зээлийн шинжилгээ гаргагч "Си Пи Ти Эй Аудит" ХХК нь 2011 онд байгуулагдсан ба аудит зөвлөх үйлчилгээний салбарт тасралтгүй 15 гаруй жил үйл ажиллагаа явуулж байна. Тус компани нь салбартаа олон жил ажилласан туршлагатай мэргэжилтэн бүхий 15 ажилтантай ба давхардсан тоогоор Монголын мэргэшсэн нягтлан бодогч 9, аудитор 5, Монголын татварын мэргэшсэн зөвлөх 5, гэрээний мэргэжилтэн 2, туслах аудитор 5 гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

"Си Пи Ти Эй Аудит" ХХК нь Монгол Улсын аудитын тухай хууль, НББ-ын тухай хууль болон Аудитын Олон Улсын Стандартын дагуу чанарын өндөр түвшинд үйлчилгээгээ гүйцэтгэж байгаа ба аж ахуй нэгж байгууллага болон групп компаниудад тусдаа болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудит, санхүүгийн тайлангийн бүрдэл хэсгийн аудит, санхүүгийн тайлангийн баталгаажуулалт, дотоод аудит чиглэлээр үйлчилгээг хүргэж байна.

Зээлийн санхүүгийн шинжилгээ хийх гэрээ:

"Инвескор ББСБ" ХК нь сонгогдсон зээлийн данснууд санхүүгийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаарх дүгнэлт гаргуулахаар "Си Пи Ти Эй Аудит" ХХК-тай 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр "ХБҮЦ Зээлийн багцад санхүүгийн шинжилгээ хийх гэрээ" байгуулсан байна. Гэрээгээр гэрээт ажлын цар хүрээ буюу сонгогдсон зээлийн хувийн хэргийг харилцан тохиролцсон ажил үйлчилгээний дагуу хянаж, харилцан тохиролцсон ажил үйлчилгээний гүйцэтгэл болон илрүүлсэн асуудлуудыг нэгтгэж тайлагнах асуудлыг зохицуулжээ. Аудитын байгууллага нь Монгол улсын хууль тогтоомж болон Олон улсын стандарт 4400 "Харилцан тохиролцсон ажил үйлчилгээ"-нд нийцүүлэн гэрээт ажлыг гүйцэтгэнэ.

Энэхүү гэрээгээр ажлын хамрах хүрээ, зээлийн шалгуур, хязгаарлалт, шинжилгээний ажлын тайланг хүргүүлэх хугацаа, үйлчилгээний хөлс, бизнес үйл ажиллагааны ерөнхий нөхцөл буюу талуудын хүлээх хариуцлага, үйлчилгээний төлбөр зэрэг бусад харилцааг зохицуулсан байна.

10.4. Хуулийн фирм

Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс ХНН

Улсын бүртгэлийн дугаар	9022001010
Регистрийн дугаар	5495997
Үүсгэн байгуулагдсан огноо	2011.07.06
Үйл ажиллагааны чиглэл	Хууль зүйн зөвлөгөө өгөх
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Сүхбаатарын талбай 2 Сэнтрал тауэр 13 давхар 1301
Утас	(+976) 1133 0048
Веб хуудас	www.mdsa.mn
Цахим хаяг	info@mdsa.mn
Удирдах гишүүн	Д.Дүгэржав

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -12- 3
БҮРТ

СЗХ
2025 .12. 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ХБҮЦ дээр ажилласан туршлага	ЛэндМН актив ХБҮЦ Бэрс ХБҮЦ Инвескор Актив ХБҮЦ ҮЦСК актив нэг, хоёр ХБҮЦ МИК актив 1 13, 21, 23, 24, 28, 29, 38 Бэрс-2 ХБҮЦ Бэрс-3 ХБҮЦ Бичил 2 ХБҮЦ Бичил 3 ХБҮЦ Инвескор ХБҮЦ Бичил 4 ХБҮЦ Нэткапитал ХБҮЦ Си И Си Ая ХБҮЦ

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь 2011 онд байгуулагдсан бөгөөд 3 партнер, 9 хуульч, эрх зүйчийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тус фирмийн хуульчид нь олон улсын эрх зүйг үндэсний хууль тогтоомж, туршлагатай уялдуулан үндэсний болон олон улсын хөрөнгө оруулагчдад төрөл бүрийн салбарт эрх зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. Хуульч, хуулийн фирмүүдийн чансаа тогтоодог Asia Law сэтгүүлээс "Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс" ХХН-ийг 2021, 2022, 2024 оны "Монгол улсын шилдэг хуулийн фирм"-ээр шалгаруулсан.

Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ:

Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ гаргах, Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд санал болгох хүрээнд төслийн бүтэц, оролцогч талууд, тэдгээрийн хооронд үүсэх харилцаа, байгуулсан гэрээ, гэрээний төслүүд нь хүчин төгөлдөр, хуульд нийцсэн эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргаж, үнэт цаасны холбогдох зөвшөөрөл авах асуудлаар хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, багцын хөрөнгөд тавигдах шаардлага зэргийг тодорхойлж, хөрөнгийн багцад шинжилгээ хийж, тайлан гаргуулахаар Инвескор ББСБ ХК нь "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-тэй Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээг 2025 оны 5-р сарын 23-ний өдөр байгуулсан байна. Гэрээ нь нийтлэг үндэслэл, гэрээт ажил, гэрээний хугацаа, гэрээт ажлын хөлс хуулийн зөвлөхийн эрх, үүрэг, үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, харилцах хүмүүс, хариуцлагын хязгаарлалт, гэрээг дуусгавар болгох, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, бусад зүйл гэсэн 11 бүлгээс бүрдэх зохицуулалттай байна.

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь 2025 оны 11-р сарын 03-ны өдрийн Д-25/257 тоот Автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (ХБҮЦ) олон нийтэд нээлттэй санал болгох хүрээнд сонгогдсон зээлийн данснуудын хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээний тайлан, 2025 оны 11-р сарын 28-ны өдрийн Д-25/251 тоот "Инвескор Өсөлт ТЗК" ХХК-аас Автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (ХБҮЦ) гарган нийтэд санал болгохтой холбогдуулан бэлтгэсэн Хууль зүйн дүгнэлтийг тус тус гаргасан.

Хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайланг хавсаргасан ба Хууль зүйн дүгнэлт нь Үнэт цаасны танилцуулгын хамт эх хувиар хүргэгдэнэ.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

122

2025/11/28

10.5. Хөрөнгө итгэмжлэн удирдагч

"Эм Ай Си Жи" ХХК

Улсын бүртгэлийн дугаар	9011216044
Регистрийн дугаар	5344891
Үүсгэн байгуулагдсан огноо	2009.12.14
Үйл ажиллагааны чиглэл	Хөрөнгө итгэмжлэн удирдах Бизнесийн зөвлөгөө өгөх
Тусгай зөвшөөрөл авсан огноо	2022.11.25
Хаяг	Улаанбаатар, БГД, 6-р хороо, Пума 2-2 тоот
Утас	(+976) 7515 7733
Веб хуудас	www.micg.mn
Цахим хаяг	info@micg.mn
Гүйцэтгэх захирал	Б.Билэгтсайхан
ХБҮЦ дээр ажилласан туршлага	БИД – ХБҮЦ

Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээ:

"Инвескор Өсөлт ТЗК" ХХК, "Эм Ай Жи Си" ХХК нарын хооронд 2025 оны 11-р сарын 18-ны өдөр 25/3-7 тоот "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ" байгуулагдсан байна. Гэрээний дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан үйлчилгээ үзүүлэх буюу Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн багцыг итгэмжлэн удирдах, Үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх, Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчид үйлчилгээний хөлс төлөх холбоотой харилцааг зохицуулсан байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагч компаниудтай ашиг сонирхлын зөрчилгүй болно. Түүнчлэн ХБҮЦ нь олон тооны бага дүнтэй зээлээс бүрдсэн тул зээлийн багцын орох урсгал болон үнэт цаасны төлөлтийн хяналтыг Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь программ ашиглан хэрэгжүүлнэ. Зээлийн багцын мэдээлэл болон, эргэн төлөлтийн хуваарь, таамаглал дээр үндэслэн Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ХБҮЦ-ны мөнгөн урсгал болон ТЗК-ийн санхүүгийн төсөөллийг гаргасан.

10.6. Аудитын үйлчилгээ үзүүлэгч

"Лидер экаунт Аудит" ХХК

Улсын бүртгэлийн дугаар	9018001108
Регистрийн дугаар	5937639
Үүсгэн байгуулагдсан огноо	2015.03.05
Үйл ажиллагааны чиглэл	Аудитын үйл ажиллагаа эрхлэх
Тусгай зөвшөөрөл авсан огноо	2015.07.08
Хаяг	Улаанбаатар, Чингэлтэй, 2-р хороо, төмөрчний, 8, 405
Утас	(+976) 7011 4519
Цахим хаяг	leaderaudit.25@gmail.com
Гүйцэтгэх захирал	П.Шаравхорол

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -12- 25
БҮРТГЭВ-09

ҮЦХ
2025. 12. 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

10.7. Оролцогч байгууллагууд нь нэгдмэл сонирхол, бизнесийн холбоо хамааралтай эсэх талаарх мэдээлэл

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож буй доор дурдсан байгууллагууд нь холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд Үнэт цаас гаргагч "Инвескор Өсөлт ТЗК" ХХК болон үүсгэн байгуулагч "Инвескор ББСБ" ХК нарт холбогдох мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй бөгөөд эдгээр байгууллага нь Үнэт цаас гаргагч "Инвескор Өсөлт ТЗК" ХХК болон үүсгэн байгуулагч "Инвескор ББСБ" ХК нартай аливаа байдлаар нэгдмэл сонирхолгүй, энд дурдсанаас өөрөөр бизнесийн холбоо хамааралгүй болно. Үүнд:

1. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэгч ""Эм Ай Си Жи" ХХК
2. Зээлийн шинжилгээ гаргагч "Си Пи Ти Эй Аудит" ХХК
3. Хөндлөнгийн хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс" ХХН
4. Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч "Голомт Капитал ҮЦК" ХХК
5. Аудитын үйлчилгээ үзүүлэгч "Лидер Экаунт Аудит" ХХК

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд туслах андеррайтераар ажиллаж буй "Инвескор Капитал ҮЦК" ХХК нь үнэт цаас гаргагч болон үүсгэн байгуулагчтай нэгдмэл сонирхолтой бөгөөд талуудын эрх бүхий этгээдүүд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрч, холбогдох шийдвэр, тогтоолыг гаргасан байна.

Оролцогч байгууллагууд нь бизнесийн нэгдмэл сонирхол, холбоо хамааралгүй талаарх албан бичгүүдийг хавсралтаас харна уу.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
InvesCore FI
БҮРТГЭВ-02

2025.12.25
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга

Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл үнэн зөв болохыг батлав:

Овог нэр: Далайжамц овогтой Баясгалан Албан тушаал: Үнэт цаас гаргагч “Инвескор Өсөлт ТЗК” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Гарын үсэг: ..... (Тамга/тэмдэг)	Овог нэр: Далайжамц овогтой Баясгалан Албан тушаал: Үүсгэн байгуулагч “Инвескор ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Гарын үсэг: ..... (Тамга/тэмдэг)
Овог нэр: Элгэль овогтой Баасанбат Албан тушаал: Үнэт цаас гаргагч “Инвескор Өсөлт ТЗК” ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Гарын үсэг: ..... (Тамга/тэмдэг)	Овог нэр: Санжхуяг овогтой Ган-Эрдэнэ Албан тушаал: Үндсэн андеррайтер “Голомт Капитал ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Гарын үсэг: ..... (Тамга/тэмдэг)
Овог нэр: Болд овогтой Итгэл Албан тушаал: Үнэт цаас гаргагч “Инвескор Өсөлт ТЗК” ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Гарын үсэг: ..... (Тамга/тэмдэг)	Овог нэр: Мөнхгэрэл овогтой Бат-Оргил Албан тушаал: Туслах андеррайтер “Инвескор Капитал ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Гарын үсэг: ..... (Тамга/тэмдэг)

InvesCore Growth

АРВАН НЭГ. ХАВСРАЛТ



11. ХАВСРАЛТ

11.1 Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000348462

2025.06.13 / Бүртгэсэн он.сар.өдөр /
9011880461 / Хуулийн хэрэгжих дугаар /
7167257 / Регистрийн дугаар /

Инвескор өсөлт
Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хэлбэрийн хэлбэр /

Дүрэм
/ Үүсэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр | 01 | 2025.06.06
/ шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр /

66100 Санхүүгийн тайлан баланс бэлтгэн гаргах түүнтэй холбоотой зөвлөгөө өгөх
/ Код / / Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй | 1 | 10,000.00
/ хугацаа / / гишүүдийн тоо / / хөрөнгийн хэмжээ, мөнгөн төрөөөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, гарисын, 42, Ай Си Тауэр 14 давхар 1401 тоот, Утас1: 77090099, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

УЛСЫН БҮРТГЭДИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
СҮХБААТАР ДҮҮРГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС
/ Бүртгэсэн байгууллагын нэр /
УЛСЫН БҮРТГЭГЧ С.ОЮУНЧИМЭГ
/ гарын үсэг /

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

InvesCore FI

2025 . 12 . 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах бичиг баримт бичгээр оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Сэрээлэн овоотой Тулга-э Гүбсэлгэх зөвхөрөл -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2025.08.13	С.Оюунчимэг
2	Инвескор өсөлт онооссон нэр Инвескор өсөлт ТЭК багц өөрчлөлтийг бүртгэв.	2025.10.22	Б.Эрдэнэчимэг
3	Далайжамц овоотой Баясгалан-г Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2025.10.22	Б.Эрдэнэчимэг
4	Гишүүн тоо нийт 3 болж өөрчлөгдөнийг бүртгэв.	2025.10.22	Б.Эрдэнэчимэг
5	66190 Санхүүгийн тайлан баланс болгон гаргах түүнтэй холбоотой зөвлөгөө өгөх үйл ажиллагаа хассаныг бүртгэв. 66300 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2025.10.22	Б.Эрдэнэчимэг

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ хэвартай бол хүчинтэй.

000348482

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЭК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

128

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
InvesCore FI
2025-12-31
БҮРТГЭВ-02

СЭХ
2025.12.25
БҮРТГЭВ
№ 01

"ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК" ХХК-ийн Хувьцаа
эзэмшигчийн хурлын 2025 оны 10-р сарын 14-ны өдрийн
25/1-3 тоот шийдвэрийн Хавсралт

"ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК"
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИЙН ДҮРЭМ

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ASS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

129

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
1119289111 ≙ 5481589
Улаанбаатар хот

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

СЗХ
2025 оны 12 сар 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. **"ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК"** ХХК /цаашид **"Компани"** эсхүл **"ТЗК"** гэх/ нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж энэхүү дүрэм /цаашид "Дүрэм" гэх/-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулах хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

1.2. Компанийн оноосон нэр (монголоор)

а) Бүтэн нэр: **"Инвескор Өсөлт Тусгай Зориулалтын Компани"** ХХК, товчилсон нэр нь **"Инвескор Өсөлт ТЗК" ХХК**

б) Англи нэр буюу товчилсон нэр: **"Invescore Growth Special Purposed Company" LLC** буюу **"Invescore Growth SPC" LLC**

1.3. Компанийн оршин байгаа газар:
Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Парисын гудамж, Ай Си Тауэр барилга, 14 давхар;
Харилцах утасны дугаар: 7709-0077

1.4. Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл

Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл	Регистрийн дугаар	Хувь хэмжээ	Хаяг	Утас
Инвескор ББСБ ХК	6060854	100%	Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Парисын гудамж, Ай Си Тауэр барилга, 14 давхар;	77090077

1.5. Компани нь өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

1.6. Компани нь ажилтангүй ба өөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л үйлчилгээг гуравдагч этгээдтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлнэ.

1.7. Компанийн одоогийн болон ирээдүйн өр төлбөр нь (татварыг оролцуулан) тоогоор илэрхийлэгдэх ба түүний боломжит эх үүсвэрээр хангагдахуйц боломжтой байна.

ХОЁР. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Компани нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан тусгай зориулалтын компани байх бөгөөд эрхлэх цорын ганц үйл ажиллагаа нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу зээлийн хөрөнгө худалдан авах, зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах болон тухайн худалдан авах үнэт цаасыг гаргахтай холбоотой бүхүү тэдгээрийн дагуу хийгдэх бусад үйл ажиллагаа байна.

2.2. Компанийн зорилго: Компани нь зээлийн хөрөнгийг багцлан худалдан авч, тэдгээрийг өөрийн хөрөнгө болон санхүүгийн тайлан тэнцэлд тусгах бөгөөд худалдан авсан зээлийн хөрөнгийн багцын төлбөрийг төлөх үүднээс зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргана.

2.3. Компани дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

2.3.1. Дүрэмд зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэх, эсхүл үйл ажиллагаа явуулах;
2.3.2. Баталгаат үнэт цаасыг худалдсанаас олсон орлогоос эргүүлэн төлөх шаардлагаас бусдаас зээл авах;

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth SPC ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

130

2025/11/28

2.3.3. Компанийн гаргасан баталгаат үнэт цаас төлөгдөж дууссаагүй байх үед Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрснөөс бусад тохиолдолд өөрийн хувьцаа эзэмшигчид ногдол ашиг төлөх, эсхүл аливаа бусад хэлбэрээр ногдол ашиг хуваарилах;

2.3.4. Хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулах;

2.3.5. Санхүүгийн Зохицуулах Хорооны зөвшөөрөлгүйгээр Дүрэмд өөрчлөлт оруулах;

2.3.6. Үнэт цаас гаргах өргөдөл, үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зардлыг төлөхтэй холбоотой хууль зөрчиж, хөрөнгө оруулагчийн эрх ашиг хохироолтой гэрээ хэлцэл байгуулж, эсхүл зах зээлийн ханшаас өндөр үнэ тогтоох;

2.3.7. Хууль, холбогдох журамд заасан бусад.

ГУРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД БА ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

3.1. Компани нь нэг бүр нь 100.000 (Нэг зуун мянган) төгрөгийн үнэтэй 100 (Нэг зуун) ширхэг зарласан бөгөөд гаргасан энгийн хувьцаанаас бүрдэх 10,000,000 (Арван сая) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болно.

3.2. Компанийн хувьцаа эзэмшигч нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хувьцаагаа худалдах, барьцаалах, эсхүл шилжүүлэх эрхгүй.

3.3. Компанийн хувьцаа эзэмшигч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Компанийн эрэг өөрийн гаргасан шаардлага, эсхүл түүний өмнө Компанийн хүлээх аливаа үүрэг, харилцлагатай холбоотойгоор ямар нэгэн хууль зүйн маргаан үүсгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх. Компанид харилцлага хүлээлгэхээр санал гаргах буюу санал өгөх, эсхүл Дүрмийн 8.2-р заалтад зааснаас бусад тохиолдолд Компанийг татан буулгахаар хүсэлт гаргаж үл болно.

ДӨРӨВ. КОМПАНИЙН УДИРДЛАГА

4.1. ТЗК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид "ХЭХ" гэх/ байх ба хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээ болон бусад асуудлыг Компанийн тухай хууль заасан журмын дагуу зохицуулна. Компанийн ХЭХ-ын бүрэн эрхийг Хувьцаа эзэмшигчийн ТУЗ хэрэгжүүлнэ.

4.2. Компанийн ХЭХ-ийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ шийдвэр гарснаас хойш 10-аас доошгүй хоногийн дараа хуралдуулна.

4.3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөө цагт компанийн эрх барих дээд байгууллагын бүрэн эрхийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл хэрэгжүүлнэ.

4.4. ТЗК-ийн ТУЗ нь Компанийг үйл ажиллагааг удирдаж, хяналт тавьж ажиллах чиг үүрэгтэй байна. ТУЗ нь өөрийн үйл ажилагаандаа ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баримтална.

4.5. ТЗК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 3 гишүүнтэй байх бөгөөд нийт гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна.

4.6. ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос батлсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журамд заасан шаардлагыг хангасан байна.

9.14. ТУЗ-ийн аль нэг гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан эсхүл нас барсан тохиолдолд түүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль явуулах хүртэл ТУЗ-өөс түр томилно.

9.15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуульд заасан хугацаанд зарлан хуралдуулаагүй тохиолдолд ТУЗ-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахаас бусад бүрэн эрх дуусгавар болно.

2025/11/28

9.16. Хувьцаа эзэмшигчдийн хуряын шийдвэрээр ТУЗ-ийн бүрэн эрх, бүрэн бүрэлдэхүүнийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.

9.17. ТУЗ түүний хурлын бүрэн эрх, хуралтай холбоотой бусад асуудлыг Компанийн тухай хууль болон "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-д заасны дагуу зохицуулна.

10. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРОО

10.1. ТУЗ нь байнгын үйл ажиллагаатай Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин, урамшууллын хороо, Эрсдэлийн удирдлага, Тогтвортой байдлын хороодтой байна.

10.2. ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог Компанийн тухай хуулийн 81-р зүйлд заасны дагуу байгуулж болно.

10.3. ТУЗ нь хороодын бүтэц, бүрэлдэхүүнийг Компанийн тухай хуулийн 81.2 дах хэсэгт заасны дагуу томилно.

10.4. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах, Компанийн тухай хууль болон энэхүү Дүрэмд заасан асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй байна.

10.5. ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, бүрэн эрх хэмжээ болон үйл ажиллагааны журмыг ТУЗ батална.

11. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

11.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-ийн сонгосон Гүйцэтгэх Захирал (цаашид "**Гүйцэтгэх Захирал**" гэх) хэрэгжүүлэх ба Гүйцэтгэх захирал нь Дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

11.2. Гүйцэтгэх Захирал нь Компанийг төлөөлж энэхүү Дүрэмд заасан өдөр тутмын үйл ажиллагааг тусгайлсан итгэмжлэлгүйгээр хэрэгжүүлнэ.

11.3. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно.

11.4. Гүйцэтгэх Захирал нь өөрт олгогдсон бүрэн эрхээ зохистой үйл ажиллагаанд хэрэгжүүлэх ба энэхүү Дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээтэй зөрчилдөх хэлбэрээр ажиллахыг хориглоно. Гүйцэтгэх Захирал нь өөрийн эрх, үүргийг хэрэгжүүлэхдээ үнэнч шударга байж Компанийн эрх, ашиг сонирхлыг тэргүүнд тавьж ажиллана.

11.5. Гүйцэтгэх Захирал нь дор дурдсан эрх хэмжээтэй байна. Үүнд:

11.5.1. Компанийн стратегийн бодлого, дунд хугацааны болон жилийн бизнес төлөвлөгөө, төсвийг Компанийн зорилго, зорилтод нийцүүлэн боловсруулж ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах;

11.5.2. Компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалингийн систем зэргийг батлагдсан хүрээнд удирдан, зохион байгуулах, тэдгээртэй холбоотой шийдвэр гаргах;

11.5.3. Компанийн үйл ажиллагааг тухайн жилийн батлагдсан бизнес төлөвлөгөө, төсвийн хүрээнд эрхлэн явуулах, захиран зарцуулах;

11.5.4. Компанийн жилийн бизнес төлөвлөгөөг батлах үед тодорхойлох боломжгүй байсан эсхүл ТУЗ-өөс тусгайлан тогтоосон эрхэд хамаарахгүй 1,500,000,000 (Нэг тэрбум таван түүн сая) төгрөг хүртэлх зах зээлийн үнэгүй үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, барьцаалах, барьцаалуулах болон бусад хэлбэрээр захиран зарцуулахтай холбоотой гэрээ хэлцэл бие даан байгуулах, уг эрхээ өөр этгээдэд итгэмжлэлээр олгох

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317039 1119077129
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

11.5.5. Зээлийн хорооны гишүүдийг томилох, чөлөөлөх;

11.5.6. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой дотоод журам, дүрэм заавар батлан мөрдүүлэх;

11.5.7. Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-өөс шаардсан тайлан, мэдээлэл, баримт бичгийг тухай бүр бэлтгэн гаргаж өгөх;

11.5.8. Компанийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн шүүхийн маргаан, өр барагдуулах үйл ажиллагаа, хэрэг хянан шийдвэрлэх болон захиргааны журмаар шийдвэрлүүлэх аливаа ажиллагаанд Компанийг төлөөлөн оролцож, асуудлыг шийдвэрлэх, энэ талаар өмгөөлөгч болон бусад тусгайлан эрх авсан холбогдох этгээдүүдтэй гэрээ байгуулах, Компанийг төлөөлөх этгээдэд итгэмжлэл олгох, эрх ашгийг хамгаалах холбогдох арга хэмжээг авах;

11.5.9. Компанийн үндсэн болон гэрээт ажиллагсдыг ажилд авах, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ болон бусад төрлийн гэрээ байгуулах, цуцлах, дуусгавар болгох, тэдгээрийн ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, урамшуулах, Хөдөлмөрийн тухай хууль болон Компанийн Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтанд хөдөлмөрийн сахилгын арга хэмжээ авах, холбогдох гэрээний дагуу хариуцлага тооцох;

11.5.10. Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарахаас бусад Компанийн эрх бүхий албан тушаалтныг томилох, Монгол улс дахь салбар, төлөөлөгчийн газар байгуулах, үйл ажиллагааны чиглэлийг тогтоох, түүний гүйцэтгэх удирдлагыг бие даан томилох, чөлөөлөх, бүрэн эрх хэмжээг тогтоох, ажлын байрны тодорхойлолтыг батлах, шаардлагатай тохиолдолд хугацаанаас нь өмнө чөлөөлөх, тэдгээрийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх.

11.6. Гүйцэтгэх Захирал нь дор дурдсан үүргийг хүлээнэ. Үүнд:

11.6.1. Компанийн дүрэм, Хувьцаа Эзэмшигчийн хурал, ТУЗ-өөс батлагдсан бодлогын баримт бичгийг заасан үүргийг биелүүлж, Компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллах;

11.6.2. Компанийн үйл ажиллагааг Монгол Улсын хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, Банк бус санхүүгийн байгууллагад холбогдох хууль, тогтоомж, журам болон Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банкны шаардлагад бүрэн нийцүүлж ажиллах;

11.6.3. Хувьцаа Эзэмшигч болон ТУЗ-ийн шийдвэр, тогтоол, Компанийн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах;

11.6.4. Санхүүгийн тайлан бүртгэлийг холбогдох хууль, тогтоомж, заавар, журмын дагуу үнэн зөв гаргуулах;

11.6.5. Хөлсөөр ажиллах гэрээгээр тогтоосон үүргийг биелүүлэх.

11.7. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр Компанийн нэгдлийн оролцогчид хамаарахгүй этгээдийн гүйцэтгэх удирдлагаар ажиллахыг хориглоно.

11.8. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь өөрийн бууруулай үйл ажиллагааны улмаас, Компанид учруулсан эд хөрөнгийн хохирлыг өөрийн хөрөнгөөр Компанийн өмнө хариуцна.

11.9. Гүйцэтгэх захирал нь бүрэн эрхийн хүрээнд тушаал гаргана.

12. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

12.1. ТУЗ нь Гүйцэтгэх Захирлын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлнэ.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
6217839 ᠠ 1119277129
УЛААНБААТАР ХОТ

159

2025/11/28

12.2. Компанийн ТУЗ-өөс хэрэгжүүлэх хяналтад дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

12.2.1. Гүйцэтгэх Захиралтай байгуулсан гэрээний хэрэгжилт;

12.2.2. Компанийн ТУЗ-ийн батлсан Компанийн стратеги, дунд болон жилийн бизнес төлөвлөгөө, төсвийн биелэлт;

12.2.3. Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны төлөвлөгөөний биелэлт, бүрдүүлэлт;

12.2.4. Компанийн өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар тогтоосон Гүйцэтгэх Захирлын эрх хэмжээний хэрэгжилт;

12.2.5. Компанийн хувьцаа Эзэмшигч болон ТУЗ-ийн гаргасан шийдвэр, тогтоолын хэрэгжилт.

12.3. Дотоод хяналтын үйл ажиллагааны журмыг ТУЗ-ийн хурлаас батална.

12.4. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудиторын шалгалт нь заавал бус байна. Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд заавал шалгалт хийнэ.

12.5. Заавал бус шалгалтыг ТУЗ-ийн шийдвэр, Компанийн энгийн хувьцааны арван хувиас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх захирлын шийдвэрээр хэдий ч хийж болно. Аль нэг хувьцаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэнээс бусад шалгалтын хөлсийг Компани хариуцан төлнө. Хувьцаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэн шалгалтын хөлсийг тухайн хувьцаа эзэмшигч хариуцаж төлөх бөгөөд шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтан эсхүл хувьцаа эзэмшигч хуулийн этгээд, хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

12.6. Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг холбогдох дотоод журам болон холбогдох хууль тогтоомжийн актад заасны дагуу Компанийн дотоод хяналт хариуцсан ажилтан хяналт тавьж ажиллана.

13. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮРТГЭЛ ТАЙЛАН, НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТ

13.1. Компанийн санхүүгийн жил нь 1 дүгээр сарын 1-ний өдрөөс (эхний жилийн хувьд байгуулагдсан өдрөөс) эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр (сүүлийн жилийн хувьд Компанийн үйл ажиллагааг зогсоосон өдөр) дуусна.

13.2. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар болон бусад албан татвар, гаалийн хураамж, газрын төлбөр болон бусад төлбөр хураамжийг төлнө.

13.3. Компани нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж болон нягтлан бодох бүртгэлийн дүрэм, журмын дагуу санхүү, нягтлан бодох бүртгэлээ хөтөлж холбогдох тайлан, балансыг татвар, санхүүгийн байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хууль тогтоомжид заасан хугацаанд хүргүүлнэ.

13.4. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Гүйцэтгэх Захирал харнуцна. Компанийн орон тоонд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа Ерөнхий нягтлан бодогч энэхүү хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

13.5. Компани нь Санхүү аж ахуйн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл тайлан тэнцэл, татварын тооцооллын үнэн зөв магадлал. хөндлөнгийн байгууллагаар шалгалт хийлгэж, ажил сайжруулах туслалцаа авч байна.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
Growth ACS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ᵾ 1119277129
УЛААНБААТАР ХОТ

160

2025/11/28

13.6. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд энгийн хувьцаа эзэмшигчид цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна.

13.6.1. Ногдол ашиг хуваарилсны дараа Компани төлбөрийн чадвартай байх;

13.6.2. Ногдол ашиг хуваарилсны дараа Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;

13.6.3. Ногдол ашиг хуваарилсны дараа Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас илүү хувиар багассан тохиолдолд ногдол ашгаа шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчдээ Хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг Гүйцэтгэх Захирал хэрэгжүүлнэ.

13.6.4. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх болон нийгэмд хандсан арга хэмжээ зохион байгуулах, сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг Гүйцэтгэх Захирал боловсруулан ТУЗ-д танилцуулж, батлуулж мөрдөнө.

13.7. Компани нь жил бүр давуу эрхийн хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилах бөгөөд энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахаас тэргүүн эзлэхэд тухайн жилийн ногдол ашгийг дараа жилийн 4 сарын 30-ны өдрийн дотор олгоно.

13.8. Давуу эрхийн хувьцаа эзэмшигчид хуваарилах ногдол ашгийн хэмжээг эзэмшиж буй давуу эрхийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийн Монгол банкны бодлогын хүү дээр 5 (тав) хувь нэмж тооцон тодорхойлно.

13.9. Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ нь энэ тухай шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

13.10. ТУЗ нь Ногдол ашиг хуваарилах болон түүнтэй холбоотой бусад харилцааг Компанийн Ногдол ашгийн бодлогод заасны дагуу зохицуулна.

14. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

14.1. Компанийн ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх Захирал, Тэргүүн дэд захирал, хариуцсан захирлууд (C level), Ерөнхий нягтлан бодогч, Газрын захирлууд болон Зээлийн хорооны гишүүд нь Компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно.

14.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хууль, ажилтантай байгуулсан гэрээ, холбогдох бусад журамд заасан эрхийг эдлэх, үүргийг хүлээнэ.

14.3. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь томилогдсоноос хойш ажлын 10 өдрийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад өгөх ба уг жагсаалтад өөрчлөлт орсон тухай бүр уг мэдээллийг Компанид мэдэгдэнэ. Нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт гаргах заавырыг ТУЗ батална.

15. КОМПАНИЙГ ООРЧЛОН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ, ӨР ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХ

15.1. Компанийн тухай хуульд зааснаар Компанийг хувааж, түсгаарлах, болон өөр хуулийн этгээдэд нэгтгэх, нийлүүлэх замаар өөрчлөн байгуулж болно.

15.2. Компанийг хувьцаа Эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгаж болно.

15.3. Хувьцаа Эзэмшигчдийн хурал нь татан буулгах комиссыг томилно.

15.4. Татан буулгах комисс томилсноор тухайн Компанийн бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжинэ.

15.5. Татан буулгах комисс нь татан буулгах ажлыг бүрэн гүйцэтгэсний дараа тайлан гаргана.

15.6. Татан буулгах комиссоос эзэлдүүлэгчийн өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгө нь Компанийн гүхай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгогдоно.

15.7. Татан буулгах комисс нь Компанийн тухай хуульд заасны дагуу ажиллан, Компанийг улсын бүртгэлийн байгууллагын улсын бүртгэлээс хасалт хийлгэснээр татан буугдах ажиллагаа дуусгавар болгоно.

15.8. Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн бууцтай үйл ажиллагааны улмаас Компанид ямар нэг хохирол учруулсан бол уг хохирлыг хуульд заасан журмын дагуу хариуцан арилгана.

15.9. Компанийг татан буулгах тохиолдолд давуу эрхийн хувьцаа эзэмшигчид төлөх төлбөр, түүнийг төлөх журам, дэс дарааллыг холбогдох хууль тогтоомж болон Компанийн шийдвэрийн дагуу зохицуулах бөгөөд энгийн хувьцаа эзэмшигчдээс тэргүүн ээлжинд давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд татан буулгалтын үнийг олгоно.

16. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

16.1. Энэхүү Дүрэм, Компанийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн хувьцаа эзэмшигчдийн хурал шийдвэрлэж чадаагүй, эсхүл тухайн шийдвэрийг эс зөвшөөрсөнтэй холбоотой аливаа маргааныг гагцхүү шүүхээр шийдвэрлүүлнэ.

17. БУСАД ЗҮЙЛ

17.1. Компани нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс батлагдсан холбогдох заавар, журмыг мөрдөн ажиллана.

17.2. Энэхүү Дүрэм нь бүртгэх байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

ИНВЕСКОР ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ ТӨЛӨӨЛЖ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.БАЯСГАЛАН

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

ИНВЕСКОР ББСБ ХК
(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

Аудитлагдсан Санхүүгийн Тайлан
2024 оны 12 дугаар сарын 31

тайлан

2025/11/28

2025 -12- 25
БҮРТГЭВ-02
2025 12 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ИНВЕСКОР ББСБ ХК

Агуулга – 2024 оны 12 дугаар сарын 31

Агуулга	Хуудас
Компанийн талаарх мэдээлэл	1
Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл	2
Төвчилсөн үзүүлэлтийн жагсаалт	3
Харааг бус аудиторын дүгнэлт	4-7
Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	8
Санхүүгийн байдлын тайлан	9
Өмчийн өөрчлөлтийн тайлан	10
Мөнгөн гүйлгээний тайлан	11-12
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	13-68

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЭК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

ИНВЕСКОР ББСБ ХК

Ерөнхий мэдээлэл

Гүйцэтгэх удирлага	Гүйцэтгэх захирал	Д.Баясгалан
	Хөрөнгө оруулалт хариуцсан захирал	С.Тулга
	Бизнес хариуцсан захирал	Ш.Оюунчимэг
	Дижитал үйлжил хариуцсан захирал	О.Тогтадор
	Үйл ажиллагаа хариуцсан захирал	Ц.Алтанцэвэг
	Хүний нөөц хариуцсан захирал	З.Батцэцэг
Төлөөлөн удирдах зөвлөл	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	Б.Анхболд
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Д.Баясгалан
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Р.Пүрэв
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Т.Тэлмэн
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн	Намики Хирохито
	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	Д.Энхбат
	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	Ч.Өнөржаргал
	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн	Ч.Хашчулуун
	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга	Б.Буд
Албан ёсны хаяг	**Инвескор ББСБ ХК** 14-р давхар, Ай Си Тауэр барилга, Парисын гудамж, 1 хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс	
Аудитор	**Эрнст энд Янг Монголия Аудит ХХК** 15-р давхар, Алтан Жолоо Тауэр Сөүлийн гудамж, 13А Улаанбаатар хот, Монгол Улс	

2025/11/28

ИНВЕСКОР ББСБ ХК

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга ба гүйцэтгэх удирдлагын эцэслэл

Инвескор ББСБ ХК-ийн (цаашид "Компани" гэх)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ")-ийн дарга Баянмөнхийн Анхболд, Гүйцэтгэх захирал Далайжамцын Баясгалан, Санхүүгийн бүртгэл, Тайлагналын Газрын захирал Ганхуягийн Ариунзул, бид Компанийн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал болон тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс батлаж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын ("СТОУС")-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

Баянмөнхийн Анхболд
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
Дарга

Далайжамцын Баясгалан
Гүйцэтгэх Захирал

Ганхуягийн Ариунзул
Санхүүгийн Бүртгэл, Тайлагналын
Газрын Захирал

Монгол улс, Улаанбаатар хот
Огноо: 2025 оны 4 дүгээр сарын 11

166

2025/11/28

InvesCore FI
2025-12-31
БҮРТГЭВ-02

2025 12 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ХО	Хорогдуулсан өртөг
ХБЗА	Худалдаж буй хөрөнгийн алдагдал
ҮАХТ	Үр ашигт хүүгийн түвшин
БҮЦБДО	Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлого
БҮЦАА	Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдал
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд
СТОУС 7	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 7: Санхүүгийн хэрэглүүрийн тодруулга
СТОУС 9	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 9: Санхүүгийн хэрэглүүр
СТОУС 13	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 13: Бодит үнэ цэнийн хэмжилт
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
НББОУСЗ	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл
СТОУТХ	Санхүүгийн тайлагналын олон улсын тайлбарын хороо
АУМ	Алдагдал үүсэх магадлал
БДО	Бусад дэлгэрэнгүй орлого
ТТБМ	Төлбөр төлөгдөхгүй байх магадлал
ЗҮТБХТ	Зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр
МИК	Монголын Ипотекийн Корпораци
НХНА	Нэгж хувьцаанд ногдох ашиг

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ASS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317859 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Голомт Капитал УЦК ХХК
Голомт Капитал
1119259111 5481569
Улаанбаатар хот

167

2025/11/28

2025 -12- 1
БҮРТГЭБ-02

2025 12. 25
БҮРТГЭВ
№ 01

Ernst & Young Mongolia Audit LLC
15/F, Altan Joloo Tower
Seoul Street 13/A
Ulaanbaatar 14252
Mongolia

tel: +976 11 314032 / +976 11 312695
ey.com

Building a better working world

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Инвескор ББСБ ХК-ний хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид Инвескор ББСБ ХК (цаашид "Компани" гэх)-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдроор дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдэх санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээрх нэрлэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал, тухайн өдөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НББОУСЗ")-өөс батлаж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу материаллаг ачаагаар, бодитойгоор илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандартууд ("АОУС")-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээсэн бидний үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн *"Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага"* хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс батлагдсан *"Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"*-ийн дагуу Компанитай харааг бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд гэдэг нь тайланг жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их ач холбогдолтой байсан гэж аудиторын мэргэжлийн үнэлэмжээр үзсэн асуудлууд юм. Эдгээр асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь анхаарч, аудиторын дүгнэлт өгөхдөө авч үзсэн бөгөөд бид эдгээр асуудлуудын талаар тусдаа дүгнэлт гаргадаггүй болно. Аудитын гол асуудлыг бид хэрхэн авч үзсэн талаарх тайлбарыг доор өгөв.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт дурдсан үүрэг хариуцлагууд болон эдгээр асуудлуудтай холбоотой үүрэг хариуцлагыг бид бүрэн биелүүлсэн. Үүний дагуу бид санхүүгийн тайлангуудын материаллаг бурууг илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээнд тохирсон аудитын горимуудыг гүйцэтгэсэн. Дор дурдсан асуудлыг анхаарч үзэхдээ гүйцэтгэсэн горимуудыг багтаасан аудитын горимуудын үр дүн нь энэ хавсаргасан санхүүгийн тайлангуудад өгсөн бидний аудитын дүгнэлтийн үндэслэл болно.

Аудитын гол асуудал	Гүйцэтгэсэн аудитын горимууд
Зохицуулагч компанийн бууралт	
Удирдлага нь хөрөнгө оруулсан өртгөөр бүртгэгдсэн хөрөнгө оруулагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг тооцохдоо үнэлэмж болон өндөр түвшний төсөөлөл ашигладаг. 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар хөрөнгө оруулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулагчдад олгосон зээл болон урьдчилгаа нь 591,005,452 мянган төгрөг бүху Компанийн нийт хөрөнгийн 76.2%-ийг эзэлж байгаа бөгөөд холбогдох тооцооллын тодорхойгүй байдлаас үүдэн хөрөнгө оруулагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг бид аудитын гол асуудал гэж үзсэн.	2024 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаарх хөрөнгө оруулагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдлын санг тооцоолох аргачлалыг үнэлэхдээ бид компанийн ХБЗА-ыг багтаах, бүртгэх, хянах хяналтын загвар болон үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг үнэлэх, мөн хөрөнгө оруулагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг тооцоолох ХБЗА-ын загварт компанийн ашигласан арга зүй, өгөгдөл, төсөөлүүдийг үнэлэх зэрэг аудитын горимуудыг гүйцэтгэсэн. Дээр дурдсан горимуудаас гадна бид Компанийн ХБЗА-ын загвар болон ашигласан арга зүй, таамаглалын үндэслэлийн талаарх ойлголтыг авч, загварын үндэслэлгүй байдлыг үнэлж, салбарын жишгээр харьцуулсан.

A member firm of Ernst & Young Global Limited

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Голомт Капитал УЦК ХХК
Golomt Capital
1119299111 5451599
Улаанбаатар хот

2025/11/28

InvesCore FI
БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга
2025 12. 25
БҮРТГЭВ
№ 01

EY
Building a better working world

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Инвескор ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд (үргэлжлэл)

Аудитын гол асуудал

Зээлийн үнэ цэнийн бууралт

Үнэ цэнийн бууралтын арга/аргачлал нь ирээдүйг таамагласан Хүлээгдэж Буй Зээлийн Алдагдал (ХБЗА)-ын загварт суурилсан. Энэхүү ХБЗА-ын загварын бүрэлдэхүүн хэсгүүд нь нэхэмжлэл төсөөлөл, болон тооцоолол шаардлагатай. Үүнд:

- ХБЗА загвар боловсруулах, загварын гол өгөгдлүүд болох Төлбөр Төлөгдөхгүй Байх Магадлал ("ТТБМ") болон Алдагдал үүсэх магадлал ("АҮМ")-ыг сонгох;
- Чанаргүйдэлд Өртөх Дүн ("ЧӨД") болон ашиглагдаагүй зээлийн үүргийн хервүүлэлтийн коэффициентийг тодорхойлох; ба
- ХБЗА-ын загварт орууллах эдийн засгийн өгөгдлүүдийг тодорхойлохын тулд ирээдүйн макро эдийн засгийн хувилбаруудыг сонгох, мөн тэдгээрийг магадлалаар нь жинлэх;

Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлого болон нягтлан бодох бүртгэлийн гол тооцоолууд болон үнэлэмжүүдийг Санхүүгийн тайлангийн Тодруулга 3-т толилуулсан.

Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа мөн тэдгээртэй холбогдох зээлийн эрсдэлийн удирдлагын тодруулгуудыг санхүүгийн тайлангийн Тодруулга 2.4, 7, 13, 35-д тус тус толилуулсан.

Гүйцэтгэсэн аудитын горимууд

Түүчлэн бид ашиглаасан таамаглалуудын үндэслэлтэй байдал, шаталлын ангиллын үндэслэл, ТТБМ, АҮМ болон ЧӨД-ийг тодорхойлох онөвчтой байдаа, загварт тусгагдсан макро эдийн засгийн хэтийн хувьсагчдыг авч үзсэн.

Шаталлын ангилаа зохистой эсэхийг шалгахдаа бид тайлант өдрийн байдлаар зээлийн хугацаа хэтрэлтийн мэдээлэл, ХБЗА-ын загвар ашиглаасан гол өгөгдлүүдийн Компанийн боломжит дотоод эх үүсвэрээс олж авсан түүхэн мэдээлэл, гадаад эх үүсвэрээс олж авсан тухайн салбарын болон санхүү, эдийн засгийн мэдээллүүдтэй харьцуулсан. Бидний хяналтын горимд дараах ажлууд багтсан. Үүнд:

- Санамсаргүй түүврийн аргаар, ТТБМ, АҮМ-ыг дотоод болон гадаад эх сурвалжийн мэдээллүүдтэй харьцуулсан;
- Зээлийн хервүүлэлтийн үүнд зүйлсийн таамагланыг оролцуулан ашиглаасан ЧӨД-ийн зохистой байдлыг санамсаргүй түүврийн үндсэн дээр үнэлсэн, ; ба
- Макро эдийн засгийн хэмжүүрүүдийг боломжит гадаад эх сурвалжийн мэдээллүүдтэй тулгасан;

Бид ХБЗА-ын загварын гол өгөгдлүүдэд ашигласан үнэлэмжүүдийн туршлагатай байдлыг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулах байдлаар авч үзсэн.

Мөн бид санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгуудын зохистой байдлыг үнэлсэн.

Жилийн тайланд тусгагдсан бусад мэдээлэл

Компанийн Захирлууд болон Гүйцэтгэх удирдлагууд бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэст аудитын тайлан гарсан өдрөөс хойш гарахаар хүлээгдэж буй жилийн тайланд тусгагдах санхүүгийн тайлангууд болон тэдгээрт хамаарах аудиторын тайлангаас бусад мэдээлэл ("Бусад хэсэг") багтана.

Санхүүгийн тайлангуудад өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээлэлд хамрахгүй бөгөөд тэдгээрт ямаа хэлбэрийн баталгаажуулах дүгнэлт гаргадаггүй болно.

Санхүүгийн тайлангуудын аудиттай холбоотой бидний хүлээх хариуцлага нь бусад мэдээллийг уншиж, тэдгээр нь санхүүгийн тайлангууд эсвэл аудитын явцад бидний олж авсан мэдээлэлтэй материалаг байдлаар зөрүүтэй эсвэл алдаатай эсэхийг харгалзаж үзэх явдал юм.

A member firm of Ernst & Young Global Limited

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УДК" ХХК
InvesCore CAPITAL
8317839 5119277128
УЛААНБААТАР ХОТ

169

2025/11/28

2025 оны 12 дугаар сарын 25
БҮРТГЭВ-02
СЭХ
он 2025 сар 12 сар 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Building a better working world

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Инвескор ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Жилийн тайланд тусгагдсан бусад мэдээлэл (үргэлжлэл)

Жилийн тайлангийн "Бусад хэсэг"-ийг уншиж үед гэнд материаллаг бурүу илэрхийлэл байна гэж дүгнэхэд ур асуудлын талаар бид засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгдэх шаардлагатай байдаг.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, бодитойгоор илэрхийлэх ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг дүнг бурүу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгохоо шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүсэх материаллаг бурүу илэрхийлэлээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анхаг эсх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"-ын дагуу хийгдэх аудит нь оршин байгаа материаллаг бурүу илэрхийллийг байнга нарүүлэх гэсэн баталгаа биш юм. Бурүу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материалагт тооцогдоно.

"АОУС"-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэмж, мэргэжлийн ул итгэх зарчмыг барьцлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг бурүу илэрхийлэлийн эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловеруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, бурүу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг бурүу илэрхийллийг нарүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан бурүу илэрхийллийг нарүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдлыг дүгнэхэд өгөх зорилгоор биш гүхайн нөхцөл байдлын тохирохуйц аудитын горим боловеруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэгүүлсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.

A member firm of Ernst & Young Global Limited

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЭК ХХК
InvesCore Growth OBS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
170
InvesCore CAPITAL
6317833 △1119277125
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

InvesCore FI
БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга
2025.12.25
БҮРТГЭВ
№ 01

EY
Building a better working world

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (УРГЭЛЖЛЭЛ)

Инвескор ББСБ ХК нийт хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитын аудиторын хариуцлага (үргэлжлэл)

- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь бодитой үзэхийлэгдэх шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дүгнэлт болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгдэг.

Мөн бид өөрсдийн хараат бус байдлын хөндсөн ёс зүйн шаардлагуудыг хангасан тухай мэдэгдлийг засаглал хариуцсан этгээдүүдэд хүргэж, бидний хараат бус байдалд зохистойгоор хамааралтай гэж үзэж болох бүхий л харилцаа болон бусад асуудлуудын талаар болон хэрвээ шаардлагатай тохиолдолд аливаа эрсдэлийг арилгахаар авсан арга хэмжээг мэдэгдэг.

Засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгдсэн асуудлаас бид тухайн зайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлансийн аудитад хамгийн өндөр ач холбогдолтой бүхий асуудлуудыг аудитын онцгойлсон асуудлууд гэж тодорхойлдог. Хууль тогтоомж нь уг асуудлуудын талаар олон нийтэд мэдээлэхийг хоригдсон эсхүл тун хөвөр тохиолдолд аудиторын тайланд тухайн асуудлуудын талаар мэдээлэх нь олон нийтийн хүртэх үр өгөөжөөс илүү сөрөг үр дагаварт гэж үзэхээр бусад тохиолдолд тэдгээр асуудлуудыг бид аудиторын тайландаа толилуулдаг.

Бусад зүйл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дууссавар болсон жилийн эцсийн компанийн санхүүгийн тайлангуудад өөр аудитор аудит хийж гүйцэтгэсэн ба 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдөр эдгээр санхүүгийн тайлангуудын талаар зөрчилгүй дүгнэлт өгсөн.

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчийн захиалгаар аудитыг гүйцэтгэсэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Ernst & Young Mongolia Audit LLC

ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан:

Доржбатын Мандахбаяр
Партнер

Батлсан:

Адриан Чу
Партнер

Монгол улс, Улаанбаатар хот
Огноо: 2025 оны 4 дүгээр сарын 11

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ADR LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
171
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Голомт Капитал УЦК ХХК
Голомт Капитал
2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

2025 12 25
БҮРТГЭВ
№ 01

ИНВЕСКОР ББСБ ХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дууссаар болсон жилийн
Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

	Тодруулга	2024 мян.төг	2023 мян.төг
Үр ашигт хүүтэй арга тооцоолсон хүүгийн орлого	4	185,854,149	113,554,326
Үр ашигт хүүтэй арга тооцоолсон хүү болон түүнтэй адилтгах зардал	4	(77,519,560)	(43,893,877)
Бусад хүү болон түүнтэй адилтгах зардал	4	(1,883,565)	(195,251)
Хүүгийн цэвэр орлого		**106,451,024**	**69,465,198**
Хураамж ба шимтгэлийн орлого	5	429,880	232,541
Хураамж ба шимтгэлийн зардал	5	(16,017,010)	(537,661)
Хураамж, шимтгэлийн цэвэр зардал		**(15,587,130)**	**(305,120)**
БҮЦАА-аар илэрхийлэгдэх бусад санхүүгийн хэрэглүүрийн цэвэр алдагдал	6	(441,480)	(282,556)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал	7	(14,345,267)	(7,188,916)
Үйл ажиллагааны бусад орлого	8	3,011,455	2,792,054
Үйл ажиллагааны цэвэр орлого		**79,088,602**	**64,480,660**
Хүний нөөцийн зардал	9	(12,657,001)	(9,197,754)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	18	(1,110,974)	(845,282)
Ашиглах эрхтэй хөрөнгийн хорогдуулга	20	(794,405)	(1,092,496)
Биет бус хөрөнгийн хорогдуулга	19	(619,210)	(482,903)
Үйл ажиллагааны бусад зардал	10	(9,670,709)	(4,956,822)
Татварын өмнөх ашиг		**54,236,303**	**47,905,403**
Орлогын албан татварын зардал	11	(12,241,817)	(12,174,183)
Тайлант жилийн ашиг		**41,994,486**	**35,731,220**
Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр):	30		
Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг		554	472
Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг		534	472
Бусад дэлгэрэнгүй орлого:			
Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлангуу оохин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):			
Өмчийн аргаар бүртгэсэн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн нөөцийн цэвэр өөрчлөлт		1,636,635	(693,487)
Бусад дэлгэрэнгүй орлого/(зарлага), цэвэр		**1,636,635**	**(693,487)**
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		**43,631,121**	**35,037,733**

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth Asset LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
9317839 ᠳᠤᠨ1119277128
УЛААНБААТАР ХОТ

172

2025/11/28

МОНГОЛ ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIA STOCK EXCHANGE
InvesCore FI
БҮРТГЭВ-02

БҮРТГЭВ
No 01

ИНВЕСКОР ББСБ ХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх
Санхүүгийн байдлын тайлан

	Тод-руулга	2024 мян.төг	2023 мян.төг
Хөрөнгө			
Бэлэн ба банкин дахь мөнгө	12	120,981,762	75,680,796
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	13	591,005,452	441,545,228
БҮЦБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө	14	21,910,646	7,587,265
Бусад хөрөнгө	15	5,580,573	7,042,787
Өмчлөх бусад хөрөнгө	16	1,991,106	918,529
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	17	3,309,939	–
Үндсэн хөрөнгө	18	8,562,045	6,930,745
Биет бус хөрөнгө	19	2,817,910	4,741,328
Аливлах эрхтэй хөрөнгө	20	2,394,416	1,680,004
Охин компанидад оруулсан хөрөнгө оруулалт	21	15,676,146	8,654,091
Хойшлогдсон татварын хөрөнгө	11.3	947,428	–
Нийт хөрөнгө		775,177,423	554,780,773
Өр төлбөр			
Зээлээр авсан санхүүжилт	22	304,644,654	200,490,982
Бондын өр төлбөр	23	44,268,204	66,829,499
Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр	24	181,194,329	140,489,413
Хойдогч өглөг	25	1,333,156	1,818,929
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд	26	724,036	282,556
Орлогын албан татварын өглөг	11	3,346,020	5,897,994
Хойшлогдсон татварын өглөг	11	–	291,574
Бусад өр төлбөр	27	53,795,465	5,319,522
Түрээсийн өр төлбөр	28	2,625,099	1,561,527
Нийт өр төлбөр		591,930,963	422,981,996
Эздийн өмч			
Хувьцаат капитал	29	17,193,952	17,193,952
Нэмж төлөгдсөн капитал	29	29,820,733	29,820,733
Давуу эрхийн хувьцаа	29	11,831,009	–
Бусад нөөц	31	5,821,694	1,690,885
Хуримтлагдсан ашиг		118,579,072	83,093,207
Нийт эздийн өмч		183,246,460	131,798,777
Нийт өр төлбөр ба эздийн өмч		775,177,423	554,780,773

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ARS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
173
6317239 1119277129
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 - 12 - 31
БУРТГЭВ-02

2025 оны 12 дугаар сарын 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ИНВЕСКОР ББСБ ХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөр дуусгавар болсон жилийн
Өмчийн өөрчлөлтийн тайлан

	Хувьцаат капитал мян.төг Тодруулга 29	Өөрт төлөгдөөгүй капитал мян.төг Тодруулга 29	Дахин үнэлгээ хуньцаа мян.төг Тодруулга 29	Бусад нөөц мян.төг Тодруулга 31	Хуримтлагдсан ашиг мян.төг	Нийт эзэмшлийн үнэ мян.төг
2023 оны 1-р сарын 1-ний бөлэгдэр	17,193,952	29,820,733	–	2,384,371	50,240,270	99,639,327
			–			
Тайлант жилийн ашиг	–	–	–	–	35,731,220	35,731,220
Бусад дэлгэрэнгүй орлого	–	–	–	(693,487)	–	(693,487)
Төлсөн ногдол ашиг (Тодруулга 29)	–	–	–	–	(2,878,283)	(2,878,283)
2023 оны 12 сарын 31-ний бөлэгдэр	17,193,952	29,820,733	–	1,690,885	83,093,207	131,798,777
Тайлант жилийн ашиг	–	–	–	–	41,994,486	41,994,486
Бусад дэлгэрэнгүй орлого	–	–	–	1,636,635	–	1,636,635
Гэрээсэн дүүрэ эрхийн хуньцаа	–	–	12,000,000	–	–	12,000,000
Хуньцаа гаргахтай холбоотой зардал	–	–	(168,991)	–	–	(168,991)
Дахин үнэлгээний нөөц	–	–	–	(170,929)	170,929	–
Нөөцийн хөдөлгөөн*	–	–	–	2,665,103	(2,665,103)	–
Төлсөн ногдол ашиг (Тодруулга 29)	–	–	–	–	(4,014,447)	(4,014,447)
2024 оны 12 сарын 31-ний бөлэгдэр	17,193,952	29,820,733	11,831,009	5,821,694	118,579,872	183,246,460

*Нөөцөд тусгай зорилгынхын нөөц багтсан бөгөөд нөөцийн Санхүүгийн Зохицуулах Хороонд ("СЗХ") өмнөөгөөр нийцүүлэн бэлтгүүлсэн (Тодруулга 31).

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЭК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 [illegible] 9025001486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
[illegible]
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

ИНВЕСКОР ББСБ ХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дууссаныр болсон жилийн
Мөнгөн гүйлгээний тойлан (үргэлжлэл)

	Тод-руулга	2024 мян.тог	2023 мян.тог
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Татварын өмнөх ашиг		54,236,303	47,905,403
Тохируулга:			
Хүүгийн зардал	4	79,403,125	44,089,128
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэглүүрийн БҮЦ-ийн өөрчлөлт	6	441,480	282,556
Санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнийн бууралтын гарз	7	14,345,267	7,188,916
Үндсэн хөрөнгө борлуулсны олз, цэвэр	8	(19,294)	(5,090)
Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт	8	(814,437)	(73,556)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз	10	160,560	–
Ногдол ашгийн орлого	8	(1,054,683)	(1,693,300)
Өмчлөх бусад хөрөнгө борлуулсны гарз	10	118,112	–
Үндсэн хөрөнгө даатгасан хассаны гарз	10	61,003	91,764
Өмчлөх бусад хөрөнгө даатгасан хассаны гарз	16	–	(9,787)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	18	1,110,974	845,282
Бичиг бус хөрөнгийн хорогдуулга	19	619,210	482,903
Ашиглах эрхтэй хөрөнгийн хорогдуулга	20	794,405	1,092,496
Гадаад валютын ханшийн хэрэгжээгүй цэвэр зөрүү	10	720,403	141,279
Үйл ажиллагааны хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		**150,122,428**	**100,337,994**
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтүүд:			
3 сараас дээш хугацаатай банкуудаас авах авлага		(2,801,000)	(1,200,000)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа		(168,584,093)	(190,142,363)
Бусад хөрөнгө		(4,032,590)	(3,157,595)
Бусад өр төлбөр		49,043,656	4,418,489
Үндсэн үйл ажиллагаанаас хүлээн авсан/(зарцуулсан) мөнгөн гүйлгээ		**23,748,398**	**(89,743,475)**
Төлсөн орлогын албан татвар	11.2	(16,360,488)	(7,723,294)
Төлсөн түрээсийн өр төлбөрийн хүү		(491,463)	(200,259)
Төлсөн хүү		(64,864,897)	(36,915,749)
Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ		**(57,968,450)**	**(134,582,777)**
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	18	(2,828,004)	(6,643,907)
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		44,021	316,128
Биет бус хөрөнгийн худалдан авалт	19	(1,157,127)	(1,514,744)
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	19	2,461,335	–
Өмчлөх бусад хөрөнгө борлуулсны орлого		576,023	1,741,707
Хөрөнгө оруулалтын худалдан авалт		(19,990,320)	(3,693,480)
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		7,938,978	2,326,618
Хөрөнгө оруулалтын хугацаа дуусахад олсон орлого		–	33,507
Охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт		(6,235,439)	(2,937,687)
Хүлээн авсан ногдол ашиг		268,067	46,875
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ		**(18,922,466)**	**(10,324,983)**

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайланчийн салшгүй хэсэг болно.

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 12 31
БҮРТГЭВ-02

ОЗА
2025 12 25
ГГЭВ

ИНВЕСКОР ББСБ ХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дууссаар болсон жилийн
Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

	Тод-руулга	2024 мян.төг	2023 мян.төг
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Төлсөн ногдол ашиг		(4,014,447)	(2,878,283)
Зээлээр авсан санхүүжилтийн татан авалт		671,752,677	221,853,297
Зээлээр авсан санхүүжилтийн эргэн төлөлт		(561,224,231)	(86,463,220)
Харилцагчаас татсан итгэлцэл		262,855,012	36,488,273
Харилцагчдад төлсөн итгэлцэл		(226,956,171)	(12,722,611)
Гаргасан бонд		44,235,555	68,060,000
Бондын эргэн төлөлт		(66,300,000)	(46,101,096)
Түрээсийн үндсэн төлбөр	28	(597,253)	(1,264,128)
Санхүүгийн үйл ажиллагаанаас олсон цэвэр мөнгөн гүйлгээ		**119,751,142**	**176,972,232**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт		**42,860,226**	**32,064,472**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө эхний үлдэгдэл	12	**74,493,331**	**42,345,147**
Гадаад валютын ханшийн зөрүү		(354,218)	83,712
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө эцсийн үлдэгдэл	12	**116,999,339**	**74,493,331**
Хүүтэй холбоотой мөнгөн гүйлгээ:			
Хүлээн авсан хүүгийн орлого		**185,742,411**	**103,090,838**
Хүүний төлөлт		**(62,915,786)**	**(36,915,749)**

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнээс үүссэн өр төлбөрийн хөдөлгөөн:

	Зээлээр авсан санхүүжилт		Бондын өглөг	
	2024 мян.төг	2023 мян.төг	2024 мян.төг	2023 мян.төг
1 сарын 1-нээр	**280,490,982**	**63,749,950**	**66,829,499**	**44,170,514**
Шинээр нэмэгдсэн	671,752,677	221,853,297	44,235,555	68,060,000
Хуримтлагдсан хүү	28,900,412	12,340,045	13,885,814	9,269,159
Хүүгийн төлөлт	(23,814,751)	(10,494,231)	(14,382,664)	(8,569,078)
Үндсэн зээлийн эргэн төлөлт	(561,224,231)	(86,463,220)	(66,300,000)	(46,101,096)
Хувьцаа руу шилжүүлсэн	(12,000,000)	(494,859)	–	–
Гадаад валютын ханшийн хөдөлгөөн	539,565	–	–	–
12 сарын 31-нээр	**304,644,654**	**200,490,982**	**44,268,204**	**66,829,499**

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277129
УЛААНБААТАР ХОТ

176

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
InvesCore FI
БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга
2025 12 25
БҮРТГЭВ
No. 01

ИНВЕСКОР ББСБ ХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

	Нэгтгэлээ		Хорвох боломжтой бонд	
	2024	2023	2024	2023
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
1 сарын 1-нээр	140,489,413	111,873,636	1,818,929	2,242,798
Шинээр нэмэгдсэн	262,855,012	36,488,273	–	–
Хүүгээгдсэн хүү	28,713,370	21,658,283	345,597	426,131
Хүүгийн төлөлт	(23,887,001)	(16,807,189)	(831,370)	(850,000)
Үндсэн зээлийн эргэн төлөлт	(226,956,171)	(12,722,611)	–	–
Гадаад валютын ханшийн хөдөлгөөн	(20,294)	(979)	–	–
12 сарын 31-нээр	181,194,329	140,489,413	1,333,156	1,818,929

	Түрээсийн өр төлбөр	
	2024	2023
	мян.төг	мян.төг
1 сарын 1-нээр	1,561,527	683,751
Мөнгөн бус нэмэлт	1,595,551	2,139,811
Түрээсийн өөрчлөлт	134,499	–
Цуцлагдсан түрээс	(69,605)	–
Тайлант хугацааны хүүгийн зардал	491,463	200,259
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн төлөлт	(491,463)	(200,259)
Түрээсийн өр төлбөрийн үндсэнтөлбөрийн төлөлт	(597,253)	(1,264,128)
Гадаад валютын ханшийн хөдөлгөөн	380	2,093
12 сарын 31-нээр	2,625,899	1,561,527

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
177
InvesCore CAPITAL
6317839 9111927712
УЛААНБААТАР ХОТ

Golomt Capital
2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

2025 -12- 25
БҮРТГЭВ
№ 01

ИНВЕСКОР ББСБ ХК

Санхүүгийн тайлангийн тодруулга
2024 оны 12 дугаар сарын 31

1. Компанийн мэдээлэл

Инвескор ББСБ ХК ("Компани") нь Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу, үүсгэн байгуулагчийн 2016 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн шийдвэрээр Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани хэлбэрээр үүсгүүдэгдсэн 2016 оны 04 дугаар сарын 30-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт Монгол Улсын хууль тогтоомжуудад нийцүүлэн бүртгүүлж регистрийн дугаар 6060854, 9010002004 тоот гэрчилгээг авсан.

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 159 дүгээр тогтоолын дагуу Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх 1/554 тоот тусгай зөвшөөрлийг авсан.

2019 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Монголын хөрөнгийн биржид нийт хувьцааныхаа 15 хувийг олон нийтэд санал болгосноор тус компани хувьцаат компани болсон.

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь зээл олгох, факторингийн үйл ажиллагаа, богино хугацаат санхүүгийн хэрэглүүрд хөрөнгө оруулах, итгэлцлийн үйлчилгээ, толбөрийн баталгаа гаргах юм.

Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн болон дүрмийн сан Тодруулга 29-д тодруулсан болно.

Компани нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 250 ажилтантай байсан (2023: 183).

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн тогтоолоор 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дууссаар болсон жилийн санхүүгийн тайлангуудыг гаргахыг зөвшөөрөв.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд

2.1. Тайлан бэлтгэх үндэслэл

Санхүүгийн тайлан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэсэн.

Санхүүгийн тайлан бэлтгэхэд баримталсан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг Тодруулга 2.4-т тусгасан бөгөөд өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд уг бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үеүдэд тууштай баримталж мөрдсөн болно.

Компанийн санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварынх нь дарааллаар толилуулсан. Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах 12 сарын дотор (богино хугацаанд) ба 12 сараас хойших хугацаанд (урт хугацаанд) хүлээн авах эсвэл төлөх төлбөрийн талаарх шинжилгээг Тодруулга 37-д толилуулсан.

Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд дүнгүүдийг мянганы оронгоор нарийвчилж, Компанийн үйл ажиллагааны валют болон Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр тайлагнасан.

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь нягтлан бодох бүртгэлийн таамаглал тооцоолол хэрэглэхийг шаарддаг. Мөн компанийн удирдлагаас нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд удирдлагаас үнэлгээ хэрэглэхийг шаарддаг. Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол, үнэлгээ, түүний санхүүгийн тайланг бэлтгэхэд үзүүлэх нөлөөг Тодруулга 3-т тусгасан болно.

Компани нь үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх гэсэн үндсэн дээр санхүүгийн тайланг гаргасан.

Компанийн нэгдсэн санхүүгийн тайланг мөн бэлтгэсэндээ бөгөөд Инвескор ББСБ ХК болон түүний охин компанидын нэгдсэн санхүүгийн тайлан нь Компанийн бүртгэлтэй хаяг дээр нийтэд нээлттэй байна.

Үнэлгээний үндэслэл

Санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад тусгайлан тодруулснаас бусад зүйлсийн хувьд түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн болно (дэлгэрэнгүйг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэсгээс үзнэ үү):

- БҮЦБДО-оор илэрхийлсэн санхүүгийн хөрөнгүүр
- БҮЦАА-аар илэрхийлсэн үүсмэл санхүүгийн хөрөнгүүр
- Өмчлөх бусад хөрөнгө – түүхэн өртөг эсвэл борлуулалтын зардлыг хассан зах зээлийн үнэлгээний аль бага дүнгээр бүртгэгдэнэ.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ETS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6200039 рд.1119277123
УЛААНБААТАР ХОТ

178

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
InvesCore FI
2025 12 31
БҮРТГЭВ-02

ҮЦТХ
2025 оны 12 дугаар сар 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ИНВЕСКОР ББСБ ХК

Санхүүгийн тайлангийн тодруулга
2024 оны 12 дугаар сарын 31

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

2.2. Шинэ болон нэмэлт өөрчлөлт оруулсан стандарт, тайлбар

2024 оны анх удаа хэрэглэж бусад нэмэлт өөрчлөлт, тайлбарыг доор тэмдэглэн харуулав.

• НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлтүүд	*Богино хугацаат болон биелүүлэх нөхцөл шаардлагуутай урт хугацаат өр төлбөрийн ангилал*
• СТОУС 16-ийн нэмэлт өөрчлөлтүүд	*Борлуулалт буцаан түрээслэсэн хөрөнгийн түрээсийн өр төлбөр*
• СТОУС 7 болон НББОУС 7-ийн нэмэлт өөрчлөлтүүд	*Бэлэгсэн нийлүүлэгчийн санхүүжилтийн зохицуулалт*

Эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь тайлант хугацаанд Компанийн санхүүгийн тайланд ямар нэгэн нөлөө үзүүлээгүй.

2.3. Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд

Энэхүү албан бичиг Тайлангийн салшгүй хэсэг байна.

Хүндэтгэсэн,

"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН ГИШҮҮН, ХУУЛЬЧ

Д.ДҮГЭРЖАВ

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЭК ХХК
InvesCore
Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
8317039 ⁂1119277120
УЛААНБААТАР ХОТ

338

2025/11/28

АГУУЛГА

НЭГ. УДИРТГАЛ 5

Дүн шинжилгээний зорилго 5

Ажлын хийж гүйцэтгэсэн хугацаа, баг 5

Тайлангийн үр өгөөж 5

Тасалбар болгох өдөр, сонгогдсон зээлийн дансдын мэдээлэл 5

Дүн шинжилгээ хийсэн арга зүй 8

Тайлан гаргахад үндэслэл болгон ашигласан баримт бичиг 8

Хангагдсанд тооцох нөхцөл 10

Материал хадгалах хугацаа 11

ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ХОЛБОГДОХ ДҮГНЭЛТ 11

Шалгуур үзүүлэлт 1. Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх. 11

Шалгуур үзүүлэлт 2. Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хууль нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа (фидуцийн) хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх; 13

Шалгуур үзүүлэлт 3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх. 14

Шалгуур үзүүлэлт 4. Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ, эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуци болон барьцаа зүйлийн холбогдох эрхийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй, эсхүл хязгаарлаагүй байх. 14

Шалгуур үзүүлэлт 5. Зээлтэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хууль нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, түүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх. 15

Шалгуур үзүүлэлт 6. Фидуцийн болон барьцааны гэрээ хүчин төгөлдөр байлгахад Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх. 16

Нэгдсэн дүгнэлт 17

Хавсралт 1. Түүврийн аргаар сонгогдсон зээлийн статус 20

Хавсралт 2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн үйл ажиллагаатай холбоотой тайлбар, тодруулга 22

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

339

2025/11/28

НЭГ. УДИРТГАЛ

Дүн шинжилгээний зорилго

МДСХ нь ХБҮЦ-ийн хэлцэлд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдахаар санал болгосон зээлийн хөрөнгийн багцаас нийт зээлийн багцын үнийн дүнгээр 95%-ийн итгэлцлийн түвшин, 5%-ийн хүлээгдэж буй алдааны дээд хязгаартай байхаар тооцож, нийт зээлийн багцын үнийн дүнгийн 9,19%-тай тэнцэх 83 зээлийн дансыг сонгож, тэдгээр нь Хуулийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээ хийж, дүн шинжилгээний материалыг үндэслэн Тайлан гаргах зорилготой.

Ажлын хийж гүйцэтгэсэн хугацаа, баг

МДСХ нь Хөндлөнгийн дүн шинжилгээг 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Тайлангийн үр өгөөж

Энэхүү Тайланг үнэт цаасжуулах ажиллагаатай нь холбогдуулан зөвхөн Үнэт цаас гаргагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид зориулан гаргасан бөгөөд энэхүү Тайлангийн үр өгөөжийг Үнэт цаас гаргагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хүртэх эрхтэй байна.

Тасалбар болгох өдөр, сонгогдсон зээлийн дансдын мэдээлэл

Хөндлөнгийн дүн шинжилгээг 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөр тасалбар болгон гүйцэтгэсэн бөгөөд уг хугацаанаас хойш нөхцөл байдал өөрчлөгдөж болно.

МДСХ нь Хөндлөнгийн дүн шинжилгээг хийхдээ санхүүгийн хөндлөнгийн шинжээчийн сонгосон зээлийн данстай давхардаагүй зээлийн дансдыг сонгож дүн шинжилгээ хийсэн болно. ББСБ-аас бүрдүүлсэн хөрөнгийн багц нь тээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлээс бүрдэх бөгөөд МДСХ нь хөрөнгийн багцын жагсаалт дахь нийт 61,097,267,982 төгрөгийн үнийн дүн бүхий 1672 зээлийн дансдаас дараах нөхцөл, шалгуурыг харгалзан, түүврийн аргаар 5,644,069,407 төгрөгийн үнийн дүн бүхий 83 зээлийн дансдыг сонгосон болно:

- Салбар бүрээс тээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл хамруулах (зарим салбарт үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл олгоогүй тул тэдгээр салбарт үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл байхгүй байж болно);
- Зээлийн багц дахь барьцаа хөрөнгө (тээврийн хэрэгсэл болон үл хөдлөх)-ийн эзлэх хувь хэмжээ ойролцоо түвшинд байх;
- Үл хөдлөх хөрөнгийн барьцааны хувьд газар, орон сууц, хашаа байшин, үйлдвэрийн зориулалттай бүс зэрэг бүх төрлийн үл хөдлөх хөрөнгийг оролцуулах;
- Зээл олгосон хугацаа ойролцоо түвшинд байх;
- Зээлийн төлөгдөөгүй үлдэгдлийн хэмжээ дундаж үнийн дүнгээс багагүй байх (зарим цөөн зээлтэй салбарын хувьд үнийн дүн бага байж болно)

Түүврийн аргаар сонгогдсон дансдын мэдээллийг танилцуулбал:

Барьцаа хөрөнгийн төрлөөр:

Хөрөнгийн багц нь (1) Автотээврийн хэрэгсэл болон (2) үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлээс бүрдэж байна. Нийт 1672 зээлээс Автотээврийн хэрэгслийн зээл 1601, үл хөдлөх хөрөнгийн зээл 71 байх бөгөөд зээлийн үлдэгдлээр хөрөнгийн багцад эзлэх хувийг жилээвэл, Автотээврийн хэрэгслийн зээл нь нийт зээлийн багцын 91 хувь, үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл нь нийт зээлийн багцын 9 хувийг тус тус эзэлж байна. МДСХ нь түүврийн аргаар зээлийн дансдыг сонгохдоо ББСБ-ын салбар бүрээс автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийг хамруулж, барьцаа хөрөнгийн төрөл тус бүрийн нийт хөрөнгийн багцад эзлэх хувь

2025/11/28

InvesCore FI
2025 -12-
БУРТГЭВ-02

2025 оны 12. 26-ны
БУРТГЭВ
№ 01

хэмжээтэй ойролцоо хэмжээгээр сонгосон болно. Сонгогдсон 83 зээлийн 68 нь Автотээврийн хэрэгслийн зээл, 15 нь үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл бүху зээлийн үлдэгдэл дүнгээр жинлэвэл, Автотээврийн хэрэгслийн зээл нь сонгогдсон зээлийн түүврийн 76 хувь, үл хөдлөх барьцаалсан зээл нь сонгогдсон зээлийн түүврийн 24 хувийг тус тус эзэлж байна.

График 1. Хөрөнгийн багцын барьцаа хөрөнгийн төрөл



График 2. Зээлийн түүврийн барьцаа хөрөнгийн төрөл

Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хувьд үл хөдлөх нь орон сууц, нийтийн орон сууц, автозогсоол, амины орон сууц, газар өмчлөх, эзэмших эрх, үйлдвэрийн зориулалттай үл хөдлөх хөрөнгө зэрэг олон шинж чанартай байх бөгөөд МДСХ нь зээлийн түүврийг сонгохдоо үл хөдлөх хөрөнгийн олон талт шинж чанарыг агуулсан зээлийг түүвэрлэсэн болно.

Тасалбар болгох өдрийн байдлаар Хөрөнгийн багцад Дорноговь аймаг, Сонголон, Энхтайван, Автоэкспо салбарт үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл байхгүй байна.

Зээл олгосон салбарын тоогоор:

Хөрөнгийн багц дахь мэдээллээс үзвэл, 1507 зээл Улаанбаатар хотод, 165 зээл орон нутагт олгогдсон байна. МДСХ нь зээлийн түүврийг сонгохдоо бүх салбарын зээлийг хамруулсан болно:

№	Салбар	Хөрөнгийн багц дахь зээлийн тоо	МДСХ-н сонгосон зээлийн тоо
	Улаанбаатар хот дахь салбар:	**1507**	76
1.	Авто иогиолбор салбар	279	10
2.	Авто экспо салбар	125	5
3.	Баянзүрх салбар	112	4
4.	Да хүрээ салбар	344	12
5.	Дүнжингарав салбар	77	5
6.	Их Монгол салбар	49	4
7.	Сонголон салбар	16	2
8.	Төв салбар	54	4
9.	Тэнгис салбар	43	4
10.	Хан-Уул салбар	174	9
11.	Шангри-Ла салбар	6	2
12.	Энхтайван салбар	12	2
13.	Ярмаг салбар	81	7
14.	10-р хороолол салбар	135	6
	Орон нутаг дахь салбар:	**165**	7
15.	Эрдэнэт салбар	88	3
16.	Дархан салбар	66	3
17.	Дорноговь салбар	11	1

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore GROWTH ASSET LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

341

2025/11/28

	Нийт тоо	1672	83

Хүснэгт 4. Хөрөнгийн багц болон Зээлийн түүврийн салбарын үзүүлэлт

Зээл олгосон хугацаагаар:

Хөрөнгийн багц нь ББСБ-ын 2021, 2022, 2023, 2024, 2025 онд тус тус олгогдсон зээлээс бүрдсэн байна. Тодруулбал, нийт 1672 зээлээс 2021 онд олгогдсон 1 зээл, 2022 онд олгогдсон 9 зээл, 2023 онд олгогдсон 85 зээл, 2024 онд олгогдсон 640 зээл, 2025 онд олгогдсон 937 зээл байх бөгөөд зээлийн үлдэгдэл үнийн дүнгээр жилээвэл, 2021 оны зээл 0.1 хувь, 2022 оны зээл 0.4 хувь, 2023 оны зээл 7 хувь, 2024 оны зээл 35 хувь, 2025 оны зээл 57 хувийг эзэлж байна. МДСХ нь зээлийн түүврийг сонгохдоо хөрөнгийн багцад эзлэх зээлийн хувь хэмжээтэй ойролцоо түвшний зээлүүдийг сонгосон буюу үүнээс 2023 оны 2 зээл, 2024 оны 39 зээл, 2025 оны 42 зээлийг тус тус сонгосон болно. Зээлийн түүврийг үнийн дүнгийн эзлэх хувь хэмжээгээр дүйцүүлбэл, 2023 оны зээл 2 хувь, 2024 оны зээл 39 хувь, 2025 оны зээл 42 хувийг эзэлж байна. 2022 оны 4 зээлийн үлдэгдэл бага дүнтэй учир зээлийн түүвэрт сонгоогүй болно.

График 3. Хөрөнгийн багцын зээл олгосон оноор



График 4. Зээлийн түүврийн зээл олгосон оноор

Зээлийн түүврийн төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл:

МДСХ нь зээлийн түүврийг сонгохдоо зээлийн төлөгдөөгүй үлдэгдлийн хэмжээ дундаж үнийн дүнгээс багагүй байх шалгуурыг харгалзан сонгосон бөгөөд зарим цөөн зээлтэй салбарын хувьд тус үнийн дүнгээс бага байж болно. Хөрөнгийн багцын мэдээллээс үзвэл, зээлийн дундаж үлдэгдлийн хэмжээ 33,827,738 төгрөг байх бөгөөд зээлийн түүвэрт тус дүнгээс бага дүнтэй 9 зээл (цөөн зээлтэй салбаруудаас буюу Шангри-Ла, Тев салбар, Энхтайван, Дүнжингарав, Сонголон, Гэнгис салбар) дундаж үлдэгдлээс дээш үнийн дүнтэй 74 зээлийг сонгосон болно.



График 5. Зээлийн түүврийн төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
УЛААНБААТАР ХОТ

342

2025/11/28

Дүн шинжилгээ хийсэн аргачлал

Бид хөндлөнгийн дүн шинжилгээ хийхдээ сонгосон зээлийн дансны зээлийн хувийн хэрэг (зээлийн гэрээ, фидуцийн гэрээ, ипотекийн гэрээ, хувийн мэдээлэл, орлого нотолсон баримт зэрэг), түүнд агуулагдсан ББСБ-ын дотоод мэдээлэл, дүгнэлт, шийдвэр, бусад нотлох баримт, үйл баримтыг Үнэт цаас гаргагчтай урьдчилан тохиролцож, баталгаажуулан бэлтгэсэн шалгуур болон МДСХ-ийн зүгээс боловсруулсан шалгуурын дагуу шалгах, үнэлэх замаар түүврийн аргаар сонгогдсон зээлийн данснуд анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу "Инвескор ББСБ" ХК-аас цаасан болон цахим хэлбэрээр авч шалгах ажлыг өөрийн байранд биечлэн гүйцэтгэсэн.

Дүн шинжилгээ хийсэн арга зүй

МДСХ нь дүн шинжилгээ хийхдээ ХБҮЦ гаргах хэлцлийн хүрээнд Анхны үүрэг гүйцэтгүүлүүнэт цаас гаргагчаас тодорхойлсон хөрөнгийн багцад тавигдсан хуулийн 6 шалгуур үзүүлэлт, тэдгээрийн хүрээнд МДСХ-ийн зүгээс боловсруулсан 43 шалгуур (үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл), 33 шалгуур (Автотээврийн хэрэгслийн зээл) асуултын дагуу хууль тогтоомжийн хүрээнд ББСБ-ын гаргаж өгсөн зээлийн дансны хувийн хэрэг, түүнд агуулагдсан материал болон Тайлан гаргахад үндэслэл болгон ашигласан баримт бичиг, хууль тогтоомжид тулгуурлан бэлтгэлээ. Түүнчлэн дүн шинжилгээг гүйцэтгэхдээ Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс өгсөн зээлийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой тайлбар, тодруулгыг харгалзсан бөгөөд тус тайлбар, тодруулгыг энэ Тайлангийн Хавсралт 2-т тусгав.

Дүн шинжилгээ хийх явцад нэмэлт тодруулга, тайлбар, нотлох баримт шаардлагатай асуудлаар ББСБ-д тухай бүр цахим шуудан илгээж харин тайлбар, нотлох баримтуудыг хүлээн авсан болно.

МДСХ нь сонгогдсон зээлийн дансыг шалгуур асуултын дагуу шалгаж, харицулах замаар үнэлсэн. Зээлийн данс нь шалгуур үзүүлэлтийг хангасан түвшингээр нь улаан, шар, ногоон өнгөөр ялгаж тодруулсан. Үүнд:

★ - Зээлийн гэрээ, фидуцийн гэрээ, ипотекийн гэрээний аль нэг нь эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь хүчин төгөлдөр бусад тооцогдох эрсдэлтэй, хуулийн шаардлага хангаагүй зээлийн дансыг улаан өнгөөр тэмдэглэсэн.

☆ - Зээлийн гэрээ, фидуцийн гэрээ, ипотекийн гэрээний аль нэг нь эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь эрсдэлтэй байж болзошгүй, эрсдэлийн зэргийг дахин үнэлэх шаардлагатайг шар өнгөөр тэмдэглэсэн.

★ - Зээлийн гэрээ, фидуцийн гэрээ, ипотекийн гэрээний аль нэг нь зээлийн дансны шалгуур үзүүлэлт, хуулийн шаардлага хангасан, хүчин төгөлдөр зээлийн дансыг ногоон өнгөөр тэмдэглэсэн.

Нэгдсэн дүгнэлтийг гаргахдаа зээлийн дансыг бүрдүүлж буй зээлийн гэрээ, фидуцийн гэрээ, ипотекийн гэрээний аль нэг нь улаан, шар өнгөөр тэмдэглэгдсэн нөхцөлд зээлийн данс нь эрсдэлтэй бүлэгт орохоор тооцож үнэлсэн.

Тайлан гаргахад үндэслэл болгон ашигласан баримт бичиг

МДСХ нь зээлийн дүн шинжилгааг дор дурдсан материалуудтай танилцсаны үндсэн дээр гүйцэтгэж, энэхүү Тайланг гаргасан болно. Үүнд:

1. *Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлийн үйл ажиллагаанд зохицуулж буй дотоод дүрэм журам, баримт бичиг:*
   - 1.1. "Инвескор ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/13 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Зээлийн үйл ажиллагааны журам;
   - 1.2. "Инвескор ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны 7 дугаар сарын 30-ний өдрийн А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Барьцаа хөрөнгийн үнэлгээний журам;

343

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025-12-31
БҮРТГЭВ-02

2025 12 25
БҮРТГЭВ
№ 01

1.3. "Инвескор ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/31 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Зээлийн хорооны үйл ажиллагааны журам;

1.4. "Инвескор ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/212 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Зээлийн эрсдэлийн удирдлагын журам;

1.5. "Инвескор ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/168 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Зээлийн хувийн хэрэг бүртгэлийн журам;

1.6. "Инвескор ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/106 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Барьцаа хөрөнгийн үнэлгээний журам;

1.7. "Инвескор ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн А/97 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Зээлийн скоринг хөгжүүлэлтийн журам;

1.8. "Инвескор ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 44 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан Зээлийн бодлого;

1.9. "Инвескор ББСБ" ХК-ийн Бизнес хариуцсан захирлын 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн А/08 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Салбарын захирлын зээл шийдвэрлэх эрх шинэчлэн батлах тухай тушаал;

1.10. "Инвескор ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/158 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Зээлийн мониторингийн хяналт хийх журам;

1.11. "Инвескор ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/167 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Зээлийн мэдээллийн сангийн журам;

1.12. "Инвескор ББСБ" ХК-ийн Зээлийн хорооны 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 3/50 дугаар "Бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий нөхцөлд шинэчлэлт оруулах тухай" тогтоол.

2. *Хууль:*

2.1. Иргэний хууль (2002);
2.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002);
2.3. Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2021);
2.4. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль (2009);
2.5. Улсын бүртгэлийн ерөнхий хууль (2018);
2.6. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ (2018);
2.7. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль (2010);
2.8. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2013);
2.9. Зээлийн мэдээллийн тухай хууль (2011);
2.10. Нотариатын тухай хууль (2011);
2.11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017);
2.12. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль (2009);
2.13. Автотээврийн тухай хууль (1999);
2.14. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль (2015);
2.15. Зөрчлийн тухай хууль (2017);
2.16. Даатгалын тухай хууль (2004);
2.17. Жолоочийн даатгалын тухай хууль (2011).

3. *Эрх бүхий байгууллагаас тогтоосон дүрэм, журам:*

3.1. СЗХ-ноос батлагдсан Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам (2025);
3.2. Засгийн газраас батлагдсан эд хөрөнгийн эрхийн бүртгэл хотлох журам (2018);
3.3. Монголбанкны ерөнхийлөгч, СЗХ-ны даргын хамтарсан тушаалаар батлагдсан үл хөдлөх эд хөрөнгө барьцаалуулагчид мэдээлэл өгөх журам (2010);

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
344
InvesCore CAPITAL
6317839 ⚓ 1119277128
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025-12-31
БҮРТГЭВ-02

2025.12.25
БҮРТГЭВ
№ 01

3.4. Монголбанкны ерөнхийлөгч, СЗХ-ны даргын хамтарсан тушаалаар батлагдсан Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах арга зүй (2023);
3.5. Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам (2018);
3.6. СЗХ-ноос батлагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам (2022);
3.7. МХБ-ээс батлагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам (2020);
3.8. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам (2020);
3.9. Бусад холбогдох хууль тогтоомж.

Хангагдсанд тооцох нөхцөл

Энэхүү Тайланг боловсруулахдаа бид дараах нөхцөл хангагдсан гэж үзсэн болно. Үүнд:

1. Бидний судлан шинжилсэн бүх баримт бичгийн хуулбар, эсхүл маягтууд нь үнэн зөв, тэдгээр дээрх тэмдэгтийн хураамжийн төлбөр нь төлөгдсөн гэсэн тэмдэглэгээ болон бусад аливаа тэмдэглэгээ, гарын үсэг, тамга тэмдэг нь үнэн;
2. Бүх баримт бичгүүд нь тэдгээрийг үйлдсэн талуудын бүрэн эрхийн хүрээнд үйлдэгдсэн бөгөөд одоо хүчин төгөлдөр байгаа, цаашид хүчин төгөлдөр хэвээр байх бөгөөд тэрхүү баримт бичгийн талуудын тухайн баримт бичгийн дагуу хүлээсэн үүрэг нь бүх холбогдох хуулийн хүрээнд бүрэн хүчин төгөлдөр хэрэгжинэ;
3. Бидэнд өгөгдсөн аливаа баримт бичгийн хуулбар, эсхүл цахим хувь нь тухайн баримт бичгийн эх хувьтайгаа нийцсэн бөгөөд тэдгээрийг бүрэн хуулбарласан, цаашид ямар нэгэн өөрчлөлт орохгүйгээр хүчин төгөлдөр хэрэгжинэ;
4. Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбарыг хувийн хэрэгт хавсаргасан бол эх хувь нь ББСБ-д хадгалагдаж байгаа;
5. Бидэнд өгөгдсөн баримт бичгийн дагуу үүсэх аливаа үүрэг нь Монгол Улсаас бусад эрх зүйн тогтолцоонд хүчин төгөлдөр байх ба тэдгээр үүргийн хэрэгжилт хууль бус, хүчин төгөлдөр бус, эсхүл хэрэгжих боломжгүй биш байна;
6. Монгол Улсаас өөр улсад үйлдэгдсэн аливаа баримт бичиг нь тийнхүү үйлдэгдсэн улсын хуулийн шаардлагыг хэлбэрийн болон агуулгын хувьд бүрэн хангасан, хүчин төгөлдөр баримт бичиг ба тэдгээрийн хэрэгжилт нь тийнхүү хэрэгжих улсын хуулийн шаардлагыг мөн хангасан болно;
7. Тухайн баримт бичгүүд дээр төрийн байгууллага болон бусад эрх бүхий байгууллагаас авах шаардлагатай зөвшөөрөл, батламжийг авсан, зохих шийдвэр гарсан, тэдгээр баримт бичгийг хүчин төгөлдөр болгоход шаардагдах аливаа бусад хэлцэл хийгдсэн, бусад баримт бичгүүд үйлдэгдсэн;
8. Төрийн эрх бүхий байгууллагын тодорхойлолт, лавлагаа, төрийн үйлчилгээний цахим мэдээллийн сангаас татсан мэдээлэл болон албан ёсны хэвлэмэл хуудас бүхий лавлагаа нь зээлийн хувийн хэрэгт байх тохиолдолд тус лавлагааг авахад шаардлагатай аливаа хураамж, төлбөрийг төлсөн;
9. "Инвескор ББСБ" ХК, түүний ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан аливаа мэдээлэл нь үнэн зөв, бодитой;
10. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын төлбөр бүрэн төлөгдсөн;
11. Зээлдэгчид зээл олгохын өмнө ББСБ нь фидуцийн зүйл болох тээврийн хэрэгслийн гэрчилгээ, гаалийн мэдүүлэг, татвар төлсөн эсэхийг авч цалгадаг;
12. Хөндлөнгийн санхүүгийн шинжээч нь өр орлого болон зээл үнэлгээний харьцаа, орлого нотлох баримтыг шалгадаг;
13. www.smartcar.mn вэбсайтад оруулсан мэдээллээр зээлдэгч нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгуулсан;
14. Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт тодорхойлсон зээлийн эргэн төлөлт нь холбогдох эрх бүхий этгээдийн батлагдсан дүрэм, журамд заасан хүү тооцоолох аргад нийцсэн;
15. Зээлийн гэрээ, фидуцийн гэрээ, ипотекийн гэрээн дэхь гарын үсэг нь зээлдэгч, барьцаалагчийн гарын үсэг мөн;

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЭК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
345
InvesCore CAPITAL
6317809 1119277128
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

2025 -12- 25
БҮРТГЭВ
№ 01

16. Автотээврийн хэрэгслийн улсын дугаарыг холбогдох стандарт, журмын дагуу олгосон.

Бид дараах нөхцөлөөр тайланг боловсруулсан болно. Үүнд:

1. Энэхүү Тайланд өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд энэхүү судалгаа шинжилгээ нь зөвхөн хууль зүйн асуудлаар хийгдсэн бөгөөд Автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлтэй холбоотой дурдагдсан аливаа тоон мэдээллүүдийн талаар бид нарийн мэдлэггүй, тэдгээрийн үнэн зөв байдлыг тогтоохгүй болно;
2. Энэхүү Тайланд өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд бидний хийсэн ажил энэхүү тайлангийн тайлбар хэсгийн судалгаа шинжилгээний ажлын хүрээгээр хязгаарлагдаж байгаа болно;
3. Энэхүү Тайланд тусгайлан дурдсанаас бусад аливаа судалгаа, шинжилгээ, асуулга хийгдээгүй болно. Тийнхүү хийгдээгүй судалгаа, шинжилгээ, асуулгын үндэс болсон аливаа мэдээлэл, бүртгэл нь бүрэн биш, шинэчлэгдээгүй, жишээ нь, тухайн баримт бичиг нь холбогдох эрх бүхий байгууллагад бүртгэгдээгүй, хувийн хэргээс устсан, алга болсон эсхүл бусад байдлаар хувийн хэрэгт байхгүй болсон байж болно;
4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүх баримт бичиг, гэрээ, төлөвлөгөө, харилцаа холбоо, зөвшөөрөл, хувийн хэрэгтэй танилцсан, тэдгээрийг судалсан гэх амлалтыг энэхүү судалгаа шинжилгээтэй холбоотой бид гаргахгүй болно;
5. Бидний судалгаа шинжилгээ нь энэхүү Тайлан гарах үед хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Монгол Улсын хуулийн хүрээнд хийгдсэн бөгөөд бид өөр бусад эрх зүйн тогтолцооны холбоо, хамаарал, нөлөөллийн талаар ямар нэгэн үзэл бодол илэрхийлээгүй болно;
6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс гаргуулан үзсэн зээлийн хувийн хэргүүдэд хийсэн судалгаа нь зээлийн хувийн хэргүүдийн ерөнхий төлөвлөлт, эсхүл тэрхүү хувийн хэргүүдийн багцын төлөвлөлт, эсхүл аливаа ерөнхий дүгнэлт, санал гаргахад хангалттай статистик мэдээлэл болж тайлбарлагдахгүй, тооцогдохгүй болно.
7. Түүврийн аргаар сонгосон зээлийн дансдаас бусад зээлийн данстай холбоотой дүгнэлт гаргаагүй болно;
8. Фидуци, барьцааны зүйл болох автотээврийн хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгийн бүрэн бүтэн байдал, эдэлгээ, чанарын талаар бид нарийн мэдлэггүй, тэдгээрийн болон түүний эзэмшлийн талаарх нөхцөл байдлыг тогтоохгүй болно.

Материал хадгалах хугацаа

МДСХ нь хуулийн тайлан гаргахад ашигласан болон судалгаа шинжилгээнд хамруулсан зээлийн данс бүрийг шалгаж баримтжуулсан баримт бичиг, эцсийн тайланг Үнэт цаас гаргагчид хүлээлгэж өгснөөс хойш 2 (хоёр) жилийн хугацаанд хадгална.

ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ХОЛБОГДОХ ДҮГНЭЛТ

Шалгуур үзүүлэлт 1. Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх.

МДСХ нь нэгдүгээр шалгуур үзүүлэлтийн хүрээнд түүврийн аргаар сонгогдсон нийт 83 зээлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч олгосон эсэх, фидуцийн гэрээний дагуу автотээврийн хэрэгслийн өмчлөгчөөр Анхны үүрэг гүйцэтгүүлэгч бүртгэгдсэн эсэх, ипотекийн гэрээний дагуу барьцаалсан үл хөдлөх хөрөнгийн барьцаалагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч эсэх, зээлийн мөнгөн төлбөрийн үүрэг болон фидуцийн зүйлийг шаардах эрх, барьцааны эрх нь гуравдагч этгээдийн шаардлагаас ангид эсэхийг нягталж шалгалаа.

Сонгогдсон зээлийн дансдын хувийн хэргээс үзвэл, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлдэгч (үндсэн болон зарим тохиолдолд хамтран зээлдэгч)-тэй зээлийн гэрээ байгуулж, зээлийн гэрээний үндсэн дээр автотээврийн хэрэгсэл барьцаалсан тэсэл бол фидуцийн гэрээ, үл хөдлөх хөрөнгө барьцаалсан бол ипотекийн гэрээ байгуулж, фидуцийн зүйлийн өмчлөх эрх, барьцааны бүртгэлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нэр дээр бүртгүүлсэн байна. Тодруулбал:

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
346
InvesCore CAPITAL
8317839 1119277129
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIA STOCK EXCHANGE
InvesCore FI
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

2025 12 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Фидуцийн гэрээний дагуу фидуцийн зүйл болох автотээврийн хэрэгсэл өмчлөх эрхийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлж, автотээврийн хэрэгсэл эзэмших, ашиглах эрх Зээлдэгчид байна. Сонгогдсон 83 зээлийн дансдын 68 нь автотээврийн хэрэгслийн зээл бөгөөд тэдгээр автотээврийн хэрэгсэл нь бүгд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд бүртгэгдсэн буюу автотээврийн хэрэгслийн гэрчилгээ (хуулбар хувь)-г бүртгэгчийн тамга, тэмдэглэгээгээр гэрчилснээс үзвэл, тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг бүртгэлийн байгууллага бүртгэж, баталгаажуулан, тээврийн хэрэгслийн гэрчилгээг ББСБ-д олгосон байна. Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 3.1, Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 8[1]-д зааснаар тээврийн хэрэгслийн жолооч нь тухайн тээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээтэй байх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ холбогдох бусад бичиг баримт бичигтэйгээр замын хөдөлгөөнд оролцохоор заасан. Иймхүү тус хууль тогтоомжийн дагуу ББСБ нь тээврийн хэрэгслийн гэрчилгээний эх хувийг хадгалах боломжгүй, зээлдэгчид хадгалагддаг байна.

Мөн Автотээврийн тухай хуулийн 17.1[2], Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21.2-д зааснаар бүх тээврийн хэрэгслийн гэрчилгээг авто тээврийн асуудал эрхэлсэн бүртгэлийн байгууллагаас олгосон байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21.2-д "*Импортоор оруулж ирсэн тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нь зохих техникийн норм, дүрэм, стандарт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлт буюу гэрчилгээгээр баталгаажсан байна*" гэж, мөн хуулийн 21.4-д "*Замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага хангасныг гэрчлэх шинжлэх ухааны холбогдох байгууллага, эсхүл техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлтгүйгээр тухайн тээврийн хэрэгслийг бүртгэхийг хориглоно*" гэж, Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмын 10 дугаар зүйлийн 1.2-т зааснаар "*техникийн хяналтын үзлэгт тэнцээгүй бол автотээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзана*" гэж тус тус заасны дагуу болон Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний мэдээллийн санд (www.smartcar.mn) тусгагдсан илэрцийн дагуу фидуцийн зүйл болох тээврийн хэрэгсэл нь хуульд заасан техникийн хяналтын үзлэг, оношилгоонд хамрагдсан гэж үзлээ. Мөн Автотээврийн хэрэгсэл бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмын 10 дугаар зүйлийн 1.3, 1.4, 1.9-т тус тус зааснаар тээврийн хэрэгсэл албан татвар төлөөгүй, хуулийн дагуу оногдуулсан торгуулийг төлж барагдуулаагүй, Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу тээврийн хэрэгслийн өмчлөгч жолоочийн даатгалд даатгуулаагүй тохиолдолд автотээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзахаар зохицуулсан тул тээрийн хэрэгсэлтэй холбоотой албан татвар, торгууль байхгүй, эсхүл бүрэн төлөгдсөний дараа тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн гэж үзэв.

Түүнчлэн барьцааны мэдэгдэл бүртгэх цахим мэдээллийн сан (www.mpr.gov.mn)-аас 68 Автотээврийн хэрэгсэлд холбогдуулан аливаа барьцаа бүртгэгдсэн эсэхийг шалгавал, барьцааны бүртгэл байгаагүй болно.

Мөн ипотекийн гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь барьцааны зүйл болох үл хөдлөх хөрөнгө (орон сууц, автозогсоол, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх)-ийг барьцаалж, барьцааны эрхийг холбогдох улсын бүртгэлд бүртгүүлдэг байна. Сонгогдсон 83 зээлийн 15 нь үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл бөгөөд тэдгээр зээлийн барьцааг холбогдох улсын бүртгэлд бүртгүүлсэн байна. Түүнчлэн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн барьцаа бүртгэгдээгүй, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь тэргүүн ээлжинд шаардлагаа хангуулах боломжтой байна. Зээлийн хувийн хэрэгт үл хөдлөх хөрөнгө болон газрын гэрчилгээний хуулбар хувийг хавсаргасан байх бөгөөд мэдээллийн аюулгүй, найдвартай байдлыг хангах үүднээс Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь гэрчилгээний эх хувийг салбарт зохих шаардлага хангасан газарт хадгалдаг талаар бидэнд мэдэгдсэн.

[1] Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 8. Замын хөдөлгөөний дүрэмд заасан бичиг баримт бичиггүй тээврийн хэрэгсэл жолоодсон бол хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний торгохоор торгоно.

[2] Авто тээврийн тухай хуулийн 17.1 Автотээврийн хэрэгсэл хүн амын эрүүл эмнэ, байгаль орчинд нөлөө үзүүлэх сөрөг хүчин зүйлсийн зөвшөөрөгдөх хэмжээний түвшин, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангасан байдлаар жолоодлого техникийн хяналт хийж гэрчилгээ олгоно.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
347
InvesCore CAPITAL
6917839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

Иймд дүн шинжилгээ хийх явцад зээлийн дансны хувийн хэрэгт авагдсан материал, ББСБ-ын өгсөн нэмэлт мэдээлэл, цахим мэдээллийн сангийн илэрцийн дагуу зээлийн дансыг бусад гуравдагч этгээдэд худалдах, уг зээлийн мөнгөн хөрөнгө, зээлийн хүүгийн төлбөрийн шаардах эрх, фидуцийн зүйл, үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрхийг бусдын өмнө үүрэг хүлээсэн аливаа хэлцлийн үүргийн гүйцэтгэл хангах нөхцөл байдал илрээгүй тул сонгогдсон 83 зээлийн дансдын зээлийн хөрөнгө нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байгаа бөгөөд зээл, фидуцийн зүйл, барьцаа хөрөнгө нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байна гэж дүгнэлээ.

Шалгуур үзүүлэлт 2. Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа (фидуцийн) хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх;

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд ББСБ-ын зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ хуулинар тодорхойлсон хэлбэрийн шаардлагыг хангасан эсэх, зохицуулалт нь хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх, зээл олголт зохих ёсоор хийгдэж, зээл эргэн төлөх үүрэг үүссэн эсэх, шаардлагатай тохиолдолд зээлийг фидуцийн хөрөнгө болох төөврийн хэрэгсэл, эсхүл барьцаа хөрөнгө болох үл хөдлөх хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулан төлүүлэх нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх зэрэг асуудлыг шалгаж үзлээ.

ББСБ нь зээлийн гэрээг бичгээр байгуулж, талууд гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулдаг байна. Нийт дүн шинжилгээнд хамрагдсан зээлийн дансдын хувьд Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (цаашид "БЭБХЭМХМХШЗҮАтХ" гэх)-ийн 20 дугаар зүйлд заасан нөхцөлийг зээлийн гэрээнд бүрэн тусгаж, гэрээг бичгээр байгуулан, талууд гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна. Түүнчлэн ББСБ-ын Зээлийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.10 дахь хэсэгт зээлдэгч, барьцаалуулагч, батлан даагч нь итгэмжлэл, дардас ашиглаагүй байхаар заасан бөгөөд МДСХ-н сонгосон 83 зээлийн хувьд итгэмжлэлийн үндсэн дээр байгуулсан гэрээ байгаагүй, бүх зээлийн гэрээ нь зохих журмын дагуу байгуулагдсан байна.

Мөн зээлийн гэрээ нь ББСБ-аас зээлдэгчид санал болгож байгаа, хуулийн заалтыг тодотгосон журам тогтоосон, байнга хэрэглэгдэх шинжтэй, урьдчилан тогтоосон нөхцөл болохын хувьд Иргэний хуулийн 200 дугаар зүйлд заасан стандарт гэрээ болно. Гэрээний зохицуулалтаас харвал, зээлийн гэрээ нь Иргэний хуулийн 202 дугаар зүйлд заасан гэрээний стандарт нөхцөлийг хүчин төгөлдөр бусад тооцох зохицуулалт агуулаагүй, мөн БЭБХЭМХМХШЗҮАтХ болон холбогдох бусад дүрэм, журамд заасан нөхцөлийг зөрчөөгүй буюу зээлийн гэрээний зохицуулалт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Мөн ББСБ нь зээлийн гэрээ болон холбогдох үүргийн гүйцэтгэл хангуулах гэрээг байгуулж, холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлснээр зээлдэгч тус бүрт зээлийн данс нээж, зээлийн шимтгэлийг суутган зээлдэгчид зээл олгодог байна[3]. БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.5-д "зээлийн гэрээнд заасны дагуу зээлийг зээлдэгчийн зээлийн дансанд шилжүүлснийг зээл олгосонд тооцно" гэж заасны дагуу МДСХ нь зээлдэгч бүрийн зээлийн дансны хуулгыг авч шалгасны үндсэн дээр зээл олголт хууль ёсны дагуу бүрэн хийгдсэн гэж үзэж байна. Иймд, Зээлдэгч нь тус олгогдсон зээлийг зээлийн гэрээгээр тохиролцсон хүүгийн хамт гэрээний хавсралтаар тодорхойлсон эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх үүрэг хүлээж байна[4].

Мөн Зээлийн гэрээний 7.1 дэх хэсэгт "Зээлдэгч нь гэрээний хугацаа дуусгавар болоход зээл, хүүгийн төлбөрийг бүрэн төлж барагдуулаагүй, эсвэл Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тохиолдолд Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор байгуулсан барьцаа, фидуцийн гэрээ, батлан даалт, баталгааны гэрээнд заасан эд хөрөнгө, эх үүсвэрээр төлөгдөөгүй үндсэн зээл,

[3] Зээлийн гэрээний 3.1. Талууд нь Гэрээ, зээлийн барьцаа, батлан даалт, фидуци (эрх шилжүүлэлтийн гэрээ) байгуулж, холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн өдөр зээлийн мөнгөн хөрөнгийг Гэрээнд заасан зээл хүлээн авах дансанд шилжүүлэх, Зээлийн гэрээний 3.2. Гэрээний дагуу зээлийн үйлчилгээний шимтгэл төлөхөөр талууд тохиролцсон бөгөөд шимтгэлийг зээлийн үлийн дүнгээс суутган төлөхийг Зээлдэгч зөвшөөрсөн тул зээлийн мөнгө гэрээнд заасан шимтгэлийг суутгаж, үлдэх үлийн дүнг Зээлдэгчийн Гэрээнд заасан дансанд шилжүүлснээр зээл олголт бүрэн хийгдсэн гэж үзнэ.

[4] Зээлийн гэрээний 4.1. Зээлдэгч нь зээлийн үндсэн төлбөрийг Гэрээний Хавсралт 1-д заасан зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу тухай бүр Зээлдүүлэгчийн Хавсралт 1-д заасан харилцах дансанд төлнө.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЭК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ж1119277128
УЛААНБААТАР ХОТ

348

2025/11/28

ИХ ХУРЛЫН ХӨРӨНГӨӨР БИРЖ
2025-12-31
БУРТГЭВ-02

2025 оны 12 сарын 25
БҮРТГЭВ
№ 01

хүү болон нэмэгдүүлсэн хүүг үл маргах журмаар хангуулна" гэж заасны дагуу зээлийг барьцаа хөрөнгөөс гаргуулах боломжтой байна.

Иймхүү, Тус зээлийн гэрээний дагуу зээлийг фидуцийн хөрөнгө болох тээврийн хэрэгсэл болон барьцаа үл хөдлөх хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байна.

Иймд, сонгодсон нийт 83 зээлийн дансдын зээлийн гэрээ нь зээлдэгч (үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хууль нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа (фидуцийн) хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх тул сонгодсон 83 зээлийн дансад нь энэхүү хоёрдугаар шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

Шалгуур үзүүлэлт 3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамаарууллан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх.

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд МДСХ нь Зээлдэгч, барьцаалуулагч үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох, гэрээнээс татгалзах, гэрээ цуцлах тухай хүсэл зориг илэрхийлсэн эсэх, холбогдох баримт бичиг зээлийн хувийн хэрэгт авагдсан эсэх болон зээлийн мэдээллийн лавлагаагаар зээлийн гэрээний үүрэг дуусгавар болсон эсэхийг шалган баталгаажуулж үзлээ.

БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 25.1-д зааснаар зээлдэгч зээлийн гэрээгээр тохиролцсон хугацаанаас өмнө хэдийд ч зээлийн гэрээний үүргээ бүхэлд нь болон хэсэгчлэн гүйцэтгэж болно. Зээлийн гэрээний 4.5[5]-т зээлдэгч зээлийн эргэн төлөлтийн хуваарьт хугацаанаас өмнө эргэн төлөлт хийх, илүү төлөлт хийж болох агуулга бүхий заалт тусгасан нь зээлдэгчийн хуульд заасны дагуу зээлийн гэрээний төлберийг урьдчилан төлөх эрхийг хангаж буй зохицуулалт болохыг дурдаж байна.

МДСХ нь сонгосон 83 зээлийн дансдын зээлийн мэдээллийн сангийн лавлагааг үзэхэд тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээний үүрэг дуусгавар болоогүй ба зээлийн хувийн хэрэгт зээлийн болон фидуцийн, ипотекийн гэрээний үүргийг хугацаанаас өмнө дуусгавар болгох, гэрээнээс татгалзах, цуцлахтай холбоотой аливаа баримт бичиг авагдаагүй байна.

Иймд, тасалбар болгох өдрийн байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр сонгодсон 83 зээлийн дансдын зээл олгох хэлцэл нь үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамаарууллан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх тул энэхүү шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

Шалгуур үзүүлэлт 4. Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ, эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуци болон барьцаа зүйлийн холбогдох эрхийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй, эсхүл хязгаарлагдаагүй байх.

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь фидуци (тээврийн хэрэгсэл), барьцаа хөрөнгө (үл хөдлөх хөрөнгө) болон зээлийн мөнгөн хөрөнгийг эргүүлэн шаардах эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэхэд хууль болон гэрээгээр хориглосон, хязгаарласан нөхцөл байгаа эсэх, фидуцийн зүйл, барьцаа хөрөнгө хамтран өмчлөгчтэй тохиолдолд хамтран өмчлөгчийн зөвшөөрөл байгаа эсэх асуудлыг шалган үзлээ.

ББСБ нь зээлдүүлэгч зээлийн гэрээний шаардах эрхийг үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрхийн хамт бусдад шилжүүлэхийг хориглоогүй, аливаа байдлаар хязгаарласан талаар зээлийн гэрээнд тусгаагүй байна. Иргэний хуулийн 123.3-т заасны дагуу үүрэг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд шаардах эрхийг шилжүүлэхийг хязгаарласан нөхцөл байхгүй тохиолдолд шаардах эрх эзэмшигч нь уг эрхээ Иргэний хуулийн 123.2-т заасны дагуу үүргийн мөн чанарт харшлаагүй нөхцөлд

[5] Зээлийн гэрээний 4.5. Зээлдэгч нь Гэрээний Хавсралт 1-д заасан эргэн төлөлтийн хуваарьт хугацаанаас өмнө эргэн төлөлт хийх, эсвэл илүү төлөлт хийх тохиолдолд Зээлдүүлэгчтэй мэдэгдэнэ.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ETF LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
349
InvesCore CAPITAL
6317030 1119277128
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

ҮЦТ
2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр
БҮРТГЭВ
№ 01

үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрлийг авахгүйгээр бусдад шилжүүлэх эрхийг олгосон байна. Зээлийн гэрээ, Эд хөрөнгө эзэмшил, өмчлөлд шилжүүлэх гэрээ (Фидуци), Ипотекийн гэрээнд энэхүү эрхийг хязгаарласан, эсхүл хориглосон аливаа зохицуулалт оролгүй болно.

Фидуцийн гэрээний дагуу фидуцийн зүйл болох тээврийн хэрэгслийн цор ганц өмчлөгч нь Зээлдүүлэгч (Анхны үүрэг гүйцэтгүүлэгч) байх ба фидуцийн зүйлтэй холбоотой хамтран өмчлөгчийн эрх байхгүй болно. Иймд, зээл төлүүлэх зорилгоор тээврийн хэрэгслийг барьцаалуулах, худалдан борлуулах, бусдад шилжүүлэх эрхийг фидуцийн гэрээний дагуу түүнийг өмчилж буй Анхны үүрэг гүйцэтгүүлэгч эдэлнэ. Харин эзэмших, ашиглах эрхийг өөр этгээд хэрэгжүүлж байгаа нь ажиллагааны шуурхай байдалд нөлөөлж болох талтайг дурдах нь зүйтэй.

Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хувьд барьцаа хөрөнгөтэй холбогдуулан хамтран өмчлөгчийн зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд зээлийн түүвэр дэх 15 үл хөдлөх барьцаалсан зээлийн 4 нь хамтран өмчлөгчтэй байх ба холбогдох зөвшөөрлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч авсан байна.

Иймд, сонгогдсон 83 зээлийн дансад нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ, эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, бусдад шилжихийг хориглоогүй, эсхүл хязгаарлаагүй байх дөрөвдүгээр шалгуур үзүүлэлтийг хангасан гэж үзэв.

Шалгуур үзүүлэлт 5. Зээлтэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүгээсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, түүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх.

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд ББСБ-ын зээлдэгчтэй байгуулсан Эд хөрөнгө эзэмшил, өмчлөлд шилжүүлэх гэрээ (фидуци) болон ипотекийн гэрээ нь хуулинар тодорхойлсон хэлбэрийн шаардлагыг хангасан, зохицуулалт нь хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх, фидуци болон барьцааны эрх нь үүргийн гүйцэтгэлийг хангах аргаар баталгаажсан бусад шаардлагаас давуу, тэргүүн ээлжид шаардлага хангуулах боломжтой эсэх, зохих ёсоор үүсгэгдэж хүчин төгөлдөр болсон эсэх зэрэг асуудлыг шалгаж үзлээ.

Фидуцийн гэрээ

Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах талаар зээлийн гэрээ болон фидуцийн гэрээгээр тохиролцсон байх ба талууд фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахыг зөвшөөрсөн байна.

Иргэний хуулийн 235.5-д "*хуульд өөрөөр заагаагүй бол үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээг бичгээр хийнэ*" гэж заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгэгч нь фидуцийн эрхийг баталгаажуулсан гэрээг зээлдэгчтэй бичгээр байгуулсан нь фидуцийн гэрээний хуульд заасан хэлбэрийн шаардлагыг хангасан байна. ББСБ-ын Зээлийн үйл ажиллагааны журмын 4.10-т заасаар барьцаалуулагч нь гэрээг итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй буюу итгэмжлэлээр байгуулахыг хориглосон дотоод дүрэм журам тогтоон мөрддөг байна. Сонгогдсон 68 тээврийн хэрэгслийн зээлийн дансдад итгэмжлэлээр төлөөлүүлж гэрээг байгуулсан тохиолдол гараагүй тул хуульд заасан төлөөлөх, төлөөлүүлэх харилцаа үүсээгүй болохыг дурдаж байна.

Мөн Фидуцийн гэрээний 1.5-т "*...Зээлийн гэрээний үүргээ хугацаанд 30 хоногоор хэтрүүлсэн тохиолдолд Фидуцийн зүйлийг Үүрэг гүйцэтгүүлэгчийн анхны шаардлагаар тэдний заасан газарт бодитоор хүлээлгэх өгөх ба түүнтэй холбоотой гарах зардлыг харицуна*" гэж, 1.6-д "*Үүрэг гүйцэтгүүлэгч нь Гэрээний 1.5 дах хэсэгт заасны дагуу Фидуцийн зүйлийг өөрийн бодит эзэмшилдээ авснаар үл маргах журмаар худалдан борлуулж, Зээлийн гэрээний гүйцэтгээгүй үүрэг болон Үүрэг гүйцэтгэгчийн төлөт хотирол, зардлыг тооцуулна*" гэж зохицуулснаас үзвэл, фидуцийн эрх нь хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд үүрэг гүйцэтгэгчийн зээлийг фидуцийн зүйл болох автотээврийн хэрэгслийг худалдан борлуулж төлүүлэх боломжтой байх шалгуурыг хангаж байна.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 9119277129
УЛААНБААТАР ХОТ

350

2025/11/28

Мөн Иргэний хуулийн 235.1[6], Фидуцийн гэрээний 4.2-т *"Үүрэг гүйцэтгэгч нь Фидуцийн зүйлийг энэхүү гэрээ, зээлийн гэрээгээр хүлээсэн үүрэгээ бүрэн биелүүлэх хүртэлх хугацаанд аливаа хохирол, өр төлбөр, зардал, анз, гуравдагч этгээдийн шаардах эрх зэргээс ангид байлгахыг үүгээр баталж байна"* гэж, мөн 2.2.9-т *"Фидуцийн зүйлийг аливаа гуравдагч этгээдийн өлгөө хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор давхар үүрэг ногдуулах нөө, хохирол, өр төлбөр, зардал, анз зэргээс ангид байлгах"* гэж зохицуулснаас үзвэл, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь фидуцийн зүйлийн хууль ёсны өмчлөгч бөгөөд зээлдэгч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр фидуцийн зүйлийг бусад үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар аливаа хохирол, өр төлбөр, давхар үүрэг ногдуулах, гуравдагч этгээдэд шаардах эрх үүсгэх зэргээр захиран зарцуулах боломжгүй тул зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг давуу буюу тэргүүн ээлжид фидуцийн эрхээр хангуулахаар талууд тохиролцсон гэж үзнэ.

Ипотекийн гэрээ

Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд барьцаа хөрөнгө (үл хөдлөх)-өөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах талаар зээлийн гэрээ болон ипотекийн гэрээгээр тохиролцсон байх ба талууд үл хөдлөхийн барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулахыг зөвшөөрсөн байна.

Иргэний хуулийн 156 дугаар зүйл, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д зааснаар үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг бичгээр эсхүл цахимаар байгуулж, улсын бүртгэлд бүртгүүлэх ба талуудын аль нэг нь хүсвэл барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлж болно. Сонгогдсон 15 үл хөдлөх барьцаалсан зээлийн хувьд ипотекийн гэрээг бичгээр байгуулж, нотариатаар гэрчлүүлэн, холбогдох барьцааны эрхийг улсын бүртгэлд бүртгүүлсэн байна. ББСБ нь ипотекийн гэрээний дагуу (газраас бусад) аливаа барьцаалбар үйлдэгтүй байна.

Мөн Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д барьцааны гэрээнд тусгах шаардлагатай нөхцөлүүдийг тодорхойлсон бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ипотекийн гэрээ нь хуульд заасан тэдгээр шаардлагыг хангаж байна.

Үл хөдлөх барьцаалсан 15 зээлийн дансдын үл хөдлөх эд хөрөнгийн лавлагаанаас үзвэл Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн барьцаа бүртгэгдсэн бөгөөд аливаа гуравдагч этгээдэд давхар барьцаалаагүй байх тул барьцаа хөрөнгөөс тэргүүн ээлжинд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн үүргийг хангуулах боломжтой байна.

Иймд, ББСБ-ын фидуцийн болон ипотекийн гэрээ нь хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн, зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг фидуци болон барьцааны эрхээр хангуулах боломжтой байх тавдугаар шалгуурыг хангаж байна.

Шалгуур үзүүлэлт 6. Фидуцийн болон барьцааны гэрээ хүчин төгөлдөр байлгахад Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн үйл ажиллагаатай холбоотой дотоод дүрэм, журам нь ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмын дагуу эсэх, зээлийг тэдгээр дүрэм, журмын дагуу олгосон эсэх, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байгаа эсэхийг шалгалаа.

Зээлийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг Иргэний тухай хууль (2002), Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2021), Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль (2009), Газрын тухай хууль (2002), Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002) болон Санхүүгийн зохицуулах

[6] Иргэний хуулийн 235.1 Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээгээр Аааашид "фидуци" гэх/ үүрэг хүлээгч нь мөнгө төлөх үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, үүрэг хүлээгч үндсэн үүргээ хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч уг эд хөрөнгийг түүнд бүхэлд нь өгөх үүргийг тус тус хүлээнэ.

2025/11/28

БҮРТГЭВ-02

2025 12 25
БҮРТГЭВ
№ 01

хорооноос баталсан Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам (2025) болон холбогдох бусад дүрэм, журмаар зохицуулж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор батлагдсан Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, 3.14-т зааснаар банк бус санхүүгийн байгууллага нь зээлийн хүү бодох, барьцаа хөрөнгийг үнэлэхдээ эрх бүхий байгууллагаас баталсан журам, заавар, аргачлалыг мөрдөг болгож ажиллаж, Хорооноос тогтоосон өр, орлогын болон зээл, үнэлгээний харьцааг баримтлан ажиллаж, зээлийн үйл ажиллагааны ерөнхий нөхцөл, зээл судлах, шийдвэрлэх, олгох, хянах үйл ажиллагаа, зээлийн бүтээгдэхүүнтэй уялдуулсан хүү, шимтгэл, хураамж, хугацааны нөхцөл, зээлийн эрсдэлийг удирдах, зээлийн эргэн төлөлтөд тавих хяналт, харилцлага, зээлийн барьцаа хөрөнгөнд тавигдах шаардлага, үнэлгээ, хүлээн авах, хадгалах, хүлээлгэн өгөх, бүртгэлээс хасах, харилцагчийн нууцлал, аюулгүй байдал болон бусад шаардлагатай зохицуулалтыг өөрийн үйл ажиллагаандаа нийцүүлэн баталж мөрдөж болно.

ББСБ-ын хувьд зээлийн үйл ажиллагаатай холбогдуулан энэ Тайлангийн "Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлийн үйл ажиллагааг зохицуулж буй дотоод дүрэм журам, баримт бичиг" хэсэгт дурдсан дүрэм, журам, шийдвэрийг дагаж мөрдөг бөгөөд эдгээр дүрэм журам нь ББСБ-ын үйл ажиллагааны онцлогт нийцсэн, ердийн практикт мөрдөгдөг ерөнхий журам (харилцагчийг танин баталгаажуулах, харилцагчийн өр, орлогыг судлах, фидуци болон барьцаа хөрөнгийг үнэлэх, зээл олгох шийдвэр гаргах, гэрээ байгуулах, шаардлагатай зөвшөөрөл, баталгааг гаргуулах, барьцаа хөрөнгийг даатгуулах)-ын дагуу байна.

МДСХ-н гүйцэтгэсэн хяналт шалгалтын явцад сонгогдсон 83 зээл нь дээр дурдсан зээлийн үйл ажиллагаатай холбоотой дотоодод дагаж мөрдөг журмыг зөрчсөн гэх аливаа нөхцөл нлрээгүй тул тэдгээр зээл нь холбогдох журмын дагуу олгогдсон, фидуци болон барьцаа хөрөнгө нь зохих ёсоор тодорхойлогдож, шаардлага хангасан байна. МДСХ нь зээлийн хүү тооцоолох аргачлал, эргэн төлөлтийн хуваарийн тооцоололтой холбоотой аливаа дүгнэлт гаргаагүй болохыг дурдаж байна.

Шалгуур 1-т дурдсаны дагуу зээлийн гэрээ, фидуцийн болон ипотекийн гэрээ, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ нь эх хувиар, тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн гэрчилгээ нь хуулбараар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувийн хэрэгт хадгалагдаж байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд буй фидуцийн зүйл болох тээврийн хэрэгслийг зээлдэгч (эсхүл түүний итгэмжилсэн этгээд) эзэмшиж, ашиглаж байна. Тээврийн хэрэгслийн гэрчилгээг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өөрийн эзэмшил, хадгалалтад эх хувиар байлгадаггүй нь Автотээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д заасны дагуу хууль зүйн үндэслэлтэй тул хуулбар хувийг хувийн хэрэгт хадгалдаг байна. Мөн үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний аюулгүй, найдвартай байдлыг хангах үүднээс үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг салбарт эх хувиар, зээлийн хувийн хэрэгт хуулбар хувиар хадгалдаг байна. Иймхүү үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй дээр дурдсан баримт бичгийн эх хувь, эсхүл хуулбар хувь анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалтад хамгаалалтад байна гэж үзлээ.

Иймд, сонгогдсон 83 зээл болон фидуцийн өмчлөх эрх, барьцааны эрх нь хүчин төгөлдөр байлгахад Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрдөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх зургаадугаар шалгуур үзүүлэлтийг хангасан гэж үзэв.

Нэгдсэн дүгнэлт

Хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр нийт 83 зээлийн дансад нь Тасалбар болгох өдрийн байдлаар хуулийн 6 шалгуурыг хангасан байна. Холбогдох зээлийн гэрээ, фидуцийн болон барьцааны гэрээ нь хүчин төгөлдөр, аливаа эрсдэл үүсээгүй байна. Зээлийн, фидуцийн болон ипотекийн гэрээнд үүргийн гүйцэтгэлийн зүйл (тээврийн хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгө, газрын эрх)-тэй холбоотой шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгагдаагүй болно.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA15551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

352

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
InvesCore FI
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

2025 .12. 25
БҮРТГЭВ
№ 01

МДСХ нь энэхүү Тайланг гаргахдаа тайлангийн Хавсралт 2-т заасан "Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн үйл ажиллагаатай холбоотой тайлбар, тодруулга"-ыг харгалзан зарим зөрүүтэй асуудлыг тодорхойлсон хэдий ч хүлээн зөвшөөрөх хэмжээнд гэж үзэн, зөрчилд тооцоогүй болно.

1. Шалгуур үзүүлэлтүүдийг хангасан дансдууд.

Энэ ангилалд багтсан нийт данс Үнэт цаас гаргагчаас тавигдсан шалгуур үзүүлэлтүүдийг хангасан (Хавсралт 1. Түүврийн аргаар сонгогдсон зээлийн статус) бөгөөд Зээлийн гэрээ, Фидуцийн гэрээ, Ипотекийн гэрээ, төөврийн хэрэгслийн гэрчилгээ, Үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрх нь хүчин төгөлдөр байгаа утгыг илэрхийлнэ. "Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн үйл ажиллагаатай холбоотой тайлбар, тодруулга" (Хавсралт 2)-д дурдсан мэдээлэл нь эрх зүйн эрсдэл үүсгэхгүй, хууль тогтоомжоор заасан шаардлага зөрчөөгүй зээлийг ойлгоно.

2. Эрсдэлийн зэргийг дахин үнэлэх шаардлагатай данс.

Дүн шинжилгээ хийж тайлан гаргах өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь, эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь эрсдэлтэй байж болзошгүй, эрсдэлийн зэргийг дахин үнэлэх шаардлагатай гэж үзэхээр зээлийн данс илрээгүй болно.

3. Хүчин төгөлдөр бусад тооцогдох эрсдэлтэй данс.

Дүн шинжилгээ хийж тайлан гаргах өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь хүчин төгөлдөр бусад тооцогдож болзошгүй, хуулийн шаардлага хангаагүй зээлийн данс илрээгүй болно.

График 3.Зээлийн гэрээ, фидуцийн болон барьцааны гэрээний хүчин төгөлдөр байдлын үзүүлэлт.



Энэхүү тайлан нь түүнийг тухайлан зорилуулж гаргасан этгээдүүдээс бусад этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага бий болгохгүй.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т зааснаар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нэг удаагийн гаргалтыг баталгаажуулж байгаа хөрөнгийн нийлбэр нь хөрөнгийн багцыг бүрдүүлнэ. ББСБ нь тусгай зориулалтын компаниар дамжуулан 50 (тавин) тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахаар төлөвлөж буй бөгөөд хөрөнгийн багц нь тасалбар болгох өдрийн байдлаар 61,097,267,982 төгрөг буюу хөрөнгийн багцын үнийн дүн нь ХБҮЦ-ийн үнийн дүнгээс өндөр байна.

Мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т зааснаар хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үед үнэт цаас гаргагчийн эзэмшилд байх бөгөөд эрхийн доголдолгүй байх шаардлагатай. Дээр дурдсанчлан Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
Growth RES LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

353

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

ОН 2025 оны 12. 25-нд
БҮРТГЭВ
№ 01

зээлийн багцаас хөрөнгийн багц бүрдүүлж, зээл болон түүнд хамаарах эрх (зээлийн шаардах эрх, үүрэгийн гүйцэтгэл хангуулах эрх, түүний холбогдох эрхийн хамт)-ийг Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр Үнэт цаас гаргагчид шилжүүлж байгаа тул Хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь үнэт цаас гаргагчийн эзэмшилд байх бөгөөд эрхийн доголдолгүй байна.

Хөрөнгийн багц дахь хөрөнгө нь төвөрийн хэрэгсэл болон үл хөдлөхөөс бүрдэх бөгөөд үл хөдлөх хөрөнгийн хувьд барилга бүрэн баригдаж, улсын бүртгэлийн гэрчилгээ гарсан тул Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх хэсэгт заасан шаардлага (дуусаагүй барилга, сул чөлөөтэй газрын барьцаа биш байх)-ыг хангасан гэж үзнэ.

МДСХ нь зээлийн үйл ажиллагаатай холбоотой зарим санал, зөвлөмжөө Үнэт цаас гаргагчид мэдэгдсэн болно.

ХҮНДЭТГЭСЭН,

"ӨМГӨӨЛДИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН ГИШҮҮН, ХУУЛЬЧ

Д.ДҮГЭРЖАВ

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ASS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

354

2025/11/28

Хавсралт 1. Түүврийн аргаар сонгогдсон зээлийн статус

№	ББСБ	Зээлийн дансны дугаар	Статус
1.	Инвескор ББСБ ХК	A17024012402	★
2.	Инвескор ББСБ ХК	A110240919003	★
3.	Инвескор ББСБ ХК	A120250421005	★
4.	Инвескор ББСБ ХК	A130240819002	★
5.	Инвескор ББСБ ХК	A150240707005	★
6.	Инвескор ББСБ ХК	A150240926007	★
7.	Инвескор ББСБ ХК	A150241227008	★
8.	Инвескор ББСБ ХК	A150250502001	★
9.	Инвескор ББСБ ХК	A160240922002	★
10.	Инвескор ББСБ ХК	A160240924002	★
11.	Инвескор ББСБ ХК	A160241004002	★
12.	Инвескор ББСБ ХК	A160241122001	★
13.	Инвескор ББСБ ХК	A160241213007	★
14.	Инвескор ББСБ ХК	A160241220001	★
15.	Инвескор ББСБ ХК	A160250111005	★
16.	Инвескор ББСБ ХК	A160250125001	★
17.	Инвескор ББСБ ХК	A180241202001	★
18.	Инвескор ББСБ ХК	A190240917002	★
19.	Инвескор ББСБ ХК	A220240729001	★
20.	Инвескор ББСБ ХК	A220241016001	★
21.	Инвескор ББСБ ХК	A220241114001	★
22.	Инвескор ББСБ ХК	A220241118003	★
23.	Инвескор ББСБ ХК	A220241127007	★
24.	Инвескор ББСБ ХК	A220250224002	★
25.	Инвескор ББСБ ХК	A220250424003	★
26.	Инвескор ББСБ ХК	A250240731002	★
27.	Инвескор ББСБ ХК	A250240809002	★
28.	Инвескор ББСБ ХК	A250241230002	★
29.	Инвескор ББСБ ХК	A250250214004	★
30.	Инвескор ББСБ ХК	A260240913001	★
31.	Инвескор ББСБ ХК	A260241213003	★
32.	Инвескор ББСБ ХК	A260250224005	★
33.	Инвескор ББСБ ХК	A340250403001	★
34.	Инвескор ББСБ ХК	B150250428001	★
35.	Инвескор ББСБ ХК	A190250224003	★
36.	Инвескор ББСБ ХК	A260240909004	★
37.	Инвескор ББСБ ХК	A290250220001	★
38.	Инвескор ББСБ ХК	A130250506002	★
39.	Инвескор ББСБ ХК	A150250505011	★
40.	Инвескор ББСБ ХК	A260250505003	★
41.	Инвескор ББСБ ХК	B170250217001	★
42.	Инвескор ББСБ ХК	M110250402002	★
43.	Инвескор ББСБ ХК	M130250110003	★

355

2025/11/28

44.	Инвескор ББСБ ХК	M180250508001	★
45.	Инвескор ББСБ ХК	M290250505001	★
46.	Инвескор ББСБ ХК	M300250429004	★
47.	Инвескор ББСБ ХК	B160250514006	★
48.	Инвескор ББСБ ХК	B190250522001	★
49.	Инвескор ББСБ ХК	B220250507002	★
50.	Инвескор ББСБ ХК	B260250513002	★
51.	Инвескор ББСБ ХК	B120250406001	★
52.	Инвескор ББСБ ХК	A15023100906	★
53.	Инвескор ББСБ ХК	A16023040702	★
54.	Инвескор ББСБ ХК	A29024053001	★
55.	Инвескор ББСБ ХК	A120240902001	★
56.	Инвескор ББСБ ХК	A170250411001	★
57.	Инвескор ББСБ ХК	A180250414001	★
58.	Инвескор ББСБ ХК	B130240627001	★
59.	Инвескор ББСБ ХК	M20024011002	★
60.	Инвескор ББСБ ХК	X300250428004	★
61.	Инвескор ББСБ ХК	A110241003001	★
62.	Инвескор ББСБ ХК	A190250331001	★
63.	Инвескор ББСБ ХК	A230250402002	★
64.	Инвескор ББСБ ХК	B110250430001	★
65.	Инвескор ББСБ ХК	A120241202001	★
66.	Инвескор ББСБ ХК	B290250317001	★
67.	Инвескор ББСБ ХК	B340240814001	★
68.	Инвескор ББСБ ХК	A120240701004	★
69.	Инвескор ББСБ ХК	A120250708011	★
70.	Инвескор ББСБ ХК	A130250707006	★
71.	Инвескор ББСБ ХК	A150240703002	★
72.	Инвескор ББСБ ХК	A150250602005	★
73.	Инвескор ББСБ ХК	A160240720005	★
74.	Инвескор ББСБ ХК	A160250629008	★
75.	Инвескор ББСБ ХК	A200250905002	★
76.	Инвескор ББСБ ХК	A220250704004	★
77.	Инвескор ББСБ ХК	A230240708002	★
78.	Инвескор ББСБ ХК	A250240905001	★
79.	Инвескор ББСБ ХК	A260250620002	★
80.	Инвескор ББСБ ХК	B170240613015	★
81.	Инвескор ББСБ ХК	A150240609003	★
82.	Инвескор ББСБ ХК	A300250718007	★
83.	Инвескор ББСБ ХК	M350250718001	★

-ooOoo-

ИНВЕСКОР ӨӨЛТ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101496

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

356

2025/11/28

InvesCore FI
БҮРТГЭЛ-02
2025 12 25
РЕГЭВ
№ 21

Автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (ХБҮЦ) гарган нийтэд санал болгохтой холбогдуулан зээлийн үйл ажиллагаатай холбоотой тайлбар

Нэг. Хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээний явцад анхаарах асуудлууд нь Захиалагч буюу "Инвескор ББСБ" ХК (цаашид "анхны үүрэг гүйцэтгэгч" гэх)-ийн өгсөн ажлын даалгаврын салшгүй хэсэгт тооцогдоно.

Хоёр. Хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээний явцад эдгээр харилцан тохиролцож шийдвэрлэсэн асуудлууд үүссэн нөхцөлд тухайн дансыг хуулийн шаардлага хангасан (зөвхөн энэхүү харилцан тохиролцсон асуудлын хувьд) гэж тооцно.

Гурав. Инвескор Өсөлт ТЗК ХХК-ийн хөрөнгийн багцад эдгээр тайлбартай давхацсан зээл байж болно.

Дөрөв. Зээлийн үйл ажиллагаатай холбоотой дэлгэрэнгүй тайлбар, жагсаалт

1	Зээлийн шимтгэл, хамтран зээлдэгч, төвөрийн хэрэгслийн урьдчилгаа төлбөр, татвартай холбоотой	Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д зааснаар "Банк, эрх бүхий хуулийн этгээд харилцагчаас зөвхөн гэрээнд тусгасан шимтгэл, хураамжийг төлүүлэх бөгөөд өөрийн үзүүлсэн нэг төрлийн үйлчилгээнд үйлчилгээний шимтгэл, хураамжийг давхардуулан авахгүй" гэж заасны дагуу "Инвескор ББСБ" ХК нь Зээлийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.3-т "*гэрээний дагуу зээл олголтын шимтгэл төлөхөөр талууд тохиролцсон бөгөөд шимтгэлийг зээлийн үнийн дүнгээс суутган төлөхийг Зээлдэгч гэрээний дагуу зөвшөөрсөн тул зээлийн нийт үнийн дүнгээс шимтгэлийг суутгаж, үлдэх үнийн дүнг Зээлдэгчийн гэрээнд заасан данснаас шилжүүлнэ*" гэж зохицуулж, харилцагчаас бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий нөхцөлийн дагуу зээл тус бүрээс тодорхой хэмжээний зээлийн шимтгэл авдаг болно. Мөн "Инвескор ББСБ" ХК-ийн Зээлийн гэрээний 2 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэгт (зарим гэрээнд заалтын дугаарлалт нь өөрөөр туссан байж болно) "зээлдэгч нь зээл олголтын шимтгэлийг гэрээний 2.1.7 дахь заалтад заасны дагуу Зээлдүүлэгчид төлөх ба уг шимтгэлийг Зээлдэгчид гэрээний дагуу олгох зээлийн үнийн дүнгээс суутган төлөх талаар талууд харилцан тохиролцсон болно. Иймхүү суутгал хийсэн нь зээлийг дутуу олгосон гэх үндэслэл болохгүй" гэж заасны дагуу зээлийн шимтгэлийг Зээлдүүлэгчид олгох зээлийн төлбөрөөс суутган тооцдог болно. "Инвескор ББСБ" ХК-ийн Зээлийн үйл ажиллагааны журамд төвөрийн хэрэгслийн урьдчилгаа төлбөрийг зээлийн хүүнийн хэрэгт хадгалах тухай зохицуулалт тусгаагүй тул урьдчилгаа төлбөрийн баримтыг зээлийн хүүнийн хэрэгт хавсаргаагүй, баримтыг бүрдүүлдэггүй болно. "Инвескор ББСБ" ХК-ийн Зээлийн үйл ажиллагааны журамд зээлдэгч заавал хамтран зээлдэгчтэй байх шаардлага тавигдаагүй бөгөөд "Инвескор ББСБ" ХК-ийн Зээлийн эрсдэлийн журмын 8.2-т зааснаар зээлийн эрсдэлийг тооцоолсны үндсэн дээр хамтран зээлдэгчтэй байх эсэхийг шийдвэрлэхээр зохицуулсан тул зарим зээлийн хүүнд үндсэн зээлдэгч нь хангалттай орлогын эх үүсвэртэй тохиолдолд хамтран зээлдэгчгүйгээр зээл олгож болно. Зээлийн гэрээний харилцаа дуусгавар болоход "Инвескор ББСБ" ХК нь төвөрийн хэрэгслийн татвар төлөгдсөн эсэхийг шалгасны үндсэн дээр төвөрийн хэрэгслийг Зээлдэгчийн нэр дээр шилжүүлдэг тул төвөрийн хэрэгслийн татвар төлсөн баримтыг зээл олгоход шаардлагагүй, энэ талаарх баримтыг зээлийн хүүнийн хэрэгт хавсаргадаггүй болно.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6217639 ...1113277128
УЛААНБААТАР ХОТ

357

2025/11/28

2025-12-1
БУРТГЭВ-02

2025 оны 12 сар 25 өдөр
БУРТГЭВ
№ 01

		Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор зээлдэгчтэй байгуулж буй Эд хөрөнгө эзэмшил, өмчлөлд шилжүүлэх гэрээ (фидуши)-ний 2.2.4-т зааснаар үүрэг гүйцэтгэгч нь фидушийн зүйлийг ашиглах явцад алдаа торгууль ... улсад төлөх татварыг харгуаан төлөх үүрэгтэй талаар заасан тул зарим фидуцийн эд зүйл буюу тээврийн хэрэгсэл нь татвар, торгуультай байж болно.
2	Зээлийн хорооны шийдвэртэй холбоотой	"Инвескор ББСБ" ХК-ийн дотоод дүрэм, журам шийдвэрт зааснаар зээл олгох тухай шийдвэрийг зээлийн үнийн дүнгээс хамаарууллж салбарын захирал, салбарын удирдлагын захирал, тэргүүн дэд захирал эсхүл гүйцэтгэх захирал, зээлийн хороо, төлөөлөн удирдах зөвлөл тус тус шийдвэрлэдэг (Зээлийн эрсдэлийн журмын хавсралт 2.1). "Инвескор ББСБ" ХК-ийн Smart LOS систем дээр зээлийн шийдвэр гаргах эрх бүхий этгээдүүд зээл олгохыг зөвшөөрөн баталгаажуулах үйлдэл хийдэг бөгөөд зээлийн шийдвэрийн бариятыг зээлийн хувийн хэрэгт хэвлэмлээр хадгалах шаардлага байхгүй, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулдаггүй болно. Мөн Smart LOS системийн зээлийн шийдвэрт тэмдэглэл үйлдсэн нь зээл олгохыг зөвшөөрсөн гэж үзэж болно.
3	Хувийн хэрэгт авагдсан бариятай холбоотой	Зээлдэгчийн иргэний үнэмлэх шинэчлэгдсэнтэй холбоотойгоор иргэний үнэмлэхээс хаягийн мэдээллийг тодруулах боломжгүй байгаа тохиолдолд "ХУР" төрийн мэдээлэл солилцооны системээс зээлдэгчийн иргэний үнэмлэхийн хаяг, оршин суугаа хаягийн мэдээллийг татан зээлдэгчийн хаягийн мэдээллийг тодруулах ажиллагааг хийж баталгаажуулсан гэж үзнэ. Зээлдэгчийн зээлийн мэдээллийн сангийн хэвийн бус ангилал засагдсан эсхүл зээлийн үлдэгдэлгүй бөгөөд түүнээс хойш 2, 3 зээлийг авч зээлийн төлөлт хэвийн байх тохиолдолд зээл олгох боломжтой шаардлага хангасан зээлдэгч хэмээн үзэж зээл олгосон байж болно. Фидуци буюу тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг "Инвескор ББСБ" ХК нь шилжүүлэн авсан, зээлдэгч тээврийн хэрэгслийг бодит эзэмшилдээ авч ашиглаж байгаа нь зээл зорилалтын дагуу ашиглагдсан гэж үзэх тул БЭБХЭМХМХШЗУАтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.2-т заасны дагуу зээлийн хувийн хэрэгт зээлийн ашиглалт шалгасан баримт бичгийг бүрдүүлээгүй байж болно. 2025 оны 5 дугаар сарын 01-нээс эхлэн Үндсэн болон Хамтран зээлдэгчийн Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Газарт өр төлбөртэй эсэх лавлагааг авдаг болсон, мөн зээлдэгчийн гар өргөдлийг хувийн хэрэгт хавсаргадаг болсон тул тус хугацааназ өмнө тэдгээр баримт бичиг байхгүй байж болно. Фидуцийн зүйлийн үнэлгээг Худалдах худалдан авах гэрээнд заасан үнээр тодорхойлдог. Зээлийн хувийн хэрэгт авагдсан тээврийн хэрэгслийн үнэлгээ нь ялгаатай байж болох бөгөөд зарим тохиолдолд хувьцаа худалдах худалдан авах гэрээнд заасан үнээр, зарим тохиолдолд зах зээлийн харьцуулсан үнэлгээгээр үнэлдэг. Зээлийн үйл ажиллагааны журамд зээлдэгч нь хуулийн этгээдээс тээврийн хэрэгсэл худалдан авч байгаа тохиолдолд тухайн байгууллагын эрх бүхий этгээдийн гарын үсгээр баталгаажсан нэхэмжлэхийг авахаар заасан боловч худалдах худалдан авах гэрээнд тээврийн хэрэгсэл нийт үнэ, урьдчилгаа төлбөр, үлдэгдэл төлбөр, худалдагч талын дансны мэдээлэл тусгагдсан бол худалдагч талын нэхэмжлэхийг хувийн хэрэгт хавсаргадаггүй. Зээлдэгч тус бүрт зээлийн дансны хуулга, депозит данс үүсдэг бөгөөд зээлдэгчид олгосон зээлийн мэдээлэл, зээлдэгчийн төлж буй зээлийн орлогууд

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

358

2025/11/28

		нь огноогоор тодорхой харагдаг, мөн шилжүүлгийн баримтыг банкнаас авдаг тул зээлийн хүүний хэрэгт зээл шилжүүлсэн шилжүүлгийн баримтыг хавсаргадаггүй. Иймд зээл олгосон баримтыг зээлийн дансны хуулгаар тодорхойлно. Бизнесийн зээлийн хувьд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний анхан шатны үнэлгээг Smart LOS системд автоматаар үнэлэх бөгөөд анхан шатны үнэлгээ дунд болон өндөр эрсдэлтэй гарсан технологид зээлийн эцийн засагч дунд шатны үнэлгээний маягтыг дагуу байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэдэг. Иймд, анхан шатны үнэлгээгээгээр эрсдэл бага гэж гарсан бол байгаль орчин, нийгмийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийдэггүй, холбогдох баримт зээлийн хувийн хэрэгт байхгүй болно. A15023100906 тоот зээлийн хувьд зээлийн хорооны шийдвэр байхгүй бөгөөд LOS Smart системийн шинэчлэлийн явцад устсан болно. Үүнд холбогдуулан зээл олголттой холбоотой аливаа эрсдэл үүсэхгүй болно. Зарим зээлийн хувьд (A220240923003, A150240707005, A150240926007, A150240926007, A150241109010 A150241227008, A220250224002, A220240923003 тоот зээлийн данс) Хувийн мэдээлэл мууруулах, боловсруулах, ашиглах зөвшөөрлийн маягт зээлийн хувийн хэрэгт байхгүй бөгөөд агентаар дамжуулан зээл олгох технологид тус зөвшөөрлийг цахим платформоор баталгаажуулж авдаг.
4	Зээлийн гэрээ, фидуцийн гэрээтэй холбоотой	Хамтран зээлдэгч нь фидуцийн зүйлийг өмчлөгүй технологид эд хөрөнгө эзэмшил, өмчлөлд шилжүүлэх гэрээ буюу Фидуцийн гэрээнд хамтран зээлдэгчийг гэрээний оролцогч тал болгон оруулаагүй, гэрээнд гарын үсэг зуруулаагүй байж болно. Зээлийн дансдын хувьд фидуцийн гэрээнд хамтран зээлдэгчийн мэдээллийг оруулаагүй, гарын үсгээр баталгаажуулаагүй байж болно. Иргэний хуулийн 235.1-т "*үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээгээр (цаашид "фидуци" гэх) үүрэг хүлээгч нь мөнгө төлөх үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, үүрэг хүлээгч үндсэн үүрэгээ хугацаанд гүйцэтгэсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч уг эд хөрөнгийг түүнд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ*", 235.4-т "*үүрэг хүлээгч мөнгө төлөх үүрэгээ хугацаанд нь биелүүлж, шилжүүлсэн эд хөрөнгөө буцаан авсан буюу нөхүү үүрэгээ биелүүлээгүй бол өмчлөлд шилжүүлсэн эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгч бодитойгоор гаргуулан авснаар үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ дуусгавар болно*" гэж тус тус заасан. Мөн фидуцийн гэрээний 1.2-т "*зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар дараах хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх*", 1.1-т"*үүрэг гүйцэтгэгч нь гэрээний 1.2 дах хэсэгт заасан хөдлөх эд хөрөнгүүдийг үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, өмчлөлд шилжүүлэх ба үүрэг гүйцэтгэгч нь зээлийн гэрээнд заасан үүрэгээ зохих ёсоор хугацаанд нь гүйцэтгэсэн тохиолдолд эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан шилжүүлнэ*" гэж заасан. Дээрхээс үзвэл, фидушийн гэрээний дагуу "Инвескор ББСБ" ХК нь зээлийн гэрээний үүрэг хангагдсан технологид тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг үүрэг гүйцэтгэгчид буюу зээлдэгчид буцаан шилжүүлэх үүрэг хүлээж байна. Иймд, зээлийн гэрээний дагуу үүрэг гүйцэтгэгч нь үндсэн зээлдэгч, эсхүл хамтран зээлдэгчийн хэн байгаагаас үл шалтгаалан зээлийн гэрээний үүрэг гүйцэтгэж буй этгээдэд (үндсэн зээлдэгч) тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг буцаан шилжүүлэх үүрэг хүлээж байна. Фидушийн зүйл болох автотээврийн хэрэгслийг тээврийн хэрэгслийн гэрчилгээнд заасан арлын дугаараар тодорхойлох бөгөөд тээврийн хэрэгслийн

359

2025/11/28

		улсын дүгнэр өөрчлөгдсөнийг зээлийн гэрээ болон эд хөрөнгө эзэмшил, өмчлөлд шилжүүлэх гэрээ (фидуцийн гэрээ)-нд оруулаагүй байж болно. Зээлийн гэрээ, эд хөрөнгө эзэмшил, өмчлөлд шилжүүлэх гэрээ (фидуцийн гэрээ), ипотекийн гэрээнд зээлдэгчийн оршин суугаа хаягийг оршин суугаа газрын тодорхойлолтоор бус иргэний үнэмлэхийн хаяг, анкетанд бичсэн хаяг, эсхүл тээврийн хэрэгсэл худалдах, худалдан авах нотариатаар батлагдсан гэрээн дэх хаяг байж болно. Зээлийн гэрээ, эд хөрөнгө эзэмшил, өмчлөлд шилжүүлэх гэрээ (фидуцийн гэрээ), ипотекийн гэрээнд үндсэн болон хамтран зээлдэгчийн хаягийг тусгахдаа уттад нөлөөлөхгүй, илт алдаатай бус техникийн алдаа гаргасан байж болно. Зээлийн гэрээгээр тохиролцсоны дагуу зээлийн төлбөрийг "XXX" ХХК, эсхүл Монгол Улсын иргэн ХХХ буюу тээврийн хэрэгсэл борлуулагчийн дансанд шилжүүлсэн байж болно. Зарим зээлийн данстын (A120240701004 тоот) хувьд Фидуцийн гэрээнд тээврийн хэрэгслийг ББСБ-д шилжүүлэхээс өмнөх улсын дугаарыг оруулсан байж болно.

----oOo----

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317830 1110277128
УЛААНБААТАР ХОТ

360

2025/11/28

MDSKhanLex

“ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК” ХХК-ИАС АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ БАРЬЦААЛСАН ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС (ХБҮЦ) ГАРГАН ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ САНАЛ БОЛГОХТОЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

Хаана:	**“ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК” ХХК-д**
Хаяг:	**Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Парисын гудамж, 42, ай си тауэр, 14 давхар, 1401 тоот**
Утас/Факс:	**(976) 77090099**
Хаанаас:	**“ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС” ХХН**
Хаяг:	**Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2 Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот**
Утас/Факс:	**(976-11) 330048, (976-11) 330049**
Огноо:	**2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр**

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

361

2025/11/28

2025-12-31
БҮРТГЭВ-02

2025 оны 12 сар 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

Монгол Улс, Улаанбаатар хот 14200
Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2
Сангилал Тауэр, 13 давхар, 1301 тоот

Утас: +976 11 330048
Факс: +976 11 330049
Олон улс: +1 (978) 9033574

2025.11.28 № Д-25/251

"ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК"
ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТАНАА

"ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК" ХХК-ИАС АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ БАРЬЦААЛСАН ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС (ХБҮЦ) ГАРГАН ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ САНАЛ БОЛГОХТОЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН (цаашид **"МДСХ"** гэх) нь **"Инвескор Өсөлт ТЗК"** ХХК (цаашид **"Компани"**, эсхүл **"Үнэт цаас гаргагч"** гэх)-ийн автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гарган олон нийтэд нээлттэй санал болгохтой холбогдуулан энэхүү хууль зүйн дүгнэлт (цаашид **"Дүгнэлт"** гэх)-ийг гаргаж байгаа болно. Энэхүү Дүгнэлт нь тухайлан зориулж гаргасан этгээдүүдээс бусад этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг, хариуцлага бий болгохгүй. Дүгнэлт нь холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгдсэн бөгөөд аливаа гуравдагч этгээдэд ашиглай байх, эсхүл давуу байдлыг бий болгох мэдээлэл агуулаагүй, аливаа баталгаа өгөх зорилгогүй болно.

Дүгнэлтийг боловсруулахад ирүүлсэн бүрдүүлбэр материал, баримтуудад агуулагдсан дараах асуудлаар МДСХ нь хариуцлага хүлээхгүй ба Дүгнэлт гаргаагүй болно. Үүнд:

1. Дүгнэлт нь зөвхөн хууль зүйн асуудлаар хийгдсэн бөгөөд аливаа бусад мэдээлэл, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ зэрэг тусгай мэргэжлийн хүрээний мэдээллийн талаар бид ямарнай мэдлэггүй, тэдгээрийн үнэн зөв байдлыг тогтоохгүй болно;
2. Дүгнэлтэд өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд МДСХ-ийн хийсэн ажил энэхүү Дүгнэлтийн тайлбар хэсгийн судалгаа шинжилгээний ажлын хүрээгээр хязгаарлагдаж байгаа болно;
3. Нотариатын гэрчилсэн, улсын бүртгэл болон бусад эрх бүхий бүртгэлийн байгууллагад бүртгэгдсэн үйлдэл нь бодит эсэх;
4. Бусад улсын хууль тогтоомж буюу бусад эрх зүйн харьяаллын хүрээнд хийгдсэн, хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх;
5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "...санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна" гэж заасны дагуу санхүүгийн мэдээлэл,

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277129
УЛААНБААТАР ХОТ

362

2025/11/28

андеррайтерын судалгаа, дүгнэлт, таамаглал болон нийтэд илэрхий бусад мэдээллийн талаар;

6. Эд хөрөнгө, эдийн бус баялгийн үнэлгээ, хувьцааны үнэ, ханшийн мэдээллийн талаар;
7. Дүгнэлтэд тусгайлан дурдсанаас бусад аливаа судалгаа, шинжилгээ, асуулга хийгдээгүй болно. Тийнхүү хийгдээгүй судалгаа, шинжилгээ, асуулгын үндэс болсон аливаа мэдээлэл, бүртгэл нь бүрэн биш, шинэчлэгдээгүй, жишээ нь, тухайн баримт бичиг нь холбогдох эрх бүхий байгууллагад бүртгэгдээгүй, хувийн хэргээс устсан, алга болсон эсхүл бусад байдлаар архив, хувийн хэрэгт байхгүй болсон байж болно;
8. Компанийн бүх баримт бичиг, гэрээ, төлөвлөгөө, харилцаа холбоо, зөвшөөрөл, хувийн хэрэгтэй танилцсан, тэдгээрийг судалсан гэх амлалтыг МДСХ нь энэхүү Дүгнэлттэй холбоотой гаргахгүй болно;
9. Дүгнэлт боловсруулах үед хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Монгол Улсын хуулийн хүрээнд хийгдсэн бөгөөд МДСХ нь өөр бусад эрх зүйн тогтолцооны холбоо, хамаарал, нөлөөллийн талаар ямар нэгэн үзэл бодол илэрхийлээгүй болно.

Дор дурдсанаас бусад тохиолдолд бидний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү Дүгнэлтийг ашиглах, ишлэл авах, бусад баримт бичигт оруулан дурдах, бусдад хувилан хүргүүлэхийг хориглоно. Үүнд:

1. "Инвескор Өсөлт ТЗК" ХХК-иас автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах (цаашид "Үнэт цаас" эсхүл "ХБҮЦ" гэх)-тай холбогдуулан Компани болон Компанитай гэрээгээр ажиллаж буй нягтлан бодогч, хуульч болон мэргэжлийн зөвлөхүүд;
2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу Компанийн мэдээлэл, тайлан гаргаж хүргүүлэх шаардлагатай төрийн болон өөрийгөө зохицуулах байгууллага.

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь Үнэт цаас гаргагч "Инвескор Өсөлт ТЗК" ХХК болон түүний үүсгэн байгуулагч "Инвескор ББСБ" ХК-тай аливаа сонирхлын зөрчилгүй болохоо үүгээр мэдэгдэж байна.

Дүгнэлтийг дээрх хаягласан этгээдэд хүргүүлсэн өдрөөс хойш хууль тогтоомжид өөрчлөлт орсон болон бусад үйл ажиллагаатай холбогдуулан МДСХ нэмэлт хууль зүйн дүгнэлт гаргах үүрэг хүлээхгүй болно.

Мөн Компанийн зүгээс ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан, Дүгнэлт гаргах явцад танилцуулаагүй, буруу, дутуу танилцуулсан нөхцөлд үүсэх асуудлаар МДСХ хариуцлага хүлээхгүй.

Энэхүү албан бичиг нь Дүгнэлтийн салшгүй хэсэг байна.

Хүндэтгэсэн,

"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН ГИШҮҮН, ХУУЛЬЧ Д.ДУГЭРЖАВ

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 1167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

363

2025/11/28

АГУУЛГА

Удиртгал 5

Хангагдсанд тооцох нөхцөл 5

1. **Компани үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрчилгээ, тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх** 8

2. **Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэх** 11

3. **Компанийн дүрэм, үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журам, зааврууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх** 14

4. **Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээд буюу анхны үүрэг гүйцэтгүүлэгч, худалдагчтай байгуулсан хөрөнгө шилжүүлэх, худалдах, худалдан авах, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө иттэмжлэн удирдах гэрээ, хэлцэл болон Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх** 19

5. **Үнэт цаас гаргагч нь хөрөнгө иттэмжлэн удирдагч, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч бусад этгээдүүдтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсэх** 22

6. **Хөрөнгийн багц дахь хөрөнгийн төрөл бүрээс хамааруулан санамсаргүй түүврийн аргаар сонгох замаар үнэт цаас гаргагчаас тогтоосон хууль зүйн шалгуур үзүүлэлт хангаж буй эсэх** 25

7. **Багцын хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрээ, хэлцэлд үүргийн гүйцэтгэлийн зүйлтэй холбоотой аливаа шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгасан эсэх** 26

8. **Үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан мэдээлэл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, бусад холбогдох хууль журамд нийцэж буй эсэх, үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх** 27

9. **Тухайн компанийн эрхэлдэг үйл ажиллагаатай холбоотойгоор хийсэн хууль зүйн нэмэлт судалгаа шинжилгээ** 29

ИНВЕСКОР ӨӨЛТ ТӨК ХХК
InvesCore Growth ARS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
364
InvesCore CAPITAL
6317839 5119277128
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН (цаашид "МДСХ", эсхүл "Бид" гэх) нь Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "СЗХ" гэх)-ны 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 25 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-т зааснаар Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх эрхтэйгээр анх бүртгэгдсэн бөгөөд СЗХ-ны 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 42 тоот тогтоолоор тус бүртгэлд өөрчлөлт оруулан шинэчлэн бүртгүүлсэн Үнэт цаасны зохицуулалттай этгээд (Хавсралт 1.1)-ийн хувьд энэхүү хууль зүйн үйлчилгээг үзүүлэх эрхтэй болно.

Монгол Улсын хуулийн этгээд болох "ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК" ХХК (Регистрийн дугаар: 7167257) (цаашид "Компани", эсхүл "Үнэт цаас гаргагч" гэх) нь автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гарган олон нийтэд нээлттэй санал болгох гэж буйтай холбогдуулан Хууль зүйн дүгнэлт гаргуулахыг Компанийн үүсгэн байгуулагч "Инвескор ББСБ" ХК (цаашид "ББСБ" гэх) нь биднээс хүсэж, улмаар 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр "Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ" (Хавсралт 1.2)-г байгуулан, тус гэрээний дагуу энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргаж байна.

Дүгнэлтийг зөвхөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн үндсэн дээр гаргаж байна. Тус Компани нь Компанийн тухай Монгол Улсын хуулийн 42 дугаар зүйл (Үнэт цаас гаргах тухай шийдвэр), Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйл (Үнэт цаас), 6 дугаар зүйл (Үнэт цаас гаргах), 7 дугаар зүйл (Үнэт цаас гаргагч), 8 дугаар зүйл (Нийтэд санал болгон үнэт цаас гаргах журам), 9 дүгээр зүйл (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 11 дүгээр зүйл (Үнэт цаасыг нийтэд санал болгох), Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйл (Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах), Монголын хөрөнгийн бирж ХК (цаашид "МХБ" гэх)-ийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2020/06 тоот тогтоолоор батлаж, 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 24 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2.5.5 дугаар зүйл (Хууль зүйн дүгнэлтийн агуулга), Санхүүгийн Зохицуулах хорооны 2022 оны 06-р сарын 22-ны өдрийн 360 дугаар тогтоолоор баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам"-ын 2 дугаар зүйл (Тусгай зориулалтын компанид тавигдах шаардлага), 5 дугаар зүйл (Баталгаат үнэт цаасыг бүртгэх шаардлага), 3 дугаар зүйл (Тусгай зориулалтын компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц), 7 дугаар зүйл (Үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага), 8 дугаар зүйл (Хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдах шаардлага, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ), 10 дугаар зүйл (Аудитын шалгалт болон хууль зүйн дүгнэлт)-д тус тус заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлж, нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн байна.

Хангагдсанд тооцох нөхцөл

Энэхүү Дүгнэлтийг боловсруулахдаа Бид дараах нөхцөл хангагдсан гэж үзсэн болно. Үүнд:

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
УЛААНБААТАР ХОТ

365

2025/11/28

1. Дүгнэлт гаргахад ашигласан Үнэт цаасны танилцуулга нь эцсийн хувилбар бөгөөд энэхүү Дүгнэлтийг гаргах үеийн байдлаар Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргэгдэж, ХБҮЦ-ны албан ёсны Үнэт цаасны танилцуулга болж ашиглагдах;
2. Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээ, мэдээллийг оруулсан эгтээд нь хууль тогтоомж буюу тухайн талын дүрэм, дотоод дүрэм журам, эрх бүхий этгээдтэй байгуулсан гэрээ, эрх бүхий этгээдээс авбал зохих хууль ёсны, хүчин төгөлдөр зөвшөөрөл, итгэмжлэл, эрхийг зохих ёсоор авсны үндсэн дээр үнэт цаасны танилцуулгад мэдээллийг үнэн зөв бүрэн гүйцэт байдлаар тусгасан;
3. Үнэт цаасны танилцуулгад тусгасан нөхцөл ирээдүйд хэрэгжих тохиолдолд тухайн нөхцөл нь хуулийн дагуу, зохих ёсоор, эрхийн болон биет байдлын доголдолгүй хэрэгжих;
4. Үнэт цаасны танилцуулгыг батлах, бүртгүүлэх үйлдэл нь хуульд нийцсэн, зохих ёсоор, хүчин төгөлдөр байдлаар хийгдэх;
5. Үнэт цаасны танилцуулгад дурдсан санхүүгийн тоо, мэдээ, баримт, үзүүлэлт, тооцоо, тайлан болон бусад үзүүлэлтийг аудитын үйлчилгээ эрхлэх эрх бүхий байгууллага хянан баталгаажуулсан, эдгээр мэдээ мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэт;
6. Үнэт цаасны танилцуулгад тусгасан хөрөнгийн багцад хийсэн судалгаа шинжилгээ үнэн зөв, бүрэн гүйцэт байх;
7. Үнэт цаасны танилцуулгад тусгасан хэлцэл хийх, гэрээ байгуулах, хэлцэл батлах талаарх үйлдэл нь хуульд нийцэж зохих ёсоор, хүчин төгөлдөр байллаар хийгдэх;
8. Үнэт цаасны танилцуулгад тусгасан талуудын хооронд байгуулагдах гэрээ, хэлцлийг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу зохих ёсоор байгуулах, гэрчлүүлэх, бүртгүүлэх;
9. Үнэт цаасны танилцуулгад тусгасан андеррайтер, аудитор, мэргэжлийн оролцогчдын хийсэн судалгаа, дүгнэлт, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв;
10. Дүгнэлт гаргахад ашиглагдсан (а) бидэнд ирүүлсэн бүх баримт бичгт дурдсан мэдээлэл үнэн, зөв, бүрэн гүйцэт; (б) тэдгээр баримт бичгт зурагдсан гарын үсэг, дарагдсан тамга, тэмдэг зохих ёсны бөгөөд үнэн зөв; (в) бидэнд ирүүлсэн бичиг баримтуудын хуулбар нь тэдгээрийн эх хувьтай нийцсэн, бүрэн; (г) бидэнд ирүүлсэн бичиг баримтууд нь хамгийн сүүлд батлагдсан хувилбар буюу тэдгээрт өөрчлөлт ороогүй, хүчингүй болоогүй;
11. МДСХ-зөс тавьсан асуулт, тодруулгад Үнэт цаас гаргагч, түүнний хувьцаа эзэмшигч, бусад оролцогчоос амаар болон бичгээр өгсөн хариулт, тайлбар, түүнийг нотлох баримт бичиг үнэн зөв;
12. Бидний судлан шинжилсэн бүх баримт бичгийн хуулбар, эсхүл загвар, маягтууд нь үнэн зөв, тэдгээр дээрх аливаа тэмдэглэгээ, гарын үсэг, тамга тэмдэг нь үнэн;
13. Бүх баримт бичгүүд нь тэдгээрийг үйлдсэн талуудын бүрэн эрхийн хүрээнд үйлдэгдсэн;
14. Бидэнд өгөгдсөн баримт бичгийн дагуу үүсэх аливаа үүрэг нь Монгол Улсаас бусад эрх зүйн тогтолцоонд хүчин төгөлдөр байх ба тэдгээр үүргийн хэрэгжилт хууль бус, хүчин төгөлдөр бус, эсхүл хэрэгжих боломжгүй биш байна;
15. Монгол Улсаас өөр улсад үйлдэгдсэн аливаа баримт бичиг нь тийнхүү үйлдэгдсэн улсын хуулийн шаардлагыг хэлбэрийн болон агуулгын хувьд бүрэн хангасан, хүчин төгөлдөр баримт бичиг ба тэдгээрийн хэрэгжилт нь тийнхүү хэрэгжих улсын хуулийн шаардлагыг мөн хангасан;
16. Компани, түүний албан тушаалтан, ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан аливаа мэдээлэл нь үнэн зөв, бодитой;
17. Шүүх, төрийн эрх бүхий байгууллагаас авсан мэдээлэл, баримт бичиг нь үнэн зөв;

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
366
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

18. Бидний судалж ашигласан баримт бичгийг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь тийнхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй;
19. Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргахтай холбоотойгоор бэлтгэл ажил гүйцэтгэхэд шаардлагатай гэрээ, хэлцэл (Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ, Зээлийн багцад санхүүгийн шинжилгээ хийх гэрээ)-г "Инвескор ББСБ" ХК байгуулсан болно. Эдгээр гэрээг "Инвескор Өсөлт ТЗК" ХХК-ийн эрх ашгийн үүднээс байгуулсан тул тэдгээр гэрээнд тусгагдсан "Инвескор ББСБ" ХК-ийн зарим эрх, үүргийг Үнэт цаас гаргагч хэрэгжүүлж болно.

Энэхүү ХБҮЦ-ны бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7 дугаар зүйл, СЗХ-ны 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 360 тоот тогтоолоор батлагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам ("СЗХ-ны журам"), СЗХ-ны дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 94/А/62 дугаар тушаалаар батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2020/06 тоот тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам" болон ТУЗ-ийн 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан "МХБ-ийн Арилжааны журам"-д заасны дагуу явагдана гэж үзлээ.

Санхүүгийн зохицуулах хороноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгож, зөвшөөрлийг улсын бүртгэлд бүртгүүлэхээс өмнө "Инвескор Өсөлт ТЗК" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй байгуулсан гэрээнүүд нь тусгай зориулалтын компанийн хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд компанийн нэр уг хугацаанаас өмнө ба дараа өөрөөр туссан болохыг анхаарна уу.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн үнэт цаасны танилцуулга, бусад холбогдох мэдээллүүдийг үндэслэн Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн дор дурдсан Дүгнэлтийг гаргаж байна.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101466

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
367
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

2025 12 26
БҮРТГЭВ
No 01

MDSKhanLex

1. Компанийг үүсгэн байгуулах эрхийг болон түүнийг үүсгэн байгуулах бүртгүүлсэн болсон нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрчилгээ, тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх

"Инвескор Өсөлт" ХХК нь 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн "Инвескор ББСБ" ХК-нийн Хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч Төлөөлөн удирдах зөвлөл, түүнийг төлөөлөх бүрэн эрх бүхий "Инвескор ББСБ" ХК-нийн Гүйцэтгэх захирлын 01 дугаар "Инвескор Өсөлт ХХК-ийг үүсгэн байгуулах шийдвэр" (Хавсралт 1.3)-ын үндсэн дээр Санхүүгийн тайлан баланс бэлтгэн гаргах, түүнтэй холбоотой зовлогоо огох чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар байгуулагдаж, 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Улсын бүртгэлд бүртгүүлсэн (Хавсралт 1.4) байна. "Инвескор ББСБ" ХК-нийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хараат болон охин компанийг үүсгэн байгуулах, тэдгээрийн гүйцэтгэх удирдлагыг томилох болон хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрх бүхий этгээд (Хавсралт 1.7) бөгөөд "Инвескор ББСБ" ХК-нийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 05 сарын 15-ны өдрийн 25/34 тоот тогтоолоор (Хавсралт 2.1) охин компанн үүсгэн байгуулах, охин компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрх, үүргийг итгэмжлэлгүйгээр хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигчийн шийдвэрийг Компанийн нэрийн өмнөөс төлөөлөн баталгаажуулах, гарын үсэг зурах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс "Инвескор ББСБ" ХК-нийн Гүйцэтгэх захирал Д.Баясгаланд олгосон байна. Иймд, Компани үүсгэн байгуулах шийдвэрт эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулсан гэж үзлээ. "Инвескор Өсөлт" ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө уг үнэт цаасаа бүртгүүлэхийн өмнө Санхүүгийн зохицуулах хороонооос авахаар төлөвлөж, 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 1 дугаартай албан бичиг (Хавсралт 1.11)-ээр хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 413 дугаар тогтоол (Хавсралт 1.12), ТЗ 315/81 дугаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ (Хавсралт 1.10)-ээр Компанид хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

Иймд, 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр "Инвескор Өсөлт" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч "Инвескор ББСБ" ХК-нийн Төлөөлөн удирдах зөвлөл, түүнийг төлөөлөх бүрэн эрх бүхий "Инвескор ББСБ" ХК-нийн Гүйцэтгэх захирлын 25/1-3 дугаар "Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" шийдвэр (Хавсралт 3.2)-ийн үндсэн дээр Компани нь "ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК" ХХК болж, ингэсэн нэр, эрхлэх үйл ажиллагааны төрөлд өөрчлөлт оруулан дүрмээ улсын бүртгэлд 2025 оны 10 дугаар сарын 22-ний өдөр бүртгүүлсэн байна (Хавсралт 1.13, 1.14).

Компанийн тухай мэдээлэл:

Улсын бүртгэлийн гэрчилгээ дугаар: 000348482
Улсын бүртгэлийн дугаар: 9011880461;
Регистрийн дугаар: 7167257;
Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр: "ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК" Хязгаарлагдмал хариуцлагатай компани;
Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах;

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101485

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
368
InvesCore CAPITAL
6317239 ДД1119277129
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
InvesCore FI
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

2025 12. 25
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

Хугацаа: Хугацаагүй;
Хувьцаа эзэмшигчдийн тоо: 1;

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Гаргасан хувьцаа			Хөрөнгө нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь
		Тоо ширхэг	Нэрлэсэн үнэ		
			Нэг бүрийн үнэ	Бүгд	
1.	"Инвескор ББСБ" ХК	100	100,000	10,000,000	100%

Хөрөнгө нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ: 10,000,000 төгрөг;
Хуулийн этгээдийн албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Парисын гудамж 42, Ай Си тауэр, 14 давхар, 1401 тоот;
Гүйцэтгэх захирал: С.Тулга.

Компани үүсгэн байгуулагчийн тухай мэдээлэл:

Улсын бүртгэлийн гэрчилгээ дугаар: 000233959;
Улсын бүртгэлийн дугаар: 9010002004;
Регистрийн дугаар: 6060854;
Хуулийн этгээдийн нэр, харилцлагын хэлбэр: "Инвескор ББСБ" Хувьцаат компани (Хавсралт 1.6, 1.7);
Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ: СЗХ-ны 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 159 дугаар тогтоолын дагуу ТЗ 101/554 дугаар бүхий Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй (Хавсралт 1.15)
Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл: Зээлийн, факторингийн, богино хугацаат санхүүгийн хэрэгслэлд хөрөнгө оруулалт хийх, итгэлцлийн, төлбөрийн баталгаа гаргах, гадаад валютын арилжаа эрхлэх (Хавсралт 1.16, Хавсралт 1.17, Хавсралт1.18);
Хугацаа: Хугацаагүй.

ТЗК үүсгэн байгуулах этгээд нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4 дүгээр зүйлд зааснаар банк бус санхүүгийн байгууллага байж болно.

Компанийг үүсгэн байгуулагч "Инвескор ББСБ" ХК нь Зөвшөөрлийн тухай хуулийн 3.1.1, 8.1.2.7, 8.1.2.8, 8.1.2.9, 8.1.2.11, 8.2.2.29, 8.2.2.31, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 6.1, 9.1-д тус тус заасны дагуу СЗХ-ны 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 159 дугаар тогтоол (Хавсралт 1.16)-оор Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагаа эрхлэх, факторингийн үйлчилгээ үзүүлэх, богино хугацаат санхүүгийн хэрэгслэлд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх, СЗХ-ны 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 17 дугаар тогтоол (Хавсралт 1.17)-оор Банк бус санхүүгийн байгууллагын төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 259 дугаар тогтоол (Хавсралт 1.18)-оор Банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна. СЗХ-ны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 669 дугаар тогтоол (Хавсралт 1.9)-оор хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан хүчингүй болгосон байна. Мөн Санхүүгийн

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore
CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

369

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025-12-31
БҮРТГЭВ-02

2025 оны 12 сарын 25 өдөр
ТАНИЛЦУУЛГА
№ 01

Зохицуулах Хорооноос 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр ирүүлсэн 9/2775 тоот албан бичиг (Хавсралт 9.26)-т зааснаар "Инвескор ББСБ" ХК-д олгосон тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн зэрэг тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр бус гэж үзэх нөхцөл байдал үүсээгүй байна.

Түүнчлэн 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2528000200345I дугаар лавлагаа (Хавсралт 1.8)-нд зааснаар "Инвескор ББСБ" ХК нь татан буугдсан, дампуурсан талаарх тэмдэглэлгүй тул тухайн лавлагаа гарах өдрийн байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа, эрх зүйн чадвар, чадамжтай хуулийн этгээд тул "Инвескор ББСБ" ХК нь тусгай зөвшөөрөл олгох компани үүсгэн байгуулах эрх бүхий этгээд болно.

Иймд, энэхүү улсын бүртгэлийн гэрчилгээ (Гэрчилгээний дугаар 000348482, Улсын бүртгэлийн дугаар 9011880461, Регистрийн дугаар 7167257) бүхий "ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК" ХХК нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн, тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр байна.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
370
InvesCore CAPITAL
6317839 д.1119277128
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

“Инвескор ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн “Тусгай зориулалтын компани үүсгэн байгуулах тухай” 25/34 тоот тогтоол (Хавсралт 2.1)-оор “Инвескор ББСБ” ХК нь өөрийн харилцагчдад олгосон зээлийн багцын тусгаарлаж хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгын хүрээнд “Инвескор Өсөлт” ХХК оноосон нэртэйгээр 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани байгуулахаар тогтоон, охин компани үүсгэн байгуулахад шаардлагатай баримт бичгүүд, шийдвэрийг батлах, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхтэй холбоотой хүсэлт гаргах, төлөөлөн гарын үсэг зурах, охин компани нь Санхүүгийн зохицуулах хороноос Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авах, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгүүлэх хүртэлх хугацаанд итгэмжлэлгүйгээр төлөөлөх, охин компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрх, үүргийг итгэмжлэлгүйгээр хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигчийн шийдвэрийг компанийн нэрийн өмнөөс төлөөлөн баталгаажуулж, гарын үсэг зурах зэрэг бүрэн эрхийг “Инвескор ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Баясгаланд олгосон байна.

СЗХ-ны журмын 10.4.6 дахь хэсэгт заасны дагуу зээлийн дансдад санхүүгийн шинжилгээ хийсэн "Си Пи Ти Эй Аудит" ХХК-иас 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр "Харилцан тохиролцсон горимоор гүйцэтгэсэн гэрээт ажлын тайлан" (Хавсралт 8.26), зээлийн дансдад хуулийн шинжилгээ хийсэн “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН-өөс 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр “Автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гарган олон нийтэд нээлттэй санал болгох хүрээнд хөрөнгийн багц дахь сонгогдсон зээлийн данс нь хуулийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан” (Хавсралт 6.1)-г тус тус гаргажээ. Эдгээр тайлан нь “Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах тухай” Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 25/2-5 тоот тогтоол (Хавсралт 2.2)-ын 1 дүгээр хавсралтаар батлагдсан хөрөнгийн багцаас санамсаргүй түүврийн аргаар сонгосон зээлийн дансад нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл, “Хөрөнгийн багцын хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлт”-ийг хангасан болохыг баталгаажуулсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн “Тусгай зориулалтын компанн үүсгэн байгуулах тухай” 25/34 тоот тогтоол (Хавсралт 2.1), Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагч нарын хооронд 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан “Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ” (Хавсралт 4.1)-ний дагуу “Инвескор ББСБ” ХК-ийн багцалсан зээлийн хөрөнгийг Үнэт цаас гаргагчид шилжүүлэхээр тохиролцож, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахаар шийдвэрлэсэн байна. Тус Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 25/34 тоот тогтоол нь Компанийн тухай хуульд заасан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гаргах (Хавсралт 2.5) журмын дагуу явагдсан байна.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

371

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

2025 -12- 25
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах шийдвэр:

~~Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны бүтцэл ажлыг хангах хүрээнд~~ "Инвескор ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 25/35 дугаар "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нөхцөлийг урьдчилсан байдлаар тогтоох тухай" тогтоол (Хавсралт 2.3) гарч, тус тогтоолоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нөхцөлийг урьдчилсан байдлаар тогтоож, үнэт цаас гаргах, бүртгүүлэхтэй холбоотойгоор хөндлөнгийн аудитор, андеррайтер, хуулийн зөвлөх үйлчилгээ болон бусад шаардлагатай мэргэжлийн этгээдүүдтэй "Инвескор ББСБ" ХК-ийг төлөөлөн шийдвэр гаргах, гэрээ байгуулахаар хэлэлцээр хийж, гэрээнд гарын үсэг зурах, холбогдох төлбөр хийх эрхийг Гүйцэтгэх захирал Д.Баясгаланд олгосон байна. Тус тогтоол нь Компанийн тухай хуульд заасан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гаргах (Хавсралт 2.4) шаардлагад нийцсэн байна.

Улмаар Компанийн Хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч болох "Инвескор ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс бүрэн эрх олгогдсон, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд буюу "Инвескор ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 1 дугаар "Инвескор Өсөлт ХХК-ийг үүсгэн байгуулах" шийдвэр (Хавсралт 1.3)-ийн дагуу "Инвескор Өсөлт" ХХК-ийг байгуулж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахаар шийдвэрлэсэн байна. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай" 413 дугаар тогтоол (Хавсралт 1.12)-оор тусгай зөвшөөрөл олгосныг үндэслэн "Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах тухай" Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 25/2-5 тоот тогтоол (Хавсралт 2.2) гаргаж, Компани Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай Монгол Улсын хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид "Үнэт цаас" гэх)-ыг дараах нөхцөлтэйгөөр гаргахаар шийдвэрлэсэн. Үүнд:

Үнэт цаасны нэр	Инвескор Өсөлт ХБҮЦ
Үнэт цаасны төрөл	"Инвескор ББСБ" ХК-ийн автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас
Үнэт цаас гаргагч	"Инвескор Өсөлт ТЗК" ХХК
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	"Инвескор ББСБ" ХК
Үнэт цаасыг санал болгох хэлбэр	Олон нийтэд нээлттэй санал болгох
Үнэт цаас гаргах хугацаа	2025 оны 4-р улирал (Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэй холбоотой энэ хугацаа өөрчлөгдөх боломжтой бөгөөд Хороонд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгүүлснээс хойш 6 сарын хугацаанд олон нийтэд санал болгон худалдана)
Татан төвлөрүүлэх хөрөнгийн нийт дүн	50.0 тэрбум төгрөг
Үнэт цаасны нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
Үнэт цаасны нийт тоо, ширхэг	500,000 ширхэг

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore
Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
372
InvesCore
CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

Үнэт цаасны хугацаа	18 (арван найм) сар
Үнэт цаасны хүү (жилийн)	18.5% (арван найм нарийн таван хувь)
Хүү төлөх давтамж	Улирал бүр
Үндсэн төлбөр төлөх давтамж	Үнэт цаасны хөрөнгө оруулагч эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх өдрөөс хойш 12 сарын дараа 50%, хугацааны эцэст үлдсэн 50%
Үнэт цаасны зарчуулагч	"Инвескор ББСБ" ХК-аас авто тээврийн хэрэгсэл болон үл хөдлөх барьцаалсан хөрөнгийн бүрэн хуулдаж авах
Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	Монголын Хөрөнгийн Бирж
Үнэт цаасны хадгалалт, төлбөр тооцоо эрхлэх байгууллага	"Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв"

Энэхүү тогтоол нь Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.5, Үнэт цаасны зах зээлийн тухай Монгол Улсын хуулийн 5.1.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3.4 дэх хэсэгт тус тус нийцсэн байна.

373

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2025 -12- 31 БҮРТГЭВ-02

2025 оны 12, 2 дугаар БҮРТГЭВ № 01

MDSKhanLex

3. Компанийн дүрэм, үүсгэн байгуулагчийн гэрээ, журам, заавруудын хуулийн шаардлага хангасан эсэх

Компанийн дүрэм:

"Инвескор Өсөлт" ХХК-ийн анхны дүрэм. "Инвескор Өсөлт" ХХК-ийн дүрмийг Компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч Төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлөх бүрэн эрх бүхий этгээд болох "Инвескор ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн "Инвескор Өсөлт ХХК-ийг үүсгэн байгуулах" 01 тоот шийдвэр (Хавсралт 1.3)-ийн хавсралтаар батлаж, улсын бүртгэлийн тамгаар баталгаажуулсан байна (Хавсралт 1.5). Дүрэм нь нийт 11 бүлэгтэй бөгөөд Компанийн оноосон нэр, оршин байгаа газар, компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл, үйл ажиллагааны үндсэн чиглэл, үйл ажиллагаа эрхлэх хугацаа, Компанийн эрх, үүрэг, хариуцлага, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө, Компанийн удирдлага болон Гүйцэтгэх удирдлага, тэдний эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлох, Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт, Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцаа болон бусад харилцааг зохицуулсан байна. Тус Дүрэмд Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан Компанийн дүрэмд тусгах нэр бүхий 8 заалт, зохицуулалтуудаас 16.2.8 дугаар зүйлд заасан буюу ""Ахмадын сан" байгуулах, менгэн хөрөнгийн хэмжээг тогтоох" тухай зохицуулалт тусгагдаагүй байх боловч "Инвескор ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн "Тусгай зориулалтын компани үүсгэн байгуулах тухай" 25/34 тоот тогтоол (Хавсралт 2.1)-д дурдсаны дагуу "Инвескор ББСБ" ХК нь өөрийн харилцагчдад олгосон зээлийн багцаа тусгаарлаж хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгын хүрээнд "Инвескор Өсөлт" ХХК оноосон нэртэйгээр 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани байгуулахаар болсон байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.1-т "Тусгай зориулалтын компани нь Компанийн тухай хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу байгуулагдсан, тус хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг авсан хязгаарлагдмал хариуцлагатай компани байна" гэж, 12.3-т "Тусгай зориулалтын компанийг баталгаат үнэт цаас гаргах бүрт байгуулна" гэж, 2.4-т "Тусгай зориулалтын компанийг банк, банк бус санхүүгийн байгууллага байгуулж болно" гэж, түүнчлэн тус хуулийн 12.12.5-д "тусгай зориулалтын компани нь хөдлөлмерийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулахыг хориглоно" гэж тус тус заасны дагуу "Инвескор ББСБ" ХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгын хүрээнд "Инвескор Өсөлт" ХХК-ийг үүсгэн байгуулсан байх ба "Инвескор Өсөлт" ХХК нь СЗХ-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах "тусгай зориулалтын компани"-ий зөвшөөрлийг авснаар ажилтангүй үйл ажиллагаа явуулах тул Компанийн тухай хуулийн 16.2.8-д заасан зохицуулалтыг Дүрэмдээ тусгаагүй нь хуулийн зөрчил гэж үзэгдэхээргүй байгааг дурдаж байна. "Инвескор Өсөлт" ХХК-ийн Дүрэм нь Компанийн тухай хууль болон бусад холбогдох кууль тогтоомжийн зохицуулалтад нийцсэн байна. Мөн "Инвескор Өсөлт" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч "Инвескор ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлж Гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 76.1.18 болон 83.8-т заасан бүрэн эрхийн хүрээнд дүрмийг баталсан, Гүйцэтгэх захирлын дүрэм баталсан шийдвэр нь тус хуулийн 17.9-т зааснаар улсын бүртгэлд бүртгэгдсэн байна.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК InvesCore Growth ABS LLC УЛААНБААТАР ХОТ ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ

374

2025/11/28

InvesCore FF
2025 -12- 31
БҮРТГЭБ-02

2025 12 25
БҮРТГЭВ
No 01

MDSKhanLex

"ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК" ХХК-ийн дүрэм. Ийнхүү Компанид СЗХ-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон тул Компанийн хувьцаа эзэмшигчийн 2025 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн "Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 25/1-3 дугаар шийдвэр (Хавсралт 3.2)-ийн хавсралтаар "ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК" ХХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулга (Хавсралт 1.14)-ыг батлсан байна. Энэхүү дүрэм нь нийт 8 бүлэгтэй бөгөөд компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг, компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл, компанийн үйл ажиллагаа, компанийн хувьцаа эзэмшигчид ба хувь нийлүүлсэн хөрөнгө, компанийн удирдлага, компанийн санхүүгийн үйл ажиллагаа, аудит ба хяналтын тогтолцоо, компанийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэл, дүрэм хүчин төгөлдөр болох ба татан буугдах ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан байна. СЗХ-оос 2025 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 413 тоот тогтоол (Хавсралт 1.12)-оор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Компанид олгосноор дүрэм нь хүчин төгөлдөр мөрдөгдөх үндэслэл бий болж улсын бүртгэлд бүртгэгдсэн байна (Хавсралт 1.14). Энэхүү дүрэмд Компанийн оноосон нэр "Инвескор Өсөлт ТЗК" болох талаар болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэхээр тусгасан нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 17.9 болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.9, 12.11, 12.12 дугаар зүйлүүд, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3.4, 5.11, 6.11 болон бусад холбогдох зохицуулалтад тус тус нийцсэн байна.

Компанийн дотоод үйл ажиллагааны журмууд:

Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам. Компаннийн хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд Компанийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн нэл тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих зорилго бүхий нийт 4 бүлэг зохицуулалттай энэхүү журам (Хавсралт 3.5)-ыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 25/2-8 тоот тогтоол (Хавсралт 3.1)-ын 5 дугаар хавсралтаар батлсан байна. Энэхүү журмаар Компанн нь мэдээлэл хүргэхдээ баримтлах зарчим, мэдээлэл хүргэх журам, мэдээллийн архивыг бүрдүүлэх, хадгалах үйл ажиллагаа болон журмыг мөрдөж эхлэх нөхцөл, журамд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1, 79.1 дэх хэсэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.2.3, 39 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай" журмын 11 дүгээр зүйлийн холбогдох хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам", Монголын Хөрөнгийн Биржийн "Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам" болон Монголын Хөрөнгийн Биржийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 9.5-9.7 дахь хэсэгт заасан шаардлагыг тус тус хангасан байна.

Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 25/2-8 тоот тогтоол (Хавсралт 3.1)-ын 3 дугаар хавсралтаар "Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам" (Хавсралт 3.7)-ыг батлсан байна. Журам нь нийт 7 бүлэг

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ADD LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6347639 1119277138
УЛААНБААТАР ХОТ

375

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2025 -12- 31 БҮРТГЭВ-02

2025 12 25 өдөр БҮРТГЭВ №01

MDSKhanLex

зохицуулалттай бөгөөд нийтлэг үндэслэл, эрсдэлийн ангилал, эрсдэлийг удирдах арга хэмжээ, эрэн төлөлтийн сайжруулах, сэлгэрхэлын зорчил, тэдгээрийг мэдэгдэх, журам зөрчсөн ажилтан, албан тушаалтан болон оролцогч байгууллагуудад хариуцлага тооцохтой холбоотой харилцаат зохицуулсан байна. Журам нь холбогдох хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 25/2-8 тоот тогтоол (Хавсралт 3.1)-ын 6 дугаар хавсралтаар "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам" (Хавсралт 3.6)-ыг батлажээ. Журам нь нийт 7 бүлэг бүхий зохицуулалттай бөгөөд Компаннйн гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг Зээлдэгчид болон Үйлчилгээ үзүүлэгчдээс цуглуулах, цуглуулсан төлбөроор үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр төлөхтэй холбогдсон Компанийн үйл ажиллагаа болон Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдүүдийн хооронд үүсэх үйл ажиллагаа, хүлээх хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Журам нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн, хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдах журам. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 25/2-8 тоот тогтоол (Хавсралт 3.1)-ын 2 дугаар хавсралтаар "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам" (Хавсралт 3.8)-ыг батлсан байна. Журмаар нийтлэг үндэслэл, хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах, хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах дараалал, сул чөлөөтэй эх үүсвэрийн удирдлага, журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтан болон оролцогч байгууллагад хариуцлага ногдуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна. Журам нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл, 15 дугаар зүйл, 18.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 25/04 тоот тогтоол (Хавсралт 3.11)-ын 1 дүгээр хавсралтаар "Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам" (Хавсралт 3.4)-ыг батлажээ. Энэхүү журам нь нийт 8 бүлэгтэй бөгөөд хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдах шаардлага, тэдгээрийг сонгох, гэрээ байгуулах, хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг солихтой холбогдсон харилцааг зохицуулсан байна. Уг журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, 33.2 дахь хэсэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.8, 12.11.4, 19.1, 19.8, 19.10, 20.1, 20.3, 40.1 дэх хэсэг, Аудитын тухай хуулийн 17 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын холбогдох хэсэг, Монголын хөрөнгийн биржээс батлсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 3.2.12.2 дэх хэсэг болон бусад холбогдох зохицуулалтад нийцсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 25/2-8 тоот тогтоол (Хавсралт 3.1)-ын 1

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТӨК ХХК InvesCore Growth ETF LLC УЛААНБААТАР ХОТ АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК InvesCore CAPITAL 6317639 1119277126 УЛААНБААТАР ХОТ

376

2025/11/28

дүгээр хавсралтаар энэхүү "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам" (Хавсралт 3.3)-ыг батлсан байна. Журам нийт 5 бүлэгтэй бөгөөд нийтлэг үндэслэл, төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрх, зохион байгуулалт, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ажлын нөхцөл хангамжтай холбогдсон харилцааг зохицуулсан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам нь Компанийн тухай хуулийн 75.8, 76.1, 80.1, 80.5, 80.6, 80.9, 80.11, 80.12, 80.14, 82 дугаар зүйл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.8 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын 3 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг тус тус хангасан бөгөөд Компанийн дүрэмд нийцсэн байна.

Монго угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 25/2-8 тоот тогтоол (Хавсралт 3.1)-ын 7 дугаар хавсралтаар "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам" (Хавсралт 3.9)-ыг батлсан байна. Журмаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас батлагдсан дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна. Тус журам нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Монгол Банкны Ерөнхийлөгчийн 2019 оны 01-р сарын 21-ний өдрийн А-26 дугаар тушаалаар батлагдсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журамд нийцсэн бөгөөд холбогдох бусад хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

Тусгай зориулалтын компанийг татан буулгах журам. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 25/2-8 тоот тогтоол (Хавсралт 3.1)-ын 4 дүгээр хавсралтаар "Тусгай зориулалтын компанийг татан буулгах журам" (Хавсралт 3.10)-ыг батлсан байна. Журмаар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэснийг дараа ТЗК-ийг татан буулгахтай холбоотойгоор ТЗК, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулсан байна. Тус журам нь татан буулгах нөхцөл, бэлтгэл ажлыг хангах, татан буулгахтай холбоотой үйл ажиллагаа, хариуцлага болон бусад гэсэн 5 бүлэг бүхий зохицуулалттай байна. Энэхүү журам нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 22 болон 23 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 32.6 дугаар зүйл болон Компанийн дүрэмд тус тус нийцсэн бөгөөд холбогдох бусад хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

"Инвескор Өсөлт ТЗК" ХХК-ийн ТУЗ нь Компанийн дотоод үйл ажиллагааны журмуудыг Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10, 76.1.13 дахь хэсэг, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд батлаж, ТУЗ-ийн хурал нь Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.5-д заасны дагуу хүчин төгөлдөр байх ба ТУЗ-ийн шийдвэр нь Компанийн тухай хуулийн 80.6-д зааснаар саналын эрхийн хэмжээнд хүрсэн байх тул дээр дурдсан журмуудыг батлагдсан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 25/2-8 тоот тогтоол (Хавсралт 3.1) болон 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 25/04 тоот тогтоол (Хавсралт 3.11) нь хуулийн хүчин төгөлдөр байна.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101466

"ИНВЕСКОР КАПИТАЛ ТҮК" ХХК
УЛААНБААТАР ХОТ

377

2025/11/28

Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 25/2-8 тоот тогтоол тогтоол (Хавсралт 3.1) болон 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 25/04 тоот тогтоол (Хавсралт 3.1 I)-оор батлагдсан журмууд нь хуулийн хүчин төгөлдөр, хууль тогтоомжид нийцсэн ба ТЗК-ийн дүрэм (Хавсралт 1.14) нь холбогдох эрх зүйн актаар тогтоосон алдаа зөрчилгүй байна.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
6317839 1119277129
УЛААНБААТАР ХОТ

378

2025/11/28

4. Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээд болон анхны үүрэн гүйцэтгүүлэгч, хуваарилагчтай байгуулсан хөрөнгө шилжүүлэх, худалдах, худалдан авах, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, хэлцэл болон Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл нь хүчин төгөлдөр биелэгдэж байгаа эсэх, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх

Бид тус Компаниас ирүүлсэн Компанийн үйл ажиллагаанд голлох ач холбогдол бүхий дор дурдсан гэрээг хянасан болно.

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой гэрээний төслүүд:

Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ. Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой "Инвескор ББСБ" ХК болон "Инвескор Өсөлт ТЗК" ХХК нарын хооронд 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр 25/3-2 дугаар "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ" (Хавсралт 4.1) байгуулагдсан байна. Тус гэрээ нь зээлийн багц хөрөнгө болон түүнд холбогдох эрхийг Үнэт цаас нь гаргагч худалдан авч, гэрээнд заасан үнийг төлөх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг худалдах, зээлийн хөрөнгийг солихтой холбоотой харилцааг зохицуулж байна. Энэхүү гэрээ нь Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ. Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой "Инвескор ББСБ" ХК, "Инвескор Өсөлт ТЗК" ХХК болон "Эм Ай Си Жи" ХХК нарын хооронд 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр 25/3-4 дугаар "Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 4.2) байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 9 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчаас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулан, шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, Зээлийн эрсдэлийг удирдах журмын дагуу зээлийн хяналт тавьж, зээл төлүүлэх ажиллагаа явуулах болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас төлбөр цуглуулах үйл ажиллагаанд хяналт тавих, Үнэт цаас гаргагч нь үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбогдох харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Хөрөнгийн барьцааны гэрээ. "Инвескор ББСБ" ХК, "Инвескор Өсөлт ТЗК" ХХК нарын хооронд 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр 25/3-3 дугаар "Хөрөнгийн барьцааны гэрээ" (Хавсралт 4.3) байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 8 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээгээр Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлэх Хөрөнгийн багцад буй Авто тээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор барьцаалуулагч нь Барьцааны зүйлийн өмчлөх эрхийг Барьцаалагчид барьцаалуулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ББСБ LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
379
InvesCore CAPITAL
8317839 1119277129
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ. "Инвескор Өсөлт ТЗК" ХХК болон "Эм Ай Си Жи" ХХК нарын хооронд 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр 25/3-7 дугаар "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ" (Хавсралт 4.4) байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 6 бүлэг болон хавсралтаас бүрдсэн байна. Гэрээний дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан үйлчилгээ үзүүлэх буюу Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн багцыг итгэмжлэн удирдах, Үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх, Үнэт цаас гаргагч нь Хороно итгэмжлэн улирдагчид үйлчилгээний хөлс төлөх холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь Иргэний хууль, Санхүүгийн зохицуулах хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 8.2 дугаар зүйлд заасан мэдээллийг тусгасан, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ. Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотойгоор "Инвескор ББСБ" ХК, "Инвескор Өсөлт ТЗК" ХХК болон "Эм Ай Си Жи" ХХК нар хооронд 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр 25/3-6 дугаар "Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ" (Хавсралт 4.5) байгуулагдсан байна. Тус гэрээ нь нийт 13 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Зээлийн эргэн төлөлтийн данс, уг дансанд цугларах зээлийн төлөөрийн орлогыг барьцаалах, ТЗК-ийн ХБҮЦ-ны төлөөрийг төлөх зорилгоор Зээлийн эргэн төлөлтийн данснаас ТЗК-ийн Төлбөр цуглуулах дансанд Гэрээ буюу журмаар тогтоосон хугацаанд үл маргах журмаар шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулж байна. Энэхүү гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Үнэт цаас гаргахтай холбоотойгоор байгуулсан гэрээнүүд:

Санхүүгийн тайлангийн аудитын гэрээ. Үнэт цаас гаргагчийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийлгэхээр ТЗК нь Лидер Экаунт Аудит ХХК-тай 2025 оны 11 сарын 19-ний өдөр СТА/ААНБ-2025/01 тоот Санхүүгийн тайлангийн аудитын гэрээ" (Хавсралт 4.6) байгуулсан байна. Уг гэрээ нь нийтлэг үндэслэл, үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, гүйцэтгэгчийн эрх, үүрэг, аудитын үйлчилгээний төлбөр, бусад гэсэн 5 бүлгээс бүрдэх зохицуулалттай бөгөөд аудит нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Аудитын тухай хууль, Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал, Нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм, журмын дагуу аудитыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэхээр тохиролцсон байна. "Лидер экаунт Аудит" ХХК нь Сангийн сайдын 2015 оны 07 дугаар сарын 08-ний өдрийн 191 тоот тушаалын дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх 17-2015 тоот тусгай зөвшөөрөл (Хавсралт 4.7, Хавсралт 4.8, 4.11)-тэй байх тул аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч бүртгүүлсэн, энэхүү гэрээг байгуулах эрхтэй болно. Гэрээний агуулгаас харвал, Аудитын тухай хуульд заасан гэрээнд тусгавал зохих мэдээллийг тусгасан, гэрээ нь хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

Банк бус санхүүгийн байгууллагад зориулсан Lite Banker Системийн ашиглалтын үйлчилгээний гэрээ. СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 2.1.5, 11.2-т заасны дагуу ТЗК нь хөрөнгөтэй холбоотой мэдээллийг хадгалах нэгдсэн системтэй байх шаардлага тавигдсан. Үүнтэй холбоотойгоор "Инвескор ББСБ" ХК болон "Дайнамикс Софт" ХХК нарын хооронд 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр SUPX250001 тоот "Ашиглалтын үйлчилгээний гэрээ" (Хавсралт 4.9) байгуулагдсан байна. Уг гэрээгээр "Дайнамикс Софт" ХХК нь Хэрэглэгч болох "Инвескор ББСБ" ХК-д тус гэрээний 3.1 дүгээр зүйлд заасны дагуу Lite Banker программын хэвийн, тасралтгүй ашиглалтад

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ББСБХК
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

380

2025/11/28

шаардлагатай программын алдааг засварлах, программын сайжруулсан хувилбарыг нийлүүлэх, заавар зөвлөгөө өгөх, программын талаарх аливаа сэтгэгдэл, хүсэлт, гомдолд хариу өгөх, үйлчилгээний тайлан гаргаж өгөх, системээс боломжтой лог бүртгэлийн мэдээллийг шүүж өгөх зэрэг бусад үйлчилгээг үзүүлэх, "Инвескор ББСБ" нь үйлчилгээг гүйцэтгэгчээс хүлээн авч төлбөр төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. "Инвескор ББСБ" ХК нь Үнэт цаас гаргагчид Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу тус гэрээгээр тохиролцсон үйлчилгээг үзүүлэх бөгөөд үйлчилгээг эрхлэхэд шаардлагатай техникийн нөхцөлоор бүрэн хангагдсан байх талаар зааван бөгөөд уг Системийн ашиглалтын үйлчилгээний гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Оффисын талбайн түрээсийн гэрээ. Үнэт цаас гаргагч "Инвескор Өсөлт" ХХК нь "Инвескор ББСБ" ХК-тай 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдөр Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Парисын гудамж, Ай Си Тауэр, 14 давхар, 1401 тоот хаягт байрлах 362.8 м.кв талбайг оффисын талбайн зориулалттаар түрээслэхээр "Оффисын талбайн түрээсийн гэрээ" (Хавсралт 4.10)-г байгуулжээ. Түрээсийн гэрээний түрээсийн төлбөр нь үнэ төлбөргүй бөгөөд "Инвескор Өсөлт" ХХК татан буугдах хүртэлх хугацаанд хүчинтэй байхаар байгуулагдсан ба тус гэрээ нь Иргэний хуульд нийцэж байна.

Андеррайтерийн, аудитын, хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ. Энэхүү гэрээний талаар Дүгнэлтийн 5 дугаар бүлгээс танилцана уу.

Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулсан гэрээ, Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсгээгүй байна.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
381
5117833 1119277128
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

2025.12.25 ... БҮРТГЭВ №01

БҮРТГЭВ-02

5. Үнэт цаас гаргасан нь хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргах эрх эзэмшигч аливаа этгээдийн өмнө хүлээсэн үүрэг, амлалтын зөрчилгүй эсэх

Оролцогч байгууллагууд:

Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах ажиллагаанд Үйлчилгээ үзүүлэгч болон Захиргааны үйлчилгээ үзүүлэгчээр "Инвескор ББСБ" ХК, Хөндлөнгийн хуулийн шинжээч, хуулийн зөвлөхөөр "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН, Санхүүгийн шинжээчээр "Си Пи Ти Эй Аудит" ХХК, Санхүүгийн хөндлөнгийн аудиторoор "Лидер экаунт Аудит" ХХК, Андеррайтераар "Голомт Капитал ҮЦК" ХХК, туслах андеррайтераар "Инвескор Капитал ҮЦК" ХХК, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Эм Ай Си Жи" ХХК нар тус тус ажиллаж байгаа болно (Хавсралт 5.1).

Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ. Гэрээний дэлгэрэнгүй тайлбартай Дүгнэлтийн 4 дэх хэсгээс танилцана уу (Хавсралт 4.4). Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Эм Ай Си Жи" ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 635 дугаар тогтоолын дагуу ТЗ 316/19 тоот үнэт цаасны зах зээлд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 5.2) авсан тул тус гэрээг байгуулах эрх бүхий этгээд болно.

Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ. Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ гаргах, Монголын Хөрөнгийн Биржээр олон нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв эсэх, сонгогдсон зээлийн дансдууд хуулийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргуулахаар "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-тэй Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ (Хавсралт 1.2)-г 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан байна. Гэрээ нь нийтлэг зүйл, гэрээт ажил, гэрээний хугацаа, гэрээт ажлын хөлс, зардал, төлбөр тооцоо, хуулийн зөвлөхийн эрх, үүрэг, үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, харилцах хүмүүс, хариуцлагын хязгаарлалт, гэрээг дуусгавар болгох, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, бусад зүйл гэсэн 11 бүлгээс бүрдэх зохицуулалттай байна. Дүгнэлтийн 1 дүгээр бүлэгт зааснаар "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь үнэт цаасны зохицуулалттай этгээдэд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээд болно (Хавсралт 1.1).

Зээлийн багцад санхүүгийн шинжилгээ хийх гэрээ. Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах, олон нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэх, сонгогдсон зээлийн дансдууд санхүүгийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаарх дүгнэлт гаргуулахаар "Си Пи Ти Эй Аудит" ХХК-тай ХБҮЦ Зээлийн багцад санхүүгийн шинжилгээ хийх гэрээ (Хавсралт 5.4)-г 2025 оны 05 дугаар сарын 27-ний өдөр байгуулсан байна. Энэхүү гэрээгээр ажлын цар хүрээ, зээлийн шалгуур, аудитор болон үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, онцгой эрх ба хариуцлага, ажил гүйцэтгэх хугацаа, ажлын төлбөр, давагдашгүй хүчин зүйл болон бусад харилцааг зохицуулсан байна. Гэрээ нь Аудитын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.3 дахь хэсэг, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 40.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журмын холбогдох шаардлагыг хангасан байна. "Си Пи Ти Эй Аудит" ХХК нь үнэт цаасны зохицуулалттай этгээдэд аудитын үйлчилгээ үзүүлэх эрх олгогдсон этгээд байх (Хавсралт 5.5, 5.6, 5.7) тул уг үйлчилгээг үзүүлэх эрх бүхий этгээд болно.

ИНВЕСКОР ӨӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
382
InvesCore CAPITAL
6317839 1119277129
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

InvesCore FI
2025 -12- 01
БҮРТГЭВ-02

2025 оны 12 сарын 26
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

Андеррайтерийн үйлчилгээний гэрээ. Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн зах зээлд нийтэд санал болгон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх болон андеррайтерийн үйлчилгээний төлбөр төлөхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахаар "Инвескор Өсөлт ТЗК" ХХК болон "Инвескор ББСБ" ХК нь үндсэн андеррайтер "Голомт Капитал ҮЦК" ХХК, туслах андеррайтер "Инвескор Капитал ҮЦК" ХХК нартай нар 25/3-8 тоот "Андеррайтерийн үйлчилгээний гэрээ" (Хавсралт 5.8)-г 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан байна. Гэрээ нь нийтлэг үндэслэл, нэр томъёо, гэрээний хугацаа, үйлчилгээний төлбөр, талуудын эрх, үүрэг, хариуцлага, маргаан шийдвэрлэх, нууцлал, гэрээ дуусгавар болох, бусад гэсэн арван бүлэг бүхий зохицуулалттай байна. Энэхүү гэрээгээр үндсэн андеррайтер нь үнэт цаас гаргах бэлтгэл хангах үйлчилгээ үзүүлэх, үндсэн андеррайтер болон туслах андеррайтер нь шаардлагатай санхүүжилтыг хамтран татан төвлөрүүлж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3-т заасан хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах (Best effort) хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхээр тохиролцсон байна. Гэрээ нь Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

"Голомт Капитал ҮЦК" ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 156 дугаар тогтоолын дагуу ТЗ 301/97 тоот үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 5.9, 5.10)-тэй тул тус гэрээг байгуулах эрх бүхий этгээд болно. Энэхүү гэрээ нь холбогдох хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

"Инвескор Капитал ҮЦК" ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 315 дугаар тогтоолын дагуу ТЗ 301/113 тоот үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 5.14, 5.15, 5.16)-тэй тул тус гэрээг байгуулах эрх бүхий этгээд болно. Түүнчлэн "Инвескор ББСБ" ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр 25/41 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай" тогтоол (Хавсралт 5.17)-оор өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор Зөвлөх үйлчилгээний гэрээг "Инвескор Капитал ҮЦК" ХХК-тай байгуулах зөвшөөрлийг олгосон байна. Энэхүү тогтоолыг Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт нийцүүлэн гаргасан байна.

Энэхүү Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ нь холбогдох хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ. Компанийн ХЭХ, ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын чиг үүргийг гүйцэтгэх, албан бичиг хэргийн ажил гүйцэтгэх, Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай хамтран нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг холбогдох стандарт журам зааврын дагуу хийх, ТЗК-ийн мөнгөн хөрөнгөөс шаардлагатай мөнгөн гүйлгээг ХИУ гүйцэтгэхэд хяналт тавих, хамтран гүйцэтгэх, хүүгийн орлогын албан татвар тайлагнах, Компанийн цахим хуудасны хөгжүүлэлт, хөтлөлтийг хариуцах зэрэг Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотойгоор 25/3-5 тоот "Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 5.11)-г Үнэт цаас гаргагч нь "Инвескор ББСБ" ХК-тай 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан байна. Гэрээ нь нийтлэг үндэслэл, үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс, баталгаа мэдэгдэл, гэрээ дуусгавар болох, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, нууц мэдээлэл, маргаан шийдвэрлэх, бусад зүйл гэсэн 9 бүлэг бүхий зохицуулалттай байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.12.5-д зааснаар

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

383

2025/11/28

2025 -12- 01
БҮРТГЭВ-02

2025 12. 25
№ 01

Тусгай зориулалттын компани нь хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулахын хэрэгцээгүй тул компанийн захиргааны шинжтэй ажлуудыг бие даасан хуулийн этгээдтэр гүйцэтгүүлэхээр тохиролцсон энэхүү гэрээ нь хуулийн хүчин төгөлдөр байна.

Энэхүү төсөлд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, төлбөр цуглуулах болон захиргааны үйлчилгээ үзүүлэгч, хорогийн барьцааны болон зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээний барьцаалуулагчаар оролцож байгаа "Инвескор ББСБ" ХК нь Үнэт цаас гаргагчийн толгой компани болохыг, түүнчлэн андеррайтер "Инвескор Капитал УЦК" ХХК нь Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани юм. Үнэт цаас гаргагч нь эдгээр компанитай нэгдмэл сонирхолтой учир дараах шийдвэр гаргасан байна:

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай. Компанийн ТУЗ-ийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 25/2-7 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрөл олгох тухай" тогтоол (Хавсралт 5.12)-оор "Инвескор ББСБ" ХК-тай дараах гэрээг байгуулахыг зөвшөөрсөн байна.

- Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 5.11)
- Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ (Хавсралт 4.1)
- Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 4.2)
- Хөрөнгийн барьцааны гэрээ (Хавсралт 4.3)
- Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ (Хавсралт 4.5)

Энэхүү тогтоолыг Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт нийцүүлэн гаргасан байна (Хавсралт 5.12).

Үнэт цаас гаргагч болон энэхүү үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөндлөнгийн хуулийн шинжээч, санхүүгийн шинжээч байгууллагуудтай аливаа сонирхлын зөрчилгүй талаарх мэдээллийг бидэнд ирүүлсэн (Хавсралт 5.14, 5.15).

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЗК ХХК
InvesCore Growth ББСБ LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
384
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
InvesCore FI
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

2025 .12. 25 Өдөр
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

б. Хөрөнгийн багц дахь хөрөнгийн гэрээ бүрээс хамааруулан санамсаргүй түүврийн аргаар сонгосон хамаарч үнэт цаас гаргагчаас тогтоосон хууль зүйн шалгуур үзүүлэлт хангаж буй эсэх

Бид Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчийн хүсэлтийн дагуу санамсаргүй түүврийн аргаар сонгосон 83 зээлийн дансдад Үнэт цаас гаргагчийн тогтоосон б шалгуур үзүүлэлтээр 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хооронд хууль зүйн дүн шинжилгээ гүйцэтгэж, Автотээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (ХБҮЦ) гарган олон нийтэд нээлттэй санал болгох хүрээнд хөрөнгийн багц дахь сонгогдсон зээлийн данс нь хуулийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан (Хавсралт 6.1)-г гаргасан.

Түс тайлангаар санамсаргүй түүврийн аргаар сонгосон 83 зээлийн дансдууд нь Үнэт цаас гаргагчийн тогтоосон дараах шалгуурыг хангасан болохыг тэмдэглэсэн байна. Үүнд:

1. Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх;
2. Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд ут зээлийг барьцаа (фидуцийн) хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх;
3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацааныаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх;
4. Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ, эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуци болон барьцааны зүйлийн холбогдох эрхийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй, эсхүл хязгаарлаагүй байх;
5. Зээлтэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, түүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх;
6. Фидуцийн болон барьцааны гэрээ хүчин төгөлдөр байлгахад Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх.

Дэлгэрэнгүй мэдээллийг тус тайлан (Хавсралт 6.1)-аас үзнэ үү.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТӨК ХХК
InvesCore Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
АТА16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

385

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 12 31
БҮРТГЭВ-02

он 2025сар 12. 26өр.
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

7. Багцын хөрөнгөөс үүсэлтэй гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох зээлийн хүүгээ, гүйлгээний шимтгэл, зээл, хадгаламж үүсгэн гүйцэтгэлийн үүсэлтэй холбоотой алдагдал шаардах эрхийг шилжүүлэхгүй бөгөөд хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгасан эсэх

Хууль зүйн дүн шинжилгээний тайлан (Хавсралт 6.1)-аар багцын хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох зээлийн, фидуцийн болон барьцааны гэрээ нь хууль тогтоомжид нийцсэн бөгөөд тус гэрээ, хэлцэлд үүргийн гүйцэтгэлийн зүйл (фидуци, барьцаа)-тэй холбоотой шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгагдаагүй болох талаар дүгнэсэн болно. Дэлгэрэнгүйг Хууль зүйн дүн шинжилгээний тайлан (Хавсралт 6.1)-аас үзнэ үү.

ИНВЕСКОР ӨСӨЛТ ТЭК ХХК
InvesCore
Growth ABS LLC
УЛААНБААТАР ХОТ
ATA16551 7167257 9025101486

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore
CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

386

2025/11/28

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
InvesCore FI
2025 -12- 31
БҮРТГЭВ-02

2025 оны 12 сарын 25
БҮРТГЭВ
№ 91

MDSKhanLex

8. Үнэт цаасны танилцуулга гүйцэт тусгагдсан эсэхтэд нь Үнэт цаасны эх сурвалжийн хэсэг нь. Хэрэглэгч баталгаажсан үнэт цаасны тухай хуульд бусад холбогдох зүйл заалтыг анхаарч үзэх, үнэн зөв хүчин төгөлдөр эсэх

МДСХ нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий дараах мэдээлэл Үнэт цаас гаргагч, төрийн болон бусад эрх бүхий байгууллагаас гаргуулсан баримтай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна гэж үзлээ. Үүнд:

- Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах шийдвэр, нөхцөл;
- Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны эргэн төлөлтийн нөхцөл, хүү, хүүг тооцох аргачлал, үнэт цаас гаргагч гаргасан үнэт цаасаа буцаан худалдаж авах нөхцөлгүй тухай;
- Хөрөнгийн багц дахь зээлийн дансдын тоо;
- Үнэт цаас гаргагчийн оноосон нэр, үйл ажиллагааны чиглэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн огноо, оршин байгаа газрын шууданчийн болон холбоо барих хаяг;
- Үнэт цаас гаргагчийн бүртгэл, зөвшөөрөл;
- Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, түүнд хувьцаа эзэмшигч нарын эзлэх хувь, зарласан болон гаргасан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ;
- Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт;
- Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, ТУЗ-ийн гишүүний талаарх мэдээлэл, тэдгээрийн боловсрол, ажлын туршлагын талаарх мэдээлэл;
- Үнэт цаас гаргагчийн оролцогч талуудтай хийсэн гэрээ, хэлцэл, гэрээгээр хүлээж буй эрх, үүрэг;
- Хөрөнгийн багцад тавигдах хуулийн болон санхүүгийн шаардлага үзүүлэлт;
- Хөрөнгийн багц дахь зээлийг солих, нэмэгдүүлэх, буцаан худалдах нөхцөл, түүний холбогдох зохицуулалт;
- Үнэт цаасны төлбөр төлөх төлбөрийн зохицуулалт;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан гэрээ (Хөрөнгө худалдах, худалдан авах, Фидуцийн барьцааны гэрээ, Төлбөр цуглуулах, төлбөр төлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ);
